



**Өмнөговь аймгийн  
Байгаль орчин, аялал  
жуулчлалын газар**





**Хөдөө аж ахуйн их  
сургуулийн  
Агроэкологийн  
сургууль**



**Говь гурвансайханы  
байгалийн  
цогцолборт газрын  
хамгаалалтын  
захиргаа**

## **ГОВЬ ГУРВАН САЙХАНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОР ГАЗРЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ, ДААЦЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



**Улаанбаатар хот**

**2022 он**

**Захиалгат ажлын нэр:** Говь гурвансайханы Байгалийн Цогцолборт Газрын аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа

**Хугацаа:** 2022 он

**Захиалагч байгууллага:** Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

**Гүйцэтгэгч байгууллага:** Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Агроэкологийн Сургууль

**Удирдагч:**

Т.Оюунчимэг, доктор, дэд профессор

**Судлаачид:**

Ш.Оюунтуяа, доктор, дэд профессор

М.Уянга, докторант

Б.Баасаннамжий, докторант

Н.Сарангарав, докторант

С.Цогт, докторант

С.Мөнхнасан, докторант

Б.Сэр-Од, докторант

О.Доржсэмбэ

Б.Оргилмаа, магистр

Д.Ганчулуун, магистр

Н.Нарангарав

Э.Золзаяа, БОХУ-III оюутан

Н.Амарбаясгалан, БОХУ- IV оюутан

Г.Билэгдэмбэрэл, БОХУ-IV оюутан

О.Болд-Эрдэнэ, БОХУ- IV оюутан

Ө.Мөнхбат, БАЖ-III оюутан

## АГУУЛГА

ОРШИЛ.....	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГГБЦГ-ЫН ДОТООД БҮСЧЛЭЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА.....	3
1.1. ГГБЦГ-ЫН ДОТООД БҮСЧЛЭЛ.....	3
1.1.1. Хамгаалалтад авсан үндэслэл, нутаг дэвсгэрийн хэмжээ.....	3
1.1.2. Дотоод бүсчлэл.....	3
1.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГГБЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ, ДААЦЫН СУДАЛГАА ..	12
2.1. ГГБЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУУРЬ НӨӨЦҮҮД.....	12
2.1.1. Байгаль, газарзүйн нөхцөл, нөөц.....	12
2.1.2. Нийгэм, эдийн засгийн нөхцөл, нөөц.....	33
2.1.3. Аялал жуулчлалын голлох нөөц, бүтээгдэхүүнүүд.....	39
2.2. Аялал жуулчлалын даацыг тогтоох арга зүйн үндэслэл, судалгаанд ашигласан тайлан, мэдээ.....	63
2.2.1. Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ хийсэн арга зүй.....	63
2.2.2. Байгалийн ландшафтын эрсдэлийн үнэлгээ хийсэн арга зүй.....	65
2.2.3. Аялал жуулчлалын даац тогтоосон арга зүй.....	67
2.2.4. Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ хийсэн арга зүй.....	68
2.2.5. Аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ хийсэн арга зүй.....	69
2.3. ГГБЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацын үнэлгээ.....	72
2.3.1. Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ.....	72
2.3.2. Байгалийн ландшафтын иж бүрдлийн эрсдэлийн үнэлгээ.....	76
2.3.3. Аялал жуулчлалын даацыг тооцох.....	81
2.3.4. Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ.....	84
2.3.5. ГГБЦГ-ын аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ.....	85
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГГБЦГ-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ТОГТВОРТОЙ ХӨГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛ, ЧИГ БАРИМТЛАЛ.....	97
3.1. ГГБЦГ-т аялах аялагчдын хэв шинж, хэтийн төлөв.....	97
3.1.1. ГГБЦГ-т аялагч, жуулчдын хэтийн төлөв, прогноз.....	98
3.1.2. Аялагч, жуулчдын зах зээлийн хэв шинж, эрэлт хэрэгцээ.....	99
3.2. ГГБЦГ-ын аялал жуулчлалыг хөгжүүлэх чадавх.....	110
3.2.1. Аялагчдыг тогтвортой нэвтрүүлэх Хамгаалалтын Захиргааны хүний нөөцийн чадавх.....	110
3.2.2. ГГБЦГ-ын Хамгаалалтын захиргааны менежментийн чадавх.....	112
3.2.3. Аялагч, жуулчдыг хүлээн авах байршуулах хэрэгслийн чадавх, зөвшөөрөгдөх дээд хэмжээ.....	114

3.3. ГГБЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ, ДААЦАД ҮНДЭСЛЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, ЗӨВЛӨМЖ.....	116
3.3.1. ГГБЦГ-ын нөхцөл байдалд хийсэн шинжилгээ .....	116
3.3.2. ТХГН-т нэвтрэх гадаад, дотоод жуулчдын тоо, орлого, зарлагыг тооцох аргачлал .....	124
3.3.3. ТХГН-ын нөөц, даацын онцлогийг харгалзсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний норм стандартыг тогтоох .....	128
3.3.4. Цаашид хэрэгжүүлэх боломжтой, санал болгож буй аяллын хөтөлбөр, маршрут .....	132
3.3.5. ГГБЦГ-т аялал жуулчлалыг түүний нөөц, даацад тохируулан хөгжүүлэхэд анхаарах зүйлс.....	134
3.3.6. Аялал жуулчлалын нөөцийг зохистой ашиглах, хамгаалах байдлаар ГГБЦГ-т хөгжүүлэх боломжтой аяллын зарим төрлүүд .....	136
3.3.7. Аялал жуулчлалын нөөцийг зохистой ашиглах, хамгаалах талаар өгөх зөвлөмж .....	140
ДҮГНЭЛТ.....	144
НОМ ЗҮЙ.....	148

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АИХ	Ардын Их Хурал
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БЦГ	Байгалийн Цогцолборт Газар
ГБДЦГ	Говийн Бага Дархан Цаазат Газар
ГБДЦГХЗ	Говийн Бага Дархан Цаазат Газрын Хамгаалалтын Захиргаа
ГГБЦГ	Говь Гурван Сайханы Байгалийн Цогцолборт Газар
ГГБЦГХЗ	Говь Гурван Сайханы Байгалийн Цогцолборт Газрын Хамгаалалтын Захиргаа
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ӨГУТХГХЗ	Өмнөговь аймгийн Улсын Тусгай Хамгаалалттай Газрын Хамгаалалтын Захиргаа
ТХГН	Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
УИХ	Улсын Их Хурал
ХНЧ	Хүний нөөцийн чадавх

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. ГГБЦГ-ын дотоод бүсчлэл, эзлэх хувь .....	4
Хүснэгт 2. ГГБЦГ-ын онцгой болон аялал жуулчлалын бүсүүдэд хамаарах газар нутгууд ба талбайн хэмжээ .....	4
Хүснэгт 3. Сүүлийн 10 жилд ГГБЦГ-т зочилсон жуулчдын тоо (2012-2021) .....	6
Хүснэгт 4. ГГБЦГ-аар аялах бусад маршрутууд .....	10
Хүснэгт 5. ГГБЦГ-т тэмдэглэгдсэн ашигт, малтмалын орд, илрэлүүд .....	13
Хүснэгт 6. Агаарын температурын үзүүлэлтүүд, тэдгээрийн өөрчлөлт .....	15
Хүснэгт 7. Дулааны хэмжээ, түүний өөрчлөлт .....	16
Хүснэгт 8. ГГБЦГ-ийн Хөхтөн амьтны зүйлийн бүрдэл .....	20
Хүснэгт 9. ГГБЦГ-ын шувуудын зүйлийн бүрдэл .....	22
Хүснэгт 10. Мөлхөгчдийн зүйлийн бүрдэл .....	26
Хүснэгт 11. ГГБЦГ-т хамаарах сумдын нутаг дэвсгэрийн хэмжээ (га) .....	33
Хүснэгт 12. ГГБЦГ-ын бүсүүдэд амьдарч буй өрх, хүн амын тоо .....	34
Хүснэгт 13. ГГБЦГ-ын газрын нэгдмэл сан .....	37
Хүснэгт 14. ГГБЦГ-ын бүсүүд дэх өвөлжөөний тоо (2022 оны байдлаар) .....	38
Хүснэгт 15. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд .....	47
Хүснэгт 16. ГГБЦГ дахь түүх, домог бүхий газрууд .....	58
Хүснэгт 17. ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт зохион байгуулагддаг эвентүүд .....	60
Хүснэгт 18. ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазууд .....	61
Хүснэгт 19. Ландшафтын эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт .....	65
Хүснэгт 20. Аялал жуулчлалд гадаргын налууг харгалзах үзүүлэлтүүд .....	65
Хүснэгт 21. Хөрсний чанарын үнэлгээ .....	67
Хүснэгт 22. Рекреацийн үйл ажиллагааг улирлын ялгаагаар үнэлэх үзүүлэлтүүд .....	68
Хүснэгт 23. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээний шатлал .....	70
Хүснэгт 24. ГГБЦГ-ын уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал .....	71
Хүснэгт 25. ГГБЦГ-ын ургамлын рекреацийн нөөцийн үнэлгээний шалгуур, шатлал .....	71
Хүснэгт 26. ГГБЦГ-ын амьтны рекреацийн нөөцийн үнэлгээний шалгуур, шатлал .....	72
Хүснэгт 27. ГГБЦГ-ын хүний үйл ажиллагаанд ашиглагдаж буй газрууд .....	72
Хүснэгт 28. ГГБЦГ-ын авто замын нөлөөллийн зэрэг .....	73
Хүснэгт 29. Малчдын бэлчээр ашиглалтын нөлөөлөл .....	74
Хүснэгт 30. Говь Гурван Сайханы БЦГ-ын жуулчны баазуудын нөлөөлөл .....	75
Хүснэгт 31. Байгаль ландшафтад үзүүлж буй хүний үйл ажиллагааны нөлөө .....	75
Хүснэгт 32. ГГБЦГ-ын гадаргын налуу ба аялал жуулчлалд тохиромжтой байдал .....	76
Хүснэгт 33. ГГБЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн үнэлгээ (сумдаар) .....	78
Хүснэгт 34. ГГБЦГ-ын хөрсний чанарын үнэлгээ .....	80
Хүснэгт 35. Байгаль ландшафтын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ .....	80
Хүснэгт 36. ГГБЦГ-ын рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ .....	84
Хүснэгт 37. ГГБЦГ-ын ландшафтын үндсэн хэв шинжүүд .....	85
Хүснэгт 38. ГГБЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ .....	86
Хүснэгт 39. ГГБЦГ-ын уур амьсгалын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ .....	87
Хүснэгт 40. ГГБЦГ-ын гадаргын усны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ .....	89
Хүснэгт 41. ГГБЦГ-ын ургамалжилтын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ .....	91
Хүснэгт 42. Амьтны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ .....	92
Хүснэгт 43. Ландшафтын аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ .....	94
Хүснэгт 44. Монголд ирсэн гадаадын жуулчдын сонирхдог зүйлс .....	97
Хүснэгт 45. Нийт жуулчдын тоог тэгшитгэлийн Х утгад шилжүүлсэн байдал .....	98
Хүснэгт 46. Судалгаанд оролцогчдын аяллын ерөнхий хандлага .....	100
Хүснэгт 47. ГГБЦГ-аар зорчсон гийчдээс авсан зорилтот судалгааны үр дүн .....	100
Хүснэгт 48. ГГБЦГ-ын аялал жуулчлалын үйлчилгээний чанарын үзүүлэлт .....	104



Хүснэгт 49. ГГБЦГ-аар зорчигч гийчдийн ерөнхий сэтгэл ханамж.....	104
Хүснэгт 50. Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ.....	104
Хүснэгт 51. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл.....	106
Хүснэгт 52. ГГБЦГ-аар аялах үеийн судалгааны үр дүн.....	106
Хүснэгт 53. ГГБЦГ-т ирээд юу үзэж сонирхсон бэ? .....	107
Хүснэгт 54. ГГБЦГ-т ирээд үзэж сонирхсон зүйлсээс хамгийн их сэтгэл ханамж авсан зүйлс .....	107
Хүснэгт 55. ГГБЦГ-ын аялал жуулчлалын үйлчилгээний чанар .....	108
Хүснэгт 56. Хөтчийн үйлчилгээнд өгсөн сэтгэл ханамж.....	108
Хүснэгт 57. ГГБЦГ-ын аялал жуулчлалын үйлчилгээний сэтгэл ханамж.....	108
Хүснэгт 58. ГГБЦГ-ыг бусдад санал болгох байдал .....	109
Хүснэгт 59. Гадаадын иргэдээс авсан судалгааны төгсгөлийн хэсэгт оролцогчдоос задгай асуултаар санал авсан.....	109
Хүснэгт 60. Маркетингийн чадавх.....	112
Хүснэгт 61. Үйлдвэрлэл, үйлчилгээний чадавх .....	113
Хүснэгт 62. Бүтээгдэхүүний чадавх .....	113
Хүснэгт 63. Менежментийн чадавх .....	113
Хүснэгт 64. Хүний нөөцийн чадавх.....	113
Хүснэгт 65. Санхүүгийн чадавх.....	113
Хүснэгт 66. ГГБЦГ-ын одоо байгаа жуулчны баазын хүчин чадал (жилээр).....	115
Хүснэгт 67. ГГБЦГ-ын SWOT шинжилгээ.....	116
Хүснэгт 68 ГГБЦГ-ын нөхцөл байдалд хийсэн SWOT-АНР шинжилгээний үр дүн.....	117
Хүснэгт 69. СРМ матриц .....	123
Хүснэгт 70. ГГБЦГ-ын үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо.....	125
Хүснэгт 71. ГГБЦГ-ын аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа явуулсан нийт өдрийн тоо (2022 оны 3-р улирал).....	126
Хүснэгт 72. ГГБЦГ-ын дотоодын нэг жуулчинд ногдох аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлого (2022 оны 3-р улирал).....	127
Хүснэгт 73. ГГБЦГ-ын аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын ТХГН-д аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал (2022 оны 3-р улирал) .....	127
Хүснэгт 74. Хүснэгт. ГГБЦГ-ын бүсүүдэд хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэл .....	128
Хүснэгт 75. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний стандарт, норм.....	129
Хүснэгт 76. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний эко стандартууд.....	131
Хүснэгт 77. Маршрут 1. Баян төхөмийн нуурт шувуу ажиглах аялал /хавар, намрын улирал/ .....	132
Хүснэгт 78. Маршрут 2. Үлэг гүрвэлийн мөрөөр аялал /хавар, намрын улирал/.....	132
Хүснэгт 79. Маршрут 3. Морь ба тэмээн аялал.....	133
Хүснэгт 80. Маршрут 4. Холын зайн өвөрмөц аяллын замнал.....	133
Хүснэгт 81. Нэн ховор, ховор амьтдыг ажиглах боломжтой газрууд.....	136
Хүснэгт 82. ГГБЦГ-ийн нэн ховор ургамалын тархац, сумдаар.....	138
Хүснэгт 83. ГГБЦГ-ийн ховор ургамалын тархац, сумдаар .....	139

## ЗУРАГ

Зураг 1. ГГБЦГ-ын дотоод бүсчлэл.....	6
Зураг 2. ГГБЦГ-т үйл ажиллагаа явуулдаг жуулчны баазууд .....	7
Зураг 3. ГГБЦГ-ын түр амрах цэг, ухуулах самбар, бие засах газар.....	9
Зураг 4. Түр амрах цэг бүхий тохижуулсан авто зогсоолууд .....	9
Зураг 5. ГГБЦГ-ын аяллын маршрутууд .....	10
Зураг 6. ГГБЦГ-аар аялах бусад маршрутууд.....	11
Зураг 7. Агаарын температурын өөрчлөлт, хандлага.....	15
Зураг 8. Хур тунадасны өөрчлөлт, хандлага .....	16
Зураг 9. Судалгааны нутгийн уур амьсгалын зураг.....	16
Зураг 10. Монгол орны зоогеографийн мужлал (А.Г.Банников).....	19
Зураг 11. Монгол орны ургамал газарзүйн тойрог.....	27
Зураг 12. Говь Гурвансайханы БЦГ-ийн хөрсний зураглал.....	30
Зураг 13. ГГБЦГ-т байрлах малчдын өвөлжөөний байршил.....	39
Зураг 14. Хонгорын гол дахь гэр буудлуудын байршил.....	62
Зураг 15. Ёлын аманд үйл ажиллагаа явуулж буй зөвшөөрөлгүй гэр буудлууд.....	62
Зураг 16. Ёлын аманд үйл ажиллагаа явуулж буй гэр шопууд .....	63
Зураг 17. ГГБЦГ-ын авто зам ашиглалтын нөлөөлөл .....	73
Зураг 18. ГГБЦГ дахь малчин өрхийн бэлчээр ашиглалт.....	74
Зураг 19. Жуулчны баазаас ГГБЦГ-т үзүүлэх нөлөөлөл.....	75
Зураг 20. Байгаль ландшафтад үзүүлж буй хүний үйл ажиллагааны нэгдсэн нөлөө.....	76
Зураг 21. ГГБЦГ-ын гадаргын налуугийн аялал жуулчлалд тохиромжтой байдал.....	77
Зураг 22. ГГБЦГ-ын гадаргын хэрчигдлийн шигүү.....	78
Зураг 23. ГГБЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн зэрэг .....	80
Зураг 24. ГГБЦГ-ын байгаль ландшафтын эрсдлийн нэгдсэн үнэлгээ .....	81
Зураг 25. ГГБЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ.....	87
Зураг 26. ГГБЦГ-ын уур амьсгалын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ .....	89
Зураг 27. ГГБЦГ-ын гадаргын усны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ.....	90
Зураг 28. Ургамалжилтын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ .....	92
Зураг 29. Амьтны аялал-рекреацийн үнэлгээ.....	93
Зураг 30. ГГБЦГ-ын ландшафтын аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ.....	96
Зураг 31. Олон улсын аялал жуулчлалын 1950-2030 онд хүрэх төлөв байдал.....	97
Зураг 32. Stata программын тооцоолол.....	99
Зураг 33. Хувьсагчдын хамаарал.....	99
Зураг 34. Хонгорын элс орчимд шинээр аялал жуулчлалын үйл ажиллагаа төлөвлөх боломжит байршил .....	116



## ГРАФИК

График 1. ГГБЦГ-ын бүсүүдийн эзлэх хувь .....	4
График 2. ГГБЦГ-т зочилсон жуулчдын тоон өөрчлөлт .....	7
График 3. Булаг шандын усны горим .....	17
График 4. Булаг шанд, рашаан усны ашиглалт.....	17
График 5. ГГБЦГ-ын малын төрөл .....	35
График 6. ГГБЦГ-ын нийт малын тоо толгойн өсөлт ᠑2᠐17-2᠐2᠐᠐ .....	35
График 7. Малын тоо, толгойн өсөлт 2᠐17-2᠐2᠐ (төрлөөр).....	36
График 8. ГГБЦГ-ын бүсүүд дэх малын тоо толгойн өсөлт.....	36
График 9. ГГБЦГ-ын онцгой бүс дэх малын тоо толгойн өсөлт .....	37
График 10. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалт .....	57
График 11. ГГБЦГ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрлүүд.....	57
График 12. ГГБЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэл.....	79
График 13. ГГБЦГ-ын нутаг дэвсгэрийн хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн зэрэг .....	79
График 14. Гийчдийн ирэх давтамж болон аяллын үргэлжлэх хугацаа .....	102
График 15. Гийчдийн сонирхсон үзмэрүүд /давхардсан тоогоор/ .....	103
График 16. Дээрх үзмэрүүдээс хамгийн их сонирхол татсан байдал.....	103
График 17. ГГБЦГ-ын ажилчдын бүрэлдэхүүн.....	111
График 18. ГГБЦГ-ын ажилчдын мэргэшсэн.....	118
График 19. Мэргэжлийн бус ажилчдын.....	111
График 20. ГГБЦГ-ын менежментийн чадавхын шинжилгээний үр дүн .....	114

## ОРШИЛ

Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт зүйлс болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах зорилгоор тодорхой нутаг дэвсгэрийг улсаас тусгай хамгаалалтад авдаг. 2020 оны байдлаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нийт хэмжээ 120 байршилд 32.8 сая га-д хүрч, Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 21 хувийг эзлэх болжээ. Үүнээс байгалийн цогцолборт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ улсын нийт нутаг дэвсгэрийн 8.6% буюу 13,496,402 га-г эзэлж байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт зохион байгуулагдах аялал жуулчлалын үйл ажиллагаа нь тухайн хамгаалалттай нутаг дэвсгэр болон орон нутаг, түүний оршин суугчдад эдийн засгийн үр өгөөж өгч, байгаль хамгаалах ажилд ихээхэн дэмжлэг болох боломжтой. Гэвч аялал жуулчлалын бүхий л төрлүүд байгаль орчинд ямар нэг нөлөөлөл үзүүлдэг тул аливаа хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хэр хэмжээнд дэмжих болон хязгаарлах, түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, мөн нөлөөллийг бууруулах зэрэг асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн нөөц, даацад тулгуурлан тогтоох нь байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой.

Говь Гурван Сайханы Байгалийн Цогцолборт Газрыг байгуулах, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах шийдвэрийг 1993 оны 11-р сарын 12-ны өдрийн УИХ-ын 83 дугаар тогтоолоор гаргасан бөгөөд өдгөө Өмнөговь аймгийн 6 сум, 10 багийн нутаг дэвсгэрт Говь гурван сайхан уул, Сэврэй Зөөлөнгийн нуруу, тэдгээрийн хоорондох хоолой, түүнд тогтсон Хонгорын элс, Зулганайн элсэн тарамцгийг хамран 2.171.737 га талбайд оршдог Монгол улсын томоохон тусгай хамгаалалттай газар нутгуудын нэг болжээ. Тус цогцолборт газар нь анх ӨГУТХГХЗ-ны бүрэлдэхүүнд хамаарч байгаад хожим 2006 оны 07 сарын 24-ний өдрийн БОАЖ-ын сайдын 238 тушаалаар ГТБЦГ-ын Хамгаалалтын захиргааг байгуулж одоогоор 36 хүний орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнгөрсөн зууны 1960-аад оноос эхлэн Монгол оронд ирсэн гадаадын жуулчдыг Говь Гурван Сайхны Байгалийн цогцолборт газрын Ёлын ам, Хонгорын элс зэрэг үзэсгэлэнт газруудаар аялуулаг байсан ба сүүлийн жилүүдэд зорин ирэх гадаад, дотоодын жуулчдын тоо жил ирэх тусам нэмэгдсээр байна. 2022 онд одоогийн байдлаар Говь Гурван Сайхны байгалийн цогцолборт газар нь гадаадын 7027, дотоодын 14537, нийт 21654 жуулчин хүлээн аваад байна. Ковид-19 цар тахлын жилүүд болох 2020, 2021 онуудтай харьцуулахад энэ жил хүлээн авсан гадаадын жуулчдын тоо 319.4%, дотоодын жуулчдын тоо 12.4%-иар тус тус өсжээ. Говь Гурван Сайханы байгалийн цогцолборт газрыг зорин ирэх гадаад, дотоодын жуулчдын тоо цаашид ч эрчимтэй өсөхөөр байгаа тул тус хамгаалалтад авсан нутаг дэвсгэрийн үндсэн зорилгыг нь алдагдуулалгүйгээр тухайн газар нутгийн аялал жуулчлалын нөөц, байгаль орчны даацад тохируулан аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал нь зайлшгүй судалж тогтоох ёстой чухал асуудлын нэг болж байна. Энэхүү судалгааны зорилго нь Говь Гурван Сайханы байгалийн цогцолборт

газарт аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, байгалийн өөрөө нөхөн сэргэх чадвараас хүний нөлөөлөл давахгүй байх экологийн даацын дээд хязгаарыг тогтооход оршино. Иймээс тус судалгаа нь Говь Гурван Сайханы байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын нөөц, даацыг үнэлж, аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байгаагаараа ач холбогдолтой юм.

Тайлан нь 3 бүлэг, 8 дэд бүлэг, 33 зураг, үүнээс өмнө нь хийгдсэн судалгааны ажлуудаас ашигласан 5 зураг, хээрийн судалгааны үеэр авсан 3 фото зураг, тус судалгааны ажлын хүрээнд хийгдсэн 22 зураг, 83 хүснэгт, 20 график, 1 бүдүүвчийг багтаасан нийт 151 хуудас бүхий судалгааны ажлын үр дүн юм.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГБЦГ-ЫН ДОТООД БҮСЧЛЭЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

## 1.1.ГБЦГ-ЫН ДОТООД БҮСЧЛЭЛ

### 1.1.1. Хамгаалалтад авсан үндэслэл, нутаг дэвсгэрийн хэмжээ

Анх 1965 онд АИХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор Зүүн Сайхан уулын Ёлын-Амны өвөрмөц сайхан тогтоц, үзэсгэлэнт сайхан байгалийг хамгаалахаар улсын хамгаалалтад авсан байна. Улмаар 1993 оны 11-р сарын 12-ны өдрийн УИХ-ын 83 дугаар тогтоолоор ГБЦГ-ыг байгуулах, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах шийдвэр гарчээ.

Монгол улсын Засгийн Газрын 1994 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 95 дугаар тогтоолоор тус хамгаалалттай нутаг дэвсгэрийн хилийн заагийг баталсан бөгөөд хожим “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” Монгол улсын хуулиар байгалийн цогцолборт газрын хилийн цэсийг УИХ-аас баталж байх болсонтой холбоотой УИХ-ын 1995 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар тогтоолоор ГБЦГ-ын хилийн цэсийг дахин баталгаажуулсан юм. Энэхүү 1995 оны тогтоолоор тус газрын хилийн цэсийг дахин баталгаажуулахдаа экосистемийн хувьд онцгой ач холбогдол бүхий Алтан уулыг алтны уурхайн зориулалтаар ашиглах зорилгоор хамгаалалтаас гаргасан нь нэг талаар зарим бизнес эрхлэгчдийн явцуу эрх ашгийн төлөө хамгаалалтад авсан зорилгоо зөрчсөн, нөгөө талаар Төв Азийн цөл, цөлөрхөг хээрийн экосистемд ноцтой хохирол учруулахуйц үйл явдал болсон байна.

1996 оны 43-р тогтоолоор ГБЦГ-ыг байгуулсан бөгөөд Байгаль орчны сайдын 1996 оны 81 дүгээр тушаалаар ӨГУТХГХЗ гэсэн нэртэй бие даасан хамгаалалтын захиргаа байгуулагдаж нийт 4 аймгийн 16 сумыг хамарсан 4.6 сая га талбайг хариуцан ажиллаж байсан. БОАЖ-ын сайдын 2006.7.24-ний өдрийн А/238 тушаалаар ӨГУТХГХЗ-ны бүтцэд өөрчлөлт оруулж Ханбогд сумын төвд ГБЦГХЗ, ГБЦГХЗахиргааг тус тус зохион байгуулж ГБЦГ нь 2.7 сая га талбайг хамрах болсон боловч БОАЖЯ-ны сайдын 2012.06.04 ний өдрийн А/218 тушаалаар тус цогцолборт газрын Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баянговь, Баянлиг сумдын нутаг дэвсгэрт хамаарах 512 мянган га талбайг БЦГ-т шилжүүлснээр одоогийн 2.171.737 га талбайтай болсон юм.

ГБЦГХЗ, байгаль хамгаалагч нар хамгаалагдсан экосистемд тархсан биологийн олон янз байдал, тархац нутгийг хэвээр хадгалах, хамгаалах үүднээс орон нутгийн иргэдэд түшиглэн, тэдний тусламжтайгаар хамгаалж ирсэн байна.

### 1.1.2. Дотоод бүсчлэл

Байгалийн цогцолборт газар нь харьцангуй том хэмжээний нутгийг хамардаг тул аж ахуйн ашиглалтын үйл ажиллагаатай зөрчилдөх явдал зайлшгүй гардаг бөгөөд үүнийг зохицуулах арга зам нь хамгаалалтын бүсүүдийг оновчтой тогтоох явдал байдаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд Байгалийн Цогцолборт Газруудыг

хамгаалалтын онцгой, аялал жуулчлалын, хязгаарлалтын гэсэн 3 бүстэй байхаар заасан байдаг ба тэдгээр бүсүүдийг ялган тогтоох нь онол практикийн чухал ач холбогдолтой юм. Байгалийн Цогцолборт Газрын тухайд хамгаалалтын бүсүүдийг ялган тогтооход дан ганц аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах талаас хандвал өрөөсгөл болох талтай. Учир нь улсын тусгай хамгаалалттай газрын дотор дархан газрын дэд сүлжээг бүрдүүлэхэд байгалийн муж, дэд мужийг төлөөлөх зарим нутгийг Байгалийн Цогцолборт Газрын онцгой бүсээр төлөөлүүлэн үзэж болно. Иймд энэ байдлыг давхар харгалзан үзэж хамгаалалтын бүсийг тогтоох нь зүйтэй юм. Байгалийн цогцолбор газар дахь рекреацийн үйл ажиллагааг байгаль хамгаалах, нөхөн сэргээх, сургах, сурталчлах үйл ажиллагаатай зөв хослуулж зохион байгуулахын тулд хамгаалалтын бүсүүдийг ялган тогтоох шаардлагатай байдаг.

Энэхүү үндэслэлээр ГГБЦГ-ын дотоод бүсчлэлийг Байгаль орчны Сайдын 1999 оны А/159 тоот тушаалаар баталсан байна. Тус хамгаалалттай газар нутгийн 9 нэр бүхий газар нутагт 12 онцгой бүс, 11 аялал жуулчлалын бүс байх бөгөөд аялал жуулчлалын бүсийн гадуур хязгаарлалтын бүс оршино (Хүснэгт 1, График 1).

Хүснэгт 1. ГГБЦГ-ын дотоод бүсчлэл, эзлэх хувь

№	Бүсийн нэр	Тоо	Бүсийн талбай /га/	ГГБЦГ-т эзлэх хувь
	Онцгой бүс	12	233400	10.74%
	Аялал жуулчлалын бүс	11	400800	18.45%
	Хязгаарлалтын бүс		1537537	70.81%
	<b>Нийт</b>		<b>2171737</b>	<b>100%</b>



График 1. ГГБЦГ-ын бүсүүдийн эзлэх хувь

Дээрх дотоод бүсчлэлээс онцгой бүс болон аялал жуулчлалын бүсүүдийн хэмжээг газар нутгийн нэрсээр нь задлан үзвэл (Хүснэгт 2) дараах байдалтай байна.

Хүснэгт 2. ГГБЦГ-ын онцгой болон аялал жуулчлалын бүсүүдэд хамаарах газар нутгууд ба талбайн хэмжээ

№	Газрын нэр	Онцгой ба аялал жуулчлалын бүсийн нэр	Онцгой бүс /га/	Аялал жуулчлалын бүсийн талбай /га/
1	Зүүнсайхан уул	Бүст улааны онцгой бүс	2400	-
		Модот шивэрийн онцгой бүс	8600	-

		Аялал жуулчлалын бүс	-	14200
2	Дундсайхан уул	Жигмэдийн овооны онцгой бүс	2200	-
		Эрдэнэцогтын онцгой бүс		-
		Аялал жуулчлалын бүс	-	24800
3	Баруунсайхан уул	Рашааны онцгой бүс	7200	-
		Аялал жуулчлалын бүс	-	22800
4	Халтар загийн хоолой	Халтар загийн хоолойн онцгой бүс	34000	-
		Аялал жуулчлалын бүс	-	46400
5	Баянбор уул	Хүрэн ямаатын онцгой бүс	9400	-
		Аялал жуулчлалын бүс	-	13400
6	Баянцагаан уул	Хавцгайтын бүс	5600	-
		Өвгөн овооны онцгой бүс	6800	-
		Аялал жуулчлалын бүс	-	21200
7	Хонгорын гол	Базаргуучийн онцгой бүс	37600	-
		Аялал жуулчлалын бүс	-	119600
		Аялдайн амны аялал жуулчлалын бүс	-	6800
		Жаргалантын амны аялал жуулчлалын бүс	-	4000
8	Нэмэгт уул	Онцгой бүс	14400	-
		Аялал жуулчлалын бүс	-	19600
9	Зулганай, Хэрмэн цав	Зулганай, Ингэн хөөвөрийн бүс	105200	-
		Хэрмэн цав, Бурхант уулын аялал жуулчлалын бүс	-	108000
<b>Дүн</b>			<b>233400</b>	<b>400800</b>
<b>Хувь</b>			<b>10.74%</b>	<b>18.45%</b>


ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг орчны бүс гэнэ" хэмээн тодорхойлсон байна (ТХГН-ийн орчны бүсийн тухай хууль, 1997).

ТХГН-ийн орчны бүс нь тусгай хамгаалалттай газрын хилийн гадуур байгуулагдсан бүс бөгөөд нэмэлт давхарга бий болгохын тулд газар ашиглалтыг тодорхой хэмжээнд хязгаарлаж, нутгийн иргэд байгалийн баялгийг хяналттайгаар ашиглаж болох газар юм. Орчны бүсийн хөгжлийн гол зорилго нь ТХГН-ийн хамгаалалтад хувь нэмрээ оруулах явдал бөгөөд энэ нь байгалийн нөөц ашиглах дарамтыг багасгах замаар хамгаалагдсан нутгийн тогтвортой хамгаалалтаа дэмжинэ гэсэн үг юм.

ГТБЦГ-ын орчны бүсийн хилийн заагийг ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийн 5.5, 5.6 заалтуудыг үндэслэн Байгаль орчны Сайдын 2000 оны А/26 дугаар тушаалаар тогтоосон (Зураг 1). Нийт 6 сум, 12 багийн 2.171.737 га нутаг дэвсгэр



хамрагддаг бөгөөд сум бүрд Орчны бүсийн Зөвлөл, Орчны бүсийн Сан байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 1. ГГБЦГ-ын дотоод бүсчлэл

## 1.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ГГБЦГ нь “Байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлого, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон Монголын өмнөд говийн цөл, цөлөрхөг хээр, уулт хээрийн экосистемийн тэнцвэрт байдал, эртний амьтан, ургамлын үлдэц, байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт газруудын унаган төрхийг хадгалах, байгалийн нөөц баялаг, түүх, соёлын өвийг хамгаалах, танин мэдэх, тэдгээрийг зүй зохистой ашиглах, байгаль хамгаалах ажилд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж, говийн эмзэг байгальд сөрөг нөлөөгүй аялал жуулчлалыг хөгжүүлэн бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах” зорилгоор байгуулагдсан, экологи, түүх, газар зүйн хувьд онцгой ач холбогдолтой, Өмнөговь аймгийн төдийгүй манай орны үзэсгэлэнт газруудын нэг юм.

Зорин ирэх гадаад, дотоодын жуулчдын тоо жил ирэх бүр нэмэгдсээр байгаа ба цогцолборт газарт үйл ажиллагаа явуулдаг жуулчны баазаар дамжин өнгөрсөн гадаадын жуулчдын давхардсан тоон мэдээ, ТХГН-ийн хураамж төлсөн дотоодын жуулчдын тоон мэдээг үндэслэн сүүлийн 10 жилээр жуулчдын тоонд орж буй өөрчлөлтийг харуулав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Сүүлийн 10 жилд ГГБЦГ-т зочилсон жуулчдын тоо (2012-2021)

Жуулчдын төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	Нийт
----------------	------	------	------	------	------	------	------	------	------	------	------

<b>Гадаад</b>	4285	7304	10829	7949	8689	10488	17251	30557	22	-	97374
<b>Дотоод</b>	2347	2060	7181	3324	5631	9016	11271	24415	15749	8821	89815
<b>Нийт</b>	<b>6632</b>	<b>9364</b>	<b>18010</b>	<b>11273</b>	<b>14320</b>	<b>19504</b>	<b>28522</b>	<b>54972</b>	<b>15771</b>	<b>8821</b>	<b>187189</b>

Үүнийг графикаар харуулбал (График 2):




График 2. ГГБЦГ-т зочилсон жуулчдын тоон өөрчлөлт

Графикаас харвал цогцолборт газраар аялж буй гадаадын жуулчдын тоо 2012-2014 онуудад тогтмол өсөж байсан боловч 2015 онд өмнөх жилээс 37.4%-иар буурсан боловч 2016 оноос эргээд тогтвортой өссөн байна. 2019 онд жуулчдын тоо энэ арван жилд хамгийн их байсан ба өмнөх жилээс 92.7%-иар өссөн үзүүлэлттэй гарчээ. Гэвч дэлхийг хамарсан Ковид-19 цар тахлаас шалтгаалж дэлхийн аялал жуулчлалын салбар 0 зогсолт хийсэнтэй холбоотой жуулчдын тоо 2019 онтой харьцуулахад 2020 онд 71%, 2021 онд 84%-иар огцом буурсан байна.

2022 онд цар тахлын нөхцөл байдал намжиж, улс орнууд болон манай улс хил гаалиа нээн аялал жуулчлал эргэн сэргэж эхэлсэнтэй холбоотой гадаадын 7027, дотоодын 14537 жуулчин, нийт 21654 жуулчин ГГБЦГ-т хүлээн аваад байна.

Өнөөгийн байдлаар ГГБЦГ-ын нутаг дэвсгэр дээр 7 жуулчны бааз, орчны бүсэд 16 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж жуулчдыг байршуулах хэрэгслийн үйлчилгээгээр хангаж байна (Зураг 2).



Зураг 2. ГГБЦГ-т үйл ажиллагаа явуулдаг жуулчны баазууд

ГГБЦГ-т үйл ажиллагаа явуулдаг жуулчны баазууд нь нарны эрчим хүч ашиглан тог, цахилгаанаа шийддэгээс гадна бүгд өмнө нь ашиглаж байсан хөрсөнд бохирдолтой нүхэн жорлонг халж, соруулдаг боловсон нойлыг ашиглах болсон. Тэдгээрээс Говийн Өргөө жуулчны бааз өтгөнийг бордоожуулах шийдэл бүхий Финлянд технологийн 2 кабинтай гадаа ашиглах био бие засах газар байгуулан ажиллуулж байгаа нь байгаль орчинд ээлтэй шийдэл болж чадсан байна. Мөн 2 жуулчны бааз “Нүхэн жорлон угаадасны нүх техникийн шаардлага MNS 5924:2015” стандартыг хангасан агааржуулагч бүхий сайжруулсан ариун цэврийн байгууламжийг гадна орчиндоо ашиглаж байна.

Зүүнсайхан уулын Мухар шивэрт, Ёлын амуудад өмнө нь ашиглаж байсан нүхэн жорлонг халж, нийт 4 уулын аманд 6 ширхэг агааржуулагчтай сайжруулсан ариун цэврийн байгууламжийг аялагч, жуулчдад зориулан байгуулсан. Тэдгээрээс Ёлын амны авто зогсоолын орчим жуулчдын хөлд хамгийн ихээр дарагддаг тул ашиглалтын даац өндөртэй, соруулдаг боловсон ариун цэврийн байгууламжийг Ёлын амны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд аймгийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулсан байна. Түүнчлэн Хонгорын голд экологийн боловсрол олгох ажлыг Сайншанд багийн төвийг түшиглэн зохион байгуулдаг. Хонгорын голын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд мэдээллийн төв баригдсан боловч дотоод тохижилт хийгдээгүйгээс хяналтын постоор сурталчилгааны ажил хийгддэг.

ГГБЦГ-н нутаг дэвсгэрт хог хаягдал эмзэг асуудал байхаа больсон бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 08 сарын 25-ны өдрийн 3/9 тогтоолоор батлагдсан ГГБЦГ-ын хог хаягдлын менежментийг сайжруулах журмын дагуу 2022 оноос хог хаягдлын хураамж авдаг болсон нь хог хаягдлыг шийдвэрлэхэд тулгамдаж байсан асуудал болох төсвийг шийдвэрлэхэд том түлхэц болсон юм. Мөн нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл, ТББ нь хариуцан хамгаалах газрынхаа хог хаягдал, ариун цэврийн байгууламжийн ашиглалт, арчлалт, бүтээн байгуулалтын ажлын бүрэн бүтэн байдал зэргийг хариуцах болсон.

ГГБЦГ-т аялахаар ирж буй аялагч, жуулчид ихэвчлэн Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад, Бага Газрын Чулуу-Онги-Баянзаг-Даланзадгад, Богд сум-Хонгорын элс-Баяндалай-Даланзадгад гэсэн гурван чиглэлийн авто замаар ирдэг. Цогцолборт газар руу 2 үндсэн хаалгаар нэвтэрдэг бөгөөд Ёлын ам, Мухар шивэртийн амуудад аялагчдын авто машиныг байрлуулахаар тохижуулсан авто зогсоолтой. Түүнчлэн аялагчдын түр амрах цэг, отоглох цэг, төрөл бүрийн тэмдэг, тэмдэглэгээнүүдийг хамгаалалттай нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлуулсан байна (Зураг 3, 4).

Өнөөгийн байдлаар ГГБЦГ-аар аялах үндсэн 2 маршрут байна (Зураг 5). Үүнд:

**Маршрут 1:** Даланзадгад - Ёлын ам - Мухар шивэрт - Дүнгэнээгийн ам - Баян Төхөмийн нуур – Хавтрага - Сэрүүн булаг - Эрдэнэ булаг - Замын хонд - Дулаан уул – Томбон - Ганданчоймзадлин хийд - Хавцгайтын хадны зураг - Даланзадгад гэсэн нийт 516.2 км аяллын маршрут (Зураг 5)

**Маршрут 2:** Даланзадгад - Ёлын ам - Мухар шивэрт - Дүнгэнээгийн ам - Баян Төхөмийн нуур – Хавтрага - Сэрүүн булаг - Сайн шандын хийд - Нарангийн адагийн бичиг - Сэврэйн хадны зураг - Сайншандын хийд - Салхитын хадны зураг - Тэсийн нуур /Давсны үйлдвэр/ - Ухаа толгод - Зэгстийн цагаан элс - Гурван тэс – Наран даац булаг -



Хэрмэн цав - Эрэг толгой - Майхан тээгийн хоолой - Зуун мод Зулганай - Батаарын өлгий - Нэмэгтийн их хонгил - Загийн хоолой - Бор Цонж уул /Ухаа толгод/ - Хөдөө Цонж уул - Харайхын задгай - Хонгорын элс - Сэрүүн булаг - Эрдэнэ булаг - Замын хонд - Дулаан уул – Томбон - Ганданчоймзадлин хийд - Хавцгайтын хадны зураг - Даланзадгад гэсэн нийт 1173.1 км урт аяллын маршрут (Зураг 5).




Зураг 3. ГГБЦГ-ын түр амрах цэг, ухуулах самбар, бие засах газар



Зураг 4. Түр амрах цэг бүхий тохижуулсан авто зогсоолууд

Дээрх холын болон ойрын зайн аяллын маршрутуудыг зураг 5-д харуулав.

Дотоодын аялагчид өөрсдийн цаг зав, туршлага, мэдээлэл дээрээ үндэслэн дээрх маршрутуудаас өөр маршрутаар өөрсдийн дураар аялдаг бол гадаадын жуулчдын дийлэнх нь (бие даан аялагчдаас бусад) тур оператор компаниас батлан гаргасан аяллын маршрутын дагуу аялдаг байна.



Зураг 5. ГГБЦГ-ын аяллын маршрут

Энэхүү 2 төрлийн үндсэн маршрутаас гадна дараах маршрутаар аялагч, жуулчид 2-7 өдрийн аяллыг хийдэг байна (Хүснэгт 4, Зураг 6).


Хүснэгт 4. ГГБЦГ-аар аялах бусад маршрутууд

№	Маршрут	Хоног, хугацаа	Үзмэр
1	Даланзадгад – ГГБЦГ-ын Зүүн сайхан уул – Булган сум – Даланзадгад	1 шөнө, 2 өдөр	<ul style="list-style-type: none"> <li>• Ёлын ам</li> <li>• Дүнгэнээгийн ам</li> <li>• Хавцгайтын хадны зураг</li> <li>• Баян заг</li> </ul>
2	Даланзадгад – ГГБЦГ-ын Зүүн сайхан уул – Баяндалай сум – Хонгорын элс – Булган сум – Даланзадгад	2 шөнө, 3 өдөр	<ul style="list-style-type: none"> <li>• Ёлын ам</li> <li>• Дүнгэнээгийн ам</li> <li>• Хонгорын элс /Дуут манхан/</li> <li>• Хонгорын гол</li> <li>• Сэрүүнбулаг</li> <li>• Баян заг</li> </ul>
3	Даланзадгад – ГГБЦГ-ын Зүүн сайхан уул – Баяндалай сум – Хонгорын элс – Сэврэй сум – Гурван тэс сум – Хонгорын элс – Булган сум – Даланзадгад	4 шөнө, 5 өдөр	<ul style="list-style-type: none"> <li>• Ёлын ам</li> <li>• Дүнгэнээгийн ам</li> <li>• Хонгорын элс /Дуут манхан/</li> <li>• Хонгорын гол</li> <li>• Сэрүүнбулаг</li> <li>• Нэмэгтийн их хонгил</li> <li>• Нарандаац</li> <li>• Хэрмэнцав</li> <li>• Хонгорын элс</li> <li>• Баян заг</li> </ul>



4	Улаанбаатар – Цагаан суврага – Даланзадгад – Ёлын ам – Баянзаг – Онгийн нууц – Бага газрын чулуу – Улаанбаатар	5 шөнө, 6 өдөр	<ul style="list-style-type: none"> <li>• Цагаан суварга</li> <li>• Ёлын ам</li> <li>• Дүнгэнээгийн ам</li> <li>• Хавцгайтын хадны зураг</li> <li>• Баян заг</li> <li>• Онгийн хийд</li> <li>• Бага газрын чулуу</li> </ul>
5	Улаанбаатар – Цагаан суврага – Даланзадгад – Ёлын ам – Дүнгэнээгийн ам – Баяндалай – Хонгорын элс – Арц Богд уул – Өвөрхангай – Хархорин – Элсэн тасархай – Лүн - Улаанбаатар	6 шөнө, 7 өдөр	<ul style="list-style-type: none"> <li>• Цагаан суварга</li> <li>• Ёлын ам</li> <li>• Дүнгэнээгийн ам</li> <li>• Хонгорын элс /Дуут манхан/</li> <li>• Хонгорын гол</li> <li>• Сэрүүнбулаг</li> <li>• Арц Богд уул</li> <li>• Арвайхээр хот</li> <li>• Хархорин</li> <li>• Эрдэнэзуу хийд</li> <li>• Элсэн тасархай</li> </ul>

Эдгээр аяллын маршрутуудыг газрын зурагт зураглан харуулбал дараах байдалтай байна. ГГБЦГ нь Улаанбаатар хотоос 500 гаруй орчим км-ийн зайд оршдог учраас ГГБЦГ-т ирэхийн тулд 2-3 хонож ирдэг бол зарим аяллын компаниуд замдаа хонолгүйгээр өдөртөө ирдэг. Харин нэгэнт ГГБЦГ-т ирсэн жуулчид 1-4 хүртэл хоногийг тус БЦГ-т хоноглодог бөгөөд хэд хоноглох нь тухайн аялагчид Хэрмэн цав хүртэл аялах эсэхээс шалтгаалдаг байна.



Зураг 6. ГГБЦГ-аар аялах бусад маршрутууд



# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГГБЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ, ДААЦЫН СУДАЛГАА

## 2.1. ГГБЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУУРЬ НӨӨЦҮҮД

### 2.1.1. Байгаль, газарзүйн нөхцөл, нөөц

#### *Газарзүйн байрлал*

ГГБЦГ нь Монгол улсын өмнөд хэсэгт Улаанбаатар хотоос баруун урагш 627 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос баруун тийш 48 км зайд оршдог. Тус цогцолборт газар нь баруунаас зүүн тийш 404.3 км урт, өргөн нь дунджаар 50 км бөгөөд хамгийн өргөн хэсэгтээ 90.6 км, хамгийн нарийн хэсэгтээ 15 км үргэлжилсэн тусгай хамгаалалттай газар нутаг юм.

ГГБЦГ-ын нутаг дэвсгэрийн (хязгаарлалтын бүсээр) зүүн захын цэг нь х.ө 43°21'43.148", з.у 104°25'29.11"-ын солбицолд орших Үнэгт уул (д.т.д 1862.7м), баруун захын цэг нь х.ө 44°7'8.400", з.у 99°25'31.500" солбицолд Өмнөговь, Баянхонгор аймгийн зааг дээр орших Баянбулаг уул (д.т.д 1538.1м), хойд цэг нь х.ө 44°10'26.000", з.у 102°56'48"-ын солбицолд орших Халзан Хайрхан уул (д.т.д 1482м), өмнөд цэг нь х.ө 43°14'52.192", з.у 104°17'23.81"-ын солбицолд орших Хар цав уул (д.т.д 1826.7м) болно.

Байгалийн бүс, бүслүүрийн хувьд ГГБЦГ нь Монгол орны цөлийн бүс болон уулын хээрийн бүсийг хамарч оршдог бөгөөд нутгийн ихэнх хэсэг нь цөлийн бүсэд оршдог. Цогцолборт газрын баруун, баруун хойд хэсэг нь жинхэнэ цөл, баруун урд болон төв хэсэг нь хээржүү цөл, зүүн хэсэг болон Гурван сайхан уул орчмын нутаг дэвсгэр нь уулын хээрийн болон цөлжүү хээрийн дэд бүсүүдэд хамаарна.

#### *Газрын гадарга, хотгор гүдгэрийн байдал*

ГГБЦГ нь Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их муж буюу Говь Алтайн нуруу ба Говь Тянь Шанийн уулсын тогтолцоонд багтдаг. Гадарга нь өндөр уул нурууд, уудам хоолой, хотгор хослон орших тул үнэмлэхүй өндрийн хувьд зөрүү ихтэй, ерөнхий хэв шинж нь өндрийн хэмжээ, байрлалын онцлогоороо ялгаатай байдаг. Хамгийн өндөр цэг нь д.т.д 2825.6 м өндөрт өргөгдсөн Дундсайхан уулын ноён оргил Эрдэнэцогтын овоо бол хамгийн нам цэг нь д.т.д 706 м өндөртэй Ингэн хөөвөрийн хоолой юм.

Байгаль газар зүйн 3 дэд муж, 9 районд харьяалагдана. Баруун хэсэг нь Говийн их мужийн Алтайн өвөр говийн баруун хэсгийн бэлэрхэг уул, хотгор бүхий хэт гандуу цөл, өмнөд цөлийн дэд мужид, Өмнөд болон хойд, зүүн, зүүн өмнөд хэсэг нь Алтайн өвөр говийн зүүн хэсгийн бэлэрхэг уул, хотгор бүхий өмнөд цөлийн дэд мужид, Зүүн хойт хэсэг нь Говь Алтайн зүүн хэсгийн бэлэрхэг уул бүхий умард цөл, заримдаг цөлийн дэд мужид тус тус хамрагддаг.

ГГБЦГ-ын нутаг дэвсгэр дэх уулс нь элэгдэл, эвдрэлийн үйл явцад ихээр өртөж цөлжилтөд автсаны улмаас ихэнхдээ шовх хадан оргил, хяртай, эгц цавчим хажуутай, хүчтэй хэрчигдсэн, зарим газраа элгэн хадан цохио, нуранги асга чулуу ихтэй байдаг. Хормойгоосоо доош хотгорын ёроол хүртэл уудам бэлүүдийг үүсгэх ба бэлийн хурдас нь уул нуруудыг бараг өндрийн хагас хүртэл нь хучсан байдаг онцлогтой. Түүнчлэн уулс хоорондын нам хотгорууд ч тус цогцолборт газар түгээмэл тархсан байдаг. Энд Говийн

хамгийн нам цэг болох Ингэн хөөвөрийн хоолойн баруун хэсэг хамрагдахаас гадна Нэмэгтийн ар хоолой, Гурилын хоолой, Халтар загийн хоолой, Баруун, дунд, зүүн гол зэрэг хужир, марз, элсэн хуримтлал бүхий нам хотгорууд багтана.

ГГБЦГ-ын баруун хэсэгт эртний тунамал хурдасны илэрцүүд нэлээд тааралдах ба тэдгээрийн онцлог нь эртний нуур, далайн амьтдын чулуужсан яс, үлдэгдэл элбэг агуулсан байдагт оршино. Ийм газруудад Хэрмэн цав, Бүгийн цав, Гурилын хоолой, Цонжийн хотгор багтана.

### ***Геологийн тогтоц, ашигт малтмал***

Өмнөговь аймгийн газар нутгийн зарим хэсэгт 1951-1984 он хүртэл гадаад, дотоодын геологичид хайгуул судалгаа хийж 1:50000-аас 1:500000-ны масштабтай геологийн зураглал үйлдсэн байдаг. 1951-1952 онд В.С.Волконин Өмнөговь аймгийн төв, баруун хагасыг хамруулан маршрутын судалгаа хийж, 1:500000 масштабын геологийн тойм зураг зохиож, хурдас чулуулгийг анх удаа ангилжээ. 1980 онд Е.Мөнхбат, Д.Жанчив нар Дундсайхан, Баруунсайханыг хамруулан 1:500000 масштабтай геологи-гидрогеологийн зураг зохиож, ашигт малтмалын талаар ерөнхий ойлголт өгсөн бол 1982 онд Б.Дорлиг Ноён, Сэврэй сумдын нутгийг хамруулан 1:500000 масштабын геологи-гидрогеологийн зураглалын ажил хийж дээрх судалгааг үргэлжлүүлсэн байна. 1982-1984 онд Д.Тогтох нарын төв Монголд хийсэн 1:200000 масштабын зураглалын ажилд тус аймгийн баруун хойд хэсгийн багахан талбай хамарчээ.

Монгол орны өмнөд хэсэг нь хожуу палеозойн эртний эх газрын хөвөөгөөр хуримтлагдсан галт уулын нуман террейн, офиолитын иж бүрдэл, тэдгээртэй эвшил бүхий эх газар, далайн гаралтай үе давхаргаас тогтоно. Монгол орны өмнөд хэсэг дэх девоны чулуулаг нь тектоникийн харьцангуй тайван нөхцөлөөс галт уул-тектоникийн томоохон идэвхжилд шилжин нуман иж бүрдлийн систем үүссэнийг гэрчилнэ (Ламб, Бадарч, 2001). Энэхүү галт уулын нумарсан систем нь Оюу толгой, Хармагтай ба Цагаан суваргыг багтаасан Говийн порфирын бүс дэх зэс-алтны порфирын орд газруудыг агуулдаг. Девоны галавын турш энэ дүүрэгт эх газар, арлан нумын бүрэлдэхүүн хэсэг, түүнчлэн арлан нумын арын хөндийн тогтоц үүсэж бий болсон. Карбоны чулуулаг нь галт уулын идэвхижилд үргэлжлэн өртөж, девоны хурдас чулуулаг дээр илүү олон тооны эх газрын захын нум хөгжиж тогтжээ.

Пермийн цаг үеийн турш нумарсан галт уулын үйл ажиллагаа намдсан ч тектоникийн хөдөлгөөн нь идэвхтэй хэвээр үлдсэн. Девон карбоны чулуулаг дээш өргөгдөж, тэр орчмын уулс хоорондын хөндийд хурдас хуримтлагдах эх үүсвэрийг бүрдүүлж байх үед галт уулын үйл ажиллагаанд эх газрын шинж чанар илүү давамгайлж ирсэн байна.

Өмнөговь аймагт 12 төрлийн ашигт малтмалын 71 орд, 185 орчим илрэл тэмдэглэгдсэнээс 4 орд, 21 илрэл нь ГГБЦГ-т байдаг (Хүснэгт 5).

*Хүснэгт 5. ГГБЦГ-т тэмдэглэгдсэн ашигт, малтмалын орд, илрэлүүд*

№	Ашигт матмалын төрөл	ГГБЦГ-ын хэмжээнд илэрсэн	
		Орд	Илрэл
1.	Нүүрс		5

2.	Занар		1
3.	Төмөр		1
4.	Зэс		1
5.	Хар тугалга		2
6.	Алт		1
7.	Болор		1
8.	Гөлтгөнө	1	2
9.	Будгийн түүхий эд		1
10.	Барилгын чулуу	1	
11.	Давс		3
12.	Газар доорх ус	2	
13.	Ховор металл		3
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>21</b>

### ***Уур амьсгалын нөхцөл***

Байгаль цаг уурын хувьд эрс тэс, эх газрын уур амьсгалтай, дулааны улиралд халуун нь 30-38 градус, салхины хурд 5-15 м/сек, заримдаа 34-45 м/сек хүрч ширүүсдэг, 2-3 жил тутамд гангийн байдал давтагдаж цөлжилт эрчимтэй явагдаж байгаа нь сүүлийн жилүүдэд тодорхой мэдрэгдэж байдаг.

ГГБЦГ нь х.ө 43<sup>0</sup>-44<sup>0</sup>-ын дагуу орших бөгөөд энд нар жилдээ 3000 гаруй цаг гийдэг, цацрагийн тэнцэл нь 1 см<sup>2</sup>-д 3.3 ккал байдаг нь тухайн нутагт нарын эрчим хүч ашиглахад таатай нөхцөл бүрдүүлж өгдөг.

Агаарын даралт нь газар орны болон улирлын байдлаас хамааран маш их өөрчлөгддөг. Энэ нутаг нь Монгол орны хамгийн хүчтэй салхины давтамж ихтэй нутгийн нэг бөгөөд энэ нь баруун хойноос зүүн урагш чиглэсэн Алтайн их уулсын завсрын өргөн хөндийд байрласантай холбоотой. Тиймээс энэхүү нутаг дэвсгэрт салхины эрчим хүчийг ашиглах боломжтой байдгаараа мөн давуу талтай.

Жилийн дундаж агаарын температур нь +2<sup>0</sup>-оос +3<sup>0</sup> хооронд хэлбэлздэг. Жилийн хамгийн дулаан сар нь 7 сар, хамгийн хүйтэн нь 1 сар юм. Тэмдэглэгдсэн үнэмлэхүй их халуун нь +39.6<sup>0</sup>, үнэмлэхүй хүйтэн нь -42.5<sup>0</sup> хүрчээ.

Хөрсний гадаргуугийн жилийн дундаж температур нь +5<sup>0</sup> - +6<sup>0</sup> хооронд хэлбэлзэнэ. Хөрсний гадаргуу дээр хамгийн их халахдаа +64<sup>0</sup> - +65<sup>0</sup>, хөрөхдөө -42<sup>0</sup>-аас -46<sup>0</sup> хүрдэг. Хөрсний гадаргуу 11 сарын сүүлчээс бүрэн хөлдөх ба хөлдөлтийн гүн нь 1.5-2м хүрдэг.

Харьцангуй чийгшил нь жилийн дунджаар 55%-60%, хамгийн их нь өвлийн улиралд 60%-75%, хамгийн бага нь хаврын улиралд 30%-45% байна. Хур тунадасны хувьд олон жилийн дунджаар жилд 120-130 мм хур тунадас унадаг ба түүний дийлэнх буюу 58-72% нь 6-8 саруудад, 3-6% нь өвөл, үлдсэн хувь нь шилжилтийн саруудад ордог байна. Хэдийгээр олон жилийн дунджаар дээрх байдалтай боловч жил, жилийн агаарын орчил урсгалын нөхцөл байдлаас шалтгаалан заримдаа ган гачаал болох, заримдаа үер усны аюул болох явдлууд ч гардаг.

ГГБЦГ-т олон жилийн дунджаас харвал анхны цас 10 дугаар сарын сүүлчээр, сүүлийн цас 4-р сарын дундуур ордог боловч өвлийн улирлын турш тогтвортой цасан

бүрхүүлтэй байх нь ховор байдаг. Цасны зузаан нь дунджаар 4 см хүрэх боловч цас ихтэй зарим жил хунгарласан газраа 40-60 см хүрсэн тохиолдол ч байдаг.


Өмнөговь аймгийн УЦУОШАЛба нь цаг уурын 6 өртөө, ХАА-н 9 харуул, нарны цацраг судлалын 1 өртөө, Урьдчилан мэдээлэх товчоо, Холбоо зангилгаа, Зоо цаг уурын ХАА-н харуул, Усны Онги харуул, тунадасны 1 харуул, нийт 69 ажилтан, албан хаагчтайгаар ажил үйлчилгээ явуулж ирсэн.

ГТБЦГ-ын агаарын жилийн дундаж температур сүүлийн 30 жилд +1.1-ээс +1.9<sup>0</sup>C-аар дулаарч +5.4 - +6.2<sup>0</sup>C байх болсон байна. Харин үнэмлэхүй их температур +1.8-аас +4.1<sup>0</sup>C-аар дулаарсан бол үнэмлэхүй бага температур -0.1-ээс -2.3<sup>0</sup>C-аар хүйтэрсэн байна. Агаарын температурын агууриг 67<sup>0</sup>C-аас 73<sup>0</sup>C хооронд хэлбэлзэж байсан бол сүүлийн 30 жилд 70<sup>0</sup>C-аас 76<sup>0</sup>C хооронд хэлбэлзэх болжээ. Энэ нь хэдийгээр уур амьсгал дулаарч байгаа ч температурын агууриг нэмэгдэж уур амьсгалын эрс тэс шинжийг улам нэмэгдүүлж байгааг харуулж байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Агаарын температурын үзүүлэлтүүд, тэдгээрийн өөрчлөлт

Хугацаа /он/	Агаарын дундаж температур / <sup>0</sup> C/			Үнэмлэхүй их температур / <sup>0</sup> C/			Үнэмлэхүй бага температур / <sup>0</sup> C/		
	Даланзадгад	Гурвангэс	Булган	Даланзадгад	Гурвангэс	Булган	Даланзадгад	Гурвангэс	Булган
<b>1961-1983</b>	3.8	4.4	5.1	35.8	33.6	39.0	-34.2	-33.0	-34.1
<b>1991-2020</b>	5.7	5.4	6.2	39.9	36.7	40.8	-36.5	-33.0	-34.2
<b>өөрчлөлт</b>	+1.9	+1.0	+1.1	+4.1	+3.1	+1.8	-2.3	0.0	-0.1
<b>2017-2021</b>	6.1	6.1	6.9	37.6	34.7	40.8	-32.3	-28.6	-32.2

Агаарын температурын дулаарал Даланзадгад сумын нутгаар илүү эрчимтэй ажиглагдаж байгаа ба үнэмлэхүй бага температурын бууралт ч мөн илүү эрчимтэй байна (Зураг 7).



Зураг 7. Агаарын температурын өөрчлөлт, хандлага

10<sup>0</sup>C-аас дээш дулаан үеийн үргэлжлэх хугацаа сүүлийн 30 жилд 13-18 хоногоор, дулааны хэмжээ 137-437 градусаар тус тус нэмэгдсэн нь аялал жуулчлалын тохиромжтой байдлыг нэмэгдүүлж байна. Гэвч үнэмлэхүй их температур мөн нэмэгдэж байгаа нь тохиромжтой хугацааг хязгаарлах хүчин зүйл болох талтай (Хүснэгт 7)

Хүснэгт 7. Дулааны хэмжээ, түүний өөрчлөлт


Хугацаа /он/	Агаарын температур 10 <sup>0</sup> С-аас дээш хоногийн тоо			10 <sup>0</sup> С-аас дээших идэвхтэй дулааны нийлбэр		
	Даланзадгад	Гурвантэс	Булган	Даланзадгад	Гурвантэс	Булган
1961-1983	152	145	160	2618	2620	3122
2017-2021	167	163	173	3055	2916	3259
Өөрчлөлт	+15	+18	+13	+437	+296	+137

Жилд орох хур тунадасны хэмжээ Даланзадгад, Гурвантэс орчимд төдийлөн өөрчлөлт бага байсан бол Булган сумын нутгаар 40 мм-ээр нэмэгдсэн байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд орсон тунадасны хэмжээ харилцан адилгүй, ихэссэн, буурсан тодорхой зүй тогтолгүй байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар гэж ойлгож болно (Зураг 8).

Зураг 8. Хур тунадасны өөрчлөлт, хандлага



Сүүлийн 5 жилийн цаг агаарын үндсэн элементийн дундаж үзүүлэлтийг дараах зурагт харуулав (Зураг 9). Булган сумын нутаг Даланзадгад, Гурвантэс сумдаас сэрүүн, чийглэг уур амьсгалтай, хур тунадасны хуваарилагдалт бүх нутгаар харилцан адилгүй байна.



Зураг 9. Судалгааны нутгийн уур амьсгалын зураг

Салхины дундаж хурд Даланзадгад, Гурвантэс сумдын нутгаар 3-4 м/с, Булганы нутгаар 6-7 м/с байх ба хамгийн их хурд сүүлийн 5 жилийн байдлаар Даланзадгадад 26 м/с, Гурвантэсд 29 м/с, Булганд 28 м/с хүрч ажиглагджээ.

**Гадаргын болон газрын доорх усны нөөц, хангамж**

ГГБЦГ нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг бөгөөд Монголын хамгийн хуурай нутгийн нэг юм. Энд зөвхөн зун, намрын борооны үеэр түр зуурын урсгал ус үүсдэг ба зарим үед уруйн үер буудаг байна. Байнгын устай гол байхгүй. Дулааны улиралд тогтмол устай горхи үүсгэдэг Ёл (1.3км), Зулганай, Хонгор, Хавцгайт, Гэгээт зэрэг жижиг голууд, Алаг дунд булаг, Эрдэнэ булаг, Сэрүүн булаг, Хавртага зэрэг

булгууд, Зуунмод Зулганай, Харайхын задгай, Цонж шургуул зэрэг баянбүрдүүд бий. Хонгорын гол болон Зулганайн голууд нь газар доорх усны илрэлийн бүсэд орших Сэрүүн булаг, Ар гангын булгуудаас эх аван урсдаг. Түүнчлэн тус цогцолборт газрын хэмжээнд Баян Төхөм нуур, Могойтын рашаан, Ямаан усны рашаан, Нэмэгтийн рашаан, Хадатын рашаан зэрэг рашаан ус байдаг.

Хамгаалалтын захиргаанаас бүртгэлжүүлсэн нийт 200 булаг шанд, рашаан ус хамгаалалттай нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа бөгөөд тэдгээрийн 52 нь буюу 26% нь байнгын устай, үлдсэн 148 буюу 74% нь улирлын хамааралтай урсдаг байна. Түүнчлэн тэдгээр булаг шанд, рашааны 36%-ийг нутгийн иргэд унд, ахуйн хэрэглээндээ ашигладаг бөгөөд 64% нь малын бэлчээр, араатан амьтдын хэрэгцээнд ашиглагддаг (График 3, 4 )



График 3. Булаг шандын усны горим



График 4. Булаг шанд, рашаан усны ашиглалт

ГГБЦГ-ын Зүүнсайхан болон Дундсайхан уулын өндөрлөг хэсгүүдэд гадаргын усны урсац 5мм/жил, Зөөлөн, Сэврэй, Нэмэгт уулсын өндөрлөг хэсгүүд, Гурвансайхан уулын дунд хэсэгт 1мм/жил, дээрх уулсын хормой дагуу 105мм/жил байдаг нь говь нутагт гадаргын усны урсац маш бага байдгийг харуулдаг.

Гадаргын усны потенциал нөөц  $11.8 \cdot 10^6$  м<sup>3</sup>/жил, үүнээс Зүүнсайхан болон Дундсайхан уулст гадаргын ус харьцангуй их байгаа ба эдгээр уулс нь тус цогцолборт газрын 11% -ийг эзэлж, гадаргын усны нөөцийн 65.6% нь энд ногдож байна.

ГГБЦГ-т геологийн төрөл бүрийн настай хурдас чулуулагт тархсан ан цав, судал, давхарга, нүх сүвний ус ихээхэн тархсан байдаг. Усны чанар нь хуримтлалын бүсэд шорвог, тэжээгдлийн бүсэд цэнгэг байдаг байгалийн зүй тогтол илэрсэн нь ус ашиглалтын хувьд хүндрэл учруулдаг.

Газрын доорх усны нөөц 92.3 сая м<sup>3</sup>/жил бөгөөд тархалт нь жигд бус байна. Уулс хоорондын багавтар хөндий, хоолой, бэл хормой нь ГГБЦГ-ын талбайн 17.4%-ийг эзлэх боловч эдгээр хэсэгт газрын доорх усны нөөцийн 34.1% нь ногддог.

Гурвансайхан уулын дагуу гидрокарбонат, кальцийн цэнгэг ус зонхилно. Уулын хормой, бэл дагуу болон говийн бэсрэг уулст усны эрдэсжилтийн хэмжээ 1г/л хүртэл ихсэж, сульфат-гидрокарбонатын найрлагатай болдог. Уулс хоорондын хөндий, тал руу эрдэсжилт ихсэж, ус нь холимог найрлагатай болж, зарим газраа сульфат, хлорын найрлагатай ус зонхилдог. Ялангуяа Сэврэй, Гурвантэс сумдын хойд, баруун хойд талаар чанар муутай ус зонхилно.

ГГБЦГ-ын хэмжээнд нийт 698 худаг бүртгэгдсэн байгаагаас Хүрмэн суманд 7, Баяндалай суманд 143, Сэврэй суманд 364, Гурвантэс суманд 184 худаг тус тус байна.



### **Био нөөцүүд**

Говь, цөлийн далай тэнгисээс алслагдсан, байгаль, цаг уурын эрс тэс, хатуу, ширүүн байдал нь түүний өвөрмөц тогтоц бүхий газрууд, төв Азийн уугуул амьтан, ургамлын бүлгэмдэл, эртний гарал үүсэлтэй ховор, ховордсон олон зүйл амьтан, ургамлын үлдэгдэл бүхий олон нурууд, тэдгээрийг агуулсан хөндий, хотос, хоолой нь гадаад, дотоодын эрдэмтэд, байгаль судлаачид, аялагч, жуулчдын сонирхлыг зүй ёсоор татсаар ирсэн.

Энэхүү нутаг нь гадаргын хувьд өндөр уул нурууд, удам хоолой, хотгор хослон орших тул үнэмлэхүй өндрийн хувьд зөрүүтэй амьдрах орчны олон янз байдлыг үүсгэх ба эдгээр ялгаатай амьдрах орчинд ургамал, амьтны ялгаатай бүлгэмдлийг үүсгэжээ.


Нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг нь цөлийн бүсэд орших бөгөөд Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их мужид багтах ба байгаль газарзүйн 3 дэд муж, 9 районд хамаарах бөгөөд баруун хэсгээр Алтайн өвөр говийн бэлэрхэг уул, хотгор бүхий хэт гандуу цөл, өмнөд, хойд хэсгээрээ бэлэрхэг уул, хотгор бүхий өмнөд цөл, зүүн хойд хэсгээр Говь Алтайн зүүн хэсгийн бэлэрхэг уул бүхий умард цөл, заримдаг цөлд тус тус хамрагддаг.

### **I. Амьтны аймаг**

Монголын говь бол нэн эртний сөнөмөл амьтдын өлгий нутаг юм. Говийн амьтны аймгийн олонхи нь эртний гаралтай боловч түүхэн хөгжлийн явцад уур амьсгал ба ландшафтын өөрчлөлтийг даган тэдгээрийн төрөл зүйлийн бүрэлдэхүүнд бас өөрчлөлт орсоор ирсэн байна. Гуравдагч галавын сүүлчээр уул үүсэн тогтох хөдөлгөөн болж Алтайн уул сүндэрлэж эхлэхэд тус оронд хуурайшилт явагдаж, говь цөлийн амьтад зонхилон үлдсэн гэж судлаачид үздэг. Гэхдээ говийн амьтны аймаг нь ингэж бүрэлдэн тогтохын зэрэгцээ бусад газраас ирсэн зүйлийн бүрдлээр улам баяжсан.

ГГБЦГ нь амьтны газарзүйн мужлалын хувьд Алтайн өвөр говийн тойрог, Говь-Алтайн тойрог, Хойд говийн тойргуудад хамаарна (А.Г.Банников 1954, Монгол орны хөхтөн амьтны улаан данс 2006). (Зураг 10)

Энэ нутгийн ургамалжилт, ландшафт, экологийн нөхцлийн хувьд харьцангуй ялгаатай, булаг, горхи, марц, шал тойром, хөндий хоолой хотос, уул толгод, энгэр бэл, өндөр уул, хэц хад, гуу жалга, сайр садарга, элсэн цөл, дов сондуул, бударгана, шаваг, харгана, бут сөөгт цөлөрхөг хээр, цөл зэрэг элдэв экосистем нь амьтны аймгийн бүрдэл, зүйлийн олон янз хэлбэрээр харьцангуй баялаг байх таатай нөхцлийг нь бүрдүүлжээ.



1. Хөвсгөл орчмын тойрог	6. Баруун хойд Монголын тойрог
2. Хэнтийн тойрог	7. Хойд говийн тойрог
3. Баруун Хянганы тойрог	8. Говь-Алтайн тойрог
4. Монгол Дагуурын тойрог	9. Алтайн өвөр говийн тойрог
5. Хангайн тойрог	10. Баруун говийн тойрог

*Зураг 10. Монгол орны зоогеографийн мужлал (А.Г.Банников)*

ГГБЦГ-т манай орны говь цөлийн бүсийн нэгэн адил шавьжаар хооллодог амьтад, болон мэрэгчид ихээхэн тохиолдоно. Энд ялангуяа шөнийн идэвхитэй Алагдаганы овгийн мэрэгчид илүүтэй тархсан байдаг. Түүнчлэн жороо тоодог, монгол хулан жороо, цөлийн чогчиго болон зарим махчин шувууд олноор амьдардаг. Энэхүү нутаг элсэн цөл говь, уул нуруудын бүс хослох учир мөлхөгчид, хэвлээр явагчдаар баян бөгөөд шавьжийн тархац сарнимал, хоргодмол ба шөнийн амьдралтай, элсэрхэг, давсархаг орчинд дассан зүйлүүд элбэг байдгаараа онцлог. Шавьжийн тоо нийтдээ олон боловч амьдралынх нь нуугдмал хэлбэрээс болоод үл анзаарагдаж хаврын идэвхжлийн үе сул илэрнэ.

Говь нутагт чичүүл, говийн алаг даага, элсний тажигдаахай зэрэг Төв Ази, Монгол орны унаган зүйл олон байна. Одоогийн говийн амьтны аймгийн бүрэлдэхүүнд Баруун Ази болон Тураны цөлд ч хязгаарлагдмал оршдог унаган төрөл зүйлийн амьтад ч цөөнгүй байдаг билээ. Цөлөрхөг хээр, цөлийн бүсэд аагт шимт ургамал болон шавьжаар хооллодог амьтад олширч нүхэнд амьдардаг амьтад цөөрч, өвөл ичигсэдийн тоо зэргэлдээх бүс нутагтай харьцуулахад нэмэгддэг ерөнхий зүй тогтол ажиглагдана. Ургамлын үр. шавьжаар хооллож нүхэнд амьдарч өвөл ичдэг зарим зүйл алагдаага, шишүүхэй элбэг тохиолдоно. Говийн унаган зүйл болох атигдаахай элбэг байна.

Энэ нутаг нь говийн экосистемдээ онц ач холбогдолтой мэрэгчтэн, шавьж идэштэн, туулайтан зэрэг хөхтөн амьтдын төлөөлөгчидтэй, цоохор ирвэс, аргаль хонь, янгир ямаа, хулан адуу, хар сүүлтийн тархацын чухал нутаг, жороо тоодог, дэлт бүргэд зэрэг ховор зүйл шувууд тархсан байдаг учир тухайн нутгийн байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрийг аль болох өөрчлөхгүйгээр дэд бүтцийг хөгжүүлэх талаар цаашдаа анхаарч ажиллах нь чухал юм. Өнөө цагийн дэлхийн дулаарал, хуурайшилтаас үүдсэн бэлчээрийн доройтол, усны хомсдол, уул уурхайн нөхөн сэргээлт орхигдсоноос ухсан нүхнүүд, орчны бохирдол, зам харгуй дэд бүтцийн хөгжилтэй холбоотойгоор зэрлэг амьтдын амьдрах орчин тасархайтах зэрэг асуудлууд гарч буйг анхнаасаа зөв төлөвлөлт, судалгаа тооцоо, сайн менежмент дээр үндэслэн хийх хэрэгтэй юм.

Шинээр тавигдсан болон хуучин замуудын ачаалал нэмэгдэх нь хол зайд байнга нүүдэллэн шилжиж байдаг томоохон амьтад болох цагаан зээр, хар сүүлтий, хулан адууны амьдрах орчныг тасархайтуулах, нүүдэл шилжилтэнд саад болох, тасархайтсаны улмаас үлдсэн жижиг популяцуудад тэжээлийн хомсдол үүсч тоо, нөөц багассаны улмаас устах аюулд ч хүрч болзошгүй юм. Хашаалах, авто зам, суваг шуудуу татах, дамжуулах хоолой барих зэрэг шугаман бүтцийг тавьснаар зэрлэг амьтдын нүүдлэлт, шилжилт хөдөлгөөн, амьдрах чадварт ихээхэн нөлөөлдөг бөгөөд амьдрах орчны тасархайтал нь жижиг популяцийн устах эрсдэлийг нэмэгдүүлдэг нь судалгааны бүтээлүүдэд бичигдсэн байдаг. Юуны өмнө тухайн экосистем, орчны тогтолцооны өнөөгийн ерөнхий төрх төлөвийг илтгэх, үнэлэхэд зайлшгүй чухал түгээмэл тархалттай

зонхилогч зүйлүүдэд гол анхаарлаа хандуулж, зүйлийн бүрдэл олон янз хэлбэр, тохиолдоц (элбэг, ховор)-ын тухай мэдээллийг чухалчлан үзэв. Тэрчлэн Монгол болон Олон улсын хэмжээнд хууль эрхийн баримт бичгээр хамгаалалтад авсан ховор, ховордсон амьтан, шувуудын жагсаалтыг гаргасан болно.

### 1. Хөхтөн амьтад

ГГБЦГ-т тархсан хөхтөн амьтдын талаар хэвлэлийн мэдээнээс үзэхэд тус сумын нутагт шавжтан (insectivores), гар далавчтан (chiroptera), туулайтан (lagomorphs), мэрэгчтэн (Rodents), махчин (Carnivores), туруутан (Artiodactyles), туурайтан (Perissodactyls) гэх 7 багийн (Orda) 56 зүйлийн хөхтөн амьтан идээшин нутаглаж байна.

Шавжтанаас дэлдэн зараа, мэрэгчтэн багийн шар чичүүл, монгол чичүүл, морин чичүүл, элссэг зузга, бор шишүүхэй, хадны барагчин, шар үнэг, саарал чоно, говийн алагдаага, савгадаахай, гувруу тажигдаахай, тавруу тажигдаахай, соотон алагдаага, махчдаас саарал чоно, шар үнэг, хотны үен, туулайтнаас боролзон туулай тархан нутагладаг тухай А.Г.Банников (1954), Д.Авирмэд (1973), С.Дуламцэрэн (1970), В.Е.Соколов, В.Н. Орлов (1980), С.Дуламцэрэн, Д.Цэнджав (1988), Цэвэгмид, Цэнджав (1989,2004) нар тэмдэглэсэн байна.

ГГБЦГ-т тохиолдож байгаа зэрлэг хөхтөн амьтны зүйлийн бүрдлийн 50 орчим хувийг мэрэгчтэн эзэлж тус газарт зонхилогч амьтан болж чаддаг. Чичүүл, алагдаага, савгадаахай, огдойн төрлийнхөн илүү зонхилно.

Тухайн газар тархсан хөхтөн амьтдыг амьдралын хэлбэрээр түгээмэл эсэх, ичдэг эсэх, агнуурын эсэх, хамгааллын статусаар улаан номд орсон эсэх, нэн ховор амьтны жагсаалтад орсон эсэх, олон улсын конвенцын хавсралтад орсон эсэх талаар зүйл бүрээр ангилж жагсаав (Хүснэгт 8).

Хүснэгт 8. ГГБЦГ-ийн Хөхтөн амьтны зүйлийн бүрдэл

№	Зүйлийн нэр	Амьдралын хэлбэр				Статус		
		Түгээмэл	Ичдэг	Ан агнуур	Монгол улсын улаан ном	Нэн ховор	CITES	CMS
<i>1. Шавж идэштэн</i>								
1	Дэлдэн зараа	+	+					
2	Сибир малтаахай	+						
<i>2. Гар далавчтан</i>								
3	Бор турсаахай	+	+					
4	Говийн сармаахай	+	+					
5	Хожуу сармаахай	+	+					
6	Сахалт багваахай	+	+					
7	Саарал соотон багваахай	+	+					
<i>3. Туулай хэлбэртэн</i>								
8	Бор туулай	+						
9	Дагуур огдой	+						
10	Монгол огдой	+						
<i>4. Мэрэгчтэн</i>								
11	Бозлог зурам	+	+		+			
12	Гозоорой зурам	+	+		+	+		

13	Хэргэлзий оготно	+	+					
14	Хадны барагчин	+	+					
15	Түвд ов	+	+					
16	Сохдой оготно	+	+					
17	Цомч шишүүхэй	+	+					
18	Бор шишүүхэй	+	+					
19	Соколовын шишүүхэй	+	+					
20	Орог зусаг	+	+					
21	Элсний зусаг	+	+					
22	Монгол чичүүл	+						
23	Шар чичүүл	+						
24	Морин чичүүл	+						
25	Гэрийн хулгана	+	+					
26	Өмнөговийн алагдаага	+	+					
27	Говийн алагдаага	+	+					
28	Сибирь алагдаага	+	+					
29	Таванхуруут алагдаага	+	+					
30	Савагдаахай	+	+					
31	Соотон алагдаага	+	+		+			
32	Зэгэл алагдааганцар	+	+					
33	Өөхөн сүүлт атиглаахай	+	+					
34	Козловын алагдаага	+	+		+			
35	Монгол даахай	+	+					
<b>5. Махчид</b>								
36	Хярс үнэг	+		+				
37	Шар үнэг	+		+				
38	Саарал чоно	+		+				
39	Мазаалай баавгай				+	+	I	
40	Эрээн хүрнэ	+			+			
41	Өмхий хүрнэ	+						
42	Хотны үен	+						
43	Цагаан үен	+						
44	Хадны суусар			+				
45	Шилүүс мий			+	+	+	II	
46	Мануул мий			+				
47	Цоохондой мий			+	+			
48	Цоохор ирвэс			+	+	+	+	+
<b>6. Туурайтан</b>								
50	Хулан адуу			+	+		I	II
<b>7. Туруутан</b>								
51	Хар сүүлтий			+	+			
52	Цагаан зээр			+				
53	Янгир ямаа			+	+			
54	Аргаль хонь			+	+		II	
55	Халин буга			+				
<b>8. Тавхайтан</b>								
56	Хавтгай тэмээ				+	+	I	

## **2. Шүвүү**

ГТБЦГ-ийн нутаг орчим нь байгалийн бүс бүлүүрийн хувьд цөлөрхөг хээр, цөл, өндөр уул, гуу жалга, хотос хоолой, гадаргын тогтоол ус, шалыг дагаж нүүдлийн болон

суурин шувуудаас зүйлийн олон янз байдал бүрдэнэ. Тус бүс нутагт тархсан шувуудын зүйлийн бүрдлийг гаргахдаа хэвлэлийн эх сурвалж шигласан бөгөөд нийт 106 зүйлийн шувуу тэмдэглэгджээ.

Өмнөх судлаачдын (Фомин, Болд, 1991) бүтээлд Говь Гурвансайхан, түүнээс урагш орших уулс, Алтайн өмнөх говьд манай оронд байдаг шувуудын 14,2 хувь буюу 60 зүйл шувуу тэмдэглэгдсэн байдаг бол ГГБЦГ-т 29 овгийн 100 зүйл жигүүртэн шувууд тэмдэглэгдсэн байна. Говийн Бага ДЦГ орчимд хийсэн судалгаанд (Пүрэвсүрэн 2013) 200 гаруй зүйл шувууг бүртгэсэн байна.

Шувуудын IUCN-ийн олон улсын шалгуураар үнэлсэн дүнгээс дүнгээс үзэхэд олон улсын хэмжээнд нийт зүйлийн 100 буюу 94.3% нь “Анхааралд өртөхөөргүй” зэрэглэлд багтжээ. Ховордлын зэргээр “Эмзэг” 4 зүйл, “Ховордож болзошгүй” 2 зүйл шувуу тус тус бүртгэгджээ. Бүс нутгийн үнэлгээгээр нийт зүйлийн 100 буюу 94.3% нь “Анхааралд өртөхөөргүй”, “Эмзэг” 4 зүйл, “Мэдээлэл дутмаг” 1 зүйл шувуу тус тус бүртгэгджээ (Хүснэгт 9).

Дээрх ховордлын зэргээр тодорхойлсон шувуудын хамгаалагдсан байдлыг Монгол улс болон олон улсын конвенцод орсноор авч үзвэл “Монгол улсын улаан ном” -нд 6 зүйл, CITES-ийн конвенцын I хавсралтад орсон 3 зүйл, II хавсралтад 16 зүйл, CMS-ийн хавсралтад I хавсралтад 2 зүйл тус тус бүртгэгджээ. Энэхүү хүснэгтийг сайжруулан зүйлийн бүрдлийг нэмж тодорхойлох шаардлагатай.

Хүснэгт 9. ГГБЦГ-ын шувуудын зүйлийн бүрдэл

№	Латин нэр	Монгол нэр	Амьтны тухай хууль, нэн ховор	Засгийн газрын 2001 оны 264-н тогтоол	Олон улсын үнэлгээ	Бүс нутгийн үнэлгээ	МУ-н улаан ном	CITES I,II хавсралт	CMS I,II хавсралт	Тухайн бүс нутагт бүртгэгдсэн	Судалгааны явцад бүртгэгдсэн
1	<i>Ardea cinerea</i>	Хөх дэглий			АӨ	АӨ				+	+
2	<i>Anser anser</i>	Бор галуу			АӨ	АӨ				+	-
3	<i>Cygnus Cygnus</i>	Гангар хун			АӨ	АӨ	+			+	-
4	<i>Tadorna ferruginea</i>	Хондон ангир			АӨ	АӨ				+	+
5	<i>Tadorna tadorna</i>	Анхитал ангир		+	АӨ	АӨ	+			+	+
6	<i>Anas platyrhynchos</i>	Зэрлэг нугас			АӨ	АӨ				+	-
7	<i>Anas strepera</i>	Бор нугас			АӨ	АӨ				+	+
8	<i>Anas acuta</i>	Шовтгор алаг нугас			АӨ	АӨ				+	-
9	<i>Aythya ferina</i>	Улаан хүзүүт шумбуур			АӨ	АӨ				+	-
10	<i>Aythya fuligula</i>	Гэээгт шумбуур			АӨ	АӨ				+	-
11	<i>Bucephala clangula</i>	Алаг шунгаач			АӨ	АӨ				+	-
12	<i>Milvus migrans</i>	Сохор элээ			АӨ	АӨ		II		+	+
13	<i>Circus cyaneus</i>	Цагаан элэгт			АӨ	АӨ				+	-
14	<i>Accipiter nisus</i>	Морин харцгай			АӨ	АӨ		II		+	-
15	<i>Buteo rufinus</i>	Талын сар			АӨ	АӨ		II		+	-

16	<i>Buteo hemilasius</i>	Шилийн сар			АӨ	АӨ		II		+	+
17	<i>Aquila nipalensis</i>	Тарважи бүргэд			АӨ	АӨ		II		+	+
18	<i>Aquila chrysaetos</i>	Цармын бүргэд			АӨ	АӨ		II		+	-
19	<i>Gypaetus barbatus</i>	Ёл			АӨ	Э	+	I		+	-
20	<i>Aegypius monachus</i>	Нөмрөг тас			ХБ	АӨ		II		+	+
21	<i>Gyps himalayensis</i>	Гималайн хажир			АӨ	АӨ	+	I		+	-
22	<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор			Э	Э		II		+	-
23	<i>Falco peregrinus</i>	Эгэл шонхор			АӨ	М Д		I		+	-
24	<i>Falco naumanni</i>	Зээрд шонхор			Э	АӨ		II		+	+
25	<i>Falco tinnunculus</i>	Начин шонхор		+	АӨ	АӨ		II		+	+
26	<i>Alectoris chukar</i>	Хахилаг			ХБ	АӨ		II		+	-
27	<i>Anthropoides virgo</i>	Өвөгт тогоруу			АӨ	АӨ		II		+	-
28	<i>Fulica atra</i>	Халзан түнжүүр			АӨ	АӨ				+	-
29	<i>Otis tarda</i>	Тоодог		+	Э	Э	+	II	I	+	-
30	<i>Chlamydotis undulata</i>	Жороо тоодог		+	Э	Э	+	II	I	+	-
31	<i>Charadrius dubius</i>	Нарийн хиазат			АӨ	АӨ				+	+
32	<i>Charadrius veredus</i>	Дорнодын хиазат			АӨ	АӨ				+	-
33	<i>Vanellus vanellus</i>	Хавтгаалж			АӨ	АӨ				+	-
34	<i>Tringa ochropus</i>	Сүүл цагаан хөгчүү			АӨ	АӨ				+	-
35	<i>Tringa totanus</i>	Улаан хөлт хөгчүү			АӨ	АӨ				+	-
36	<i>Actitis hypoleucos</i>	Хайргын хөгчүү			АӨ	АӨ				+	-
37	<i>Calidris ruficollis</i>	Шар түрүүт элсэг			АӨ	АӨ				+	-
38	<i>Calidris ferruginea</i>	Хадуур элсэг			АӨ	АӨ				+	-
39	<i>Gallinago stenura</i>	Замбын хараалж			АӨ	АӨ				+	-
40	<i>Limosa limosa</i>	Морин цууцаль			ХБ	АӨ				+	+
41	<i>Larus ridibundus</i>	Хүрэн толгойт цахлай			АӨ	АӨ				+	-
42	<i>Larus argentatus</i>	Мөнгөлөг цахлай			АӨ	АӨ				+	-
43	<i>Sterna hirundo</i>	Хараалай			АӨ	АӨ				+	-
44	<i>Syrhaptus paradoxus</i>	Ногтруу			АӨ	АӨ				+	+
45	<i>Columba rupestris</i>	Хадны тагтаа			АӨ	АӨ				+	+
46	<i>Streptopelia orientalis</i>	Дорнын хүүрзгэнэ			АӨ	АӨ				+	-
47	<i>Cuculus canorus</i>	Эгэл хөхөө			АӨ	АӨ				+	-
48	<i>Bubo bubo</i>	Эгэл шар шувуу			АӨ	АӨ		II		+	-
49	<i>Athene noctua</i>	Хотны бүгээхэй			АӨ	АӨ		II		+	+
50	<i>Caprimulgus europaeus</i>	Эргүү бор			АӨ	АӨ				+	-
51	<i>Apus apus</i>	Хурын ураацай			АӨ	АӨ				+	+
52	<i>Apus pacificus</i>	Морин ураацай			АӨ	АӨ				+	+
53	<i>Upupa epops</i>	Бөвөөлжиг өвөөлж			АӨ	АӨ				+	-
54	<i>Galerida cristata</i>	Согсоот болжмор			АӨ	АӨ				+	-
55	<i>Eremophila alpestris</i>	Шороон алаг болжмор			АӨ	АӨ				+	+
56	<i>Alauda arvensis</i>	Боролзой болжмор			АӨ	АӨ				+	-



57	<i>Anthus richardi</i>	Хээрийн шийхнүүхэй			АӨ	АӨ				+	+
58	<i>Anthus godlewskii</i>	Годлевскийн шийхнүүхэй			АӨ	АӨ				+	-
59	<i>Anthus campestris</i>	Талын шийхнүүхэй			АӨ	АӨ				+	-
60	<i>Motacilla citreola</i>	Шар түрүүт цэгцгий			АӨ	АӨ				+	+
61	<i>Motacilla alba</i>	Хөх цэгцгий			АӨ	АӨ				+	+
62	<i>Lanius isabellinus</i>	Улбар сүүлт дунхай			АӨ	АӨ				+	-
63	<i>Lanius excubitor</i>	Үнсэн дунхай			АӨ	АӨ				+	-
64	<i>Sturnus cineraceus Temm.</i>	Бор тодол			АӨ	АӨ				+	-
65	<i>Pica pica</i>	Шаазгай			АӨ	АӨ				+	+
66	<i>Pyrhocorax pyrrhocorax</i>	Улаанхошуут жунгаа			АӨ	АӨ				+	+
67	<i>Corvus dauuricus</i>	Алагтуу хэрээ			АӨ	АӨ				+	-
68	<i>Corvus corone</i>	Хар хэрээ			АӨ	АӨ				+	+
69	<i>Corvus corax</i>	Хон хэрээ			АӨ	АӨ				+	+
70	<i>Podoces hendersoni</i>	Хулан жороо			ХБ	АӨ		II		+	-
71	<i>Prunella fulvescens</i>	Шарга хайруулдай			АӨ	АӨ				+	-
72	<i>Prunella montanella</i>	Сибирийн хайруулдай			АӨ	АӨ				+	-
73	<i>Sylvia curruca</i>	Тарчигнаа зэржигэнэ			АӨ	АӨ				+	-
74	<i>Sylvia nana</i>	Цөлийн зэржигэнэ			АӨ	АӨ				+	-
75	<i>Phylloscopus borealis</i>	Урианхайн дууч шувуу			АӨ	АӨ				+	-
76	<i>Phylloscopus inornatus</i>	Ногоовор дууч шувуу			АӨ	АӨ				+	-
77	<i>Phylloscopus proregulus</i>	Борлог дууч шувуу			АӨ	АӨ				+	-
78	<i>Ficedula parva</i>	Хурган намнаахай			АӨ	АӨ				+	+
79	<i>Oenanthe oenanthe</i>	Адууч чогчоохой			АӨ	АӨ				+	+
80	<i>Oenanthe pleschanka</i>	Мяраан чогчоохой			АӨ	АӨ				+	-
81	<i>Oenanthe isabellina</i>	Бүжимч чогчоохой			АӨ	АӨ				+	+
82	<i>Oenanthe deserti</i>	Цөлийн чогчоохой			АӨ	АӨ				+	-
83	<i>Monticola saxatilis</i>	Цохионы хөөндэй			АӨ	АӨ				+	-
84	<i>Phoenicurus phoenicurus</i>	Гал сүүлт			АӨ	АӨ				+	-
85	<i>Phoenicurus aureus</i>	Хөх зарлагат гал сүүлт			АӨ	АӨ				+	-
86	<i>Tarsiger cyanurus</i>	Хөх зоот			АӨ	АӨ				+	-
87	<i>Turdus pilaris</i>	Дуулгат хөөндэй			АӨ	АӨ				+	-

88	<i>Parus montanus</i>	Хүрэнтолгойт хөхбүх			АӨ	АӨ				+	-
89	<i>Tichodroma muraria</i>	Хэрмийн бялзуухай			АӨ	АӨ				+	-
90	<i>Passer domesticus</i>	Оронгийн бор шувуу			АӨ	АӨ				+	+
91	<i>Passer ammodendri</i>	Загийн бор шувуу			АӨ	АӨ				+	-
92	<i>Passer montanus</i>	Хээрийн бор шувуу			АӨ	АӨ				+	+
93	<i>Petronia petronia</i>	Хадны бор шувуу			АӨ	АӨ				+	+
94	<i>Montifringilla nivalis</i>	Цасны бор шувуу			АӨ	АӨ				+	-
95	<i>Pyrgilauda davidiana</i>	Монгол бор шувуу			АӨ	АӨ				+	+
96	<i>Acanthis flavirostris</i>	Улаан толгойт бужирга			АӨ	АӨ				+	-
97	<i>Bucanetes mongolicus</i>	Монгол алтан түнжүүр			АӨ	АӨ				+	-
98	<i>Carpodacus erythrinus</i>	Улаавар шувуу			АӨ	АӨ				+	-
99	<i>Coccothraustes</i>	Хөхөлт хөх болжмор			АӨ	АӨ				+	-
100	<i>Emberiza cia</i>	Цагаан хөмсөгт хөмрөг			АӨ	АӨ				+	-
101	<i>Emberiza godlewskii</i>	Годлевскийн хөмрөг			АӨ	АӨ				+	-
102	<i>Emberiza pallasi</i>	Цагаан хэвэлт хөмрөг			АӨ	АӨ				+	-
103	<i>Emberiza rustica</i>	Цагаан хөмсөгт хөмрөг			АӨ	АӨ				+	+
104	<i>Emberiza pusilla</i>	Борлог хөмрөг			АӨ	АӨ				+	-
105	<i>Emberiza hortulana</i>	Алаг хөмрөг			АӨ	АӨ				+	-
106	<i>Plectrophenax nivalis</i>	Цасч хөмрөг			АӨ	АӨ				+	-
Нийт										106	32

### 3. Мөлхөгчид (Reptila)

Монгол орны говь, цөл, цөлөрхөг хээрт 2 салбар багийн, 7 овгийн, 14 төрөлд хамаарах 22 зүйл мөлхөгчид буюу могой, гүрвэл тархан амьдардаг. ГГБЦГ-ийн мөлхөгчдийн зүйлийн бүрдлийг гаргахдаа өмнө нь судлагдсан судалгааны ажил, хэвлэл мэдээлэл ном зохиолыг ашигласан. Судлаач Х.Мөнхбаяр, Х.Тэрбиш нарын гаргасан хоёр нутагтан ба мөлхөгчдийн тархалтын зургийг үзэхэд тус цогцолборт газарт 14 зүйлийн мөлхөгчид тэмдэглэгдсэн болон байж болзошгүй гэсэн бүртгэл гарсан.

Энэ нутаг нь монгол орны аль ч нутгаас хамгийн олон мөлхөгчидтэй, зүйл тус бүрийн тоо харьцангуй элбэг байдгаараа онцлог юм. Төв Ази, Монголын амьтны аймгаас гаралтай мөлхөгчдийн 57% нь ГГБЦГ-т амьдардаг тул тус цогцолборт газар нь төв Азийн мөлхөгч амьтныг хамгаалахад чухал ач холбогдолтой нутаг юм.

Энд хонин гүрвэл, могой гүрвэл, монгол гүрвэл зэрэг байгалийн янз бүрийн нөхцөлд тааралддаг нэлээд өргөн зохилдлоготой, Монгол оронд түгээмэл тааралддаг зүйл ч байдаг. Бас нохой гүрвэл, тэмээн сүүл могой, нарийн могой зэрэг алаг цоог тархацтай, явцуу зохилдлоготой ховор зүйлүүд ч бий. Эдгээр ховор зүйлийг Монгол улсын Улаан номд (1987, 1997) оруулжээ. Дээрх зүйлүүдээс гадна Төв Ази буюу Монголын унаган зүйлд тооцогддог нүцгэн хуруут гүрвэл (*Gymnodactylus elondatus*), замба гүрвэл (*Agama stoliczkanana*), говийн гүрвэл (*Eremias przewalski*), нарийн могой (*Coluber spinalis*) зэрэг зүйлүүд амьдардаг. Мөлхөгчид нь махан идэшт шувуу, хөхтний хоол тэжээлд оролцож, өөрсдөө шавж, түүний авгалдайгаар идэшлэн говийн экосистемийн чухал бүрдэл болдог (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Мөлхөгчдийн зүйлийн бүрдэл

№	Шинжлэх ухааны болон Монгол нэр	Тэрбиш ба Мөнхбаяр нарын тэмдгэлсэн байдал	Зүйлийн баялаг
<i>1. Гүрвэлийн салбар баг</i>			
1	<i>Alsophylax pipiens</i> Pall. –Төмөр гүрвэл	+	баян
2	<i>Teratoscincus przewalskii</i> Strauch– Нохой гүрвэл	+	баян
3	<i>Cyrtopodion elongatus</i> -Говийн махир хуруут гүрвэл	+	ховор
4	<i>Laudakia stoliczkanana</i> Blanford- Замба гүрвэл	+	ховор
5	<i>Phrynocephalus versicolor</i> Strauch –Цоохор хонин гүрвэл	+	баян
6	<i>Eremias przewalskii</i> Strauch– Говийн гүрвэл	+	баян
7	<i>Eremias multiocellata</i> Gunth.–Могой гүрвэл	+	баян
8	<i>Eremias argus</i> Peters – Монгол гүрвэл	+	баян
9	<i>Eremias vermiculata</i> Blanf. –Загалт гүрвэл	+	баян
<i>2. Могойн салбар баг</i>			
10	<i>Eryx tataricus</i> Licht.– Тэмээн сүүл могой	+	ховор
11	<i>Coluber spinalis</i> Peters–Нарийн могой	+	ховор
12	<i>Elaphe dione</i> Pall.–Рашааны могой	+	баян
13	<i>Psammophis lineolatus</i> Brandt–Сум могой	+	ховор
14	<i>Aqkistrodon halys</i> Pall -Бамбай хоншоорт могой	+	баян


Судалгааны явцад Цоохор хонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*), Могой гүрвэл (*Eremias multiocellata*), Бамбай хоншоорт могой (*Aqkistrodon halys*) тааралдав.

#### 4. Шавж

ГГБЦГ-т шавжийн судалгаа хангалттай хийгдээгүй байгаа бөгөөд тодорхой тооны хайрсан далавчтан *Lepidoptera*, шулуун далавчтан *Orthoptera*, хатуу далавчтан *Coleoptera* нь энэ нутгийн шавжийн бүлгэмдлийг бий болгодгийг тогтоожээ. Энд сээр нуруугүйтэн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хувьд хамгийн баян нутгийн нэг юм. Энэ нутагт сээр нуруугүйтний судалгааг 1971 оноос эхлэн хийж эхэлсэн. ГГБЦГ-ын ойролцоох нутаг манай орны заримдаг цөл, урагш даваад жинхэнэ цөлд орно. Уулын оройгоос (2300-2500 м) хоолой хүртэл хөрс, амьтан, ургамлын хэд хэдэн бүслүүр тааралдана. Энд 5 ангийн 40-өөд овгийн 340 гаруй зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдээд байна.

## II. Ургамлын аймаг

1989 онд Академич Н.Өлзийхутаг Монгол орны ургамалжлыг ургамал газар зүйн 16 тойрог болгон ангилсан байдаг (Зураг 11).



*Зураг 11. Монгол орны ургамал газарзүйн тойрог*

Энэхүү хуваарилалтын дагуу Говь Гурвансайханы БЦГ нь ургамалжил ургамал газар зүйн 3 тойрогт хамаарагдаж байна. Үүнд:

- 1) Говь Алтайн уулын цөлөрхөг хээрийн тойрог
- 2) Алтайн өвөр говийн цөлийн тойрог
- 3) Алашаа говийн цөлийн тойрог багтдаг.

Энэхүү тойргоос гадна газарзүй, уур амьсгалаар ялгаатай Зүүнсайхан, Дундсайхан, Баруунсайхан, Баянцагаан, Зөөлөн, Сэврэй, Нэмэгт, Алтан уул, тэдгээрийн хоорондох хотос, хоолойн өөр өөрийн өвөрмөц онцлог бүхий ургамлын аймгийг бүрдүүлдэг.

2016 оны Өмнөговь аймгийн ургамалжилтын судалгаагаар 60 овог, 261 төрөл, 614 зүйл ургамал бүртгэгдсэн бол ГГЦБГ-ын нутагт одоогоор 48 овгийн 164 төрөлд хамаарах 350 гаруй зүйл гуурст ургамал бүртгэгдсэн байна.

Өмнөговь аймгийн нутагт бүртгэгдсэн бүх зүйл ургамлаас 43 овгийн 184 төрлийн 403 зүйл бэлчээрийн (65.6%), 38 овгийн 110 төрлийн 160 зүйл эмийн ашигт (26.1%), 25 овгийн 55 төрлийн 61 зүйл (9.9%), Монголд байгаа завсрын унаган, 17 овог 27 төрөл, 41 зүйл Монголын унаган ургамал (9.9%), 24 овог, 35 төрөл, 42 зүйл ховор ургамал (6.8%), 16 овог, 28 төрөл, 31 зүйл(5.0%), 9 овог, 11 төрөл, 12 зүйл үлдэц ургамал бүртгэгдсэн байна.

Бүртгэгдсэн ховор, устаж болзошгүй, унаган ба завсрын унаган ургамлууд нь ихэвчлэн бүлгэмдэл үүсгэхэд оролцож байгаа нь цаашид эдгээр ургамлын нөөц хомсдож устаж болох бүрэн боломжтойг харуулж байна. Монголын хамгийн их унаган ургамалтай тойрог нь Говь алтайн нурууны цөлөрхөг хээрийн тойрог бөгөөд Зүүнсайхан, Баруунсайхан, Дундсайхан, Зөөлөн, Баянцагаан, Сэврэй, Нэмэгт, Эхэн зулганай, Наран даац, Хонгорын элс зэрэг байгалийн өвөрмөц тогтоцтой нутгууд хамрагддаг. Говь Алтайн нурууны цөлөрхөг хээрийн тойргийн Гурвансайхан уулын системд хамрагдах нутгууд нь жинхэнэ говийн төлөөлөгчдөөс бүрдэх боловч уулын гүн

хавцал дундаа мөстлөгийн үеийн гаралтай Байгаль-Дагуурын элементүүдээр нэлээд баялаг.

ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт бүртгэгдэж тэмдэглэгдсэн нь нийт ургамлын 21,7 хувь буюу 46 зүйл нь унаган ба ховор ургамал бөгөөд энэ орчинд хүн, амьтны нөлөө их байгаа нь цаашид эдгээр ховор ургамлуудыг онцгой хамгаалах менежментийн арга хэмжээг тасралтгүй явуулах шаардлагатай.

**Нэн ховор ургамал** Өмнөговь аймгийн нутагт Хонин арц (*Juniperus sabina* L.), Шивлээхэй зээргэнэ (*Ephedra equisetina* Bge.), Элдэв навчит улиас (*Populus diversifolia* Schrenk.), Ганц судалт гишүүнэ (*Rheum uninerve* Maxim.), Регелийн будараа (*Iljinia Regelii* (Bge.) Korov.), Пржевальскийн чармай (*Gymnocarpus Przewalskii* Bge. ex Maxim.), Ягаан мүгээ (*Rhodiola rosea* L.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Элдэв навчит улиас Монгол мөнххаргана (*Ammopiptanthus mongolicus* (Maxim. ex Kom.) Cheng.), Говийн харгана (*Caragana gobica* Sancz.) L.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Pojark.), Монгол буурцгана (*Chesneya mongolica* Maxim.), Ганц навчит сальжир (*Gueldenstaedtia monophylla* Fisch.), Грубовын ортууз (*Oxytropis Grubovii* Ulzj.), Сөөгөн шимэрс (*Hedysarium fruticosum* Pall.), Эгэл үмхий өвс (*Peganum harmala* L.), Потанины хотир (*Zygophyllum Potaninii* Maxim.), Алтан бэрмэг (*Limonium aureum* (L.) Hill ex Ktze.), Сибирь тэмээн хөх (*Vincetoxicum sibiricum* (L.) Desne.), Толболт ба шар бэрээмэг (*Arnebia guttata* Bge.), Шарилж навчит хувиланги (*Pedicularis abrotanifolia* M.B. ex Stev.), Потанины улаан тулам (*Incarvilla Potaninii* Batal.), Цөлийн аргамжин цэцэг (*Cistanche deserticola* Ma.), Сайханы бамбай (*Valeriana saichanensis* Kom.), Төв Азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Novopokr.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Iljin.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Шар шарилж (*Artemisia xanthochroa* Krasch.), Монгол чоногоно (*Jurinea mongolica* Maxim.), Цагаан навчит хасзул (*Olgaea leucophylla* (Turch.) Iljin) нийт 16 овог, 28 төрөл, 31 зүйл нэн ховор ургамал бүртгэгдсэн.

Судалгаанаас харахад ган, хэт хуурайшил, уулын үер, цөлжилт, салхи зэрэг байгаль цаг уурын нөлөөнөөс болж байгалийн жамаар нөхөн сэргэж ургах чадваргүй болох болон эмнэлэг, хүнс, түлш, малын бэлчээр, уул уурхайн үйлдвэрлэл зэрэг хүний хэрэглээний хүчин зүйлээс болж тархац нөөц хомсдон жилээс жилд улам ховордсоор улмаар устаж үгүй болох аюулд хүрэх магадлалтай юм.

**Ховор ургамал** Өмнөговь аймгийн нутагт Нангиад зээргэнэ (*Ephedra sinica* Stap.), Хөх ногоон хоног будаа (*Setaria glauca* (L.) P.B.), Согтоонги дэрс (*Achnatherum inebrians* (Hance) Keng.), Эгэл нишингэ (*Phragmites communis* Trin.), Богданы арвай (*Hordeum Bogdanii* Wilensky.), Анхил сонгино (*Allium odorum* L.), Алтайн сонгино (*Allium altaicum* Pall.), Сарвуун сонгино (*Allium anisopodium* Ldb.), Потаниний цахилдаг (*Iris Potaninii* Maxim.), Хуурамч хорон хурган (*Rumex pseudonatronatus* Borb.), Говийн азар (*Calligonum gobicum* Bge. ex Meisn.), Шивүүрт цулихир (*Agriophyllum pungens* (Vahl) Link ex A. Dietr.), Ацан ажигана (*Stellaria dichotoma* L.), Монгол шээрэнгэ (*Silene mongolica* Maxim.), Сайханы намуу (*Papaver saichanense* Grub.), Том үрт тольт өвс (*Galitzkya macrocarpa* (Ik.-Gal.) V. Bocz.), Үлдэн могойн идээ (*Sedum aizoon* L.), Өргөст тошлой (*Grossularia acicularis* (Smith) Spach.), Монгол бүйлээс (*Amygdalus mongolica* Maxim.), Үнэгэн сүүлхэй лидэр (*Sophora alopecuroides* L.), Монгол тарваган шийр (*Thermopsis mongolica* Czefr.), Цагаан хошоон (*Melilotus albus* Medic.), Монгол хунчир



(*Astragalus mongolicus* Bge.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), Семеновын гиш (*Vicia Semenovii* (Rgl.et Herd.) B.Fedtsch.), Говийн хотир (*Zygophyllum gobicum* Maxim.), Шовх хотир (*Zygophyllum mucronatum* Maxim.), Арзгар сухай (*Tamarix hispida* Willd.), Зүүнгарын гоёо (*Cynomorium songaricum* Rupr.), Сахлай дэгд (*Gentiana barbata* Froel.), Юлдэн тэмээн хөх (*Vincetoxicum lanceolatum* (Grub.) Grub.), Чөдөр зэллэг сэдэргэнэ (*Calystegia hederacea* Wall.), Потанины махирс (*Lyium Potaninii* Rojark.), Феддийн аргамжин цэцэг (*Cistanche feddeana* Нав.), Нэлэмгэр сунараа (*Asperula humifusa* (M.B.) Bess.), Хадны сунараа (*Asperula saxicola* Grub. Sp. Nova), Алтайн далан хальс (*Lonicera altaica* Pall.), Навчирхаг лавай (*Asterothamnus poliifolius* Новорокр.), Хар шарилж (*Artemisia santolinifolia* Turcz. ex Bess.), Шаргал шарилж (*Artemisia rutifolia* Steph. ex Spreng.) зэрэг нийт 24 овог, 35 төрөл, 41 зүйл ургамал бүртгэгджээ.

**Унаган ба үлдэц ургамал** Монгол орны ургамлын аймгийг бүрдүүлэгч цоргот дээд ургамал 2014 оны бүртгэл бичигт бүртгэгдсэнээр 112 овгийн 683 төрлийн 3127 зүйл, үүний дотор Монгол орноос өөр нутагт ургадаггүй Монголын унаган ургамал 150 гаруй зүйл, хөрш зэргэлдээ хэл залгаа оронд ургадаг боловч тархцын зах сэжүүр нь манай оронд орж ирсэн завсрын унаган ургамал 200 гаруй байгаа нь тус ургамлын аймгийн 11.6 орчим % эзэлж байна.

Өмнөговь аймгийн нутагт Ганц судалт гишүүнэ (*Rheum uninerve* Maxim.), дагаварт эмгэн шилбэ (*Atraphaxis bracteata* Losinsk.), Иконниковын бударгана (*Salsola Ikonnikovii* Ijgin.), Пржевальскийн чармай (*Gymnocarpus Przewalskii* Bge.ex Maxim.), Монгол шээрэнгэ (*Silene mongolica* Maxim.), Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Том үрт тольт өвс (*Galitzkya macrocarpa* (Ik.-Gal.) V.Bocz.), Олон наст багдай (*Dontostemon perennis* С.А.Мей.), Гоолиг багдай (*Dontostemon elegans* Maxim.), Торгон хэрээн хошуу (*Sibbaldianthe sericea* Grub.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Монгол бүйлээс (*Amygdalus mongolica* Maxim.) Монгол хунчир (*Astragalus mongolicus* Bge.), Говийн харгана (*Caragana gobica* Sancz.) L.), Хойрог харгана (*Caragana brachypoda* Rojark.), Монгол буурцгана (*Chesneya mongolica* Maxim.), Ганц навчит сальжир (*Gueldenstaedtia monophylla* Fisch.), Павловын хунчир (*Astragalus Pavlovii* B.Fedtsch.et Basil.), Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Хөндийн хунчир (*Astragalus vellestris* R.Кам.), Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge.ex Maxim.), Сайханы хунчир (*Astragalus saichanensis* Sancz.), Грубовын хунчир (*Astragalus Grubovii* Sancz.), Бүнгийн Ортууз (*Oxytropis Bungei* Ком.), Монгол сүүт өвс (*Euphorbia mongolica* Prokh.), Козловын сүүт өвс (*Euphorbia Kozlovii* Prokh.), Монгол догар (*Caryopteris mongolica* Bge.) Говийн ганга (*Thymus gobicus* Tschern.), Танамал махирс (*Lyium truncatum* Wang ) Потанины улаан тулам (*Incarvilla Potaninii* Batal.), Зөөлөвтөр лавай (*Asterothamnus molliusculus* Новорокр.) эрэг 13 овгийн 27 төрлийн 41 зүйл Монголын унаган, 17 овгийн 52 төрлийн 61 зүйл Монголд байгаа завсарын унаган ургамал ургаж байна.


**Үлдэц (реликт) ургамал** Тус аймгийн нутагт Алтайн сонгино (*Allium altaicum* Pall.), Элдэв навчит улиас (*Populus diversifolia* Schrenk.), Одой хайлас (*Ulmus pumila* L.), Липшицын банздоо (*Saussurea Lipschitzii* Filat.), Пржевальскийн Зээргэнэ (*Ephedra Przewalskii* Stapf.), Регелийн шар мод (*Sympegma Regelii* Bge.), Регелийн будараа (*Iljinia Regelii* (Bge.) Korov.), Монгол мөнххаргана (*Ammopiptanthus mongolicus*

(Maxim .ex Kom.)Cheng.), Муркрофтын жигд (*Elaeagnus Moorcroftii* Wall.-ex Schlecht.), Яшилдуу чацаргана (*Hippophae rhamnoides* L.), Хулан хойрго (*Potaninia mongolica* Maxim.), Өад хидөөд (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), ӒӒӒӒӒ хӒӒ ӒӒ (*Haplophyllum dahuricum* (L.) G. Don.), Зүүнгарын улаанбударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.) нийт 12 зүйл үлдэц (реликт) ургамал бүртгэжээ.

### III. Хөрс

ГГБЦГ нь говь, цөлийн бүсийн уул нуруу, хөндий хоолой хосолсон урт зурвас газрыг эзлэх учир ууланд нь уулын хүрэн, уулын бор хөрс, уулын өндөрлөг хажуу, хөндий хоолойгоор нь хуурай хээрийн цайвар хүрэн, цөлөрхөг бор ба нугат-бор, цөлийн бор саарал, шалархуу хөрс зэрэг хэд хэдэн хэв шинжид хамрагдах хөрс тархахын дээр хужир, элс болон сайрын хөрс зэрэг бүс дундын хөрс багагүй талбай эзэлнэ.

ГГБЦГ-т уулын хүрэн хөрсний хэв шинжид хамаарагдах 3 дэд хэв шинжийн хөрс бүгд тархана (Зураг 12).



Зураг 12. Говь Гурвансайханы БЦГ-ийн хөрсний зураглал

Уулын хар хүрэн, хүрэн хөрс нь байгалийн үржил шимээр сайн учир дээр нь ургадаг үетэн, алаг өвс голлосон нарийн өвст бүлгэмдэл нь өндрийн энэ бүслүүрт амьдардаг сүүн тэжээлт сээр нуруутан амьтны голлох бэлчээр болж чаддаг. Харин уулын цайвар хүрэн хөрс байгалийн үржил шимээр хүрэн хөрснөөс дутмаг боловч бог малд тохиромжтой бэлчээрийг бүрдүүлдэг байна. Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс, уулын хээржүү цөлийн бор хөрс нь ургамалжилт маш сийрэг, ийм хөрс хажуугийн элэгдлийн үйл явцад хүчтэй өртөгддөг учир морфологийн тогтоц тогтворгүй.

Ухаа гүвээ, талархаг газрын хэв шинжит хөрс нь Гурвансайхан уулын хажуугийн өндөрлөг газар болон бэл түүнээс дооших хөндий хоолойгоор өргөн тархана. Хөрс үүсвэрийн онцлогоос хамаарч нугат-бор хөрстэй газарт ургамлын зүйлийн бүрэлдэхүүн харьцангуй сайн байдаг тул малын нягтшил ихсэж бэлчээрийн талхагдал үүсэх хандлага ажиглагддаг. Хужир, хужирлаг хөрс, нугын ба нугат- намгийн хөрс нь ашиглалтын хувьд



хязгаарлагдмал боловч усны нөөц, усалгааны нөхцөлийг зохицуулан хүнсний ногоо тарих боломжтой.

Уулын оройдоо бага зузаалагтай хүрэн хөрстэй. Үүнээс доошлон хүрэн хөрс, бага зузаалагтай цайвар хөрстэй ба энд ургамал нь таана, хазаар өвс зонхилдог, хааяа хялгана тааралдана. Цөлжүү хээрийн бүсэд хулан хойрго, заг, сухай зэрэг сөөглөг, бутлаг ургамал тохиолдоно. Эндээс доошилж шар шавагтай шал тойром болно.

**Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэл** Өмнөговь аймгийн хөрсний төлөв байдалд лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн түүний элэгдэл, эвдрэлийн матрицын үнэлгээ хийхэд элэгдэл, эвдрэлийн хүчин зүйлс дотроос уул уурхай, авто зам хамгийн их нөлөө үзүүлж байна. Мөн бүх сумдын нутгаар явуулсан судалгааны явцад худаг, задгай ус, сумын төвийн орчмын эргэн тойрны 5-10 км орчим газар нутаг хөрсний хүчтэй доройтолд өртсөн нь ажиглагдаж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Өмнөговь аймгийн хөрсний элэгдэл, эвдрэлийг хүний болон байгалийн хүчин зүйлээс шалтгаалсан гэж ангилж болох юм. Хүний хүчин зүйлээс шалтгаалсан хөрсний эвдрэлд уул уурхайн үйл ажиллагаа, замын эвдрэл, суурин газар орчмын, худаг булаг шанд орчмын хөрсний эвдрэл орох бол байгалийн хүчин зүйлд ус болон салхины нөлөөг хамааруулна. Олон тооны шороон замууд бий болсон нь говийн эмзэг хөрсийг доройтуулж, хөрсний жижиг хэсгүүд салхиар зөөгдөж эвдрэлд орох нөхцөлийг бүрдүүлсээр байна. Мөн малын тоо толгой нэмэгдэж бэлчээрийн даац хэтэрч байгаа учраас элсжилт нэмэгдэх, худаг уст цэгүүд орчмын хөрсний талхагдал доройтол ихсэж байна.

Өмнөговь аймгийн нутаг цөлөрхөг хээр (говийн)-ийн болон цөлийн бүсэд хамрагдах бөгөөд хөрс үүсвэрийн нөхцөл нь тухайн газар нутгийн онцлог, байгаль цаг уурын нөхцөлөөс хамаарч үржил шим ядуутай, ялзмагийн агууламж багатай, ялзмаг хуримтлалын давхарга нимгэнтэй хөрсний төрлүүд голлон тогтворжсон байдаг. Ийм төрлийн хөрсүүд гаднын ачаалал даах чадвар муу, маш эмзэг бүтэцтэй байдаг тул эвдрэл, доройтолд орох нь амархан байдаг онцлогтой. Хөрсний эвдрэлийн судалгаагаар говь, цөлийн хөрсний хувьд шороон замын эвдрэлийн эрчим өндөр бөгөөд судалгааны бүс нутагт шороон замаас үүсэх хөрсний эвдрэлийн хэмжээ 288.4-300.2 тн/га байна. Автомашины хөдөлгөөнөөс үүдэлтэй хөрсний эвдрэлийн хэмжээ нь маш өндөр байгаа нь манай орны хувьд хөрсний эвдрэл, үржил шимийн бууралт, хөрсний нягтшил ихсэх томоохон эх үүсвэр болж байна.

Хөрсний эвдрэлийн судалгаагаар говь, цөлийн хөрсний хувьд шороон замын эвдрэлийн эрчим өндөр бөгөөд судалгааны бүс нутагт шороон замаас үүсэх хөрсний эвдрэлийн хэмжээ 288.4-300.2 тн/га байна. Автомашины хөдөлгөөнөөс үүдэлтэй хөрсний эвдрэлийн хэмжээ нь маш өндөр байгаа нь манай орны хувьд хөрсний эвдрэл, үржил шимийн бууралт, хөрсний нягтшил ихсэх томоохон эх үүсвэр болж байна.

**Суурин газар болон худаг, булаг шанд орчмын хөрсний эвдрэл** Уул уурхайн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах ажилчдын суурин, суурин газрын дэд бүтэц, барилга байгууламж, машин техникийн нөлөөлөл нь хөрсийг эвдрэл, доройтол, бохирдолд оруулсаар байна. Уурхай дагасан суурьшлын бүс тэлж, хүн ам өсөхийн зэрэгцээ иргэдийн эдийн засгийн чадавх сайжирч машины хэрэглээ нэмэгдсэн нь уурхайн бүс нутагт олон салаа замуудыг бий болгож улмаар хөрсөн бүрхэвч эвдэрч доройтох, талхлагдах үзэгдэл байнга нэмэгдсээр байна.

Говь, цөлийн бүсэд мал аж ахуй эрхлэхэд тулгардаг бэрхшээлтэй зүйлсийн нэг бол ил задгай ус, булаг шанд ховор байдаг тул ихэвчлэн хөрсний ус ашиглан гаргасан худгууд ихээр ашиглагддаг явдал юм. Худаг болон булаг шанд орчмын хөрсний эвдрэл ихэвчлэн малын хөлийн нөлөөгөөр үүсдэг тул ингэж эвдэрч доройтсон хөрс байгалийн жамаар нөхөн сэргээгдэхгүй нөхцөл байдал үүсдэг. Худаг орчмын газрын 50-100 метрийн хүрээнд бэлчээрийн хөрсний эвдрэл доройтол маш хүчтэй илэрч байна.

**Хөрс усаар элэгдэх үйл явц** Энэ нь дэлхийн өнцөг булан бүрд ихээр илрэх газрын доройтлын хэлбэр болдог. Хүний нөлөөгөөр явагдах хөрсний доройтлын үнэлгээ хөтөлбөрөөс гаргасан дүнгээр Дэлхийн эх газрын экосистемийн 1100 сая га талбай усны элэгдэлд их, бага хэмжээгээр өртсөн байна. Усны элэгдэл нь хөрсний үржил шимт өнгөн давхаргыг зөөгдөлд оруулж улмаар хөрсний шимт бодисын эргэлт, ургамал нөмрөгийн өсөлт, хөгжилт зэрэг экосистемийн тэнцвэрт байдлыг хангах үйл явцад сөрөг нөлөө үзүүлдэг. Хөрс усаар элэгдэх үйл явц нь уур амьсгал, газрын гадаргын хэвгий, хөрсний физик шинж чанар зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдоно. Иймээс харьцангуй чийглэг бөгөөд зөөлөн уур амьсгалтай бүс нутагт хөрс усаар элэгдэх үйл явц эх газарлаг, эрс тэс уур амьсгалтай бүс нутагтай харьцуулахад бага явагдана.

Дэлхийн түвшинд хийгдсэн хөрс усаар элэгдэх эрсдэлийн үнэлгээнээс харахад Дэлхийн тив бүрд энэ асуудал аль нэг хэмжээнд илрэх эрсдэл өндөр байгаа ч хамрах талбайн хувьд Ази тив, нэн ялангуяа Зүүн Өмнөд Ази, Өмнөд Азийн бүс нутагт илүү эрсдэлтэй аж. Монгол орны хувьд уулархаг нутгуудад усны элэгдэл, эвдрэлийн асуудлыг хөндөх шаардлагатай байдаг. Монгол орны хэмжээнд элэгдэл нэн хүчтэй илрэх эрсдэл өндөртэй байгаа юм. Энэ нь нэг талаас гадаргын хэвгийгээр тодорхойлогдож байгаа ч нөгөө талаас хөрсөн бүрхэвчийн физик шинж чанар энэ эрсдэлд илүүтэй нөлөөлж байгаа юм. Хөрс усаар элэгдэх үйл явц нь газрын доройтлын хамгийн өргөн тархсан хэлбэр гэж тооцогддог. Монгол орны хэмжээнд хөрс усаар элэгдэх үйл явцыг RUSLE загвараар тооцсон судалгааны дүнгээс үзэхэд хөрс усаар элэгдэх эрсдэл өндөртэй газруудад жилд дунджаар 0.032 тн/га\*жил, хамгийн ихдээ 3.42 тн/га\*жил хөрс зөөгддөг байна.

Монгол орны хэмжээнд хөрсний элэгдлийг тооцсон судалгаа хомс байдаг. Ж.Цэрэнсодном нарын “Монгол орны ойт хээрийн ландшафтын топологи судалгаа” нэгэн сэдэвт бүтээлд ойт хээрийн бүсэд жилд 6-81.4 м<sup>3</sup> /га хөрс усаар зөөгддөг болохыг дурдсаны зэрэгцээ хажуугийн урсцаар 1-50 кг/га хөрс зөөгдөнө гэж дүгнэжээ.

**Хөрс салхиар элэгдэх үйл явц** Гандуу нутагт түгээмэл үзэгдэл бол шороон шуурга юм. Дэлхийн томоохон цөл, заримдаг цөлүүдийн экологийн нөхцөл энэ үзэгдэлд зохицсон байх бөгөөд зохицох механизм нь янз бүрээр илрэлээ олсон байдаг. Юуны түрүүнд гандуу нутгийн ургамал нь элс шороо хуримтлагдахад дасан зохицсон байх бөгөөд элсэн хуримтлалыг өөртөө барих экологийн механизмыг агуулсан байдаг. Үүнээс гадна цөл, заримдаг цөлүүдийн гадарга жижиг хэмхдэст чулуугаар хучигдсан байдаг ба энэ нь хөрсний нимгэн үе давхаргыг салхины нөлөөнөөс хамгаалах үүрэгтэй байдаг. Гэсэн хэдий ч хүний зохисгүй нөлөө, байгалийн гадаад болон дотоод хүчний нөлөөгөөр хөрс шороо салхиар зөөгдөх, хуримтлагдах явц эрчимжиж салхин гаралт хөрсний элэгдлийн үйл явц гандуу нутагт идэвхжих нь элбэг байдаг. Хөрс салхиар элэгдэх үйл явц нь гандуу нутаг дахь газрын доройтлыг тодорхойлох гол хэлбэрт тооцогддог. Монгол орны хэмжээнд хөрс салхиар элэгдэх үйл явцыг WEQ загвараар тооцон үзэхэд

хөрс салхиар элэгдэх эрсдэл өндөртэй газруудад жилд дунджаар 3.1 тн/га жил, хамгийн ихдээ 50 гаруй тн/га\*жил хөрс зөөгддөг байна.

Өнгөрсөн хугацаанд гарсан өөрчлөлтийн хэмжээг үнэлж үзэхэд эрчимтэй элэгдэлд орж байгаад тооцогдох газруудад өнгөрсөн 18 жилийн хугацаанд жилд 0.04-0.09 тн/га\*жил нэгжээр өсөж байгаа бөгөөд өөрчлөлтийн хэмжээ хамгийн их хэсгүүдэд 0.09 тн/га\*жил нэгжээр өссөн байна.

**Цөлжилт, газрын доройтол** Монгол улс 111.0 сая га бэлчээр, 1.7 сая га хадлагийн талбай бүхий нийт 112.7 сая га бэлчээрийн газартай. Монгол орны цөлжилт, газрын доройтлыг байгаль, уур амьсгал, нийгмийн голлох хүчин зүйлийн хүрээнд хийсэн үнэлгээгээр 2015 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөөд байгаа бөгөөд үүнээс хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газар 23.1 хувийг эзэлж байна (Зураг 2.48). Цөлжилт, газрын доройтол нэмэгдсэн газруудад Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, өмнийн болон дорнын говийн нутаг хэвээр хадгалагдан үлдэж байгаагийн зэрэгцээ өмнөх үеийн судалгаагаар тогтоогдсон Орхон-Сэлэнгийн сав нутаг, Хэрлэн голын сав, Дорнод Монголын хээрийн муж, Төв Халхын тэгш өндөрлөгийн хэмжээнд доройтлын үйл явц нэмэгдсэн дүнтэй байна.

Орон зайн тархалтын хувьд цөлжилт, газрын доройтолд өртөөд байгаа гол сумдад Булган, Баян-Овоо, Ханбогд, Манлай, Номгон, Баяндалай, Хүрмэн зэргийг дурдаж болно.

Цөлжилт, газрын доройтолд үзүүлж буй уур амьсгалын нөлөө ба түүний урвуу хамаарлыг судалсан дүнгээс үзэхэд өнгөрсөн хугацаанд илэрсэн дулаарал, хуурайшлын үйл явц нутгийн төв болон зүүн хэсэгт эрчимтэй илрэлээ олсон бөгөөд цаашид ч энэ хандлага хадгалагдан үлдэх төлөвтэй байна. Харин цөлжилт, газрын доройтол, уур амьсгалын урвуу хамаарлын хувьд газрын доройтол, цөлжилтийн гол үр дагавар нь дэвсгэр гадарга доройтоход хүргэх ба энэ нь ууршицын хэмжээ буурах цаашлаад мезо-, микро уур амьсгалын түвшинд агаарын чийгийн горимд хувьсал авчирна. Түүнчлэн доройтсон газрын талбай өсөх хирээр гадаргын альбеда мөн нэмэгдэх бөгөөд энэ нь микро түвшинд дулаарах үзэгдлийг дагуулна.

## 2.1.2. Нийгэм, эдийн засгийн нөхцөл, нөөц

### *Засаг захиргаа, нутаг дэвсгэр*

ГГБЦГ нь засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Мандах, Жаргалант, Булган сумын Хавцгайт, Сэврэй сумын Хоолт, Бүйлсэн, Сайншанд, Гурвантэс сумын Гоёот, Баяндалай сумын Төхөм, Баян, Хүрмэн сумын Хүрмэн багийн нутаг дэвсгэрт харьяалагддаг бөгөөд энэ нь аймгийн нийт сумдын 40%, багийн 16.9% юм.

Өмнөговь аймгийн нийт газар нутгийн 28.3% буюу 2.2 сая га талбай нь ГГБЦГ-т хамаардаг (Хүснэгт 11).

*Хүснэгт 11. ГГБЦГ-т хамаарах сумдын нутаг дэвсгэрийн хэмжээ (га)*

№	Сумдын нэрс	Сумдын нийт талбай /км <sup>2</sup> /	Өмнөговь аймгийн (165.4 мян км <sup>2</sup> )	Сумдын ГГБЦГ-т хамаарах талбай /га/	Сумдын ГГБЦГ-т хамаарах талбай /хувь/
---	-------------	---------------------------------------	---	-------------------------------------	---------------------------------------

талбайд эзлэх хувь					
1.	Сэврэй	8100	4.9%	664526	82.08
2.	Баяндалай	10750	6.5%	246956	22.97
3.	Булган	7498	4.5%	147744	19.7
4.	Ханхонгор	9931	6.0%	71890	7.24
5.	Гурвантэс	27970	16.9%	1028501	36.77
6.	Хүрмэн	12390	7.5%	12120	0.98
	<b>Бүгд</b>	<b>76639</b>	<b>46.3%</b>	<b>2171737</b>	<b>28.3%</b>

ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт дээрх 6 сумдын газар нутгийн 0.98-82% нь хамрагдсан ба Гоёот, Хавцгайт, Жаргалант, Хоолт багуудын төв нь БЦГ-ын дотор байрлаж байна. Эдгээр сумд нь аймгийн төвөөс 25-320 км-т алслагдсан аж.

### Хүн ам

ГГБЦГ-т харьяалагддаг 6 сумдын 10 багт нийт 2170 өрхөд 6219 хүн ам оршин суудаг бөгөөд энэ нь Өмнөговь аймгийн нийт өрхийн 9.4%, хүн амын 8.53%, сумдын нийт өрхийн 41.5%, хүн амын 41.33%-ийг эзэлж байна.

2021 оны байдлаар ГГБЦГ-ын дотоод бүсүүд болон орчны бүсэд 8 сумын 835 өрхийн 3020 хүн ам оршин сууж байгаа ба тэдгээрээс цогцолборт газрын “Онцгой бүс”-д 5 өрхийн 19 хүн, “Аялал жуулчлалын бүс”-д 64 өрхийн 202 хүн, “Хязгаарлалтын бүс”-д 618 өрхийн 2052 хүн, харин “Орчны бүс”-д 148 өрхийн 479 хүн ам оршин сууж байна. (Хүснэгт 12).

Хүснэгт 12. ГГБЦГ-ын бүсүүдэд амьдарч буй өрх, хүн амын тоо

№	Сумдын нэр	Оршин сууж буй өрхийн тоо				Оршин сууж буй хүн амын тоо					
		Онцгой бүс	АЖ-ын бүс	Хязгаарлалтын бүс	Орчны бүс	Бүгд	Онцгой бүс	АЖ-ын бүс	Хязгаарлалтын бүс	Орчны бүс	Бүгд
1	Гурвантэс	1	9	100	44	154	6	22	340	175	543
2	Ханхонгор	-	1	30	20	51	-	2	64	47	113
3	Булган	2	18	87	1	108	3	59	291	5	626
4	Баяндалай	2	15	143	37	197	10	54	446	116	626
5	Хүрмэн	-	-	5	34	39	-	-	11	85	96
6	Сэврэй	-	16	227	11	254	-	53	820	46	919
7	Даланзадгад	-	2	17	1	20	-	4	60	5	69
8	Шинэжинст	-	3	9	-	12	-	8	20	-	28
	<b>Нийт</b>	<b>5</b>	<b>64</b>	<b>618</b>	<b>148</b>	<b>835</b>	<b>19</b>	<b>202</b>	<b>2052</b>	<b>479</b>	<b>3020</b>

Эх үүсвэр: ГГБЦГ-ын тайлан мэдээ

### Мал аж ахуй

Хамгаалалтын Захиргаанаас гаргаж өгсөн тайлан мэдээнээс харахад 2020 онд ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт 835 малчин өрх, 433084 толгой мал байна. Үүнээс 10544 нь тэмээ, 17910 нь адуу, 6598 нь үхэр, 80642 нь хонь, 317390 нь ямаа байна (График 5).




График 5. ГГБЦГ-ын малын төрөл

2017-2019 онуудад малын тоо толгойн өсөлт харьцангуй тогтвортой байсан бол 2020 онд 71796 тоо толгойгоор буюу өмнөх онтой харьцуулахад 19.9%-иар өссөн байна (График 6).



График 6. ГГБЦГ-ын нийт малын тоо толгойн өсөлт 2017-2020

Үүнийг малын төрлөөр нь авч үзвэл 2020 онд өмнөх онтой харьцуулахад тэмээ 225 толгойгоор буюу 2.2%, адуу 3579 толгойгоор буюу 25%, үхэр 1260 толгойгоор буюу 23.6%, хонин толгой 10862 толгойгоор буюу 13.5%-иар, ямаа 55870 толгойгоор буюу 21.36%-иар тус тус өссөн байна (График 7).




График 7. Малын тоо, толгойн өсөлт 2017-2020 (төрлөөр)

2020 оны байдлаар нийт малын 0.4% нь онцгой бүсэд, 11% нь аялал жуулчлалын бүсэд, 74.7% нь хязгаарлалтын бүсэд, 13.9% нь орчны бүсэд байна. Малын өсөлтийг ГГБЦГ-ын бүсүүдээр авч үзвэл (График 8)




График 8. ГГБЦГ-ын бүсүүд дэх малын тоо толгойн өсөлт

ГГБЦГ-ын дотоод бүсүүд дэх малын тоо толгой ерөнхийдөө өсөж байгаа бөгөөд ялангуяа онцгой бүсэд байрлах малчин өрхүүдийн малын тоо толгой 2020 онд өмнөх жилүүдээс огцом өссөн байна. Тухайлбал, 2018 оноос бараг 3 дахин, 2019 оноос 6 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь магадгүй Хамгаалалтын захиргаанаас гаргаж өгсөн тоон мэдээллийн алдаатай байдлаас болсон байж магадгүй боловч хол зөрүүтэй байх боломжгүй юм (График 9).



*График 9. ГГБЦГ-ын онцгой бүс дэх малын тоо толгойн өсөлт*

### **Харилцаа холбоо, дэд бүтэц**

Гурантэс, Ханхонгор сумдад Монголын цахилгаан холбооны MSAN шинэ станц байгуулагдан айл өрхүүдийг харилцаа холбооны утас, интернэтийн сүлжээнд холбосон. Хүрмэн, Булган, Баяндалай, Сэврэй сумдад Монголын Сүлжээ ХХК-ний шилэн кабель, Мобиком, Скайтел, Юнител зэрэг үүрэн телефоны операторуудын салбарууд ажилладаг. Ингэснээр орон нутгийн иргэд төдийгүй гадаад, дотоодын жуулчид ч гар утсаар ярих, интернэтэд холбогдох боломжтой болсон. Гэвч Хэрмэн цав зэрэг зарим газруудад ийм боломж байхгүй хэвээр байна.

Аймгийн төв Даланзадгадаас Гурвантэс, Баяндалай, Ханхонгор, Хүрмэн, Сэврэй, Булган сумдтай холбосон орон нутгийн чанартай замууд байдаг бөгөөд Гурвантэс сумын Нарийн Сухайтын уурхайгаас Шивээ хүрэнгийн хилийн боомт хүртэл, мөн Даланзадгадаас Баяндалай сум хүртэл хатуу хучилттай замтай.

ГГБЦГ-т хот, аймаг, сумдын хоорондын төв замуудаас гадна сумаас сум, баг, малчин айлын чиглэсэн олон салаа замууд гарч хөрсний талхагдал бий болсоор байна. Мөн малчид зун, намар, хавар отор нүүдэл хийх, буудалласан газраа шинэ зам гаргах, бартаа багатай хээр газар тээврийн хэрэгсэлтэй ан гөрөө хийх зэргээр энэ асуудал буурахгүй байна.

ГГБЦГ-т 1992 онд ЗЗАА-иар Оюутын амнаас Ёлын ам хүртэлх 12 км газрыг засуулсан боловч үүнээс өөр засаж сайжруулсан зам байхгүй байна.

Даланзадгад хотын төвд Гурвансайхан орон нутгийн нисэх онгоцны буудал байдаг бөгөөд тэрхүү буудал нь Монгол улсын Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын харьяанд байдаг.

### **Газар ашиглалт**

ГГБЦГ-ын 1760347 га талбай нь бэлчээр, 372 га талбай нь зам, шугам сүлжээ, 573081 га нь ойн сан бүхий газар бол аялал жуулчлалын чиглэлээр ашиглаж буй газрын хэмжээ 21.5 га байна (Хүснэгт 13).

*Хүснэгт 13. ГГБЦГ-ын газрын нэгдмэл сан*

№	Бэлчээр	Зам
---	---------	-----



	Сумдын нэрс	Нийт талбай /га/	ГГБЦГ-т хамрагдах талбай		Нийт талбай /га/	Үүнээс		Заганы	
			Га	Хувь		цэвэр	элстэй		
1.	Сэврэй	809572	664526	82.08	602671	567631	35040	91232	85
2.	Баяндалай	1075073	246956	22.97	246918	231158	15760	-	38
3.	Булган	749815	147744	19.7	147714	147714	-	-	30
4.	Ханхонгор	993130	71890	7.24	71858	71858	-	-	32
5.	Гурвантэс	2796727	1028501	36.77	679066	657246	21820	481849	187
6.	Хүрмэн	1239326	12120	0.98	12120	12120	-	-	-
	<b>Бүгд</b>	<b>7663643</b>	<b>2171737</b>	<b>28.34</b>	<b>1760347</b>	<b>1687727</b>	<b>72620</b>	<b>573081</b>	<b>372</b>

Газрыг худаг гаргах, өвөлжөө барих, байгууллага, аж ахуйн нэгжийн төв, салбар байгуулах, нас барагсдыг оршуулах, хогийн талбай байгуулах, газар тариалан эрхлэх, зам, бэлчээр ашиглах, судалгаа хийх, аялал жуулчлал зохион байгуулах зэргээр ашигладаг. ГГБЦГ-т Гурвантэс сумын Гоёот, Булган сумын Хавцгайт, Сэврэй сумын Хоолт багийн төвүүд, Жуулчин говь-2, Говь дисковери-2, Говийн-Анар, Говь-Эрдэнэ, Чингэсийн Өргөө зэрэг жуулчны баазууд, “Буянт хотхон” аймгийн хүүхдийн нэгдсэн зуслан, ахмадын сувилал, Айргийн эмнэлэг, Байгалийн музей, Хөгжийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сувиллын газар, Нийтлэг үйлчилгээний газрын нөхөрлөлийн болон хувь хүмүүсийн бэлэг дурсгалын дэлгүүр байрлан үйл ажиллагаа явуулж байна.


Өнөөгийн байдлаар тус цогцолборт газрын бүсүүдэд нийт 936 өвөлжөө байгаагаас 0.53% нь онцгой бүсэд, 7.37% нь аялал жуулчлалын бүсэд, 65.8% нь хязгаарлалтын бүсэд, 25.4% нь орчны бүсэд байрлаж байна (Хүснэгт 14).

*Хүснэгт 14. ГГБЦГ-ын бүсүүд дэх өвөлжөөний тоо (2022 оны байдлаар)*

№	Сумдын нэр	Багийн нэр	Бүсүүдэд байрлах малчдын өвөлжөөний тоо				Нийт
			Онцгой бүс	АЖ-ын бүс	Хязгаарлалтын бүс	Орчны бүс	
1	Гурвантэс	Гоёот	1	6	135	31	<b>173</b>
		Баясах	-	-	-	47	<b>47</b>
		Шинэ жинст	-	5	2	-	<b>7</b>
2	Ханхонгор	Мандах	1	5	24	29	<b>59</b>
		Жаргалант	-	1	27	13	<b>41</b>
3	Булган	Хавцгайт	1	18	77	-	<b>96</b>
4	Баяндалай	Баян	-	10	72	11	<b>93</b>
		Төхөм	2	5	63	26	<b>96</b>
		Наран	-	-	14	3	<b>17</b>
5	Хүрмэн	Хүрмэн	-	-	-	35	<b>35</b>
6	Сэврэй	Хоолт	-	11	75	-	<b>86</b>
		Бүйлсэн	-	-	44	12	<b>56</b>
		Сайншанд	-	7	111	4	<b>122</b>
7	Даланзадгад		-	1	6	1	<b>8</b>
	<b>Нийт</b>		<b>5</b>	<b>69</b>	<b>650</b>	<b>212</b>	<b>936</b>

*Эх үүсвэр: ГГБЦГ-ын тоон мэдээ*

Өвөлжөө, хаваржаануудын байршлыг зураг 13-т харуулав.



Зураг 13. ГГБЦГ-т байрлах малчдын өвөлжөөний байршил

### 2.1.3. Аялал жуулчлалын голлох нөөц, бүтээгдэхүүнүүд

Амрагч, аялагчдын сонирхлыг татах нэг гол зүйл нь тухайн нутаг орны байгалийн тогтоц, үзэсгэлэнт газрууд байдаг. 2018 оны Монгол банкны судалгаагаар Монголд ирж байгаа жуулчдын 17,82% нь зэрлэг, унаган байгалийг үзэхийг хүсэж буйгаа илэрхийлсэн нь тус асуулгын хамгийн өндөр үзүүлэлт байсан юм. ГГБЦГ-ын хувьд түүний үзэсгэлэнтэй, өвөрмөц тогтоц бүхий газрууд, ховор, нэн ховор ургамал, амьтад нь жуулчдын сэтгэлийг татах бусдаас ялгарах өвөрмөц онцлогийг илэрхийлдэг.

ГГБЦГ-ын аялал жуулчлалын голлох байгалийн нөөц нь:

1. Ховор, ховордсон ургамал, амьтан (2.1.1-ийг харна уу)
2. Говь, цөлийн бүсийн байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд юм.

#### **Жуулчдын зорин очдог байгалийн үзэсгэлэнт газрууд**

ГГБЦГ-т өвөрмөц, үзэсгэлэнтэй олон газрууд байдгаас гадаад, дотоодын жуулчдын сэтгэлийг татдаг, дахин давтагдашгүй дүр төрх бүхий дараах газрууд байна. Үүнд:

- ❖ Гурван Сайхан уул Энэхүү уул нь Говь Алтайн нурууны үргэлжлэл хэсэг бөгөөд эртний төрмөлийн эриний Девоны галавын далайн ёроолын шаварлаг занар зэрэг тунамал чулуулгаас тогтсон уул юм. Өмнөговь аймгийн төв Даланзадгадаас баруун тийш 180 километр цувран үргэлжилсэн Баруунсайхан, Дундсайхан, Зүүнсайхан хэмээх 3 саланги том нуруунаас бүрддэг. Говь Гурвансайхан нурууны хамгийн өндөр нь Зүүнсайхан уул бөгөөд Баяндалай, Хүрмэн, Ханхонгор сумдын нутаг дэвсгэрт оршдог. Түүний ноён оргил нь Шанд

уул д.т.д 2846м юм. Энэ ууланд Ёлын Ам, Мухар шивэртийн ам, Улиастай ам, Тосонгийн ам, Дүнгэнээгийн ам зэрэг байгалийн үзэсгэлэнт тогтоцтой газрууд олон байдаг ба Өгөдэй хааны үеэс тахиж ирсэн уул юм. Баруунсайхан уул нь Баяндалай сум, болон Булган сумын нутгийн заагт орших бөгөөд д.т.д 2514м өндөр. Энд эртний төрмөлийн эриний Силурын галавын үеийн (400 сая жилийн өмнөх) мангийн чулуулаг ил гарсан сонин тогтоц бүхий газар бий. Үүнээс гадна хавар 4 дүгээр сарын сүүлчээр монгол сакура буюу бүйлс цэцэглэдэг. Дундсайхан уул нь Баяндалай сум, Ханхонгор сумын нутагт орших ба 40 км урт уул юм. Хамгийн өндөр ноён оргил нь Эрдэнэцогт д.т.д 2825м өндөр. Энэ уулын оргил дээрээс аймгийн бүх нутгийн гуравны нэгийг эзлэх 10 сумын нутаг дэвсгэрийн ихэнх, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн нутаг Их, бага Богд, Дэлгэрхангай зэрэг 200-300 км алслагдсан уул нурууд харагдана. Говь Гурвансайхан уулыг 2012 оны 8-р сарын 24-нд Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн тахилгат уул болгосон байна.

- ❖ Ёлын ам Ёлын ам нь Гурван сайхан уулын Зүүнсайхан ууланд оршдог зөрөгт үүсэлтэй үзэсгэлэнт сайхан ам юм. Энэхүү амны үзэсгэлэнтэй байдлыг хадгалахын тулд 1965 онд дархан цаазат газар болгосон бөгөөд 1995 оноос Говь Гурвансайхны байгалийн цогцолборт газар болжээ. Ёлын ам нь Зүүнсайхан уулын хад чулууг зүүн хойш чиглэлтэйгээр зүсэн урссан голын тектоник гаралтай, 4 орчим км үргэлжилсэн бачуу, нарийн хавцал бөгөөд уулаа огтолж талд гардаг. Хавцлын гүн хэсэгт 200 гаруй метр өндөртэй цавчим элгэн хадан ханатай болдог бол хамгийн нарийн хэсэгтээ хүн л зэрэгцэн гарч болохоор 1м орчим нарийн болдог. Хавцлын арай тавиу хэсэгт цайран байгаа зузаан мөсөн доогуур горхи урсдаг. Мөс нь хайлалгүй намрын цагтай золгож жил өнжих нь элбэг байсан боловч сүүлийн жилүүдэд энэхүү мөс хайлах болсон. Бороо хур элбэгтэй зун Ёлын амны хавцлын хадан дээрээс 200 гаруй метрийн өндрөөс буух хэд хэдэн хүрхрээ үүсдэг ба өвөл нь энэ хүрхрээ хөлдөж цан хүүрэг татуулан байх нь үзэсгэлэнтэй. Энд аргал, янгир элбэг бөгөөд хавцал дээгүүр ёл, бүргэд зэрэг жигүүртэн шувууд нисэх нь бүр ч гайхамшигтай. Ёлын аманд Козловын хайруулдай-Mongolian Accentor-Prunella montanella, Алтайн хойлог-Altai Snowcock-Tetraogallus altaicus, Цармын бялзуухай-Wall Creeper-Tichodroma muraria, Ооч Ёл-Lammergier-Gypaetus barbatus зэрэг дэлхийн хэмжээнд ховордсон болон Монгол улсын Улаан номд бүртгэгдсэн шувууд байдаг, хавар, намартаа олон зүйлийн шувууд дайран өнгөрдөг. Мөн Янгир ямаа-Siberian or Asiatic Ibex-Capra ibex sibirica-ийн хамгийн их бөөгнөрөл бүхий нутагт тооцогддог ч 2009 оны тооллогоор хорогдсон мэдээ гарч байжээ. Түүнээс гадна дэлхийн хэмжээнд нэн ховордсон Говийн том араатны нэг Ирвэс-Snow Leopard-Uncia uncial, Зэрлэг муур-Pallas's cat or Manul зэрэг амьтдын гол тархац бүхий нутаг болдог учраас Ёлын амны экосистемийн байдал, хамгаалалтын дэглэмд онцгойлон анхаарах шаардлагатай.
- ❖ Мухар шивэртийн ам Зүүнсайхан уулын Ёлын амнаас урагш 7 км, аймгийн төвөөс 36 км зайд Мухар шивэртийн ам бий. Өмнөговь аймгийн есөн гайхамшигийн нэгд багтдаг бөгөөд гадаад дотоодын аялагчдын сонирхон зорьдог газар болсон. Энэ нь Зүүнсайхан уулан дахь хамгийн өндөр мөс бүхий ам юм. 10

орчим метрийн өндрөөс урсдаг жижиг булаг нь өвөл хадан хана даган тэлж хөлдөн их хэмжээний мөсөн бүрхүүлийг үүсгэдэг. Нар бага тусдаг мухар ам учир зуны ид дунд үе хүртэл мөстэйгөө байх нь бий.

Уулын гүн рүү машинаар орж тусгай тэмдэг тавьсан машины зогсоолоос цааш 750 м явган алхаж Мухар Шивэртийн эхэнд хүрнэ. Алхах замд хоёр хажуугийн хадат уулсын оройд харагдах янз бүрийн амьтан, шувууны дүрс хэлбэрийг сонирхож болно. Тэдгээр байгалийн чулуун урлалд тайлбар хийж, Мухар Шивэртийн орчныг хамгаалах ажлыг орон нутгийн иргэд хариуцан ажилладаг. Тус амны өндөр оргилуудад Ооч Ёл байнга үүрлэдэг учир аль болох дуу чимээ бага гаргаж, заасан тэмдэглэгээний дагуу аялахыг зөвлөдөг. Энэ нь Ёл шувууг үргэж дайжихгүй байхад тустай, мөн зэрлэг амьтад, шувуудыг хамгаалахад томоохон хувь нэмэр болно. Ёлын амтай нэг салбар уулс учир өглөө эрт, оройн нар буух үед анхааралтай ажиглаж явбал Мухарт Шивэртийн аманд цөөнгүй зэрлэг амьтан, шувуудыг харах боломжтой.

- ❖ **Хавцгайтын ам** Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутаг дахь Гурвансайхан уулын байгалийн цогцолборт газарт, аймгийн төв Даланзадгад хотоос 30 км-ийн зайд, х.ө 43°34'42", з.у 104°01'10" солбицолд оршино. 1 км орчим үргэлжлэх хавцал дундуур урсах голын хөндийд үүссэн байгалийн үзэсгэлэнт газар юм. Зуны цагт амрагчдын буудаллаж, амрах аяллын гол төв болдог.
- ❖ **Хэрмэн цав** Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт Шариг уулнаас баруун хойш, Алтан уулаас баруун урагш х.ө 43°28', з.у 99°48' орчим солбицолд, баруун хойш Ингэнэхөөврийн говь руу хандсан, Даланзадгадаас 450 километр, Хонгорын голын элснээс 250 километр зайтай, Гурвантэс сумын төвөөс баруун хойд зүгт энэхүү байгалийн үзэсгэлэнт газар байх бөгөөд 10 гаруй км үргэлжилсэн, 100-200 м гүнзгий, адагтаа 10 орчим км өргөн, их ганга, жалгатай гүн улаан, шар хурдас давхарлан алаглан харагдах мөргөцөгийг Хэрмэн цав гэдэг. Гангын дотроо элсэн манх болон заган ойтой. Этгээд хэлбэртэй улаан толгодууд, говийн цөл нь өнө эртний үед их далай байсныг нотлодог. Дундад зууны Европын цайз цамхгууд, төрөл бүрийн амьтад шиг хэлбэртэй "авангард" толгодуудыг холоос харахад их хотын балгас мэт харагддаг. Өмнөговь аймгийн болон Монгол улсын 9 гайхамшгийн нэгд зүй ёсоор багтдаг Монголын хамгийн том цав юм. Ойр орчиндоо хайлаас тоорой, сухай бүхий баян бүрдтэй үзэсгэлэнт нутаг. Хэрмэн цав нь дунд ба шинэ төрмөлийн эриний нуурын зузаан хурдас усны үйл ажиллагаанд угаагдан эвдэрсэн олон сархиа бүхий 250 ам.дөр.км талбайтай. Эргэн тойронд элсний нүүдэл болж зам нь хучигдсан байдаг ба Хэрмэн цав руу очиход зам нь амаргүй, ус булгийн нөөцгүй, хүн, мал амьдардаггүй, зундаа +60 хэм хүртэл халдаг, хонхор хотгор маягийн газар учраас говийнхон “үхлийн хөндий”, “тамын тогоо” ч гэж нэрлэх нь бий. Ойр орчимдоо Наран даацын булгаас өөр усгүй. Хэрмэн цав руу орох үүд хоёр байдаг гэх ба төөрөх эрсдэлтэй тул орон нутгийн хөтөчтэй явахыг зөвлөдөг.
- ❖ **Хонгорын элс** ГГБЦГ-ын нэлээд хэсгийг хамрах Хонгорын элс нь Өмнөговь аймгийн Сэврэй, Баяндалай сумдын нутагт, Их Сэврэйн уул, Зөөлөнгийн нурууны араар, Баян бор нурууны урдуур, баруун хойноос зүүн

урагш чиглэн 180 км урт үргэлжилсэн их элсэн тарамцаг юм. Улаанбаатараас баруун урагш 650 км, Даланзадгадаас баруун хойш 216 км, Сэврэй сумын төвөөс зүүн хойш 35 км зайд оршдог. Нийт 95 ам.дөр.км талбайтай, манай орны нутгийн 2.7%-ийг эзэлдэг элсний нэгээхэн хэсэг юм. Элсний хамгийн өргөн нь баруун хойшоо 27км, хамгийн нарийн нь төв хэсэгтээ 800м байдаг. Манханы өндөр нь 100-300м хүрэх ба баруун хэсгээрээ илүү өндөр, хамгийн өндөр ханан элсний өндөр нь газрын гадаргаас 195м өндөр юм. Элсэн манхнууд нь салхины нөлөөгөөр гулсахдаа нисэх онгоц мэт хүнгэнэн дуугарах нь холоос сонсогдох байхнхүү дуугардгаас нутгийн иргэд “Дуут манхан” гэж нэрэх нь бий.

Хонгорын элсний урдуур орших Хатан Сэврэй ууланд Монголын болон дэлхийн “Улаан ном”-д бүртгэгдсэн ховор шувуу Алтан хойлог энд амьдардаг. Хатан Сэврэй уултай залган оршдог Зөөлөнгийн уул, Хонгорын элсний араар орших Баян бор нурууны уулс нь говийн томоохон хөхтөн амьтан аргаль, янгирын ихээхэн нөөц бүхий нутаг билээ. Эдгээр уулсын хөндий бэл, талаар цагаан зээр, хар сүүлт зээрийн сүрэг харьцангуй элбэг. Зөөлөнгийн нурууны араас буусан үерийн ус Хонгорын элсний дундуур хойш зам гарган нэвт урсаж хөрсөнд шингэдэг. Энэ ширгэсэн ус элсний хойд захад Сэрүүн булаг, Аргангын булаг нэртэйгээр газар дээр гарч баруун тийш элснийхээ хаяагаар 10 гаруй км урсаж Хонгорын гол болно. Говийн бяцхан энэхүү гол нь эрэг орчиндоо битүү ногоон зүлэг үүсгэсэн хоёр салаа гол бөгөөд адаг дээрээ нийлэн “Адаг нуур” хэмээх бяцхан нуурыг үүсгэдэг. Элсний орой дээр гарахад цааш хэдэн зуун манхан толгод үргэлжлэн харагдана. Хонгорын элсний ойр хавийг бүхэлд нь харахад урдуураа хадтай уул, дундуураа ургамал ургах аргагүй элсэн манхан, хойд бэлээр нь гол урсаж ногоорсон баянбүрд харагдах нь үнэхээр үзэсгэлэнтэй.

Сул нүүдэллэдэг элс учраас эгц авирах боломжгүй, хөл шигдэн амархан ядардаг. Эрт үед Хонгорын элс хавийн заг асар өндөр, шигүү байжээ. 1993 оноос эхлэн гадаад, дотоодын жуулчдад өргөнөөр сурталчлагдаж, 1997 онд Японы Жайка төслөөс боловсруулсан “Монгол улсын аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-нд говийн аялал жуулчлалын хамгийн гол цэгээр тэмдэглэгдсэн юм

- ❖ **Нэмэгтийн их хонгил** Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас хойш 60 км, аймгийн төвөөс 320 км зайд орших Нэмэгт уул нь д.т.д 2769м өндөр өргөгдсөн бөгөөд ургамлын бүрхэвч нь өвөрмөц, харьцангуй том харагддаг. Энд аргаль, янгир, цоохор ирвэс зэрэг ховордсон, үзэсгэлэнт амьтад байх бөгөөд цоохор ирвэсийн Сэврэй, Гилбэнт уул руу нүүх нүүдлийн гол зам нь Нэмэгт уул юм. Баянзагтай адил улаан шаварлаг хурдаснуудаас тогтсон, уулархаг учир нэн сүрлэг, өвөрмөц дүр төрхтэй.

Нэмэгт уулын өвөрт олон зууны турш байгаль, цаг уурын янз бүрийн өөрчлөлт, эвдрэлд орсон их хонгилууд байх бөгөөд Ингэн хөөвөрийн хоолойн зүүн залгаа болж Алтан уулын баруун хойд, хойд биеэр зүүн хойшоо чиглэлтэй орших үзэсгэлэнтэй эдгээр хонгилыг Нэмэгтийн их хонгил гэдэг.

- ❖ **Зулганай** Гурвантэс сумын нутагт орших Зулганайн баянбүрд нь Монгол орны томоохон баянбүрдүүдийн нэг бөгөөд Алтан уулын баруун суганд, Цонжийн нурууны зүүн урд, Довонгийн нурууны урдуур урсах говь нутгийн үзэсгэлэнт горхи юм. Алтан уул, Тост уулаас буух ус нь энэхүү Зулганайн



баянбүрдийн гол ундарга болдог боловч Зулганайн гол өөрийн ундаргатай бөгөөд Талын хайрганы адаг хавьд элсэн эргээс ундарч баруун хойш чиглэн 12 км урсаад элсэн доогуур шурган 30 км урсан дахин ил гарч говь цөлийн дунд элсэн манхнаар хүрээлэгдэн орших шимт хөрс, мод, бут, сөөг, өвс ургамал жигдэрсэн баянбүрдийг үүсгэдэг. Энэхүү булаг шанд ундарсан байгалийн үзэмж төгс баянбүрдийг нутгийнхан нь “Зуун мод – Зулганай” хэмээн нэрлэдэг. Ургамлын бүрхэвчээр нэн баялаг, говьд ургадаг бүх төрлийн ургамал, тухайлбал, заг, товцог, жигд, хулс, тоорой, хайлаас, бургас, харгана, хармаг ургадаг. Голын голдиролд зэгс голлон ургадгаас гадна сухай, чихэр өвс элбэгтэй. Зулганайн голын ус бага зэрэг хужиртай ч ундны хэрэглээнд ашиглаж болдог.

Баянбүрд нь байгаль, экологийн тэнцвэртэй байдлыг хангахад ихээхэн үүрэг гүйцэтгэдэг тул Зулганайн голд цөлжилтийг бууруулах судалгааны ажлууд ихээр хийгдсэн. Зулганайн гол ихэвчлэн шөнөөр гарч урсдаг бөгөөд эл онцлогийг даган орой үдэш хар ялаа ихэсдэг. Эргэн тойрны мод, ургамал нь тэмээ далд орохуйц өндөр ургадаг ба энэ нь нарны хурц гэрэл, халуунаас хамгаалж байдаг.

❖ **Сэврэй уул** Говь Алтайн нурууны гурав дахь эгнээнд Нэмэгт уулаас зүүн тийш өргөрөгийн дагуу 60 км орчим сунаж тогтсон үзэсгэлэнтэй сайхан, тахилгат уул бөгөөд ноён оргил нь д.т.д 2632 м өндөр Хатан Сэврээ уул юм. Сэврэй уулыг эмэгтэйчүүдийг ивээдэг хэмээн нутгийнхан билэгшээдэг тул “Хатан” хэмээн өргөмжлөх болсон бөгөөд Ноён богд уул, Толь хад, Хонгорын элс, Хатан Сэврэй уулсын тухай уярам сайхан домог байдаг. "Сэврэй" гэдэг нэр нь "Сэври" гэсэн үгнээс үүсэлтэй бөгөөд Сэври уулнаас зүүн тийш залгасан, эрт үед Хатуугийн хяр гэдэг байсан Зөөлөнгийн нуруу оршдог. Эрт цагт тус нутагт махчин амьтад ихэд олширч мал, хүнд халдах болсоноос лам нар хуралдаж Ирвэс нэртэй байсан энэ уулыг араас нь уншиж Сэври, Хатуугийн хярыг Зөөлөнгийн нуруу гэдэг болсон домогтой.

❖ **Наран даац** Гурвантэс сумын нутагт, сумын төвөөс баруун хойш 96 км, аймгийн төвөөс баруун тийш 400 км зайд Тост уулын ар хоолойд орших байгалийн үзэсгэлэн төгөлдөр нутаг бөгөөд хайлаас, тоорой, сухай, Сибирь хармаг, улаан гоёо, бажууна, хулангийн ундаа, аргалийн ундаа, Максимын гялгар дэрс, ширэг бүхий баянбүрд юм. Наран даац нь энэ хавийн нутгийнхаа ундны усны гол нөөц газар болдог. Аймгийн төв болон Хонгорын элснээс баруун тийш Хэрмэн цав, Зулганай, Шаригийн ганга, Тосон бумбын нуруу, баруун хойш Баянхонгор, Говь-Алтай аймаг руу аялах алсын зайн аяллын гол түшиц газар болдог төдийгүй гадаад, дотоодын үлэг гүрвэл судлаачид, сонирхогчдын аяллын баги ирж байрладаг гол газрын нэг юм.

### ***Түүх, соёлын дурсгалт зүйлсийн нөөц***

***ГГБЦГ-т хамаарах сумдад хийгдэж байсан түүх, соёлын дурсгалт зүйлсийн судалгаа, шинжилгээний ажлууд***

Манай орны говийн бүсийн нутгаар “Эндрюсийн экспедиц” хэмээн алдаршсан “Төв Азийн судалгааны гуравдугаар анги”-ийнхан 1922 онд Гурван Сайхан-Баянзаг, 1923 онд Хаалган-Баянзаг-Таацын цагаан нуур-Бага Богд-Хаалган, 1925 онд Хаалган-

Баянзаг-Орог нуур-Их Богд-Баянзаг-Хялга-Хөх хот-Борзон гэсэн чиглэлээр тус тус аялж олон тооны палеонтологийн олдворт газар, археологийн дурсгалуудыг илрүүлэн олж, заримыг нь судалгааны эргэлтэд оруулан Монгол улсыг дэлхийн шинжлэх ухаанд таниулсан байдаг.

1960 онд археологич А.П.Окладников, Н.Сэр-Оджав нарын удирдсан Монгол-Зөвлөлтийн хамтарсан чулуун зэвсгийн үеийг судлах анги Гурван Сайханы нурууны хойд болон өмнөд талаас олон арван чулуун зэвсэг олсон байна. 1971-1972 онд Д.Дорж, А.П.Окладников нарын судлаачид Монголын дорнод ба өмнө зүгийн аймгуудын нутгаар хайгуул судалгаа явуулснаар Булган сумын нутаг Баянзаг, Зүүн, Баруун Хайрхан уул орчимд мезолитын үеийн бууц шинээр илрүүлэн, Баяндалай, Гурвантэс сумдын нутгаас олон сонирхолтой чулуун зэвсэг түүвэрлэсэн байна. 1985 онд МЗТСХЭ-ийн А.П.Деревянко, Д.Дорж нарын удирдсан чулуун зэвсэг судлалын анги Монголын өмнөд хэсгээр хуучин болон шинэ чулуун зэвсгийн суурин малтан судалж, өргөн цар хүрээтэй хайгуул хийснээр Булган, Гурвантэс сумдын нутгаас чулуун зэвсгийн баялаг цуглуулга хийж чаджээ.

Геологич Д.Гарамжав хээрийн судалгааны ажлаар явах үедээ Ханхонгор сумын нутагт Хан уулын “Ноён хороот” хэмээх газрын орчмын 9 хэсэг газраас хадны сийлмэл зураг илрүүлэн олжээ. 1987 онд судлаач Т.Санжмятав Баяндалай сумын нутаг Зүлэгтийн бичигт хадны бичээс, Сэврэй сумын нутаг Хар дэлийн бууц, Булган сумын нутаг Хадат ус зэрэг газраас хадны зураг олж, бүртгэсэн байна. Хүрмэн сумын нутаг Цагаан дэрс хэмээх газар дөрвөн буландаа өндөр чулуутай нэгэн дөрвөлжин булш малтан судалжээ.

Орон нутгийн түүх сонирхогч Т.Содной 1995 онд Гурван сайхан уулын Баруун сайханы зүүн үзүүрт “Энгэр хайрхан” уулын нэгэн элгэн хаднаас аргал янгир, буга, нум сум агссан хүнийг дүрсэлсэн сийлмэл зураг буйг тойм зураг үйлдэн товч мэдээллийг нийтэлсэн байдаг. 1995-1996 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан “Монголын чулуун зэвсгийн үе” төслийн хээрийн шинжилгээний анги Булган, Гурвантэс, Сэврэй сумдын нутгаар хайгуул, малтлага судалгаа хийсэн байна. 1996-1999 онд Г.Гонгоржав, Г.Энхбат нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний баг “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал” сэдэвчилсэн лавлах бүтээх ажлын хүрээнд ГГБЦГ-ын бүсэд Цахиуртын хөндийн чулуун зэвсгийн суурин, Сэврэй хадны зураг болон бусад дурсгалыг бүртгэж, гэрэл зураг, гар зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан байдаг.

2011 онд Оюутолгой төслөөс хэрэгжүүлсэн “Өмнөговь аймгийн соёлын өвийн хөтөлбөр боловсруулах” төслийн нэгдүгээр үе шатны ажлын хүрээнд хээрийн судалгааны баг Цогт-Овоо, Даланзадгад, Ханхонгор, Хүрмэн, Баяндалай, Булган, Сэврэй, Ноён, Гурвантэс гэсэн 9 сумын нутагт 146 дурсгалыг баримтжуулсан байна.

Өмнөговь аймгийн нутаг нь палеонтологийн олдворт газраар баялаг бөгөөд тэр талын судалгаа багагүй хийгджээ. Тухайлбал, 1920-иод онд хийгдсэн “Эндрюсийн экспедиц”-ээс хойш, 1946-1949 онд ажилласан ЗХУ-ын ШУА-ийн “Монголын палеонтологийн экспедиц”, 1963-1965, 1970, 1971 онд ажилласан “Монгол-Польшийн палеонтологийн хамтарсан экспедиц”, 1967-1990 онд ажилласан “Монгол-Зөвлөлтийн геологийн хамтарсан экспедиц”-ийн судалгаа, 1993 оноос ажилласан “Монгол Японы палеонтологийн хамтарсан экспедиц”-ийг дурдах боломжтой.

Соёлын өвийн төв, Өмнөговь аймгийн музейн мэргэжилтэн судлаачдаас бүрдсэн хээрийн шинжилгээний баг Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж,



бүртгэн баримтжуулах ажлынхаа хүрээнд 2014 оны 9 дүгээр сарын 5-аас 10 дугаар сарын 10-ыг хүртэлх хугацаанд Өмнөговь аймгийн зүүн өмнө, өмнөд, баруун талын Баян-Овоо, Номгон, Хүрмэн, Баяндалай, Ноён, Гурвантэс, Сэврэй сумын нутагт ажилласан бол 2015 онд Булган, Мандал-Овоо, Цогт-Овоо, Ханхонгор, Манлай, Ханбогд сумдын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогыг хийсэн байна. Дээрх хээрийн судалгааны ажлын хүрээнд Өмнөговь аймгийн 15 сумын нутаг дахь 258 дурсгалт газрын 2200 гаруй нэгж дурсгалыг давтан болон шинээр олж бүртгэн, тэдгээрийн 5100 орчим дижитал гэрэл зураг, 70 гаруй ширхэг негатив хальсны зураг, 10 гаруй гар зураг, 180 орчим минутын дүрс бичлэгээр баримтжуулан авсан байна.

ГБЦГ-ын бүсүүд дэх түүх, соёлын дурсгалууд, тэдгээрийн хамгаалалт

ГБЦГ дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд нь тухайн газрын аялал жуулчлалын үндсэн нөөц, хүн төрөлхтний үнэт өв юм.

Одоогийн байдлаар ГБЦГ-ын Хамгаалалтын Захиргаанаас түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаар орон нутгийн иргэдээс ярилцлагын аргаар судалгаа авч зарим түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тодорхой хэмжээгээр бүртгэлжүүлсэн байна. Тэрхүү бүртгэлжүүлэлт болон Соёлын өвийн Үндэсний төвийн мэдээллийг ашиглан ГБЦГ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хүснэгтээр нэгтгэн харуулахыг зорив (Хүснэгт 11).

ГБЦГ-ын үл хөдлөх дурсгал болох Баяндалай сумын нутаг дахь Цагаан Мааньтын Монгол бичээс нь БНМАУ-ын СНЗ-ийн 1971 оны 420-р тогтоолоор баталсан “Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын жагсаалт”-ын 2 дугаар хавсралт болох “Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалт”-д анх орсон байдаг. Улмаар Өмнөговь аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны 1978 оны 3-р сарын 2-ны өдрийн 10-р тогтоолоор баталсан “Сум, хороо, хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлсийн жагсаалт”-д Баяндалай сумын нутаг дахь Цагаан Мааньтын хадны монгол бичээс, Булган сумын Хадатын рашааны хадны тамга, Цагаан Маанийн хадны хоёр бичээс, Сэврэй сумын нутаг дахь Нарангийн адагт байгаа бичигт Цагаан чулуун хөшөө, Цагаан усны адагт байгаа боржин чулуун хөшөө, Жаргалантад байгаа боржин чулуун дээрх Маанийн бичээс, Хадан усны хадны сүг зургийг оруулсан байна.

1995-1998 онд УИХ-аас “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль”-д зарим өөрчлөлт оруулж шинээр аймаг, сум байгуулсан, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд хамгаалалтад оруулах шаардлагатай дурсгалууд шинээр илэрч олдсон зэрэг шалтгааны улмаас 1994 онд баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэх шаардлага урган гарснаар Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор “Улс аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэн баталжээ. Уг жагсаалтад ГБЦГ-ын нутаг дэвсгэрт орших үл хөдлөх дурсгалаас Улсын хамгаалалтад Булган сумын Цахиуртын хөндийд орших чулуун зэвсгийн үеийн дархны газрыг оруулсан байна. Харин аймгийн хамгаалалтад Сэврэй сумын нутаг Сэврэй уулын баруун үзүүр, Хар дэлийн бууцны дурсгалыг оруулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг сүүлийн 10 гаруй жилийн туршид шинээр илэрч олдсон олон арван дурсгалаар баяжуулан

шинэчлэн баталсан юм. Өмнөговь аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас уг жагсаалтын Улсын хамгаалалтад ГГБЦГ-ын Булган сумын Төгрөгийн ширээгийн палеонтологийн дурсгалт газар, Цахиуртын хөндийд орших Чулуун зэвсгийн үеийн дархны газар, Гурвантэс сумын Хэрмийн цэв, Цагаан хошуу, Бүгийн цав, Гурилын цав, Алтан-Уул, Нэмэгт, Ухаа толгодын палеонтологийн дурсгалт газруудыг тус тус хамруулсан байна. Харин аймгийн хамгаалалтад Гурвантэс сумын Хайчин уул, Наранбулагийн палеонтологийн дурсгалт газрууд, Баян толгой, Ш ивээт толгойн бунхант булш, Сэврэй сумын Арц богд уулын Хонгил, Үүдэн сайр, Замын хонд, Ягаан ховилын палеонтологийн дурсгалт газруудыг тус тус нэмж авчээ.

Хамгаалалтын захиргааны түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлжүүлэлтээс харвал зарим түүх, соёлын дурсгалын талбай, хэмжээ, солбицол, байршил тодорхойгүй, сумын хамгаалалттай дурсгалыг хэзээ хамгаалалтад авсан нь тодорхойгүй, хамгаалалтад авсан огноо, тогтоолын дугаар байхгүй, аль дурсгал сумын хамгаалалтад авагдсан, алийг нь одоогоор хамгаалалтад аваагүй байгаа нь ойлгомжтой бус, түүх, соёлын дурсгалын тайлбар сайтад байршаагүй, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тусгай хамгаалалттай газар нутагтай хольсон зэрэг зарим асуудлууд байна.

Тиймээс цаашид Соёлын өвийн Үндэсний төв, Өмнөговь аймгийн музейн мэргэжилтэн судлаачдаас бүрдсэн хээрийн шинжилгээний багийн судалгааны ажлын үр дүнгээс ГГБЦГ-ын дотоод бүсүүд болон орчны бүсэд хамаарах түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг ангилан ялгаж мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох түүхэн баримт мэдээллээр баяжуулах, веб сайтад энэ талын тодорхой, үнэн зөв, бодит мэдээллийг оруулах нь аялагчдад мэдээлэл сурталчилгаа болох, хүүхэд, залууст түүх, соёлын өв, дурсгалаараа бахархах сэдэл төрүүлэх, дараа дараагийн судалгааны ажлуудын суурь болох зэрэг олон талын ач холбогдолтой.

ГГБЦГ-т байрлах түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг дараах хүснэгтээр харуулав (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд

№	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамаарах зүйлс	Соёлын өвийн нэр	Хамгаалалтад авсан огноо	Солбицол	Байрлал	Хэмжээ
<i>Нэг. Улсын хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд</i>						
1	<b>Палеонтологийн дурсгалт газар</b>	Ухаа толгодын палеонтологийн дурсгалт газар	2008 оны 175-р тогтоол	х.ө 43°32'27.6" з.у 101°34'52.9"	Гурвантэс сум, Гоёот баг, Хязгаарлалтын бүсэд	Урт-50м, Өргөн-10м, S-0.05 га
2		Төгрөгийн ширээгийн палеонтологийн дурсгалт газар			Булган сумаас 22км, Дэн баг, Орчны бүсэд	
3		Хэрмэн цавын палеонтологийн дурсгалт газар		х.ө 43°27'52.3" з.у 99°50'42.1"	Гурвантэс сум, Гоёот баг, Аялал жуулчлалын бүс	S-25000га
4		Цагаан хошууны палеонтологийн дурсгалт газар			Гурвантэс сум,	
5		Бүгийн цавын палеонтологийн дурсгалт газар		х.ө 43°74'54.0" з.у 99°59'26.4"	Гурвантэс сумаас 110км, Гост баг, Аялал жуулчлалын бүс	Урт-12000м, өргөн-5000м, S-6000га
6		Гурилын цавын палеонтологийн дурсгалт газар			Гурван тэс сум, Гоёот баг	
7		Алтан уулын палеонтологийн дурсгалт газар		х.ө 43°39'4.4" з.у 100°30'42.5"	Гурвантэс сум, Гоёот баг, Орчны бүсэд	
8		Нэмэгтийн палеонтологийн дурсгалт газар		х.ө 43°40'18" з.у 100°52'35.7"	Гурвантэс сум, Гоёот баг, Хязгаарлалтын бүс	
9		<b>Чулуун зэвсгийн дурсгалт газар</b>		Цахиуртын хөндийн чулуун зэвсгийн үеийн дарханы газар	х.ө 44°11'27.9" з.у 102°49'5.8"	Булган сум, Дэн баг, ГГБЦГ-ын орчны бүсэд
<i>Хоёр. Аймгийн хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд</i>						
1	<b>Палеонтологийн дурсгалт газар</b>	Наран булаг палеонтологийн дурсгалт газар	2008.05.14 175-р тогтоол	х.ө 43°27'52.9" з.у 100°26'49.5"	Гурвантэс, Гоёот баг, Орчны бүсэд	Урт-30000м, Өргөн-20000м, S-60000 га
2		Ягаан ховил палеонтологийн дурсгалт газар	1993.05.08 481-р тогтоол	х.ө 43°53'56" з.у 101°51'29"	Сэврэй сумаас 58км, Сайншанд баг	
3		Хонгилын палеонтологийн дурсгалт газар		х.ө 43°53'56" з.у 101°51'29"	Гурван тэсээс 30км, Гоёот баг, Хязгаарлалтын бүс	

4		Замын хонд палеонтологийн дурсгалт газар		х.ө 43 <sup>0</sup> 45'03" з.у 102 <sup>0</sup> 43'21"	Сэврэй сумаас 70км, Хоолт баг	
5		Үүдэн сайр палеонтологийн дурсгалт газар		х.ө 43 <sup>0</sup> 10'45" з.у 103 <sup>0</sup> 40'20"	Сэврэй сумаас 60км, Сайншанд баг	
6		Хайчин уулын палеонтологийн дурсгалт газар	2008.05.14 175-р тогтоол	х.ө 43 <sup>0</sup> ' " з.у 99 <sup>0</sup> ' "	Гурвантэс	
7	<b>Чулуун зэвсгийн дурсгалт газар</b>	Цахиуртын хөндийн чулуун зэвсгийн дурсгалт газар		х.ө 44 <sup>0</sup> 10'13.5" з.у 102 <sup>0</sup> 52'24.7"	Булган сумаас 50км, Дэн баг, Орчны бүсэд	
8		Хар дэлийн бууцны хадны зураг	1998 оны ЗГ-ын 235-р тогтоол		Сэврэй сум	
9	<b>Хадны зураг, бичгийн дурсгал</b>	Баянзүрхийн хадны зураг		х.ө 43 <sup>0</sup> 41'48.3" з.у 103 <sup>0</sup> 24'13.9"	Баяндалай сумаас 40-өөд км, Төхөм баг	
10		Хавцгайтын хадны зураг		х.ө 43 <sup>0</sup> 54'15.4" з.у 103 <sup>0</sup> 31'20.9"	Булган сумаас 20км, Хавцгайт баг, Орчны бүс	
11		Цагаан маанийн хадны бичээс		х.ө 43 <sup>0</sup> 53'54" з.у 103 <sup>0</sup> 44'26"	Баяндалай сумаас 30 км, Төхөм баг	
12		Салхитын хадны зураг		х.ө 43 <sup>0</sup> 33'25.9" з.у 102 <sup>0</sup> 0'2.7"	Сэврэй сумаас 15км, Сайншанд баг	Урт-25м, Өргөн-20м, S-0.05га
13		Сэврэйн бичээс	1993.05.08 481-р тогтоол	х.ө 43 <sup>0</sup> 34'9.4" з.у 102 <sup>0</sup> 15'6.5"	Сэврэй сумаас 8км, Бүйлсэн баг,	
14		Сэврэйн хадны зураг		х.ө 43 <sup>0</sup> 33'48.7" з.у 102 <sup>0</sup> 1'3.6"		
15		Жаргалант хадны зураг		х.ө 43 <sup>0</sup> 08'21" з.у 103 <sup>0</sup> 21'24"	Сэврэй сумаас 45км, Бүйлсэн баг	Урт-60м, Өргөн-40м, S-0.24 га
16	<b>Булш, оршуулгын дурсгал</b>	Баян толгойн бунхант булш	2008.05.14 175-р тогтоол		Гурвантэс	
<i>Гурав. Сумын хамгаалалтад авсан болон хамгаалалтад аваагүй түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд</i>						
1	<b>Хадны зураг, бичгийн дурсгал</b>	Зүлэгтийн бичээс			Баяндалай сумаас 29 км, Төхөм баг, Орчны бүс	
2		Гурван баатарын хадны зураг			Сэврэй сумаас 13км, Сайншанд баг, Орчны бүс	

3		Сайрын усны хадны зураг			Сэврэй сумаас 15км, Сайншанд баг, Хязгаарлалтын бүс	
4		Хар толгойн хадны зураг		х.ө 43°43'7.5" з.у 103°27'6.3"	Сэврэй сумаас 13км, Сайншанд баг,Хязгаарлалтын бүс	
5		Өндөр толгойн хадны зураг, булш		х.ө 43°33'25.0" з.у 102°0'2.0"	Сэврэй сумаас 19км, Сайншанд баг, Хязгаарлалтын бүс	
6	<b>Булш, оршуулгын дурсгал, тахил, тайлгын байгууламж</b>	Адгийн уулзварын булш			Баяндалай сумаас 50км, Төхөм баг	
7		Өндөр зээгийн хиргисүүр		х.ө 43°45'17.2" з.у 103°20'16.9"	Баяндалай сумаас 37км, Төхөм баг, Орчны бүс	
8		Тойрмын дэнжийн булш			Баяндалай сумаас 32км, Баян баг, Хязгаарлалтын бүс	
9		Морин толгойн булш			Баяндалай сумаас 32км, Төхөм баг, Орчны бүс	
10		Хавцгайтын хиргисүүр		х.ө 43°44'19.9" з.у 101°21'40.4"	Баяндалай сумаас 32км, Төхөм баг, Орчны бүс	
11		Хавцгайтын хэнгэрэгийн булш, хиргисүүр			Баяндалай сумаас 41км, Төхөм баг, Орчны бүс	
12		Хар чулуутын хиргисүүр		х.ө 43°43'8.4" з.у 103°27'5.4"	Баяндалай сумаас 28км, Төхөм баг, Орчны бүс	
13		Хүрэн овооны Хөшөөт дөрвөлжингийн булш			Баяндалай сум	
14		Булагтайн хадны зураг, булш хиргисүүр		х.ө 43°53'54.0" з.у 103°44'26.0"	Булган сумаас 28км, Хавцгайт баг, Орчны бүс	
15		Гүн худагийн амны булш		х.ө 43°53'24" з.у 103°0'51.6"	Сэврэй сумаас 74км, Хоолт баг	
16	Цагаан мааньтын дурсгал		х.ө 43°35'11.4" з.у 103°10'41.8"	Баяндалай сумаас 35 км, Төхөм баг, Орчны бүс		
17	<b>Барилга, архитектурын дурсгал</b>	Гоёотын хийдийн туурь		х.ө 43°41'48.3" з.у 103°24'13.9"	Гурвантэс сумаас 40км, Гоёот баг, Хязгаарлалтын бүс	
18		Хоолтын хийдийн туурь		х.ө 43°43'17.5" з.у 102°46'26.5"	Сэврэй сум	



19		Зүүн уужмын хийдийн туурь			Гурвантэс сумаас баруун тийш 26км, Тост баг, Орчны бүс	
20	<b>Хөшөө дурсгал</b>	Хөшөө чулуу	2009.04.09 43-р тогтоол	х.ө 43°21'57" з.у 104°21'56"	Ханхонгор сумаас 59км, Жаргалант баг	Урт-500м Өргөн-500м S-25га

*Эх сурвалж: Соёлын өвийн Үндэсний төв “Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал” XII дэвтэр болон ГГБЦГ-ын авсан мэдээлэл*

### Түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын товч тайлбар

- *Ухаа толгодын палеонтологийн дурсгалт газар* Гурвантэс сумын нутаг Гоёот багт х.ө 43<sup>0</sup>30', з.у 101<sup>0</sup>32' солбицолд орших толгодыг Ухаа толгод гэдэг. Энэхүү газраас дэлхийд маш алдартай ховор олдворуудын нэг болох үр хөврөл нь хадгалагдаж үлдсэн үлэг гүрвэлийн өндгийг 1993 онд нээн илрүүлсэн байна. Энэхүү олдвор нь өндгөө дарж буй үлэг гүрвэлийн нэг төрөл болох Овираптор юм. 83 орчим сая жилийн тэртээх уг олдвор нь махчин үлэг гүрвэлийн төрөлд багтах бөгөөд өндөг нь үр хөврөлтэйгөө чулуужиж үлдсэнээрээ алдартай юм. Үүнээс хойш дахин ийм нээлт хийгдээгүй байгаа аж. Энэхүү нээлтийн талаар 1995 онд ШУА-ийн Палеонтологийн Хүрээлэнгийн ахмад эрдэмтэн, академич Д.Дашзэвэг, А.Пэрлээ нар АНУ-ын судлаачидтай хамтран тухайн олдворт газрын геологийн онцлог, түүнд хадгалагдаж байгаа олдвор цуглуулгын талаар дэлхийд нэр хүндтэй NATURE сэтгүүлд өгүүлэл бичиж хэвлүүлсэн нь олон улсад Монгол орныг таниулан сурталчилсан юм.
- *Төгрөгийн ширээгийн палеонтологийн олдворт газар* Булган сумын төвөөс баруун хойш 22 орчим км зайд Дэн багийн нутаг, ГГБЦГ-ын орчны бүсэд Төгрөгийн ширээ хэмээн нэрлэдэг урагшаа өндөр эрэглэсэн мөргөцөг байдаг. Төгрөгийн ширээг газарзүйн нэр томъёонд ихэвчлэн Улаан эрэг гэж нэрлэдэг. 2016 онд эвэрт үлэг гүрвэлийн бүтэн биеийн хэлхээ болон толгойн яс, нугасан хошуут үлэг гүрвэл болох 14.5-19.5 см хэмжээтэй зулзагын бүрэн бус хэлхээ яс олдож байсан. Төгрөгийн ширээний дурсгалт газар нь салхины үйл ажиллагаагаар үүссэн элсний хуримтлал гэж үздэг ба энд байсан эртний амьтдыг элсэнд дарагдан хадгалагдсан гэж үздэг. Энэхүү олдворт газраас олдож байсан, дэлхийн хэмжээний олдворт тооцогддог олдворууд бол ноцолдож байгаа махчин үлэг гүрвэл Велоцерантор, өвсөн тэжээлт Протоцерантос хоёр болон дөнгөж өндөгнөөсөө гарч байгаа Протоцерантосын 16 ширхэг зулзага, өндгөө дарж байгаа мэт хадгалагдсан Мононайкус зэрэг олдворууд юм. Эдгээр олдворууд нь энэхүү газрыг дэлхий алдартай болгосон.
- *Хэрмэн цавын палеонтологийн дурсгалт газар* Гурвантэс сумын Гоёот багт орших Хэрмэн цаваас эртний үлэг гүрвэл, хөхтөн, шавж, шувуу, яст мэлхий, матар, нуур усны амьтад болон олон зүйл ургамлын олдворыг нээн илрүүлсэн нь монголын говийг дэлхийд үлэг гүрвэлийн хамгийн их олдвортой, тэдгээр нь бүтэн олддог дэлхийн шинжлэх ухаанд нэн чухал газар нутаг болохыг баталсан. Анх 1969 онд академич Р.Барсболд, Л.П.Татаринов, А.Розанов нарын Монгол-Зөвлөлтийн судалгааны экспедицийнхэн Ингэн Хөөвөрийн хоолойд Хэрмэн цав, Хайчин уул зэрэг шинэ олдворт газруудыг нээсэн байна. Тэр цагаас хойш ШУА болон гадаадын палеонтологийн судалгааны экспедицүүдийг соронзон мэт татах болсноор жил бүр олон улсын хамтарсан судалгаанууд хийгдэж гайхамшигт олдворуудыг олох болжээ. Хэрмэн цаваас теризинозавр, завролож, тарбозавр, эвэрт үлэг гүрвэл, пинакозавр зэрэг үлэг гүрвэлийн яснуудыг олсон бөгөөд тэдгээр нь Монголын Палеонтологийн чухал үнэт олдворуудад тооцогддог. Цаашид ч дэлхийд алдартай палеонтологийн шинэ олдвор олдох боломжтой гэж үздэг ба одоогоор сайн судлагдаагүй байна. Чулуулгийн бүтэц, найрлага, амьтны үлдэгдлийн хувьд онгон төрхөөрөө байгаа ч хэт цөлөрхөг байдалтай.

- *Цагаан хошууны палеонтологийн дурсгалт газар* Энэхүү олдворт газар нь Нэмэгтийн нурууны баруун талд орших Наран даацын булгаас баруун тийш 7-8 км зайтай баруун хойноосоо зүүн урагш сунаж тогтсон газар юм. Энэ газарт Нэмэгтийн дурсгалт газраас олддог үлэг гүрвэлийн бүрэн бус хэлхээ яснуудтай адил яснууд олддог боловч хадгалалтын хувьд өгөршилд орсон байдалтай байдаг.
- *Бүгийн цавын палеонтологийн дурсгалт газар* Хэрмэн цаваас хойш 50 километр, Гурвантэс сумаас баруун хойш 110 орчим км зайд, Тост багийн нутагт байдаг Үлэг гүрвэлийн чулуужсан олдвороор баялаг нутаг юм. Эндээс эртний ургамал, амьтны үлдэгдлүүд, том, жижиг үлэг гүрвэлийн мөр зэрэг палеонтологийн олдворууд олддог. 70-80 сая жилийн өмнөх үлэг гүрвэлийн чулуужсан яс их олддог бөгөөд хөрсөн дээр нь ил хэвтдэг байжээ. Тэдгээр ил хэвтэх яснуудыг эвлүүлэн ямар нэгэн үлэг гүрвэлийн араг ясыг сэргээх боломжгүй ч тэртээ эрт галавын үеийн дэлхий ертөнцийг эргэн сануулах мэт гэрч болон үлджээ. Эндээс олдсон махан идэшт Тарбозаврын араг яс Байгалийн түүхийн музейд хадгалагдаж байна. Бүгийн цавыг Палеонтологийн дархан цаазат газар хэмээн нэрийддэг байсан ч сүүлийн үед цөлжилтөд өртөж элсээр хучигдаж эхэлсэн гэдэг.
- *Гурилын цавын палеонтологийн дурсгалт газар* Бүгийн цавын олдворт газраас 10-12 км зүүн тийш орших бөгөөд Алтан уулын баруун хойд доогуур зүүн хойноос баруун урагш үргэлжилсэн 1000 ам.км талбайтай нутаг юм. Хурдас чулуулаг, амьтны цогцолборын хувьд Нэмэгт, Бүгийн цавтай адил тогтоцтой. Эндээс хожуу цэрдийн үеийн нугасан хошуут үлэг гүрвэлийн яс олддог.
- *Алтан уулын палеонтологийн дурсгалт газар* Гурвантэс сумын Гоёот багийн нутаг дэвсгэр, Наран даацын булгаас чанх хойно байрлах энэ уулын өвөр хонгилууд нь үлэг гүрвэлийн олдвор бүхий нутаг болдог. Энэ уулын хурдас чулуулгийн найрлага, олддог палеонтологийн олдвор нь Нэмэгтийн дурсгалтай газартай ижил байдаг. Алтан уулын өвөр хормойд асар том хэмжээний, хоорондоо 2-3 км зайтай орших сайруу байдаг ба Оросын судлаачид энэхүү сайруудыг зүүн талаас нь эхлэн Алтан уул 1, 2, 3, 4 хэмээн нэрлэжээ. Алтан уул 1 буюу хамгийн зүүн талын сайрт 1946-1949 онд тэр районд ажиллаж Монгол орны аварга том үлэг гүрвэлийг нээсэн И.А.Ефремовоор удирдуулсан Зөвлөлтийн палеонтологийн экспедицийнхний босгосон дурсгалын хөшөө болох төмөр шон байхаас гадна “Үлэг гүрвэлийн булш” хэмээн нэрлэгдсэн нэг дор төрөл бүрийн үлэг гүрвэлүүдийг усны урсгал авчирч бөөгнүүлсэн бөөгнөрөл олдсон нь гайхамшигтай байгалийн үзмэр юм.
- *Нэмэгтийн палеонтологийн дурсгалт газар* Гурвантэс сумын Нэмэгт уулын өвөрт олон зууны турш байгаль цаг уурын янз бүрийн өөрчлөлт, эвдрэлд орсон их хонгилууд байх бөгөөд эндээс 1946 онд Оросын нэрт зохиолч, эрдэмтэн, судлаач И.А.Ефремовын удирдсан Орос-Монголын хамтарсан судалгааны анги ирж анхны, хамгийн том, дөрвөн хөлт, өвсөн тэжээлт 30 метр үлэг гүрвэлийг олж Нэмэгт уулын нэрийг оролцуулан Нэмэгтзаурус (*Nemegtosaurus*) хэмээн нэрлэжээ. Нэмэгтзаурус нь Дунд төрмөлийн эринд одоогоос 250 сая жилийн өмнө амьдарч байсан өвсөн тэжээлт Зауроподын төрөл ажээ. Энэхүү олдвороос хойш Монгол, Орос, Польшийн олон удаагийн экспедицүүд энэ орчинд ажиллаж

эртний амьтан ургамал, үлэг гүрвэлийн маш олон олдворуудыг нээн илрүүлсэн нь эдүгээ Орос, Европын болон Монголын байгалийн түүхийн музейнүүдэд хадгалагдаж байна.

- *Цахиуртын хөндийн чулуун зэвсгийн үеийн дарханы газар* Булган сумын төвөөс баруун хойш 50 орчим км зайд, Дэн багийн нутагт орших Цахиуртын хөндий хэмээх газар чулуун зэвсгийн томоохон суурин бий. Эртний хүмүүсийн чулуун зэвсгийн үеийн уг дарханы газар нь Азид бүү хэл дэлхийд дээгүүрт ордог. Энэхүү газрыг 1995 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан хээрийн судалгааны ажлын үеэр анх нээсэн. Эртний хүмүүс хөдөлмөрийн багаж зэвсгээ хийхдээ энэ хөндийн цахиурын төрлийн чулууг гол түүхий эдээ болгож байжээ. Тус суурин нь газрын хөрсөндөө хуучин чулуун зэвсгийн доод шатнаас эхлэн шинэ чулуун зэвсгийн эхэн үеийг хамарсан хэдэн зуун мянган чулуун зэвсгийн дурсгалыг агуулдаг. Цахиуртын хөндийн хурдас их зузаан биш, амьтны эрэл, хайгуул хийхэд тохиромжтой, амьтны үлдэгдэл ихтэй. Амьтны цогцолбор нь Нэмэгтгэй адил.
- *Наран булагийн палеонтологийн дурсгалт газар* Гурвантэс сумаас баруун хойш 96 орчим км зайд Гоёот багийн нутаг дэвсгэрт орших Наран даацын булагийн эргэн тойронд байх шар цав, цонжууд нь палеонтологийн ховор олдвор бүхий хэдэн арван сая жилийн өмнөх дээд цэрдийн үеийн хурдас бөгөөд өнөөг хүртэл олон төрлийн үлэг гүрвэл, эртний амьтан, ургамлын үлдэгдлүүд судлагдсаар байна. Энэ хавийн газраас Теризинозавр, Зауролоф, Тарбозавр, Эвэрт үлэг гүрвэл, Пинакозавр зэрэг үлэг гүрвэлийн яс олдсон нь Монголын палеонтологийн олдворын үнэт дурсгалд тооцогддог.
- *Хонгилын палеонтологийн дурсгалт газар* Гурвантэс сумын төвөөс хойд зүгт 30 орчим км зайд Гоёот багийн нутагт Хонгил хэмээх газар эртний ургамал, амьтны үлдэгдэл бүхий палеонтологийн олдворт газар бий.
- *Ягаан ховил, Замын хонд, Үүдэн сайрын дурсгалт газрууд* Арц Богдын район Цахиуртын хөндийд байх Алаг тээг, Авдрант, Жинст, Хонгил цав, Ягаан хонгил, Замын хонд зэрэг олдворт газрууд нь илэрцийн хувьд талбай нь жижиг бөгөөд бие биеэсээ 3-44 км-ийн зайд оршдог. Үлдэгдэл амьтдын хувьд харьцангуй ховордуухан, зузаалаг багатай газрууд юм.
- *Хайчин уулын палеонтологийн дурсгалт газар* Анх 1969 онд академич Р.Барсболд, Л.П.Татаринов, А.Розанов нарын удирдлагаар Монгол-Зөвлөлтийн палеонтологийн хамтарсан экспедиц Ингэн хөөврийн хоолой орчимд судалгаа хийж Гурвантэс сумын Хэрмэн цав, Хайчин уул зэрэг газруудыг нээн илрүүлж динозавр, хөхтөн, шавж, шувуу, яст мэлхий, матар, нуурын усны амьтан, ургамлын олон шинэ олдворуудыг олсон байдаг. Эдгээр олдворууд нь мезозойн үед амьдарч байсан хөхтөн амьтан болон сээр нуруугүйтэн амьтдын чулуужсан яс гэдэг нь нотлогдсон юм.
- *Баянзүрхийн хадны бичиг* Баяндалай сумын Төхөм багийн нутаг, Баруун сайхан уулын Баянзүрхийн овооны ард Өмнөговь аймгийн Баяндалай сумын төвөөс хойш 27 км зайд байх Баянзүрх хэмээх уулын бэлд дэлхийд хосгүй, Монголд ганцхан хадны сүг зураг байдаг. Энэхүү байгалийн ургаа хадан дээр

нарийн зураасаар бурхны шашны хүрээ хийд, түүний орчин, лам хувраг, сүсэгтэн олныг хамруулан шашны зан үйлийг зурсан хоёр хэсэг хадны зураг байх бөгөөд мөн энэ орчимд янгир зэрэг ан амьтны дүрслэл бүхий эртний хадны сийлмэл зургууд ч бий. Манай орны ихэнх хадны зургууд дайн байлдаан, ан гөрөө, мал аж ахуй, ан амьтан, амьдрал ахуйг түгээмэл зурагласан байдаг бол энэ зураг бурхан шашны сүм хийдийн зургийг маш баялаг агуулгаар зурсан байдгаараа онцлог бөгөөд өөр хаана ч одоогоор судлагдаагүй, олны хүртээл болоогүй зураг хэмээн үзэх хүмүүс байдаг. Энэхүү хадны зургийг Өмнөговь аймгийн соёлын биет өвийн тухай бүтээл туурвисан Амгалангийн Цоож олны хүртээл болгожээ.

- *Хавцгайтын хадны зураг* Булган сумын нутаг дахь “Хавцгайтын хадны зураг” нь Баян загийн сууринаас 40 км орчимд, эртний хүмүүсийн суурьшин байсан нэг цаг үед хамаарах магадлалтай юм. Гурван сайхан түүний орчны уулсыг одоогоос 400-500 сая жилийн өмнө үүссэн нэлээд залуу уулс хэмээн үздэг. Энэ хавийн чулуулгууд нь элсэн бүтэцтэй тэдгээрийн гадаргуу нь олон зууны нар салхинд түлэгдэн хар бараан мэт болсон нь ямарваа нэгэн багаж хэрэгслээр зурахад өнгөн хэсэг нь амархан элэгдэж цайвар өнгийн мөр гарна. Энэхүү мөр, өнгөнөөс нь мөн зурсан зургуудын дээгүүр нь тогтон ургасан хадны хагаас нь тухайн зургуудын нас, үеийг тогтоох боломжууд бий. Харин түлэгдсэн бараан өнгөний цаанаас гарах цайвар өнгө нь нимгэн, гүн ухагдсанаасаа шалтгаалан өөр өөр өнгөтэй байх боловч тэдгээрийн хуучирч элэгдсэн байдлаас нь нас, үеийг нь тогтоох боломжтой юм. Ер нь энэ уулын орчимд олон тооны сүг зураг байдаг хэдий ч “Хавцгайтын хадны сүг зураг” нь өөрийн илэрхийлэл, зохиомжоороо өвөрмөц содон, нэн уран дүрслэлтэй юм. Тус сүг зургийг 4000-5000 жилийн өмнө хүрэл зэвсгийн дунд болон сүүл, төмрийн эхэн үед бүтээгдсэн хэмээн үздэг.

“Хавцгайтын хадны сүг зураг”-т тус нутагт байхгүй буга, тэмээн хяруул гэж хэлэхээр том шувууны зураг /1920-иод оны дундуур Америкийн судлаач Рой Чапмэн Эндрюсийн багийн олсон эмэгтэй хүний хүзүүний зүүлт болгон хэрэглэж байсан Аварга тэмээн хяруулын өндөгний чулуужсан хальстай нэг талаар тохирч байгаа юм/, том бух гөрөөс /Бух гөрөөс, ирвэс гэхээсээ илүү бар, “Барын бүл”/ гэмээр дүрслэл зургууд хэд хэд давтагдан зурагдсан байдаг. Мөн тухайн зургуудаас тэр үеийн нэг өдрийн зураглалыг ч олж харах боломжтой гэж нутгийнхан хэлдэг бол мэргэжлийнхэн "Хадны зургийн галерей" гэдэг байна. Ерөнхийдөө энэ газар нь ан амьтан, адуу мал, шувуу, морьтнууд, гэр тэрэг, тамга тэмдэг зэрэг олон үеийн хадны зургийн баялаг дурсалтай газар болно.

- *Сэврэй бичээс* Сэврэй сумын төвөөс зүүн урд зүгт 8 км орчим зайд Бүйлсэн багийн нутагт орших Наран адаг хэмээх газарт эртний руни болон перс бичээст цагаан гантгиг чулуу байх бөгөөд судалгааны хүрээнд Сэврэй бичээс хэмээн алдаршсан байна. Одоо дээрх бичээс бүхий чулууг тойруулан хайс татаж хамгаалсан.
- *Зүлэгтийн бичээс* Баяндалай сумын төвөөс баруун хойд зүгт 29 км орчим зайд Төхөм багийн нутагт орших булаг шанд бүхий байгалийн үзэсгэлэнт газрыг нутгийн иргэд Зүлэгт хэмээн нэрлэх бөгөөд энд хадны ёроолд байрлах том хадан дээр монгол болон түвд бичгийн дурсгал бий.

- *Гурван баатарын хадны зураг* Сэврэй сумын төвөөс баруун урд зүгт 13 км орчим зайд Сайншанд багийн нутагт орших Ганжин хэмээх газарт морьтой хүн янгир авлаж буйг дүрсэлсэн хадны зураг байх бөгөөд нутгийнхан уг хадны зургийг “Гурван баатар”-ын хадны зураг хэмээн нэрлэдэг билээ.
- *Сайрын усны хадны зураг* Сэврэй сумын төвөөс баруун зүгт 15 км орчим зайд Сайншанд багийн нутагт орших Сайрын ус хэмээх газарт янгир болон хүн дүрсэлсэн хадны зураг байна.
- *Хар толгойн хадны зураг* Сэврэй сумын төвөөс баруун урд зүгт 13 км орчим зайд Сайншанд багийн нутагт орших Хар толгой хэмээх газарт янгир, адуу, хүн зэргийг дүрсэлсэн хадны зураг байдаг.
- *Өндөр толгойн хадны зураг* Сэврэй сумын төвөөс баруун урд зүгт 19 км орчим зайд Сайншанд багийн нутагт орших Өндөр толгой хэмээх газарт янгир, адуу, чоно, морьтой хүн зэргийг дүрсэлсэн хадны зургийн дурсгал бий. Мөн хүрлийн үеийн жижиг дугуй дараастай цөөн булш бий.
- *Адгийн уулзварын булш* Баяндалай сумын төвөөс баруун хойд зүгт 50 орчим км зайд, Төхөм багийн нутагт Баянцагаан хайрханы ард Адгийн уулзварын хэмээх газар, дэнж дээр дугуй хүрээтэй хиргисүүр, шоргоолжин булш зэрэг олон тооны булш оршуулга бүхий цогцолбор дурсгал байна.
- *Өндөр зээгийн хиргисүүр* Баяндалай сумын төвөөс баруун хойд зүгт 37 км орчим зайд Төхөм багийн нутагт дахь уулын шувтарга үзүүрийг нутгийн иргэд Өндөр зээг хэмээн нэрлэх бөгөөд энд дагуул тахилын байгууламж бүхий дугуй хүрээтэй хоёр хиргисүүр байна.
- *Тойрмын дэнжийн булш* Баяндалай сумын төвөөс зүүн хойд зүгт 32 км орчим зайд Баян багийн нутагт дахь Тойрмын дэнж хэмээх газарт орших орчин цагийн оршуулгын газрын зүүн талд 25 м урттай нэлээд томд тооцогдох нэг шоргоолжин булш байна. Мөн уг булшны эргэн тойронд дугуй дараастай хэдэн булш бий.
- *Морин толгойн булш* Баяндалай сумын төвөөс баруун хойд зүгт 32 км орчим зайд Төхөм багийн нутагт багахан судгийн зүүн талд орших Морин толгой хэмээх газарт хүрлийн үеийн дугуй дараастай булш болон дөрвөлжин булш, шоргоолжин булш байдаг.
- *Хавцгайтын хиргисүүр* Баяндалай сумын төвөөс баруун хойд зүгт 32 км орчим зайд Төхөм багийн нутагт орших Хавцгайтын эх хэмээх газарт дугуй хүрээтэй, голдоо овоолго чулуун дараастай нэг хиргисүүр байх бөгөөд уг хиргисүүрийн гадуур дагуул цагариган байгууламж бий.
- *Хавцгайтын хэнгэрэгийн булш, хиргисүүр* Баяндалай сумын төвөөс баруун хойд зүгт 41 км орчим зайд Төхөм багийн нутагт орших Хавцгайтын хэнгэрэг хэмээх газар дугуй хүрээтэй, баруун талаараа тахилын байгууламжтай, голдоо овоолго чулуун дараас бүхий нэг хиргисүүр байх ба уг хиргисүүрээс баруун тийш 500 м орчим зайд нэг тоногдсон шоргоолжин булш байна.
- *Хар чулуутын хиргисүүр* Баяндалай сумын төвөөс баруун хойд зүгт 28 км орчим зайд Төхөм багийн нутагт орших Хар чулуут хэмээх газарт, авто машины замын дэргэд дугуй хүрээтэй, хүрээний гадуур дагуул цагариган байгууламж бүхий хоёр хиргисүүр бий.



- *Хүрэн овооны Хөшөөт дөрвөлжингийн булш*
- *Булагтайн хадны зураг, булш, хиргисүүр* Булган сумын төвөөс зүүн өмнө зүгт 28 орчим км зайд Хавцгайт багийн нутагт Булагтай хэмээх багахан хадтай толгойд янгир, тэмээ, адуу зэргийг дүрсэлсэн хадны сийлмэл зураг байна. Мөн тус толгойн өмнөх талд нэг хиргисүүр байх бөгөөд түүний дэргэд хэд хэдэн дөрвөлжин булш байна.
- *Гүн худагийн амны булш* Сэврэй сумын төвөөс зүүн хойд зүгт 74 км орчим зайд Хоолт багийн нутагт орш их Гүн худагийн аманд том хэмжээний нэг шоргоолжин булш байдаг.
- *Цагаан мааньтын дурсгал* Баяндалай сумын төвөөс баруун хойд зүгт 35 км орчим зайд Төхөм багийн нутагт орших Цагаан мааньт хэмээх газарт дөрвөлжин хэлбэрийн шороон далантай, голдоо шорон далантай 2 дурсгал бий.
- *Гоёотын хийдийн туурь* Гурвантэс сумын төвөөс зүүн хойд зүгт 40 орчим км зайд Гоёот багийн нутагт Шар хад хэмээх газар нэгэн хийдийн туурь байх бөгөөд нутгийн иргэд Гоёотын хийд хэмээн нэрлэдэг байна. Тус хийдийн ихэнх барилга байшин нураад зарим нэг дуганы хана туурга үлдэж хоцорчээ.
- *Хоолтын хийдийн туурь* Сэврэй сумын төвөөс зүүн хойд зүгт 68 км орчим зайд Хоолт багийн нутагт орших Хоолт хэмээх газарт хийдийн туурь байх бөгөөд уг дурсгалт газрыг нутгийнхан Хоолтын хийдийн туурь хэмээн нэрлэдэг ажээ.
- *Зүүн уужмын хийдийн туурь* Гурвантэс сумын төвөөс баруун зүгт 26 км орчим зайд Тост багийн нутагт орших Зүүн уужим хэмээх газарт нэгэн хийдийн туурь байх бөгөөд уг туурийг нутгийн иргэд Зүүн уужмын хийдийн туурь хэмээн нэрлэх ажээ.

Дээрх улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудаас гадна ГГБЦГ-ын бүртгэлжүүлээгүй, одоогоор ямар нэг хамгаалалтад аваагүй байгаа зарим дурсгалууд байна. Үүнд:

- *Тамгатын хадны зураг* Гурвантэс сумын төвөөс зүүн хойд зүгт 55 орчим км Гоёот багийн нутагт Тамгат хэмээх газар худгийн арын болон зүүн талын хаданд соотон чихтэй, бүдүүн хүзүүтэй адуу, янгир, тэмээ, нохой, мөөг хэлбэртэй малгайтай бүрэн зэвсэглэсэн дайчид зэрэг аялаг сэдэвтэй хадны сийлмэл зургийн дурсгал бий.
- *Шар хошууны хадны зураг* Сэврэй сумын төвөөс зүүн хойд зүгт 53 км орчим зайд Хоолт багийн нутагт орших Шар хошуу хэмээх газарт янгирын дүрслэлтэй хадны зургууд байдаг.
- *Эрээн адууны хиргисүүр* Сэврэй сумын төвөөс зүүн хойд зүгт 63 км орчим зайд Хоолт багийн нутагт орших Эрээн адуу хэмээх газарт дугуй хүрээтэй, дагуул цагариган байгууламжтай нэг хиргисүүр байх бөгөөд уг хиргисүүрийн голын овгор чулуун дараас нь тоногдсоны улмаас анхны зохион байгуулалтаа алджээ.
- *Баруун булгийн адаг Шар хороотын хадны зураг* Ханхонгор сумын төвөөс өмнө зүгт 65 орчим км зайд Жаргалант багийн нутагт Баруун булагийн адаг шар хороотын хэмээн газар хадан цохионд янгир, буга, тэрэг, хүн болон хэд хэдэн тамга тэмдэг зэргийг дүрсэлсэн хадны сийлмэл зураг зургийн дурсгал

байна. Энэхүү дурсгал нь ГГБЦГ-ын орчны бүсийн хамгийн зүүн захын хэсэгт хамаарах боломжтой.

- Адуун чулууны хиргисүүр (Хамгаалалтын захиргааны мэдээлэл)
- Эхэн хавцгайтын хиргисүүр (Хамгаалалтын захиргааны мэдээлэл)
- Заламтын хиргисүүр (Хамгаалалтын захиргааны мэдээлэл)
- Баруун бөөрийн хиргисүүр (Хамгаалалтын захиргааны мэдээлэл)
- Хөвийн хиргисүүр (Хамгаалалтын захиргааны мэдээлэл)
- Гэгээтийн амны хиргисүүр (Хамгаалалтын захиргааны мэдээлэл)
- Сэврэй сумын Дулаан бүлээний хиргисүүр (Хамгаалалтын захиргааны мэдээлэл)
- Тоосготын хиргисүүр

Энэхүү судалгаагаар ГГБЦГ-т улсын хамгаалалтад авсан 9, аймгийн хамгаалалтад авсан 16, сумын хамгаалалтад авсан 20, хамгаалалтад авсан эсэх нь тодорхойгүй 12, нийт 57 түүх,соёлын үл хөдлөх дурсгалыг тодорхойлов. Улс болон аймгийн хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын мэдээллийг Соёлын өвийн Үндэсний төвийн веб сайт, сумын хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын мэдээллийг ГГБЦГ-ын тайлан мэдээнээс авч нэгтгэсэн (График 10). Сумын хамгаалалтад авсан гэх дурсгалуудыг хэзээ хамгаалалтад авсан нь тодорхойгүй байна.



График 10. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалт

Одоогоор тодорхой байгаа дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг төрлөөр нь авч үзвэл булш хиргисүүр, болон эртний амьтан, ургамлын олдворт газрууд, хадны зураг, бичээс дийлэнх байна (График 11).



График 11. ГГБЦГ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрлүүд

ГГБЦГ-аас олдсон ховор эрдэс, эрдэнийн чулууны олдвор, ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл, эртний ургамал, амьтны олдвор, археологийн олдвор, угсаатны хувцас, чимэглэл, уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг, угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл, уламжлалт тоглоом, наадгай, уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл, бичгийн дурсгалт зүйлс гэх мэт түүх, соёлын хөдлөх дурсгалууд нь гадаад улс орнуудын болон дотоодын Байгалийн түүхийн музей, Үндэсний музей, Өмнөговь аймгийн музей зэрэг улс, орон нутгийн чанартай музейнүүд болон зарим иргэдэд хадгалагдаж байна.

Өмнөговь нутгийн ард түмний билэг авьяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, зан үйл, ёс заншил, ур хийц, ардын урлаг, баяр ёслол, иргэдийн дунд ам дамжиж ирсэн домог, хууч яриа зэрэг биет бус соёлын өвүүдийг тээгч иргэд ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт цөөнгүй байдаг.

Говь нутгийн зон олон эрт үеэс эхлэн эх болсон байгаль дэлхий, уул, усаа дээдлэн биширч, онголон тахиж домог зохиож амнаас ам дамжин хойч үедээ өвлүүлэн үлдээдэг байжээ. Цогцолборт газрын хэмжээнд байх байгалийн өвөрмөц, үзэсгэлэнт газруудын ихэнх нь ард түмний дунд уламжлагдан, ам дамжин яригдаж ирсэн өөрсдийн түүх домогтой бөгөөд тэдгээрийг нэгтгэн үзвэл дараах байдалтай байна (Хүснэгт 16).

*Хүснэгт 16. ГГБЦГ дахь түүх, домог бүхий газрууд*

№	Домогт газрууд	Домгийн агуулга	Байршил		
			Гурвансайхан уул орчим	Хонгорын элс орчим	Хэрмэн цав, Нэмэгт орчим
1.	Гурван сайхан уул	Үнэнч хайрыг магтан дуулсан	+		
2.	Ёл, Охин хөтөл	Үнэнч хайрыг магтан дуулсан	+		
3.	Хэрмэн зам	Хүүхэд хүмүүжүүлэх уламжлалт арга ухаан			+
4.	Алтан уул	Байгаль дэлхийгээ хайрлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх			+
5.	Ноён, Сэврэй уулс	Хүүхэд хүмүүжүүлэх уламжлалт арга ухаан		+	
6.	Хонгорын элс	Үнэнч хайрыг магтан дуулсан		+	

### ***Үйл явдал, эвентүүд***

Аливаа арга хэмжээ, үйл явдал нь аялал жуулчлалын гол үзмэр болоод зогсохгүй аяллын бие даасан төрөл ч болох явдал байдаг. Эвент аялал жуулчлал буюу үйл явдлын аялал жуулчлал нь Монголын аялал жуулчлалын салбарт тун хурдацтай хөгжиж байгаа төрөл юм.

Булган сумын төвд Ханхонгор сумын нутаг Ёлын аманд жил бүрийн 5 дугаар сарын 3 дахь долоо хоногийн бямба гаригт “Сарлагийн баяр” арга хэмжээ, Сэврэй сумын нутагт Хонгорын элс орчимд жил бүрийн 8 дугаар сарын 15-нд “Хонгор их хурд” зэрэг арга хэмжээнүүд ГГБЦГ-т тогтмол зохион байгуулагддаг. Түүнчлэн 2017 оноос эхлэн

“Элсэн манхны баяр” арга хэмжээг Сэврэй сумын Хонгорын элсэнд 9 дүгээр сарын 2 дахь долоо хоногийн бямба, ням гаригуудад зохион байгуулж байна.

1) Сарлагийн баяр эвент

Говь нутагт аялал жуулчлалыг өргөжүүлэн хөгжүүлэх, сарлагтай холбоотой төрөл бүрийн уралдаан тэмцээнийг оруулж аялал жуулчлалын салбар дахь эвент арга хэмжээг сурталчлан таниулж, гадаад, дотоодын аялагч жуулчдыг татах, уламжлалт мал аж ахуй, сарлаг сүрэг устаж үгүй болохоос хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэн өсгөж үржүүлэх, сарлаг үржүүлэгчдийг дэмжин урамшуулах, сарлагийн ашиг шим, тэдгээрийн бүтээгдэхүүнийг нийтэд сурталчлан таниулах замаар сарлагийн амьдын үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор уг эвентийг зохион байгуулдаг.

2) Хонгорын их хурд

Хонгорын элс орчмын 4 жуулчны баазууд хамтран жил жилээр 1 бааз нь ерөнхий зохион байгуулагчаар арга хэмжээ зохион байгуулдаг. Энэхүү арга хэмжээг гадаадын жуулчид мэддэг болж жилээс жилд ирэх жуулчдын тоо нэмэгдсэн судалгаатай байдаг.

3) Элсэн манхны баяр

Энэхүү эвент нь Монгол Улс, Өмнөговь аймгийн есөн гайхамшгийн нэг, Хонгорын элс түүний орчныг дотоод, гадаад ертөнцөд таниулан сурталчлах, Монголын говийн аялал жуулчлалын хугацааг уртасган, хил дамнасан болон гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Өмнөговь аймгийн Засаг даргын “Аялал жуулчлал - Өрхийн орлого” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аялал жуулчлалын шинэ бренд бүтээгдэхүүн, эвентийг бий болгох зорилготой.

ГГБЦГ-ын бүсүүдэд зохион байгуулагддаг аялал жуулчлалын эвентүүдийн онцлог, оролцогчдын талаар дараах хүснэгтэд үзүүлэв (Хүснэгт 17).

Хүснэгт 17. ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт зохион байгуулагддаг эвентүүд

Д /д	Эвентийн нэр	Арга хэмжээ, номинаци	Хаана болох газар, сум	Зохион байгуулах газар	Анх байгуулагдсан он	Улс, аймгаас олгодог төсөв	Хураамж	Ирсэн зочид аялагчид
1	“Сарлагийн баяр”	1. Буухиа тэмцээн 2. Шилмэл сарлаг шалгаруулах үйл ажиллагаа 3. Сарлаг унаж уралдах тэмцээн	Ханхонгор сум Гурван сайханы уулын “Ёлын ам”	Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, БОАЖГазар, биеийн тамир спортын газар	2011	Орон нутаг-6-8 сая		/2018 он Гад- 40 гаруй Дот-1200 гаруй, 2019 он гад-25, дотоод-2200 гаруй /
2	“Хонгор их хурд”	1. Хурдан морь уралдуулах 2. Хүчид бөх барилдах	Сэврэй сумын Хонгорын элс “Дов”	Жуулчин говь-2, Говь дисковери-2, Говийн анар, Говь Эрдэнэ, Бүрэн жуулчны баазууд				2018 он Гад-529 Дот-216
3	“Элсэн манхны баяр”	1. Марафон гүйлт 2. Элсний оргил булаалдах тэмцээн 3. Элсний сумо 4. Элсний волейвол 5. Автомашины уралдаан, мото уралдаан, мото спортын үзүүлэх тоглолтууд 6. "Алтан элс" үдшийн шоу болон говь нутгийн онцлогийг харуулсан олон талт арга хэмжээ	Сэврэй сумын Хонгорын элс, “Дуут манхан	Аймгийн Засаг даргын тамгын газар, БОАЖГазар, ГГБЦГХЗахиргаа, Биеийн тамир спортын газар, Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо	2017	Улс- 5 сая, орон нутаг- 25-28 сая		2018 он /Гад-130 гаруй Дот-1250 гаруй, 2019 он гад 70, дотоод-2400



**Аялал жуулчлалын үйлчилгээний дэд бүтэц, байгууллагууд**

Өнөөгийн байдлаар ГГБЦГ-ын бүсүүдэд 16 жуулчны бааз үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 9 нь орчны бүсэд, 7 нь дотоод бүсүүдэд байрлан аялагч, жуулчдад үйлчилгээ үзүүлж байна (Хүснэгт 18).

*Хүснэгт 18. ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазууд*


№	Компаний нэр	Жуулчны баазын нэр	Хүчин чадал			Байрлал	
			Гэр, байшин тоо	Орны тоо	Рестораны хүчин чадал	Газрын нэр	Солбицол
1.	"Дойдо" ХХК	Бүрэн	25	70	70	Сэврэй сум, Сайншанд баг, Хонгорын гол, Жуулчин говь-2-ын хойно	х.ө 43 <sup>0</sup> 48'12.82" з.у 102 <sup>0</sup> 16'2.32"
2.	"Олгүүд" ХХК	Говь-Эрдэнэ	Б-24 Г-31	48 70	100	Сэврэй сум, Сайншанд баг, Хонгорын гол, Хөтөл дов	х.ө 43 <sup>0</sup> 49'18.9" з.у 102 <sup>0</sup> 19'53.8"
3.	"Алтан тур" ХХК элс	Дүнгэнээ	Г-50	110	50	Ханхонгор сум, Мандах баг, Эрдэнэтолгойн өвөр	х.ө 43 <sup>0</sup> 33'23.4" з.у 104 <sup>0</sup> 08'00.7"
4.	"Говь дисковери тур" ХХК	Говь дисковери-2	Г-43	130	100	Хонгорын элс	х.ө 43 <sup>0</sup> 46'27.7" з.у 102 <sup>0</sup> 20'23.5"
5.	"Говийн Анар" ХХК	Говийн Анар	Г-35	100	100	Сэврэй сум, Сайншанд баг, Хонгорын гол, Хар эрэг	х.ө 43 <sup>0</sup> 49'26.5" з.у 102 <sup>0</sup> 23'28.9"
6.	"Жуулчин говь" ХК	Жуулчин говь-2	Г-25	80	50	Сэврэй сум, Сайншанд баг, Хонгорын гол, Дуут манханы баруун урд талд	х.ө 43 <sup>0</sup> 47' 51.94" з.у 102 <sup>0</sup> 16'16.31"
7.	"Говьсайхан Арвижих" ХХК	Говийн Өргөө	Г-35	160	300	Баяндалай сум, Баян баг, Оюутын хойд дэнж	х.ө 43 <sup>0</sup> 33'28.668" з.у 104 <sup>0</sup> 02'04.384"

Дээрх баазууд нь тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсүүдэд байрлан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд харин орчны бүсэд Говь мираж, Ханбогд, Сайжрах, Гүег хаан, Говийн 3 тэмээ, Түвшин наран, Говийн наран, Говь Дисковери-1, Жуулчин говь-1, Зүүдний говь, Монгол говь, Говь тур, Баянбүрд-1, Баянбүрд-2, Баянзаг, Говь номадик лоунж зэрэг 16 жуулчны бааз үйл ажиллагаагаа явуулдаг.

Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 59 зочид буудал /гэст хаус/ үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Хонгорын гол орчимд 20 гэр буудал байрлан, нийт 22.8 га талбайд үйл ажиллагаа явуулж байна (Зураг 14). Ёлын аманд зөвшөөрөлгүй 10 гэр буудал нийт 6.3 га газарт үйл ажиллагаа явуулдаг (Зураг 15). Мөн Ёлын аманд 6 гэр шоп буюу дэлгүүр 0.37 га талбайд үйл ажиллагаа явуулж байна (Зураг 16).



Зураг 14. Хонгорын гол дахь гэр буудлуудын байршил



Зураг 15. Ёлын аманд үйл ажиллагаа явуулж буй зөвшөөрөлгүй гэр буудлууд



Зураг 16. Ёлын аманд үйл ажиллагаа явуулж буй гэр шопууд

Экологийн боловсрол олгох мэдээлэл сургалтын төвийг Хонгорын элс орчимд 2013 онд байгуулсан боловч дотоод тохижилт хийгдээгүйгээс одоогоор хяналтын постоор сурталчилгааны ажлыг явуулж байна .

## 2.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДААЦЫГ ТОГТООХ АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, СУДАЛГААНД АШИГЛАСАН ТАЙЛАН, МЭДЭЭ

### 2.2.1. Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ хийсэн арга зүй

Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээг байгаль хамгаалах арга хэмжээг зардал багатай хэрэгжүүлэх ерөнхий арга гэж үздэг. Амьдрах орчны экологийн бүрэн бүтэн байдал буюу түүхэн эсвэл байгалийн нөхцөл байдлаас хэрхэн өөрчлөгдсөнийг илэрхийлэх шууд бус хэмжүүр нь хүний үйл ажиллагааны хуримтлагдах нөлөөлөл юм. Мэдээллийн олдоц дээр тулгуурлан одоогийн хүний үйл ажиллагааны нөлөөллийн хэлбэр, эх үүсвэрийг ГМС дээр тооцоолох замаар нөлөөллийн индексийг боловсрууллаа. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь хүний үйл ажиллагааны нөлөөллийн сонгон авсан хүчин зүйл бүрээр тооцохдоо урьд өмнө нь нөлөөллийн үнэлгээний чиглэлээр хийгдэж байсан Увс нуурын ай савын дархан цаазат газруудын аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа (ТХГН-ийн Судалгааны Төв, 2018), Дарьгангын БЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа (ТХГН-ийн Судалгааны Төв, 2018) зэрэг судалгааны эх сурвалж материал дээр үндэслэсэн.

*Авто замын сүлжээний нягтрал, түүний нөлөөлөл* Авто зам нь зэрлэг амьтны амьдрах орчин, амьдралын хэв маягт олон хэлбэрээр сөрөг үр нөлөө үзүүлдэг

(Trombulak and Frissell 2000). Монгол орны ихэнх зам нь шороон бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг. Зарим замыг бусдаас илүү эрчимтэй ашигладаг тул хэд хэдэн замыг ачаалал ихтэй зам гэж тодорхойлсон. Ачаалал ихтэй зам гэсэн ангилалд улсын чанартай авто зам болон төмөр замыг хамруулж 0.5 км-ийн алслалттайгаар 2.0 км-ээр, ачаалал багатай байнга өөрчлөгдөж байдаг шороон замыг 0.25 км-ийн алслалттайгаар 1.0 км-ээр тооцож зурагласан.

**Аялал жуулчлалын баазын нягтрал, түүний нөлөөлөл** Аялал жуулчлалын баазуудын нөлөөллийг үнэлэхэд 0.5 км-ийн алслалттайгаар 2.0 км-ээр тооцож зурагласан.

**Бэлчээр ашиглалтын нөлөөлөл** Малын бэлчээр ашиглалт нь ургамлын зүйлийн бүрдэл (Fernandez-Gimenez and Allen-Diaz 2001) болон зэрлэг амьтны амьдрах орчны хэвийн нөхцөл, чанарт нөлөөлдөг. Мал зэрэгцэн оршиж буй зэрлэг амьтантай өрсөлдөж тэднийг амьдрах орчноос нь шахаж (Wingard et al. 2011, Yoshihara et al. 2008, Campos-Arceiz et al. 2004), эсвэл зэрлэг амьтны сорчлон иддэг ургамлын зүйлийн тоог бууруулах зэргээр нөлөөлдөг (Gana Wingard хэвлүүлээгүй мэдээ). Olson нар (2011)-ын судалгаагаар цагаан зээр нь малчин айл орчмын газар нутгаас зайлсхийх ба хот айлын бөөгнөрөл нь зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулж, идээшил бэлчээртээ хүрэх боломжийг хязгаарладаг нь тогтоогджээ.

Малчин өрхийн бэлчээр ашиглалтын байршлын нөлөөллийг тооцохын тулд өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны байршлын цэгэн мэдээллийг ашигладаг. Малын бэлчээрийн орон зайн бүсчлэлийг тооцохдоо ArcGis 10.3 Spatial Analyse-ийг ашигласан ба өвөл, хаврын улиралд 2-4 км, зун намрын улиралд 4-6 км радиуст бэлчээрлэдэг гэсэн судлаачдын судалгааны үр дүнд үндэслэн бэлчээрт ашиглагдаж буй газрыг тооцон гаргасан. Нөлөөллийн түвшнийг үнэлэхдээ нөлөөллийг илтгэсэн тэгшитгэлийг Systat программ дээр хүчин зүйлийн анализын аргаар тооцон гаргасан болно.

**Хүний үйл ажиллагааны хүчин зүйлсийн нэгдсэн үнэлгээ.** Хүний үйл ажиллагааны нөлөөлөл нь өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн үйл ажиллагааны хэлхээ, хүрээлэн буй орчинд өөрчлөлт үзүүлж байдаг. Хүний үйл ажиллагааны нөлөөллийг ердийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтооход бэрхшээлтэй. Хүний үйл ажиллагааны нөлөөллийг олон улсад хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ гэж нэрлэдэг. Ихэнхдээ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хуримтлагдах нөлөөллийг огт дурдаагүй эсвэл цухас авч үзсэн байдаг (Cantor & Ross 2010). Зарим байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хуримтлагдах нөлөөний талаар хэт ерөнхий зүйл оруулсан байдаг ба орон зай, цаг хугацааны хувьд нарийвчлан тодорхойлолгүй орхисон байх нь түгээмэл (Burtis & Cantor) хуримтлагдах нөлөөллийг ландшафтын түвшинд авч үзэх нь илүү зохистой (Joao 2010).

Энэ судалгаагаар ГМС-ийн мэдээллийг ашиглан хүний үйл ажиллагааны нөлөөллийг замын нягтрал, малчин өрхүүдийн бэлчээр ашиглалт гэсэн 2 хүчин зүйлээр тооцож нэгдсэн үнэлгээ гаргаж нөлөөллийг маш бага, бага, дунд зэрэг, хүчтэй, маш хүчтэй гэсэн 5 ангиллаар ялгаж үнэлсэн.



## 2.2.2. Байгалийн ландшафтын эрсдэлийн үнэлгээ хийсэн арга зүй

Ландшафтын эрсдэлийн үнэлгээ нь экологийн зохистой бүсчлэл тогтоох үндэслэл болдог. Ландшафтын эрсдэлийг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтээр дараах үзүүлэлтүүдийг сонгон авч болдог (Хүснэгт 19). Үүнд:

- Гадаргын налуу
- Хөрсний механик бүрэлдэхүүн
- Хөрсний элэгдлийн хэв шинж
- Ургамлын бүрхэвч

*Хүснэгт 19. Ландшафтын эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт*

№	Шалгуур үзүүлэлтүүд	Үнэлгээ зэрэглэл				
		Маш бага	Бага	Дунд	Хүчтэй	Маш хүчтэй
1.	Гадаргуугийн налуу /градусаар /	<3 <sup>0</sup>	3-5 <sup>0</sup>	5-8 <sup>0</sup>	8-15 <sup>0</sup>	>15 <sup>0</sup>
2.	Хөрсний механик бүрэлдэхүүн	Хүнд шавранцар	Дунд шавранцар	Хөнгөн шавранцар	Элсэнцэр	Элс
3.	Гадаргын элсэн бүрхэвч (%-иар)	0	0-20	20-40	40-60	>60
4.	Ургамлын бүрхэвч	>45	35-45	25-35	15-25	<10

Шалгуур үзүүлэлт тус бүрээр сэдэвчилсэн давхарга үүсгэж, үүсгэсэн давхруудыг давхцуулах замаар ландшафтын эрсдэлийн нэгдсэн үнэлгээг 5 шатлалтай ангиллаар үнэлж, зурагласан.

Аялал жуулчлалын байгалийн даацыг тогтооход харгалзах үндсэн параметр бол байгалийн ландшафтын эрсдэлийн үнэлгээ юм. Энэхүү асуудлын үндэс нь аялал жуулчлалын нөлөөллийг байгалийн цогцолборуудын экологийн ачааллын дээд хязгаар, байгалийн нөхөн сэргэх чадавхаас давахгүйгээр тогтооход оршино. Тиймээс БЦГ-ын аялал жуулчлалын даацыг тогтооход ландшафтын эрсдэлийн үнэлгээ чухал ач холбогдолтой.

**Гадаргын налуу** – Аялал жуулчлал хөгжүүлэхэд гадаргын налуу чухал үүрэгтэй. Судалгаагаар 2-6<sup>0</sup> налуутай нутаг дэвсгэрийн ургамлын нөмрөгийн талхагдлын хурдац харьцангуй бага, 6-12<sup>0</sup> болоход харьцангуй өндөр болдог, нутаг дэвсгэрийн налуугийн байдал 12<sup>0</sup> -аас дээш болоход талхагдал хэт хурдан явагдах тул 12<sup>0</sup>-аас дээш налуутай нөхцөлд рекреацийн үйл ажиллагааг хязгаарлах шаардлагатай болдгийг тогтоосон байна (Marsz.1972). Дэлхийн жуулчны байгууллагын санал асуултаар 10<sup>0</sup> буюу түүнээс дээш налуутай зам аялагчдын эрүүл мэнд, аялах хурдад нөлөөлж байдгийг тогтоожээ.

Гадаргын налуугийн шатлалыг боловсруулахдаа:

- Талархаг байдал;
- Уулархаг байдал;
- Аялал жуулчлал хөгжүүлэх хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан, гадаргын налуу тооцох шалгуур үзүүлэлтүүдийг үндэс болгож 20<sup>0</sup>-аас их, 12<sup>0</sup>-20<sup>0</sup>, 6<sup>0</sup>-12<sup>0</sup>, 3<sup>0</sup>-6<sup>0</sup>, 3-аас бага налуу гэж үндсэнд нь 5 ангиллыг гаргасан (Хүснэгт 20)

*Хүснэгт 20. Аялал жуулчлалд гадаргын налуу харгалзах үзүүлэлтүүд*

Налуу	Үйл явц	Аялал жуулчлал хөгжүүлэх боломж
-------	---------	---------------------------------



<b>3<sup>0</sup>-аас бага</b>	Тэгш тал ба харьцангуй талархаг, нам доор газрууд хамарна.	Нэн тохиромжтой
<b>3-6<sup>0</sup></b>	Уулсын хоорондох хөндий, голын дэнж, татам зэрэг харьцангуй талархаг газрыг хамарна. Ийм хэвгий гадарга бага зэргийн налуу гадаргад тооцогдоно.	Тохиромжтой
<b>6-12<sup>0</sup></b>	Аялал жуулчлал хөгжүүлж болох боловч ажлын бүтээмж 10-15%-иар буурдаг.	Дунд зэргийн тохиромжтой
<b>12-20<sup>0</sup></b>	Уулархаг нутгаар нэлээд тохиолдох бөгөөд ихээхэн дунд хэрчигдэж бартаатай болсон байдаг. Ийм хэвгий гадарга ашиглах шаардлагатай бол эвдрэлээс хамгаалах нэмэлт байгууламж барих хэрэгтэй.	Тохиромжгүй
<b>20<sup>0</sup>- дээш</b>	Гадаргын байдал ихээхэн хэрчигдэж бартаа ихтэй тул зөвхөн морин аялалд тогтоосон замналын дагуу явагдана.	Нэн тохиромжгүй

**Хөрсөн бүрхэвч** Аялал жуулчлал хөгжүүлэхэд хотгор гүдгэрийн хэв шинж, гадаргын бартаа, хэрчигдэл зэргээс гадна аялал жуулчлалд шууд нөлөө бүхий хөрсний бүрэлдэхүүн, үржил шимт гадаргын морфометр шинж, зүсэлтийн хэлбэр зэрэг онцгой үүрэгтэй байдаг. Түүнчлэн хөрсний хэв шинж, түүний бүтэц бүрэлдэхүүн чухал ач холбогдолтой ба хөрсний чанарын үнэлгээ хэдий чинээ сайн байх тусам рекреацийн даац төдий чинээ сайн байна.

Аялал жуулчлалын нөлөөгөөр хөрс элэгдэж эвдрэн хөрсний үржил шимт чанар алдагдан ургамал ургахгүй, амьд организмын амьдрах орчин өөрчлөгдөж улмаар экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ. Амьд бие организмын амьдрах орчин, ургамлын нөмрөг үүсэж бүрэлдэх суурь нь хөрс учраас рекреацийн даацад хөрсний чанарын үзүүлэлт чухал ач холбогдолтой. Хүний үйл ажиллагаанд удаан хугацаанд ашиглагдсан, эсвэл уур амьсгалын хуурайшилтын нөлөөгөөр органик нь эрдэсэжсэнээр хөрсний үржил шим буурдаг. Рекреацийн даацад хамгийн өртөмтгий эмзэг зүйл бол хөрс, ургамлын бүрхэвч юм. Судалгаагаар хүн зогсож байхдаа газрын гадарга дээр 200 г/см<sup>2</sup> дарамт үүсгэж байдаг бол явж байхдаа 47 кг/см<sup>2</sup> хүртэл дарамтыг үүсгэдэг болохыг тогтоосон байдаг. Гаднаас нь харахад хөрсний эвдрэл нь сүүлчийн шатанд орсны дараа буюу ургамлан бүрхэвч үгүй болж, рекреацийн алдрал бий болсон үед л мэдэгддэг. Хөрсний жижиг хэсгүүдийн хооронд хуурайшил ихэссэн хэсэгт элжилт үүсэн чөлөөтэй шилжиж байдаг. Чийгшил онцгой ихэссэн үед дээд давхарга намагжина. Гишгэлт даралтын дараа хөрсний дээд давхарга нягтарч (10–15 см), түүний нөлөө бүх хэсэгт нь усан хангамж болон тэжээлийн бодисын агууламжид нөлөөлдөг.

Нутаг дэвсгэрийн экологийн байдал болон түүнд үзүүлж буй гаднын нөлөөллийн зэрэглэлийг тодорхойлж байдаг гол үзүүлэлт бол хөрсний нягтрал юм. Газар бүр тухайн нутгийн байгаль газар зүйн онцлогоос хамааран янз бүрийн үржил шимтэй хөрстэй байдаг учраас тухайн газрын хөрсний шинж чанарыг иж бүрэн тусгасан чанарын үнэлгээ хийгдсэн байх ёстой. Хөрсний чанарын үнэлгээ нь хөрсөн дээр тогтворжсон ургамлын бүрхэвч, эдгээрийн уялдаа холбоог илэрхийлэх ландшафтын хэв шинжүүдийн даацыг тодорхойлох гол үндэс юм.

ГГБЦГ-ын хөрсний чанарын үнэлгээг 2012 онд Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид боловсруулсан хөрсний чанарын үнэлгээний стандартаар тогтоов (*Хүснэгт 21*).

*Хүснэгт 21. Хөрсний чанарын үнэлгээ*

Байгалийн бүс	Хэв шинж, дэд хэв шинж	Хөрсний чанарын үнэлгээ
Уулын цөлөрхөг хээр	Уулын цөлөрхөг хээрийн бор	4.0
	Уулын хээржүү цөлийн бор	3.1
	Уулын цөлийн бор саарал	1.0
<b>Хээрийн бүсийн чанарын үнэлгээ</b>		
Хээр (нам уулс толгод)	Сайр чулуурхаг хар шороон	58.5
	Сайр чулуурхаг хар хүрэн	40.5
	Сайр чулуурхаг хүрэн	25.2
	Сайр чулуурхаг цайвар хүрэн	16.4
	Хүрэн	38.7
	Цайвар хүрэн	23.5
	Цайвар хүрэн хужир мараалаг	16.1
	Элсэн хучаастай цайвар хүрэн	13.2
	Мараалаг цайвар хүрэн	9.6
	Элсэн хүрэн	12.0
Бусад	Хужир мараалаг нугат хүрэн	15.6
	Эвдэрсэн хөрс (хээрийн бүс)	5.0
Цөлжүү хээр	Хужир мараалаг бурдэл	9.8
	Элсэн хужирлаг	10.6
	Хагас бэхжсэн элс	2.0
	Хөдөлгөөнт элс	0.2

Эндээс үзэхэд рекреацийн үйл ажиллагаа явуулах хамгийн тохиромжтой хэв шинж бол 3°-аас ихгүй налуутай, 5,0-6,0 м хэрчигдлийн шигүүтэй, хөрсний чанар 80 %-иас дээш ургамал бүрхэвч бүхий голуудын уужим тавиу хөндий дагуух аллюви-нугын хөрстэй өлөн-үетэнт, элдэв өвс-үетэнт татмын нугын ландшафтууд юм.

Рекреацийн үйл ажиллагаа явуулахад тохиромжтой хэв шинжид голуудын хөндий рүү түрж орсон 3°-6° налуу бүхий нам уулсаар тохиолдох 4,0-5,0 м хэрчигдлийн шигүүтэй, хөрсний чанар 60-80 %-д хэлбэлзэх, 70-80 %-ийн ургамал бүрхэвч бүхий нам уулсаар тохиолдох уулын карбонатгүй хар шороон хөрсөн дээр тогтворжих элдэв өвс, үет ургамалт ойт болон нугат хээр, ойн бараан хөрсөнд тогтворжсон ойн ландшафтууд хамаарна.

Рекреацийн даацын хувьд дунд зэрэг тохиромжтой хэв шинж бол 5°-8° налуу бүхий дундаж өндөр уулсаар тохиолдох хөрсний механик бүрэлдэхүүн хөнгөн шавранцар, 25-35%-ийн ургамал бүрхэвч бүхий сайр чулуурхаг карбонатгүй хар хүрэн уулын карбонатгүй хар шороон, сайр чулуурхаг хар шороон, сайр чулуурхаг карбонатгүй хар шороон зэрэг хээрийн хөрсөн дээр тогтворжих үетэн-алаг өвс, алаг өвс-хялганат хээрийн ландшафт юм.

### 2.2.3. Аялал жуулчлалын даац тогтоосон арга зүй

Дэлхийн улс орнууд өөрийн байгаль нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан даацаа тогтоодог бөгөөд аялал жуулчлалын даацын хамгийн дээд хязгаар ямар байх ёстой гэдэг асуулт өнөөдрийг хүртэл маргаантай хэвээр байна. Тухайлбал хөрс, ургамлын талхагдлын байдал, усны нөөц, бохирдол, наран шарлагын газар гэх мэтээр олон

үзүүлэлтийг сонгож 1 га талбайд хэдэн хүн байх боломжтой гэх мэтээр тогтоосон нь ч бий.

Бид ГГБЦГ-ын аялал жуулчлалын даацыг “ТХГН-ийн Судалгааны Төв” ТББ-ын ТХГН-уудын аялал жуулчлалын нөөц, даацыг тогтоохдоо баримталдаг арга зүйг ашиглан тооцсон. Ингэхдээ тус цогцолборт газрын батлагдсан маршрут 1 хувилбар болон маршрут 2 хувилбараар тус тус физик болон бодит даацыг ялгаатай тооцсон болно.

#### 2.2.4. Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ хийсэн арга зүй

ГГБЦГ-ын аялал рекреацийн тааламжийн үнэлгээг хийхдээ доорх үзүүлэлтүүдийг гол болгон сонгон авсан (Хүснэгт 22).

- Температурын хувьд тохиромжтой (зуны улиралд 13-20<sup>0</sup>С) хоногийн тоо говийн бүсэд 100 – 120 хоног, ойт хээрийн бүсэд 70 – 90 хоног, уулархаг нутагт 60 хоног байна. Температурын горим 12.2 – 21.7<sup>0</sup>С байх нь хамгийн тохиромжтой гэж тооцсон.
- Голын усны температур 8-16<sup>0</sup>С байвал тохиромжгүй, 17-19<sup>0</sup>С бол дунд зэрэг, 20-24<sup>0</sup>С бол тохиромжтой, 25-27<sup>0</sup>С бол нэн тохиромжтой нөхцөл гэж үзсэн.
- Агаарын чийгийг 56-70% байх нь Монгол орны хувьд нэн тохиромжтой гэж тооцох бөгөөд Говийн бүсэд 50%, тал хээрийн бүсэд 50%, ойт хээрийн бүсэд 65-70%, уулархаг нутагт 70% байна.
- Нарны гийгүүлэх хугацаа говьд 1000 цаг, ойт хээрт 800 цаг байна.
- Рекреацийн үйл ажиллагаанд салхины хурд бм/сек-ээс илүү, агаарын температур, 0<sup>0</sup>С-аас бага байвал тохиромжгүй гэж тооцсон.
- Хотгор гүдгэрийг үнэлэхэд уулархаг нутаг рекреацийн нөхцөлөөр тохиромжтой ба өндөр уул, дундаж өндөр уул, нам уул, тал гэж үнэлсэн.
- Ургамлын нөмрөгийг үнэлэхдээ тайгын шилмүүст ба навчит ойг хамгийн тохиромжтой гэж тооцсон. Өндөр уулын нуга, нугат хээр нь дараагийн шатлалд орно.
- Гол мөрний сүлжээний нягтшилыг 0,20-0,25 км/км<sup>2</sup> нэн тохиромжтой гэж үзнэ.
- Орчин үед рекреацийн үйл ажиллагааг дараах хүчин зүйлүүдээр өвөл, зуны улирлын ялгаагаар үнэлсэн. (Даш, Баясгалан, Мандах, 2005). Үүнд:

Хүснэгт 22. Рекреацийн үйл ажиллагааг улирлын ялгаагаар үнэлэх үзүүлэлтүүд

№	Рекреацийн үйл ажиллагааны улирлын хүчин зүйлс	
	Өвөл	Зун
1.	Агаарын температурын тохиромжтой үеийн үргэлжлэх хугацаа	Агаарын температурын тохиромжтой үеийн үргэлжлэх хугацаа
2.	Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа	Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа
3.	Салхины горим	Нуур, голын усны дулааны горим
4.	Хотгор гүдгэр	Агаарын харьцангуй чийгшил
5.	Цасан бүрхүүл	Хотгор гүдгэр
6.	Ургамалжилт	Усан хангамж
7.		Ургамалжилт

Байгалийн эдгээр хүчин зүйлсийг үнэлэхдээ хүний биеийн эрүүл мэндийн байдалд нөлөөлөх, амралт сувилал, аялал жуулчлалыг зохион байгуулахад нөлөөлөх үзүүлэлтүүд гэж 2 хувааж үздэг. Хүний биеийн эрүүл мэндэд нөлөөлөх үзүүлэлтэд агаарын температур, нуур, голын усны горим, харьцангуй чийгшил, нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа, салхины горим орно. Амралт сувилал, жуулчлалыг хөгжүүлэх, зохион байгуулахад нөлөөлөх үзүүлэлтэд газрын гадарга, өндөр, намын байдал, хэрчигдэл, ургамалжилт, ус зүйн сүлжээ зэрэг орно. Үнэлгээг Олон улсад хэрэглэгдэж буй шалгуурыг баримтлан хийлээ.

Тухайн газар дахь тааламжийн үнэлгээг олох томъёо:

$$K = \sum A_n/n$$

K- байгалийн нөхцөлийн тааламжийн итгэлцүүр

n- үзүүлэлт

$\sum A_n$  – үзүүлэлтүүдийн онооны нийлбэр

Тааламжтай нөхцөлийн үнэлгээг тохирох нэгжүүдэд 0-4 баллаар үнэлэх бөгөөд 4 рүү тэмүүлэх тусам тааламжтай байдлыг илтгэнэ. Хэрэв 3-4 балл бол нэн тааламжтай, 2-3 балл бол тааламжтай, 1-2 балл дунд зэргийн тааламжтай, 0-1 балл бол тааламж муутай байна.

### **2.2.5. Аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ хийсэн арга зүй**

ГГБЦГ-ын байгалийн аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан “Байгалийн аялал, рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүд”-ийг ашиглан дараах арга зүйгээр хийсэн болно.

Нутаг дэвсгэрийн аялал-рекреацийн үнэлгээ хийх эхний үе шат нь байгалийн нөхцөл байдлыг судлахаас эхэлдэг. Учир нь байгалийн нөөц нь аялал рекреацийн нутаг дэвсгэрийн ашиглалтын урьдчилсан нөхцөлүүдийн нэг гол хүчин зүйл, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой. Гол зорилго нь Монгол оронд байгалийн аялал, рекреацид тохиромжтой болон тохиромжгүй бүс нутгийг үнэлэх ажлыг нэгдсэн зааварчилгаагаар хангахад оршино.

Ландшафт–рекреацийн чадавхын үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлдог.

1. Ландшафтын үнэлгээ
  - ✓ Газрын гадаргын аялал рекреацийн үнэлгээ
  - ✓ Уур амьсгалын аялал рекреацийн үнэлгээ
  - ✓ Гадаргын ус, рашааны аялал рекреацийн үнэлгээ
  - ✓ Био-нөөцийн аялал рекреацийн үнэлгээ
  - ✓ Ландшафтын гоо зүйн үнэлгээ
2. Байгаль-түүх соёлын дурсгалт газрын үнэлгээ
  - ✓ Байгаль түүх соёлын дурсгалт газруудын үнэлгээ
  - ✓ Түүх соёлын дурсгалт газруудын үнэлгээ
3. Дэд бүтцийн үнэлгээ
  - ✓ Гатлага, зам, даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ
  - ✓ Хот болон байнгын оршин суух газарт ойр эсэх
  - ✓ Тохижилтын түвшин

#### 4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ

- ✓ Тариалангийн талбай
- ✓ Одоо байгаа суурин газар
- ✓ Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
- ✓ Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс

Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль түүх соёлын дурсгал, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамааран үндсэн болон дэд үзүүлэлтүүдийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтүүдийг нэгтгэн "Байгалийн аялал-рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ"-г боловсруулна. Байгалийн аялал-рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээг 3 шатлалтай ангиллаар нийт 4 үндсэн, 27 дэд үзүүлэлтүүдийг үндэслэн гүйцэтгэсэн.

#### **Хотгор гүдгэрийн аялал, рекреацийн үнэлгээний арга зүй**

Газрын гадаргын хотгор гүдгэр нь аялал-рекреацийн үйл ажиллагаанд тодорхой үүрэгтэй. Үүнд:

1. Хотгор гүдгэрийн танин мэдэхүйн үүрэг. Энэ нь тухайн газрын гадаргын онцлог байдлаар тодорхойлогдоно.
2. Хотгор гүдгэрийн гоозүйн үүрэг. Энэ нь газар нутгийн гоо зүйн чанар, аялагчдад сэтгэл хөдлөл үүсгэж буй хэмжээгээр илэрхийлэгдэнэ.
3. Хотгор гүдгэрийн технологийн үүрэг. Гуу, жалгын сүлжээний нягтшилаар тодорхойлогдоно.

Тус нутгийн хотгор гүдгэр, тухайлбал гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налуу нь байгалийн бусад иж бүрдлийнхээ хамт тухайн нутагт рекреацийн үйл ажиллагааг явуулах боломжийг тодорхойлогч гол хүчин зүйл болдог. Улмаар аялал-рекреацийн төрлийг нэмэгдүүлэх, эсвэл хязгаарлах нөлөө үзүүлдэг. Тухайлбал, эдгээр нь технологийн маш чухал хүчин зүйл бөгөөд рекреацийн төрөл бүрийн барилга байгууламж, амралт, сувиллын газрууд, жуулчны бааз, хүүхдийн зуслан зэрэг байгууламжийг байршуулахад нөлөөлөх тул уулын чулуулаг, түүний бүтэц, жуулчны тээврийн хэрэгслийн туулах чадвар, аюулгүй ажиллагааг хангах магадлал зэргийг сайн тооцох шаардлагатай юм. Энэ нь рекреацийн үйл ажиллагаа дахь эрсдэлийг багасгана.

Газрын гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налууг баллын аргаар дараах байдлаар үнэлнэ (Хүснэгт 23).

*Хүснэгт 23. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээний шатлал*

<i>1. Хэрчигдлийн шигүү</i>		<b>Үнэлгээний балл</b>
<b>Голын гольдрол хоорондын болон нам дор газрын хоорондох дундаж зай / метр/</b>		
1000-аас доош		1
1000-2000		2
2000-3000		3
3000-4000		4
<i>2. Хэрчигдлийн гүн</i>		<b>Үнэлгээний балл</b>
<b>Хөх нуурын төвшнөөс дээш өргөгдсөн усны хагалбар газрын зонхилох өндөр, м</b>		
2000-аас дээш		1
1500-2000		2
1000-1500		3

1000-аас доош	4
<i>3. Гадаргын налуу(градус)</i>	
<b>Газрын хэвгийн зонхилох өнцөг / градус/</b>	<b>Үнэлгээний балл</b>
20 <sup>0</sup> -аас дээш	1
12 <sup>0</sup> -20 <sup>0</sup>	2
6 <sup>0</sup> -12 <sup>0</sup>	3
6 <sup>0</sup> хүртэл	4

### **Уур амьсгалын аялал, рекреацийн үнэлгээний арга зүй**

Уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг үндэсний атласт орсон нар гийгүүлэх хугацаа, агаарын температурын хоногийн дундаж 100 ба түүнээс дээш байх өдөр, агаарын харьцангуй чийгшлийн дундаж, 13 цагт (1-р сар, 4-р сар, 7-р сар, 10-р сар) гэсэн 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар дараах хүснэгтийн дагуу хийж гүйцэтгэсэн (Хүснэгт 24).

#### *Хүснэгт 24. ГТБЦГ-ын уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал*

<b>Зуны аялал-рекреацийн тохиромжтой үеийн үргэлжлэх хугацаа</b>	<b>Үнэлгээний балл</b>
<i>1. Агаарын дундаж температур нэмэх 10<sup>0</sup>-түүнээс давах хоногийн тоо</i>	
70 доош	1
70-90	2
90-110	3
110-аас дээш	4
<i>2. Нар гийгүүлэх хугацаа</i>	
<b>Жилд нар гийгүүлэх цаг</b>	<b>Үнэлгээний балл</b>
2600-аас доош	1
2600-2700	2
2700-2800	3
2800-аас дээш	4
<i>3. Харьцангуй чийгшлийн дундаж утга, 13 цагт /%/</i>	
<b>Харьцангуй чийгийн дундаж утга</b>	<b>Үнэлгээний балл</b>
40-доош ба 90-100	1
40-50 ба 80-90	2
50-60 ба 70-80	3
60-70	4

Дээрх 5 шалгуур үзүүлэлт, дөрвөн шатлалын дагуу хийсэн

### **Био нөөцийн аялал рекреацийн үнэлгээний арга зүй**

Энэхүү үнэлгээг хийхдээ ургамалжилт ба амьтны аялал рекреацийн үнэлгээг дараах шатлал, шалгуураар тус тус хийсэн болно (Хүснэгт 25, 26).

#### *Хүснэгт 25. ГТБЦГ-ын ургамлын рекреацийн нөөцийн үнэлгээний шалгуур, шатлал*

<i>1. Ховор ургамал</i>	
<b>Ховор ургамал</b>	<b>Үнэлгээний балл</b>
Байхгүй	0
1	1
2-3	2
3 дээш	3



2. Ургамалжилт	
Ургамлын хэв шинж	Үнэлгээний балл
Өндөр уулын таг, нуга, намаг, усны ургамал	1
Цөлөрхөг хээр, цөл	2
Хээр	3
Уулын ойт хээр, уулын тайга	4

Хүснэгт 26. ГГБЦГ-ын амьтны рекреацийн нөөцийн үнэлгээний шалгуур, шатлал

1. Ховор хөхтөн	
Тархсан байдал	Үнэлгээний балл
Байхгүй	0
1	1
2-3	2
3 дээш	3
2. Ховор шувуу	
Тархсан байдал	Үнэлгээний балл
Байхгүй	0
1	1
2-3	2
3 дээш	3

### Ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээний арга зүй

Ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээгээр ландшафтын болон аялал-рекреацийн хувьд онцгой ач холбогдолтой газруудыг олж тогтоох, ашиглаж байгаа болон ашиглаж болохуйц газруудад учирч буй эрсдэл, энэ эрсдэлийг бууруулах болон арилгах боломж, хүн ам байнга оршин суудаг болон эзэмшигдээгүй нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудал, түүнтэй уялдан тухайн газарт аялал-рекреацийн нутаг дэвсгэрийн систем бүрэлдэх урьдчилсан нөхцөлийг илрүүлдэг.

## 2.3. ГГБЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ, ДААЦЫН ҮНЭЛГЭЭ

### 2.3.1. Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ

ГГБЦГ-т хүний эрчимтэй үйл ажиллагаанд өртөгдөж буй дараах газрууд байна (Хүснэгт 27).

Хүснэгт 27. ГГБЦГ-ын хүний үйл ажиллагаанд ашиглагдаж буй газрууд

№	Ашиглагдаж буй газрууд	Тоо
1.	Өвөлжөө	936
2.	Замын нийт урт	2071.14
	Үүнээс: Хатуу хучилттай зам	25.77
	Хээрийн хөрсөн зам	2045.37
5.	Жуулчны бааз	7
6.	Худаг	698
7.	Булаг, рашаан	200

ГМС-ийн мэдээллийг ашиглан хүний үйл ажиллагааны нөлөөллийг:

- Авто зам буюу замын нягтрал
- Малчин өрхийн бэлчээр ашиглалт


➤ Жуулчны баазын нөлөөлөл гэсэн 3 хүчин зүйлээр тооцож нэгдсэн үнэлгээ гаргаж нөлөөллийг маш бага, бага, дунд зэрэг, хүчтэй, маш хүчтэй гэсэн 5 ангиллаар ялгаж үнэлэв.

ГГБЦГ-ын хэмжээнд нийт 2416.47 км авто зам байгаагаас хатуу хучилттай зам 25.77 км, хээрийн хөрсөн зам 2390.7 км байна. Өөрөөр хэлбэл нийт замын 1% нь засмал зам, үлдсэн 99% нь шороон зам юм. Шороон замын нөлөөллийн хүрээг 0.25 км-ийн алслалттайгаар 1.0 км-ээр тооцсон (Хүснэгт 28).

Хүснэгт 28. ГГБЦГ-ын авто замын нөлөөллийн зэрэг

Нөлөөллийн зэрэглэл	Талбай	
	Га	Хувь
Маш бага	1765830	81.38
Бага	90032.35	4.15
Дунд зэрэг	96504.29	4.45
Хүчтэй	103610.8	4.77
Маш хүчтэй	113904.2	5.25
Нийт дүн	2169881	100.00

Хүснэгтээс харахад нийт газар нутгийн 81.38% нь авто замын нөлөөлөлд маш бага өртсөн, 10% нь авто замын нөлөөлөлд их болон маш ихээр өртсөн байна (Зураг 17).



Зураг 17. ГГБЦГ-ын авто зам ашиглалтын нөлөөлөл


ГГБЦГ дахь жуулчны баазууд болон малчин өрхийн бэлчээр ашиглалтаас орчны нутаг дэвсгэрт үзүүлж буй нөлөөллийг тооцон гаргахын тулд жуулчны баазууд болон

малчин өрхийн өвөлжөөний байршлыг GPS-ийн хэмжилтийн цэгэн мэдээлэлд тулгуурлан түүний орон зайн бүсчлэлийг тооцон гаргасан (Хүснэгт 29).

Хүснэгт 29. Малчдын бэлчээр ашиглалтын нөлөөлөл

№	Ангилал	Талбай /га/	Эзлэх хувь
1	Маш бага	1151985.365	53.09
2	Бага	211859.9107	9.76
3	Дунд	280281.5655	12.92
4	Хүчтэй	339847.089	15.66
5	Маш хүчтэй	185907.3093	8.57
	<b>БҮГД</b>	<b>2169881.24</b>	<b>100.00</b>

Малчдын бэлчээр ашиглалтын нөлөөллөөс харахад нийт нутгийн 53.09% нь нөлөөлөлд маш бага өртсөн бол 24.23% нь нөлөөлөлд ихээр өртсөн байна. Ялангуяа ГТБЦГ-ын нутаг дэвсгэрийн зүүн болон өмнөд хэсгээр бэлчээр ашиглалт төвлөрсөн байна (Зураг 18).




Зураг 18. ГТБЦГ дахь малчин өрхийн бэлчээр ашиглалт

ГТБЦГ-ын жуулчны баазуудаас үзүүлж буй нөлөөллийг 2 жуулчны баазын байршлын цэгэн мэдээлэл дээр тулгуурлаж орон зайн бүсчлэлийг ArcGIS 10.8 Spatial Analyse программыг ашиглан тооцон гаргасан. Харин нөлөөллийн түвшнийг үнэлэхдээ нөлөөллийг илтгэсэн тэгшитгэлийг Systat программ дээр хүчин зүйлийн анализаар гаргасан (Хүснэгт 30).

Хүснэгт 30. Говь Гурван Сайханы БЦГ-ын жуулчны баазуудын нөлөөлөл

Нөлөөллийн зэрэглэл	Талбай	
	Га	Хувь
Маш бага	2154472.14	99.29
Бага	4810.98	0.22
Дунд зэрэг	4073.2	0.19
Хүчтэй	5477.55	0.25
Маш хүчтэй	1047.36	0.05
Нийт дүн	2169881.24	100.00

Хүснэгтээс харахад нийт газар нутгийн 99.29%-д жуулчны баазын нөлөөлөл маш бага гарсан бөгөөд одоогоор жуулчны баазын үйл ажиллагаа явуулж буй 6524.61 га талбай буюу нийт нутаг дэвсгэрийн 0.3%-д жуулчны баазын нөлөөлөл хүчтэй илэрсэн байна (Зураг 19).



Зураг 19. Жуулчны баазаас ГГБЦГ-т үзүүлэх нөлөөлөл


Авто замын нягтрал, малчин өрхийн бэлчээр ашиглалт, жуулчны баазын нөлөөллөөс харвал ГГБЦГ-ын байгаль ландшафтад үзүүлж буй хүний үйл ажиллагааны нэгдсэн нөлөөллийн үнэлгээ дараах байдлаар гарлаа (Хүснэгт 31)

Хүснэгт 31. Байгаль ландшафтад үзүүлж буй хүний үйл ажиллагааны нөлөө

№	Ангилал	Талбай га	Эзлэх хувь
1	Маш бага	17481.0693	0.81
2	Бага	1178197.565	54.30
3	Дунд	740922.0097	34.15

4	Хүчтэй	176372.539	8.13
5	Маш хүчтэй	56908.05599	2.62
6	<b>БҮГД</b>	<b>2169881.239</b>	<b>100.00</b>

Хүснэгтээс харвал нийт нутаг дэвсгэрийн 10.75%-д хүний үйл ажиллагааны нөлөө хүчтэй, 88.45%-д бага болон дунд хэмжээгээр илэрсэн байна. Нөлөөлөл хүчтэй илэрсэн нутгуудад Гурван сайхан уул, Хонгорын элс орчмын нутаг дэвсгэр багтаж байна (Зураг 20).



Зураг 20. Байгаль ландшафтад үзүүлж буй хүний үйл ажиллагааны нэгдсэн нөлөө

### 2.3.2. Байгалийн ландшафтын иж бүрдлийн эрсдэлийн үнэлгээ

Байгалийн цогцолбор газрыг доройтлоос урьдчилан сэргийлэхэд чухал асуудал болох аялал жуулчлалын даацыг тогтоох асуудлын үндэс нь байгалийн нутаг дэвсгэрийн тэнцвэрт байдал нь гадаргын налуу, хэрчигдлийн шигүү, хөрсний хэв шинж, бүтэц, ургамлын нөмрөгийн тэнцвэрт байдлаар тодорхойлогддог.

ГГЦГ-ын нутаг дэвсгэрийн 72.3% нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд маш тохиромжтой, 14.55% нь тохиромжтой байгаа бол 8.17% нь тохиромж тааруу, 3.75% нь тохиромж тааруу, 1.23% нь огт тохиромжгүй газар нутаг байна (Хүснэгт 32).


Хүснэгт 32. ГГБЦГ-ын гадаргын налуу ба аялал жуулчлалд тохиромжтой байдал

№	Гадаргын налуу	ГГБЦГ-т эзлэх талбайн хэмжээ		Тохиромжтой байдал
		Талбай /га/	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	
1.	3 <sup>0</sup> -аас бага	1568824.14	72.30	Маш тохиромжтой
	3 <sup>0</sup> -6 <sup>0</sup>	315717.72	14.55	Тохиромжтой



2.	6 <sup>0</sup> -12 <sup>0</sup>	177279.30	8.17	Дунд зэрэг тохиромжтой
3.	12 <sup>0</sup> -20 <sup>0</sup>	81370.55	3.75	Тохиромж муутай
4.	20 <sup>0</sup> -оос дээш	26689.54	1.23	Тохиромжгүй

6<sup>0</sup> хүртэлх газарт уулс хоорондын хөндий болон талархаг газрууд хамаарагдана. Гадаргын налууг жуулчны баазуудыг байгуулах, аяллын маршрут төлөвлөх, зам гүүр тавихад харгалзан үзэх боломжтой. Хүснэгтээс харахад ГГБЦГ-ын нутаг дэвсгэрийн 95.02% нь гадаргын налуугийн хувьд аялал жуулчлалд их, бага хэмжээгээр тохиромжтой байгаа бол 4.98% нь тохиромжгүй гэж үзэх боломжтой (Зураг 21).




Зураг 21. ГГБЦГ-ын гадаргын налуугийн аялал жуулчлалд тохиромжтой байдал

Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарах гол зүйлсийн нэг нь хэрчигдлийн шигүү юм. 0,5 км шигүү хэрчигдэлтэй газар буюу хамгийн их бартаатай газар нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамгийн тохиромжгүй байдаг бол 2км-ээс илүү бол тохиромжтой байдаг. ГГБЦГ-ын нутаг дэвсгэрийн Говь гурван сайхан уулын орчмоор хэрчигдлийн шигүү хамгийн өндөр байгаа бол Нэмэгт, Алтан уул орчмоор хэрчигдлийн шигүү өндөр, Хонгорын элс орчимд сул, бусад газраар дунд хэмжээтэй байна (Зураг 22).

Зургаас харахад хэдийгээр Говь гурван сайхан уул орчмоор хэрчигдлийн шигүү хамгийн өндөр байгаа ч уулсын хөндийгөөр аялал жуулчлал хамгийн их хөгжсөн газрын нэг болж байна.





Зураг 22. ГГБЦГ-ын гадаргын хэрчигдлийн шигүү

ГГБЦГ-ын нутаг дэвсгэрийн хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн үнэлгээнээс харвал маш их эрсдэлтэй сумдад Баяндалай, Булган, Гурвантэс, Сэврэй сумдын нутаг дэвсгэр багтаж байгаа бөгөөд ялангуяа маш их эрсдэлтэй нийт нутаг дэвсгэрийн 59.67%-д нь Гурвантэс сум, 33.22%-ийг Сэврэй сумын нутаг дэвсгэр багтаж байна (Хүснэгт 33).

Хүснэгт 33. ГГБЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн үнэлгээ (сумдаар)

№	Сумын нэр	Хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлтэй талбай /га/					Нийт талбай /га/
		Маш бага	Бага	Дунд	Их	Маш их	
1	Баяндалай		11800.32	54949.57	148844.75	31545.78	<b>247140.43</b>
2	Булган		10.92	47257.85	97425.90	6083.52	<b>150778.19</b>
3	Гурвантэс		1948.01		710061.49	315778.49	<b>1027787.98</b>
4	Даланзадгад				3493.06		<b>3493.06</b>
5	Сэврэй	6710.68		86473.21	394310.59	175775.54	<b>663270.02</b>
6	Ханхонгор			4560.20	64245.77		<b>68805.97</b>
7	Хүрмэн				8605.59		<b>8605.59</b>
8	<b>Бүгд</b>	<b>6710.68</b>	<b>13759.25</b>	<b>193240.83</b>	<b>1426987.16</b>	<b>529183.33</b>	<b>2169881.24</b>

Хүснэгтийг графикаар харуулбал (График 12):




График 12. ГГБЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэл

Хөрсний механик бүрэлдэхүүний эрсдлийн үнэлгээнээс харахад ГГБЦГ-ын нийт нутаг дэвсгэрийн 24.39% нь маш хүчтэй, 65.76% нь хүчтэй, 8.91% нь дунд зэрэг, 0.63% нь бага, 0.31% нь маш бага хэмжээний эрсдэл бүхий нутаг дэвсгэрүүд байна (График 13).





График 13. ГГБЦГ-ын нутаг дэвсгэрийн хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн зэрэг

Хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн зэрэглэл ийм өндөр гарч байгаа нь говь нутгийн хөрсний онцлогоос гадна цөлжилттэй холбоотой юм. Тиймээс нэн ялангуяа

эрсдэл их, маш их гарсан нутаг дэвсгэрүүдэд аялал жуулчлалын үйл ажиллагааг болгоомжтой, даацыг хэтрүүлэлгүй явуулах шаардлагатай (Зураг 23).



Зураг 23. ГГБЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн зэрэг

ГГБЦГ нь хөрсний чанарын нийт үнэлгээгээр 61.9 гэсэн үнэлгээтэй гарсан нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад “тохиромжтой” гэсэн үнэлгээтэй болохыг харуулж байна (Хүснэгт 34).

Хүснэгт 34. ГГБЦГ-ын хөрсний чанарын үнэлгээ

Байгалийн бүс	Хэв шинж, дэд хэв шинж	Хөрсний чанарын үнэлгээ
Уулын хээр	Уулын хүрэн	18.9
	Уулын цайвар хүрэн	12.1
Уулын цөлөрхөг хээр	Уулын цөлөрхөг хээрийн бор	4.0
	Уулын хээржүү цөлийн бор	3.1
	Уулын цөлийн бор саарал	1.0
Цөлжүү хээр	Хужир мараалаг бүрдэл	9.8
	Элсэн хужирлаг	10.6
	Хагас бэхжсэн элс	2.0
	Хөдөлгөөнт элс	0.2
<b>Нийт</b>		<b>61.9</b>


Дээрх үзүүлэлтүүдийг нэгтгэн байгаль ландшафтын нэгдсэн үнэлгээг харуулав (Хүснэгт 35).

Хүснэгт 35. Байгаль ландшафтын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ

№	Ангилал	Талбай га	Эзлэх хувь
---	---------	-----------	------------

1	Маш бага	17359.05	0.80
2	Бага	1176075.63	54.20
3	Дунд	748609.03	34.50
4	Хүчтэй	171420.62	7.90
5	Маш хүчтэй	56416.91	2.60
6	БҮГД	2169881.24	100.00

Байгалийн ландшафтын эрсдэлийн нэгдсэн үнэлгээгээр ГТБЦГ-ын нутаг дэвсгэрийн 10.5% нь хүчтэй болон маш хүчтэй эрсдэлтэй, 0.8% нь маш бага эрсдэлтэй, 88.7% нь бага болон дунд эрсдэлтэй гэсэн үнэлгээтэй гарсан байна (Зураг 24)



Зураг 24. ГТБЦГ-ын байгаль ландшафтын эрсдлийн нэгдсэн үнэлгээ

### 2.3.3. Аялал жуулчлалын даацыг тооцох

ГТБЦГ-ын аялал жуулчлалын даацыг “ТХГН-ийн Судалгааны Төв” ТББ-ын Монгол орны ТХГН-уудын аялал жуулчлалын нөөц, даацыг тогтооход баримталдаг арга зүйг ашиглан тооцов. Ингэхдээ тус цогцолборт газрын батлагдсан маршрут 2 маршрутаар тус тус физик болон бодит даацыг ялгаатай тооцсон болно.

ГТБЦГ-ын аялал жуулчлалын даацыг тооцохын тулд тус цогцолборт газарт төслийн баг жуулчны оргил ачааллын үе буюу 3 сард “Түмэн тэмээний баяр” эвент болон 7 сард наадмын үеийг тохиолдуулан 2 удаа очиж хээрийн судалгаа хийсэн.

**Маршрут 1** (Даланзадгад - Ёлын ам - Мухар шивэрт - Дүнгэнээгийн ам - Баян Төхөмийн нуур – Хавтрага - Сэрүүн булаг - Эрдэнэ булаг - Замын хонд - Дулаан уул – Томбон - Ганданчоймзадлин хийд - Хавцгайтын хадны зураг - Даланзадгад)-516.2км

#### 1.Физик даац.

Бид аялал жуулчлалын улирлыг жилд 6 сар, аяллын маршрутын уртыг 516.2 км, үзмэр үзэх боломжтой хугацааг 36 цаг, бодитоор жуулчин байх хугацааг 18 цаг гэж үзвэл:

$$\text{Эргэлтийн фактор} = \frac{\text{үзвэр үзэх боломжтой хугацаа}}{\text{аялагчийн байх дундаж хугацаа}} = \frac{36}{18} = 2$$

ГГБЦГ-т газарт аялал жуулчлалын улирлын үеэр өдөрт дунджаар 300 жуулчин аялж байна. Тэдгээрийн 10% нь буюу 30 хүн морин болон явган аяллаар аялдаг гэж үзвэл физик даац дээр 30 аялагчийг нэмж тооцно. Тэгвэл:

Физик /биет/ даац = 516.2км \* 2 авто машин/м \* 2 + 30аялагч = өдөрт 2094.8 буюу 2095 аялагч байна.

Физик даац нь тухайн аялал жуулчлалын бүсийн онцлог шинжүүд болох нөлөөллийн хүчин зүйлүүдийг харгалзан энд зөвшөөрөгдөх аялагчид, жуулчдын тооны дээд хязгаарыг илэрхийлдэг.

## 2.Бодит даац

Бодит даацыг тооцохын тулд "нөлөөллийн хүчин зүйлс"-ийг тооцох шаардлагатай.

$$\text{БД} = \text{ФД} - \text{ЗК1} - \text{ЗК2} - \dots - \text{ЗК}_n$$

Нөлөөллийн хүчин зүйлс буюу залруулгын коэффициент (ЗК) гэдэг нь биофизик, байгаль орчин, экологи, нийгмийн болон менежментийн хувьсагчид юм. ЗК-ийг хувиар илэрхийлэхийн тулд дээрх томъёог дараах байдлаар харуулж болно:

$$\text{Бод} = \text{ФД} * \frac{100 - \text{ЗК}_1}{100} * \frac{100 - \text{ЗК}_2}{100} * \dots * \frac{100 - \text{ЗК}_n}{100}$$

Залруулгын коэффициент тухайн газрын онцлогтой холбоотой бөгөөд дараах байдлаар хувиар илэрхийлэгдэнэ:

$$\text{ЗК} = \frac{X_{\text{хяз}}}{X_{\text{нх}}} * 100$$

Үүнд:

ЗК = залруулгын коэффициент

X<sub>хяз</sub> = хувьсагчийн функцийн хязгаар

X<sub>нх</sub> = хувьсагчийн нийт хэмжээ

Бид залруулгын коэффициент болгон замын эвдрэл, зэрлэг ам амьтан үргээх, эндемик амьтан шувууг авч үзсэн.

**2.2.Замын эвдрэл:** Үүнд зам дагуух эвдрэлд өртөгдөх байдлыг харгалзана.

Нийт замын урт = 516.2 км (X<sub>нх</sub>), маршрутын дагуу авто замын элэгдэл эвдрэлийг 30 хувь гэж тооцвол, дунд зэргийн элэгдэлтэй ховил бүхий зам 155км, (жигнэх үзүүлэлт-2), байна:

$$X_{\text{хяз}} = 155 * 2 = 310 \text{ км}, X_{\text{нх}} = 516.2 \text{ км болно.}$$

Тус цогцолборт газрын нутаг дэвсгэр нь хөрсний эвдрэлийн судалгаагаар говь, цөлийн хөрсний хувьд шороон замын эвдрэлийн эрчим өндөр бөгөөд судалгааны бүс нутагт шороон замаас үүсэх хөрсний эвдрэлийн хэмжээ 288.4-300.2 тн/га байна. Тэгвэл:

$$\text{ЗК}_{\text{эвд}} = \frac{310}{516.2} * 100 = 60\% \text{ болно.}$$

**2.3.Зэрлэг ан амьтад үргээх:** Авто хэрэгсэл, хүн, малын дуу чимээнд эндемик зүйлүүд эмзгээр өртдөг.

$$\text{Залруулгын коэффициент ЗК} = \frac{\text{хязгаартай сарууд}}{\frac{\text{ЖИЛ}}{12\text{сар}} \cdot \text{ЖИЛ}} * 100$$

Тиймээс эндемик болон нүүдлийн шувуудын залруулгын коэффициентийг:

$$З_{К1} = \frac{1}{9} * 100 = 11.1\%$$

Хөхтөн амьтдын залруулгын коэффициентийг:

$$З_{К2} = \frac{2}{9} * 100 = 22.2\%$$

Ховор амьтдын залруулгын коэффициентийг:

$$З_{К3} = \frac{2}{9} * 100 = 22.2\%$$

Говь Гурван Сайханы БЦГ дахь зэрлэг амьтдад сөргөөр нөлөөлөх залруулгын коэффициент

$$ЗК \text{ з.а.} = З_{К1} + З_{К2} + З_{К3} = 11.1 + 22.2 + 22.2 = 55.5 \text{ буюу } 55\% \text{ байна.}$$

Тэгвэл аялал жуулчлалын бодит даац нь

$$\text{Бод} = 2095 * \frac{100 - 60}{100} * \frac{100 - 55}{100} = 377.1$$

ГГБЦГ-т аялагчдын 516.2 км зайн маршрутын биет даац өдөрт 2095 аялагчид байж болох ба харин зам эвдэхгүйгээр, зэрлэг ан амьтдад сөрөг нөлөөгүйгээр аялах боломжтой бодит даац нь өдөрт 377 аялагч байна.

**Маршрут 2** (Даланзадгад - Ёлын ам - Мухар шивэрт - Дүнгэнээгийн ам - Баян Төхөмийн нуур – Хавтрага - Сэрүүн булаг - Сайн шандын хийд - Нарангийн адагийн бичиг - Сэврэйн хадны зураг - Сайншандын хийд - Салхитын хадны зураг - Тэсийн нуур /Давсны үйлдвэр/ - Ухаа толгод - Зэгстийн цагаан элс - Гурван тэс - Нарандаац булаг - Хэрмэн цав - Эрэг толгой - Майхан тээгийн хоолой - Зуун мод зулганай - Батаарын өлгий - Нэмэгтийн их хонгил - Загийн хоолой - Бор Цонж уул /Ухаа толгод/ - Хөдөө Цонж уул - Харайхын задгай - Хонгорын элс - Сэрүүн булаг - Эрдэнэ булаг - Замын хонд - Дулаан уул – Томбон -Ганданчоймзадлин хийд - Хавцгайтын хадны зураг - Даланзадгад)-1173.1км

Тус БЦГ-ын энэхүү маршрутын урт 1173.1 км, явган болон морин аялал 8-10км хийнэ гэж үзвэл гэж үзвэл:

**1. Физик /биет/ даац**

$$\text{Физик даац} = 1173.1 \text{ км} \times 2 \text{ авто машин} / \text{ км} \times 2 + 30 = 4722.4 \text{ аялагч (өдөрт)}$$

**2. Бодит даац**

Нийт замын урт = 1173.1км (Хнх), дунд зэргийн элэгдэлтэй ховил бүхий зам = 352 км (жигнэх үзүүлэлт-2), ихээхэн элэгдэлтэй ховил бүхий зам байхгүй гэж үзвэл:

$$\text{Ххяз} = 352 \times 2 = 704 \text{ км, Хнх} = 1173.1 \text{ болж байна.}$$

Эко аялагчид ирнэ гэж үзээд замын эвдрэх магадлалыг хэт өндрөөр авч үзсэнгүй.

Тэгвэл:

$$З_{К_{эвд}} = \frac{704}{1173.1} * 100 = 60\%$$

$$ЗК \text{ з.а.} = З_{К1} + З_{К2} + З_{К3} = 11.1 + 22.2 + 22.2 = 55.5 \text{ буюу } 55\% \text{ байна.}$$

Тэгвэл аяллын бодит даац:

$$\text{Бод} = 4722.4 * \frac{100 - 60}{100} * \frac{100 - 55}{100} = 850$$



ГГБЦГ-т аялагчдын холын зайн маршрутын дагуу биет даац өдөрт 4722 аялагчид байж болох боловч зам эвдэхгүйгээр, зэрлэг ан амьтдад сөрөг нөлөөгүйгээр аялах боломжтой даац нь өдөрт 850 аялагч байна.

Иймээс тус цогцолборт газрын аялал жуулчлалын улирлыг жилд 6 сар байдаг гэж үзээд дээрх 2 үндсэн маршрутуудын дагуух даацыг тус бүрд нь жилээр нь тооцож үзвэл:

Маршрут 1:  $377*30*6=67860$  жуулчин

Маршрут 2:  $850*30*6=153000$  жуулчин болж байна.

Дээрх 2 маршрут нь Гурвансайхан уул, Хонгорын элс орчим зам газраараа давхцаж байгаа тул өдөрт аялах боломжтой жуулчдын даацыг нэгтгэн дундажлан үзвэл:

$$\frac{377+850}{2} = 613.5 \text{ буюу } 614 \text{ аялагч}$$

болж байна. Үүнийг аялал жуулчлалын улирлыг 6 сар гэж үзвэл:

$$614*30*6=110520$$

аялагч болно.

#### 2.3.4. Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ

ГГБЦГ нь рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээгээр дундаж үзүүлэлт нь 2.9 балл буюу аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад “тааламжтай” гэсэн үнэлгээтэй гарсан (Хүснэгт 36).

Хүснэгт 36. ГГБЦГ-ын рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ

№	Оноо үзүүлэлт	4	3	2	1	0
A1	Дундаж температур нь 10 <sup>0</sup> с-ээс давах хоногийн тоо	130<	110-130	90-110	70-90	70 >
A2	Жилд нар гийгүүлэх хугацаа цагаар	3200<	3000-3200	2800-3000	2600-2800	2600 >
A3	Цэлмэг өдрийн тоо	120<	80-120	60-80	50-60	50 >
A4	7 сарын харьцангуй чийг %	60<	40-60	30-40	20-30	20>
A5	30 <sup>0</sup> с-ээс давж халах өдрийн тоо	10>	10-20	20-30	30-40	40<
A6	Хүйтрэлгүй үргэлжлэх хугацаа/хоног/	130<	110-130	90-110	70-90	70>
A7	30 <sup>0</sup> с-ээс бууж хүйтрэх өдрийн тоо	20>	20-40	50-60	50-70	70<
A8	Хүчтэй салхитай өдөр	10<	10-30	30-40	40-50	50>
A9	Цастай байх хоногийн тоо	50>	50-100	100-130	130-150	150<
A10	Цасны зузаан см	5>	5-10	10-15	15-20	20<
A11	Тунадасны хэмжээ мм	400<	200-400	100-200	90-100	90>
A12	Голын сүлжээний нягтшил км/км <sup>2</sup>	0,1	0,05-0,01	0,01-0,05	0,01-с бага	0
A13	Зуны улиралд гадаргын усны дулаан	бүлээн	бүлээвтэр	Хүйгэвтэр	Хүйтэн	Их хүйтэн
A14	Замын элс, шавар, намаг	Үгүй	Бага зэрэг	Дундаж	Бий	Их бий
A15	Газрын гадаргын хотгор, гүдгэрийн байдал	Нам уул, тал	Нам уул, тал	Толгодорхог	Өндөр уул	Хэрчигдэл их
A16	Нэн ховор ургамлын зүйл	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй
A17	Нэн ховор амьтны зүйл	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй

A18	Олон улсын хэмжээний хамгаалалттай газар	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй
A19	Улсын хамгаалалттай түүх, соёлын дурсгал	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй
A20	Гайхамшигт газрын үзүүлэлтээрээ	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй
A21	Аялал жуулчлалд тааламжтай хоногийн тоо	130-150	100-120	100-90	90-70	70-с доош

Тус цогцолборт газарт аялал жуулчлалын тааламжтай хугацаа бусад бүс нутгаас харьцангуй олон хоног буюу 5 сараас 9 сарын дунд үе хүртэл нийт 130-150 хоног байгаа нь аялал жуулчлалын үйл ажиллагааг эрчимтэй явуулах боломжийг олгож байна.

### 2.3.5. ГГБЦГ-ын аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ

ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт уулын, талын, хотгорын, бүсийн бус хөндийн гэсэн үндсэн 4 ангийн 38 хэв шинж ялгарч байгаа бөгөөд тэдгээрийг дэд анги болон зонхилогч хэв шинжээр нь нэгтгэн 4 ангийн 15 хэв шинжээр бүлэглэн аялал рекреацийн үнэлгээг тэдгээр 16 хэв шинж тус бүрээр нь ангилан хийлээ (Хүснэгт 37).

*Хүснэгт 37. ГГБЦГ-ын ландшафтын үндсэн хэв шинжүүд*

Ландшафт			
Анги	Дэд анги	Индекс	Хэв шинж
Уулын ландшафт	Дундаж өндөр уулын /1500-2500м/	ЛХШ 1	Өмнөд хуурай хээр (38)
		ЛХШ 2	Цөлжүү хээр (40,41)
		ЛХШ 3	Заримдаг цөл (42, 43)
		ЛХШ 4	Умард цөл (44,45)
	Нам уул /1500-доош м/	ЛХШ 5	Умард цөл (71,74)
Талын ландшафт	Өндөрлөг тал 600-1000 м хүртэл ба түүнээс дээш	ЛХШ 6	Цөлжүү хээр 100
		ЛХШ 7	Заримдаг цөл (109,111,113,114)
		ЛХШ 8	Умард цөл (117, 119, 122)
		ЛХШ 9	Өмнөд цөл (123,124,125,126,127)
Хотгорын ландшафт	Хэрчигдэлтэй ба бага хэрчигдэлтэй	ЛХШ 10	Цөлжүү хээр ба заримдаг цөл (177,180)
		ЛХШ 11	Умард цөл (185,186)
		ЛХШ 12	Өмнөд цөл (190,193)
		ЛХШ 13	Хэт гандуу цөл (196,198)
Бүсийн		ЛХШ 14	Мараа, марз (206, 207)

		ЛХШ 15	Элсэн хам бүрдэл (209)
--	--	-----------	------------------------

**ГГБЦГ-ын газрын гадарга, хотгор гүдгэрийн аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ**

ГГБЦГ-ын хотгор гүдгэр нь дундаж өндөр болон уул, тал, хотгорыг хамарч, түүний гадаад төрх нь Монголын говийн үзэсгэлэнт байдлыг бий болгодог. Тус цогцолборт газрын газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээг хийхдээ гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налуу, суурин амралтын газар байгуулах нутаг дэвсгэр гэсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийсэн.


Газрын гадаргын хотгор, гүдгэрийн рекреацийн үнэлгээ хийх үзүүлэлтийн тоон утгыг Р.А.Курушин, Ч.Баяр, Г.Лхасүрэн, Ж.Нацаг нарын “Үндэсний атлас”-т орсон 1:3000000 масштабтай “Гадаргын налуу”, 1:6000000 масштабтай “Гадаргын хэрчигдлийн шигүү”, “Гадаргын хэрчигдлийн гүн” гэсэн газрын зургуудад дүн шинжилгээ хийж, тулгуур материал болгон ашигласан. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд, шатлалын дагуу боловсруулсан арга зүйг үндэслэн ГГБЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал-рекреацийн нөөцийн үнэлгээг хийж, үр дүнг нэгтгэн үзүүлэв (Хүснэгт 38).

Хүснэгт 38. ГГБЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ

Анги	Дэд анги	Ландшафт		Хотгор, гүдгэр					
		Индекс	Хэвшинж	Гадаргын налуу	Хэрчигдлийн шигүү	Хэрчигдлийн гүн	Суурин амралтын газар байгуулах	Нийт балл	Чанарын үнэлгээ
Уулын	Дундаж өндөр уулын /1500-2500м/	ЛХШ 1	Өмнөд хуурай хээр (38)	2	4	3	3	12	Нэн өндөр
		ЛХШ 2	Цөлжүү хээр (40,41)	3	2	1	3	9	Өндөр
		ЛХШ 3	Заримдаг цөл (42, 43, )	3	2	1	3	9	Өндөр
		ЛХШ 4	Умард цөл (44,45)	3	3	2	3	11	Нэн өндөр
	Нам уул /1500-	ЛХШ 5	Умард цөл (71,74)	1	2	1	2	6	Дунд
Талын		ЛХШ 6	Цөлжүү хээр 100	2	4	2	2	10	Өндөр
		ЛХШ 7	Заримдаг цөл (109,111,113,114)	1	1	1	1	4	Сул
		ЛХШ 8	Умард цөл (117,119,122)	2	2	2	1	7	Дунд
		ЛХШ 9	Өмнөд цөл (123,124,125,126,127)	1	3	1	2	7	Дунд
Хотгорын		ЛХШ 10	Цөлжүү хээр ба заримдаг цөл (177,180)	1	1	1	2	5	Сул
		ЛХШ 11	Умард цөл (185,186)	1	1	1	1	4	Сул

Бүсийн бэлгэ	ЛХШ 12	Өмнөд цөл (190,193)	1	2	1	2	6	Дунд
		ЛХШ 13	Хэт гандуу цөл (196,198)	1	2	1	1	5
	ЛХШ 14	Мараа, марз (206, 207)	1	1	1	1	4	Сул
	ЛХШ 15	Элсэн хам бүрдэл (209)	1	2	1	1	5	Сул

ГГБЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал-рекреацийн нөөцийн үнэлгээгээр ГГБЦГ-т нэн өндөр, өндөр, дунд, сул гэсэн үндсэн 4 хэв шинж ялгарсан бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 17.1%-ийг нэн өндөр, 17.6%-ийг өндөр, 35.5%-ийг дунд, 29.8%-ийг сул хэв шинжүүд эзэлж байна (Зураг 25). Энэхүү хотгор гүдгэрийн хослол нь тус газарт аялал жуулчлалын олон төрлийг хослуулан хөгжүүлэх боломжтой болохыг илэрхийлж байна.



Зураг 25. ГГБЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ

### ГГБЦГ-ын уур амьсгалын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ


ГГБЦГ-ын уур амьсгалын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээг 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийж, үр дүнг үзүүллээ (Хүснэгт 39).

Хүснэгт 39. ГГБЦГ-ын уур амьсгалын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ

		Уур амьсгал
--	--	-------------

Индекс	Хэвшинж	Нар гийгүүлэх хугацаа	Агаарын температурын хоногийн дундаж 10 ба түүнээс дээш байх өдөр	Цасан бүрхүүлийн зузаан	Тогтвортой цасан бүрхүүлийн тогтох хугацаа	Харьцангуй чийгийн дундаж утга 13 цагт%	Нийт балл	Чанарын үнэлгээ
ЛХШ 1	Өмнөд хуурай хээр (38)	3	3	4	3	1	14	Сул
ЛХШ 2	Цөлжүү хээр (40,41)	3	2	3	4	1	14	Сул
ЛХШ 3	Заримдаг цөл (42, 43)	4	3	4	4	1	16	өндөр
ЛХШ 4	Умард цөл (44,45)	4	3	4	4	1	16	өндөр
ЛХШ 5	Умард цөл (71,74)	4	3	4	4	1	16	өндөр
ЛХШ 6	Цөлжүү хээр 100	3	4	3	3	1	14	Сул
ЛХШ 7	Заримдаг цөл (109,111,113,114)	4	4	4	3	1	16	өндөр
ЛХШ 8	Умард цөл (117,119,122)	4	2	4	4	1	15	Дунд
ЛХШ 9	Өмнөд цөл (123,124,125,126,127)	4	3	4	4	1	16	өндөр
ЛХШ 10	Цөлжүү хээр ба заримдаг цөл (177,180)	4	3	3	3	1	15	Дунд
ЛХШ 11	Умард цөл (185,186)	4	3	4	4	1	16	өндөр
ЛХШ 12	Өмнөд цөл (190,193)	4	3	4	4	1	16	өндөр
ЛХШ 13	Хэт гандуу цөл (196,198)	4	3	4	4	1	16	өндөр
ЛХШ 14	Мараа марз 206, 207	4	4	3	3	1	15	Дунд
ЛХШ 15	Элсэн хам бүрдэл 209	4	3	4	4	1	16	өндөр

Бидний судалгаагаар ГГБЦГ-ын аялал-рекреацийн тохиромжтой хугацаа нь олон жилийн дунджаар 100-120 хоног байна. Уур амьсгалын хувьд өндөр, дунд, сул үнэлгээтэй нутгууд ялгарч байгаа бөгөөд нутаг дэвсгэрийн 69.28% нь өндөр, 10.65% нь дунд, 20.06% нь сул үнэлгээтэй гарав. Уур амьсгалын хувьд нар гийгүүлэх хугацаа харьцангуй их, агаарын температурын хоногийн дундаж 10<sup>0</sup> ба түүнээс дээш байх өдрийн тоо олон, цасан бүрхүүлийн зузаан болон тогтвортой цасан бүрхүүл тогтох хугацаа бага байгаа нь аялал жуулчлалын хувьд давуу тал, харин харьцангуй чийгийн дундаж утга бага байгаа нь сул тал болж байна (Зураг 26).



Зураг 26. ГГБЦГ-ын уур амьсгалын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ

### ГГБЦГ-ын гадаргын усны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ

ГГБЦГ-ын гадаргын усны рекреацийн нөөцийн үнэлгээг 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар хийж, Үндэсний атласаас “Толын сүлжээний нягтшил” 1:12000000 масштабтай газрын зураг, “Рашаан”, “Тол мөрний нийлбэр урсац” 1:9000000 масштабтай газрын зургуудыг тулгуур материал болгон ашиглав (Хүснэгт 40).


Хүснэгт 40. ГГБЦГ-ын гадаргын усны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ

Анги	Дэд анги	Ландшафт		Гадаргын ус, рашаан				
		Индекс	Хэвшинж	Eels	Гол мөрний нийлбэр урсац	Рашааны хослол	Нийт балл	Чанарын үнэлгээ
Уулын	Дундаж өндөр уулын /1500-2500м/	ЛХШ 1	Өмнөд хуурай хээр (38)	1	1	1	3	Дунд
		ЛХШ 2	Цөлжүү хээр (40,41)	1	1	1	3	Дунд
		ЛХШ 3	Заримдаг цөл (42, 43)	1	1	0	2	Сул
		ЛХШ 4	Умард цөл (44,45)	1	1	0	2	Сул
	Нам уул /1500-	ЛХШ 5	Умард цөл (71,74)	1	1	0	2	Сул



Талын	ЛХШ 6	Цөлжүү хээр 100	1	1	1	3	Дунд
	ЛХШ 7	Заримдаг цөл (109,111,113,114)	1	1	1	3	Дунд
	ЛХШ 8	Умард цөл (117,119,122)	1	1	0	2	Сул
	ЛХШ 9	Өмнөд цөл (123,124,125,126,127)	1	1	0	2	Сул
Хотгорын	ЛХШ 10	Цөлжүү хээр ба заримдаг цөл (177,180)	1	1	1	3	Дунд
	ЛХШ 11	Умард цөл (185, 186)	1	1	0	2	Сул
	ЛХШ 12	Өмнөд цөл (190,193)	1	1	0	2	Сул
	ЛХШ 13	Хэт гандуу цөл (196,198)	1	1	0	2	Сул
Бүсийн бус хөндий	ЛХШ 14	Мараа марз 206, 207	1	1	0	2	Сул
	ЛХШ 15	Элсэн хам бүрдэл 209	1	1	0	2	Сул

ГГБЦГ-ын гадаргын усны аялал-рекреацийн нөөцийн нэгдсэн үнэлгээгээр тус цогцолборт газарт голын сүлжээний нягтшил, гол мөрний нийлбэр урсац харьцангуй багатай тул нийт нутаг дэвсгэрийн 23.4 % нь дунд, бусад буюу 76.6% нь сул үнэлгээтэй гарлаа (Зураг 27). Хэдийгээр энэ нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд сул тал болох хэдий ч Монгол орныг дэлхийд таниулсан “Монголын Говь” нутгийн нэг онцлог юм.



Зураг 27. ГГБЦГ-ын гадаргын усны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ


**ГГБЦГ-ын ургамалжилтын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ**

Говь Гурван Сайханы БЦГ-ын ургамалжилтын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг “Ургамлын бүлгэмдлийн хэв шинж”, “Нэн ховор ургамал”, “Ховор ургамал” гэсэн 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийлээ (Хүснэгт 41).

*Хүснэгт 41. ГГБЦГ-ын ургамалжилтын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ*

Ландшафт				Ургамалжилт				
Анги	Дэд анги	Индекс	Хэвшинж	Ургамлын бүлгэмдлийн хэв шинж	Нэн ховор ургамал	ховор ургамал	Нийт балл	Чанарын үнэлгээ
Уулын	Дундаж өндөр уулын /1500-2500м/	ЛХШ 1	Өмнөд хуурай хээр (38)	2	1	1	4	Өндөр
		ЛХШ 2	Цөлжүү хээр (40,41)	3	1	2	4	Өндөр
		ЛХШ 3	Заримдаг цөл (42,43)	2	0	1	3	дунд
		ЛХШ 4	Умард цөл (44,45)	2	0	0	2	Сул
	Нам уул /1500-доош м/	ЛХШ 5	Умард цөл (71, 74)	2	0	1	3	дунд
Талын		ЛХШ 6	Цөлжүү хээр 100	2	1	1	4	Өндөр
		ЛХШ 7	Заримдаг цөл (109,111,113,114)	2	0	1	3	дунд
		ЛХШ 8	Умард цөл (117,119,122)	2	0	0	2	Сул
		ЛХШ 9	Өмнөд цөл (122, 123,124,125,126,127)	2	0	1	3	дунд
Хотгорын		ЛХШ 10	Цөлжүү хээр ба заримдаг цөл (177,180)	2	1	2	5	Өндөр
		ЛХШ 11	Умард цөл (185,186)	2	0	1	3	Дунд
		ЛХШ 12	Өмнөд цөл (190,193)	2	0	0	2	сул
		ЛХШ 13	Хэт гандуу цөл (196,198)	2	0	0	2	сул
Бүсийн бус хөндий		ЛХШ 14	Мараа марз 206, 207	2	0	0	2	сул
		ЛХШ 15	Элсэн хам бүрдэл 209	2	0	1	3	Дунд

ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт 24 овог, 35 төрөл, 41 зүйл ховор ургамал, 16 овог, 28 төрөл, 31 зүйл нэн ховор ургамал бүртгэгдсэн байна. Ургамалжилтын рекреацийн нөөцийн үнэлгээгээр нэн өндөр үнэлгээтэй нутаг дэвсгэр илрээгүй ба нийт нутаг дэвсгэрийн 22.6% нь өндөр, 31.6% нь дунд, 45.8 % нь сул үнэлгээтэй бүс нутгууд ялгарсан байна. Иймд өндөр үнэлгээтэй Говь Гурван сайхан уул, Зөөлөн, Баянцагаан, Сэврэй, Нэмэгт уулс, Зулганайн эхэн, Наран даац, Хонгорын элс зэрэг байгалийн өвөрмөц тогтоцтой нутгуудад байгалийн болон ховор, нэн ховор, эмийн ургамлуудыг ажиглах аяллыг хөгжүүлэх боломжтой (Зураг 28).



Зураг 28. Ургамалжилтын аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ

### ГГБЦГ-ын амьтны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ


Говь Гурван Сайханы БЦГ-ын амьтны рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон”, “Шувууны газарзүйн мужлалт, ховор шувуу”, “Хөхтний газарзүйн мужлалт, ховор хөхтөн” гэсэн 2 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3.000.000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийлээ (Хүснэгт 42).

Хүснэгт 42. Амьтны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээ

Ландшафт				Амьтан							
Анги	Дэд анги	Индекс	Хэвшинж	Ховор хөхтөн	Ховор шувуу	Нийт балл	Чанарын үнэлгээ				
У	У	П	Д	У	Н	ЛХШ1	Өмнөд хуурай хээр (38)	2	1	3	Өндөр

		ЛХШ2	Цөлжүү хээр (40,41)	2	1	3	Өндөр
		ЛХШ3	Заримдаг цөл (42)	2	0	2	Дунд
		ЛХШ4	Умард цөл (44,45)	2	1	3	Өндөр
		ЛХШ5	Умард цөл (71,74)	2	1	3	Өндөр
	Нам уул /1500- доош м/						
Талын		ЛХШ6	Цөлжүү хээр 100	1	0	1	Сул
		ЛХШ7	Заримдаг цөл (109,111,113,114)	1	0	1	Сул
		ЛХШ8	Умард цөл (117,119,122)	2	0	2	Дунд
		ЛХШ9	Өмнөд цөл (123,124,125,127)	2	1	3	Өндөр
Хотгорын		ЛХШ10	Цөлжүү хээр ба заримдаг цөл (177,180)	1	0	1	Сул
		ЛХШ11	Умард цөл (185,186)	2	1	3	Өндөр
		ЛХШ12	Өмнөд цөл (190,193)	2	1	3	Өндөр
		ЛХШ13	Хэт гандуу цөл (196,198)	0	0	0	Сул
Бүсийн бус ханлий		ЛХШ14	Мараа марз 206, 207	0	0	1	Сул
		ЛХШ15	Элсэн хам бүрдэл 209	1	1	2	Дунд

Бидний судалгаагаар ховор амьтны аялал-рекреацийн нөөцийн үнэлгээгээр өндөр, дунд, сул хэв шинжийн нутаг дэвсгэрүүд ялгарсан (Зураг 29).



Зураг 29. Амьтны аялал-рекреацийн үнэлгээ

ГГБЦГ-ын Хүрмэн сумын нутаг Зүүн сайханы Дүнгэнээгийн эх, Сэврэй сумын Баянборын нуруу, Зөөлөн уулын баруун хойд хэсэг, Сэврэй уулын зүүн хойд хэсэг, Эрээн уул, Гурвантэс сумын Алтан, Гилбэнт, Нэмэгт, Тост уул зэрэг нутгууд өндөр үнэлгээтэй гарсан бөгөөд эдгээр газруудад аргаль хонь, янгир ямаа, цоохор ирвэс, хулан адуу, хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг дэлхийд ховорт тооцогдох болсон амьтдыг ажиглах, фото сафари аяллыг хөгжүүлэх боломжтой юм.

**ГГБЦГ-ын ландшафтын аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ**

ГГБЦГ-ын ландшафтын аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээг хийхдээ байгалийн иж бүрдлүүдийн үзүүлэлт бүрээр хийсэн үнэлгээний үр дүнг нэгтгэн гаргав (Хүснэгт 43).


*Хүснэгт 43. Ландшафтын аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ*

Индекс	Хэв шинж	Хотгор гүдгэр		Уур амьсгал		Ус		Ургамал		Амьтан		Нийт	
		Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ
ЛХШ1	Өмнөд хуурай хээр (38)	12	Нэн өндөр	14	Сул	2	Сул	4	Өндөр	3	Өндөр	34	өндөр
ЛХШ2	Цөлжүү хээр (40,41)	9	Өндөр	14	Сул	3	Дунд	4	Өндөр	3	Өндөр	32	Өндөр
ЛХШ3	Заримдаг цөл (42, 43)	9	Өндөр	16	Өндөр	2	Сул	3	Дунд	2	Дунд	32	Өндөр
ЛХШ4	Умард цөл (44,45)	11	Нэн өндөр	16	Өндөр	2	Сул	2	Сул	3	Өндөр	34	өндөр
ЛХШ5	Умард цөл (71,74)	6	Дунд	16	Өндөр	2	Сул	3	Дунд	3	Өндөр	30	Өндөр
ЛХШ6	Цөлжүү хээр 100	10	Өндөр	14	Сул	3	Дунд	4	Өндөр	1	Сул	32	Өндөр
ЛХШ7	Заримдаг цөл (109,111, 113,114)	4	Сул	16	Өндөр	3	Дунд	3	Дунд	1	Сул	27	Дунд

ЛХШ8	Умард цөл (117,119, 122)	7	Дунд	15	Дунд	2	Сул	2	Сул	2	Дунд	28	Дунд
ЛХШ9	Өмнөд цөл (123,124, 125,127)	7	Дунд	16	Өндөр	2	Сул	3	Дунд	3	Өндөр	31	Өндөр
ЛХШ10	Цөлжүү хээр ба заримдаг цөл (177,180)	5	Сул	15	Дунд	3	Дунд	5	Өндөр	1	Сул	29	Дунд
ЛХШ11	Умард цөл (185,186)	4	Сул	16	Өндөр	2	Сул	3	Дунд	3	Өндөр	28	Дунд
ЛХШ12	Өмнөд цөл (190,193)	6	Дунд	16	Өндөр	2	Сул	2	Сул	3	Дунд	29	Дунд
ЛХШ13	Хэт гандуу цөл (196,198)	5	Сул	16	Өндөр	2	Сул	2	Сул	1	Сул	26	Сул
ЛХШ14	Мараа марз 206, 207	4	Сул	15	Дунд	2	Сул	2	Сул	1	Сул	24	Сул
ЛХШ15	Элсэн хам бүрдэл 209	5	Сул	13	Сул	2	Сул	3	Дунд	2	Дунд	25	Сул

Судалгааны үр дүнгээс харвал ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт ландшафтын аялал-рекреацийн сул, дунд, өндөр гэсэн гурван түвшин ялгарсан (Зураг 30). Бидний хийсэн ландшафтын болон байгалийн бүрэлдэхүүн хэсэг болгоны аялал-рекреацийн үнэлгээний үр дүн нь тухайн нутаг дэвсгэрийг аялал-рекреацийн чадавхиар ялган бүсчлэх, ашиглалтын хэтийн төлөвийг тодорхойлох боломжийг олгож байна.





Зураг 30. ГТБЦГ-ын ландшафтын аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГГБЦГ-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ТОГТВОРТОЙ ХӨГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛ, ЧИГ БАРИМТЛАЛ

### 3.1. ГГБЦГ-Т АЯЛАХ АЯЛАГЧДЫН ХЭВ ШИНЖ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Дэлхийн II дайн дууссаны дараагаас дэлхийн эдийн засаг сэргэхийн хамт хүн амын өсөлт, орлого нэмэгдэж аялал жуулчлалын салбар аажмаар сэргэж хөгжиж эхэлсэн. 1950-иад онд дэлхийн хэмжээнд жилд 25 сая жуулчин аялж байсан бол 1970 он гэхэд дэлхийн хэмжээнд 166 сая жуулчин аялж өсөлт эрс нэмэгдсэн. Тэгвэл 2019 онд 1.5 тэрбум хүн аялал жуулчлал хийж энэ статистик 2030 он гэхэд 1.8 тэрбум жуулчинд хүрнэ (Зураг 31) гэсэн төлөв байдал ажиглагдаж байсан боловч Ковид-19 цар тахалтай холбоотой 2020-2021 онуудад олон улсын аялал жуулчлал эрс буурсан ч эргээд өсөх болно хэмээн судлаачид үзэж байна.



Зураг 31. Олон улсын аялал жуулчлалын 1950-2030 онд хүрэх төлөв байдал

Эх сурвалж: Дэлхийн аялал жуулчлалын байгууллага

2019 оны байдлаар олон улсын нийт аяллын 55% амралт чөлөөт цаг, 28% эрүүл мэнд, шашин мөргөл, 16% нь бизнес ажил хэрэг, 6% нь бусад төрлийн зорилгоор хийгдсэн байна. Аяллын 59% нь нислэг, 35% нь автомашин, 1% нь галт тэрэг, 5% нь усан онгоцоор тус тус явагджээ.

2019 онд Монгол улсад айлчилсан гадаадын жуулчдаас түүврийн аргаар авсан судалгаагаар гадаадын аялагч, жуулчдын сонирхол дараах байдалтай байсан байна. (Хүснэгт 44)

Хүснэгт 44. Монголд ирсэн гадаадын жуулчдын сонирхдог зүйлс

	Монголд ирэхээс өмнө хийхийг хүсэж байсан	Хийж үзээд сэтгэл хангалуун байна	Дараа ирэхдээ хийж үзнэ
--	---	-----------------------------------	-------------------------

Зэрлэг, онгон байгаль	256	290	254
Байгальд алхах	188	207	207
Морь унах	243	253	204
Монгол хоол идэх	237	271	161
Дэлгүүр	174	201	120
Музей, үзвэр	141	173	135
Соёл	218	209	170
Наадам	144	80	236
Спорт	90	73	174
Гэр	234	300	175
Дуу	174	218	156
Чингис Хаан	146	111	121
Бусад	22	18	19

*Эх сурвалж: Монголд аялсан гадаадын жуулчдаас авсан Монгол банкны судалгааны дүн*

Дээрх судалгаануудаас харахад Монгол улс, тэр дундаа Монголын говь байгалийн үзэсгэлэнт байдлын онцлогоороо цаашид жуулчдын анхаарлыг татсаар байх бүрэн боломжтой юм.

### **3.1.1. ГГБЦГ-т аялагч, жуулчдын хэтийн төлөв, прогноз**

ГГБЦГ-т аялсан гадаад, дотоодын жуулчид цар тахлаас өмнө жилд дунджаар 39 хувиар өсөж байсан бол 2020 онд 2.4 дахин багасаж, 2021 онд өмнөх оноосоо 78 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан. Гэвч ирэх 5 жилд тухайн бүс нутагт зорчигчдын харьцангуй өсөлтийн хувийг регрессийн тэгшитгэлээр бодож үзэхэд дараах байдалтай байна (*Хүснэгт 45*).

*Хүснэгт 45. Нийт жуулчдын тоог тэгшитгэлийн Х утгад шилжүүлсэн байдал*

Он	Дотоод жуулчид	Гадаад жуулчид	Нийт	X <sub>1</sub>	X <sub>2</sub>
2017	9016	10488	19504		
2018	11271	17251	28522	0.20007097862	0.39203524434
2019	24415	30557	54972	0.53835756707	0.43544850608
2020	15749	22	15771	-0.55025715918	-1387.954545
2021	8821	0	8821	-0.78539848089	0

Stata программын тусламжтайгаар тооцоолол хийж үзэхэд дараах үр дүн гарав (*Зураг 32*).

reg Y X1 X2						
Source	SS	df	MS			
Model	1.2865e+09	2	643262029	Number of obs =	5	
Residual	87.3996978	2	43.6998489	F( 2, 2) =	.	
				Prob > F =	0.0000	
				R-squared =	1.0000	
				Adj R-squared =	1.0000	
Total	1.2865e+09	4	321631037	Root MSE =	6.6106	

Y	Coef.	Std. Err.	t	P> t	[95% Conf. Interval]	
X1	.9992074	.0003498	2856.20	0.000	.9977022	1.000713
X2	1.001279	.000689	1453.30	0.000	.9983146	1.004243
_cons	-4.470189	7.977257	-0.56	0.632	-38.79355	29.85318

Зураг 32. Stata программын тооцоолол

Нийт жуулчдын тоо - Y

Гадаадын жуулчдын тоо - X1

Дотоодын жуулчдын тоо - X2

Сүүлийн 5 жилийн гадаад болон дотоодын жуулчдын тоон үзүүлэлт нь нийт тоон үзүүлэлтэд  $Y = A_0 + A_1X1 + A_2X2$  гэсэн шугаман хамааралтай гэж үзвэл

$$Y = -4.470189 + 0.9992074X1 + 1.001279X2$$

регрессийн тэгшитгэлээр илэрхийлэгдэхээр байна. Детерминацийн коэффициент  $R = 1.0000$  байгаа нь тэгшитгэлийн оновчтой байдал болон хамааралтай байдал зэрэг нь 95% ийн итгэх түвшинд сайн байгааг илтгэж байна. Гадаад болон дотоод жуулчдын нөлөөлөл коэффициентараа эерэг тоон үзүүлэлтэй байна (Зураг 33).

. cor Y X1 X2 (obs=5)			
	Y	X1	X2
Y	1.0000		
X1	0.9635	1.0000	
X2	0.8502	0.6782	1.0000

Зураг 33. Хувьсагчдын хамаарал

Нийт хувьсагчдын хувьд корреляци хамаарал “X1= 0.9635”, “X2= 0.8502” байгаа нь сонгож авсан үзүүлэлт нь оновчтой байгааг илтгэж байна. Энэ нь цаашдын жуулчдын тоо нь 95 хувиар өсөх магадлалтайг харуулж байна.

Жуулчдын тоо өсөн нэмэгдэхийн хирээр түүх, соёлын дурсгалт зүйлс, үзмэрүүд, байгаль орчны хамгаалал, экосистемийн зөв зохистой хэрэглээ болон нүүдэлчин ард түмний оролцоо зэргийг ханган ажиллах шаардлагатай. Уур амьсгал, ландшафтын нөхцөл байдлын нөлөөллийг тооцож аяллын үзмэрийн мэдээ мэдээлэл, жуулчдад зориулсан танин мэдэхүйн үйл ажиллагааг оновчтой төлөвлөх нь чухал юм.

### 3.1.2. Аялагч, жуулчдын зах зээлийн хэв шинж, эрэлт хэрэгцээ

#### 1. Дотоодын гийчдээс авсан судалгааны үр дүн

Судалгааг ГГБЦГ-т зорчигч иргэдээс 2022 оны 03 сарын эхний 10 хоногт болон 7-8-р сарыг дуустал хугацаанд анкетын аргыг ашиглаж авсан. Судалгаанд 150 хүн хамрагдсан. Зорилго нь ГГБЦГ-ыг зорьсон гийчдийн аяллын зан төлөв, сэтгэл ханамж

болон зорин очих газрын төвлөрөл хаана байгааг илрүүлснээр аялал жуулчлалын нөөцийг тогтоох оролдлого хийхэд оршино.

Асуулгын бүтэц нь аяллын ерөнхий хандлагыг илрүүлэх 5 асуулт болон зорин очсон газарт аялах онцлогийг тогтоосон 15, нийт 20 асуулттай. Судалгаанд оролцсон гийчдийн 48,67% нь Өмнөговь аймгийн иргэд байсан бол 24% нь Улаанбаатар хотоос зорьсон гийчид байсан. Орон нутгийн иргэд хамгийн ойрхон байх байгалийн үзэсгэлэнт газраар аялдаг болох нь үүгээр харагдаж байна. Мөн Улаанбаатар хотоос ГГБЦГ-ыг зорин очих урсгал багагүй байгаа юм.

Хүснэгт 46. Судалгаанд оролцогчдын аяллын ерөнхий хандлага

Та хаанаас ирсэн бэ?	Тоо	Хувь	Аялсан БЦГ-ууд	Тоо	Хувь
Улаанбаатараас	36	24.0	Хөвсгөл	50	33.3
Баруун бүсийн аймаг	14	9.3	Говь гурван сайхан	99	66.0
Хангайн бүсийн аймаг	3	2.0	Орхоны хөндий	50	33.3
Зүүн бүсийн аймаг	8	5.3	Хорго-Тэрхийн цагаан нуур	56	37.3
Төвийн бүсийн аймаг	15	10.0	Их Нарт	17	11.3
Өмнөговь аймаг	73	48.7	Бусад	30	20.0
Гадаад улсаас	1	0.7			
Жилд хэдэн удаа аялдаг вэ?	Тоо	Хувь	Аялдаг дундаж хоног	Тоо	Хувь
Огт аялдаггүй	24	16.0	1-3 хоног	37	24.7
1 удаа	41	27.3	4-7 хоног	59	39.3
2-3 удаа	57	38.0	10-14 хоног	38	25.3
4-5 удаа	15	10.0	15 ба түүнээс дээш	16	10.7
6 ба түүнээс дээш	13	8.7			
Хоноглодог байр сууцны төрөл	Тоо	Хувь	Хоноглодог байр сууцны төрөл	Тоо	Хувь
Жуулчны бааз	48	32.0	Майхан	81	54.0
Нутгийн айл	14	9.3	Хамаатан, найз	24	16.0
Нөхөрлөлийн гэр	9	6.0	Зочид буудал	13	8.7
			Машин	33	22.0

Судалгаанд оролцогчдын 38% нь жилд 2-3 удаа аяллаар явдаг бол 16% нь аяллаар явдаггүй гэсэн байна. Аялсан бүс нутгийг авч үзвэл бидний судалгааны зорилтот газраас гадна Хорго-Тэрхийн цагаан нуурын БЦГ-т 37.3%, Хөвсгөл нуур, Орхоны хөндийн БЦГ-уудад тус тус 33.3% нь аялж үзсэн байгаа нь Монгол орны аяллын гол замналд байх байгалийн цогцолборт газраар аялаад үзсэн гийчид судалгаанд хамрагдсан болохыг харж болно. Тэдний аяллын дундаж хоног нь 4-7 хоног байна. Мөн судалгаанд оролцогчдын 54% нь аялж байх үедээ байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн майханд хоноглодог бол 32% нь жуулчны баазыг сонгож үйлчлүүлдэг байна. 16% нь хамаатан, найз нөхдийнхөөрөө айлчлахдаа аялдаг болох нь ажиглагдав (Хүснэгт 46).

Хүснэгт 47. ГГБЦГ-аар зорчсон гийчдээс авсан зорилтот судалгааны үр дүн

Хэд дэх удаагаа ирж байна вэ?	Тоо	Хувь	Хэд хоногоор аялах вэ?	Тоо	Хувь
Анх удаа	27	18.0	1-3 хоног	72	48.0
2-3 удаа	50	33.3	4-9 хоног	51	34.0
4-6 удаа	31	20.7	10-14 хоног	24	16.0
7 ба түүнээс дээш	42	28.0	15 ба түүнээс дээш	3	2.0
Аяллын зорилго	Тоо	Хувь	Хаана хоноглох вэ?	Тоо	Хувь
Амарч, зугаалга	57	38.0	Майханд	44	29.3

Найз нөхөд, хамаатан садандаа айлчлах	35	23.3	Хамаатан, найз	26	17.3
Судалгаа, шинжилгээ хийх	3	2.0	Жуулчны бааз	41	27.3
Ажил хэргийн зорилгоор	5	3.3	Зочид буудал	5	3.3
Эмчилгээ, сувилгаа	9	6.0	Нутгийн айл	6	4.0
Тэмээний баярт оролцох	39	26.0	Машин	9	6.0
Бусад	2	1.3	Нөхөрлөлийн гэр бусад	15	10.0
<b>Мэдээллийг хаанаас авсан бэ?</b>	<b>Тоо</b>	<b>Хувь</b>			
Сонин, сэтгүүл, хэвлэл	15	10.0	<b>Аялалдаа зарцуулж буй зардал</b>	<b>Тоо</b>	<b>Хувь</b>
Интернэтээс (фэйсбүүк, инстаграм)	57	38.0	0-500000 төг	33	22.0
Телевиз, радиогоос	10	6.7	501000-1000000 төг	41	27.3
Гэр бүл, найз нөхөд, хамаатан садан, хамт олноосоо	36	24.0	1001000-1500000 төг	41	27.3
Орон нутгийн иргэдээс	12	8.0	1501000-2000000 төг	9	6.0
ГГБЦГ-ын захиргаанаас	4	2.7	2 сая төгрөгөөс дээш	26	17.3
ГГБЦГ-ын танилцуулга	3	2.0	<b>Худалдан авсан бүтээгдэхүүн, үйлчилгээ</b>	<b>Тоо</b>	<b>Хувь</b>
Байгаль хамгаалагчаас	2	1.3	Сүү, цагаан идээ худалдан авах	76	50.7
Бусад	11	7.3	Гар урлалын зүйлс худалдан авах	50	33.3
<b>Хэдэн төгрөгийн хураамж төлөхөд бэлэн байна вэ?</b>	<b>Тоо</b>	<b>Хувь</b>	Морь, тэмээ унах	56	37.3
300 төг	11	7.3	Нутгийн иргэдийн гэрт хоноглох	19	12.7
500 төг	14	9.3	Хоолны үйлчилгээ	42	28.0
800 төг	8	5.3	Жуулчны баазын үйлчилгээ	43	28.7
1000 төг	45	30.0	<b>Энэ газраар аялахыг бусад санал болгох эсэх</b>	<b>Тоо</b>	<b>Хувь</b>
1000 төг-өөс дээш	72	48.0	Тийм	132	88.0
			Үгүй	4	2.7
			Мэдэхгүй	14	9.3

Судалгаанд оролцогчдын 33.33% нь ГГБЦГ-т 2-3 дахь удаа зорчсон байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бол хамгийн бага нь анх удаа зорчсон гийчид буюу оролцогчдын 18%-ийг эзэлж байна. Мөн нийт судалгаанд оролцогчдын хэдэн удаа зорчсон байдал нь 18-33%-ийн хооронд хэлбэлзэж байгаа нь анх болон олон удаа зорчсон гийчид нь ойролцоо тооны төлөөлөл болж чадахыг харуулж байна. Үлдсэн 48% нь 1-3 хоногоор аялдаг. Судалгаанд оролцогчдын аяллын зорилгын хувьд 38% нь амарч зугаалах, 26% нь тэмээний баярт оролцох, 23.3% нь найз нөхөд, хамаатан садныдаа айлчлах зорилгоор ирсэн байна.

ГГБЦГ-аар аялах үедээ 29.3% нь майханд, 27.3% нь жуулчны баазад, 17.3% нь хамаатан, найз нөхдийндөө хонодог. Аяллын үзмэр, зорин очсон газрын мэдээллийг интернэтийн орчноос 38% нь олж авдаг байхад 24% нь гэр бүл, найз нөхөд, хамаатан, танилаасаа мэдээллийг авдаг. Гийчдийн 27,33% нь нэг удаагийн аялалдаа 500,000-1,500,000 төгрөгийг зарцуулдаг байна.



Судалгаанд оролцогчдын худалдан авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд сүү цагаан идээг нийт оролцогчдын 50.7%, морь, тэмээ унах үйлчилгээг 37.3% нь сонгосон бол 28.7% нь тухайн газарт байрлах жуулчны баазаар үйлчлүүлсэн байна. Нийт оролцогчдын 88% нь ГГБЦГ-аар аялахыг бусдад санал болгоно гэжээ.

ГГБЦГ-ын аяллын гол үзмэрүүдийн дийлэнх хувь нь байгалийн үзэсгэлэнт газар байсан ба түүнийг хайрлан хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулахаар байгаль хамгааллын хураамжийн төлбөрийг 1000 ба түүнээс дээш төгрөгөөр төлөхөд бэлэн байгаа нь нийт гийчдийн 48% нь байна (Хүснэгт 47).

ГГБЦГ-аар зорчсон гийчдээс анх удаа тус цогцолборт газарт зорчиж 1-3 хоног аялж байгаа гийчид хамгийн их буюу 63% байв. 2-3 удаа аялж байгаа гийчдийн 58% нь 1-3 хоног аялдаг бол 4-6 удаа дахин ирсэн гийчдийн аялах дундаж хоног нь нэмэгдэж 35.5% нь 4-9 хоногоор аялсан байна. Эндээс харахад анх удаа ирсэн гийчид нь цөөн хоногоор, олон удаа ирж байгаа гийчид нь илүү олон үзмэрийг үзэхээр аялдаг болох нь харагдсан (График 14).




График 14. Гийчдийн ирэх давтамж болон аяллын үргэлжлэх хугацаа

ГГБЦГ-аар зорчигчдын 70% нь Ёлын ам, 63% нь Мухар Шивэрт, 55% нь Хонгорын элсийг үзсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарч байна (График 15).




График 15. Гийчдийн сонирхсон үзмэрүүд /давхардсан тоогоор/

Үзэж сонирхсон үзмэрээс сэтгэл ханамж өндөр өгсөн үзмэрүүд нь дээрх графикаас харахад Ёлын ам, Хонгорын элс, Мухар шивэрт, Хэрмэн цав байна. Эдгээр үзмэрүүд нь ГГБЦГ-ыг сурталчлах голлох үзмэр болохыг энэхүү графикаас харж болох бөгөөд үүнийг нотлохын тулд цахим орчинд trends.google.com хайлтын системээс хайж үзлээ. Үр дүнд нь Ёлын ам, Хонгорын элс, Хэрмэн цав гэсэн үзмэрүүдийн илэрц гарч ирлээ. Гэтэл гийчдийн сэтгэл ханамж өндөртэй байгаа үзмэр нь дээрх гуравтай дүйцэхүйц Мухар шивэрт, Зулганайн баянбүрд, Хавцгайтын ам, Бичигтийн ам, Дүнгэнээгийн хавцал гэх зэрэг байгалийн тогтоц бүхий газрууд ч бас бий (График 16).




График 16. Дээрх үзмэрүүдээс хамгийн их сонирхол татсан байдал

ГГБЦГ-аар үйлчлүүлсэн иргэдийн тухайн үйлчилгээнд өгсөн чанарын үнэлгээг 1.Байгалийн нөөцийн чанар, 2.Жуулчны баазын үйлчилгээ, 3.Бие засах газар, тэмдэг тэмдэглэгээний үйлчилгээ, 4.Нутгийн иргэдийн оролцоо, харилцаа, 5.Байгаль

хамгаалагчийн харилцаа гэсэн төрлүүдээр 1-5 хүртэл баллаар үнэлүүлсэн. “1” үнэлгээг маш муу гэж ойлгох бол “5” үнэлгээ нь “маш сайн” юм (Хүснэгт 48).

*Хүснэгт 48. ГГБЦГ-ын аялал жуулчлалын үйлчилгээний чанарын үзүүлэлт*

<b>Чанарын үнэлгээний төрөл</b>	<b>Дундаж утга</b>	<b>Стандарт хазайлт</b>
Үйлчилгээний нийт дундаж чанар	3.72	0.939
Байгалийн нөөцийн чанар	4.00	1.074
Жуулчны баазын үйлчилгээ	3.57	1.161
Бие засах газар, тэмдэг тэмдэглэгээний үйлчилгээ	3.41	1.342
Нутгийн иргэдийн харилцаа	3.84	1.112
Байгаль хамгаалагчийн харилцаа	3.75	1.204

Дээрх хүснэгтээс харахад үйлчилгээний чанарын ерөнхий дундаж үнэлгээ нь 3.72 буюу дунджаас дээгүүр боловч сайн үнэлгээнд хүрч чадаагүй байна. Тэдгээрээс байгалийн нөөцийн чанарт өгсөн үнэлгээ 4 буюу сайн гэж гарсан нь тухайн газар нутгийн байгаль орчин, нөөц, баялаг нь жуулчдын сэтгэл татах гол зүйлс нь болдгийг харуулж байна. Нийтийн бие засах байгууламж, аяллын замын тэмдэг, тэмдэглэгээ нь хамгийн муу буюу дундажтай дөхүү /3.41/ байгаа нь Хамгаалалтын захиргаа, орон нутгийн захиргааны нэн тэргүүнд анхаарал хандуулах зүйл нь мөн болохыг харуулж байна.

Ерөнхий сэтгэл ханамжийг 5 баллын үнэлгээгээр үнэлсэн бөгөөд “1” бол “маш муу”, “5” бол “маш сайн” гэсэн утгаар судалгааг явуулсан (Хүснэгт 49).

*Хүснэгт 49. ГГБЦГ-аар зорчигч гийчдийн ерөнхий сэтгэл ханамж*

<b>Ерөнхий сэтгэл ханамж</b>	<b>Дундаж утга</b>	<b>Стандарт хазайлт</b>
Таны энэ байгалийн цогцолборт газраар аялах явцад төрсөн сэтгэл ханамжийн байдал?	4.17	0.610

ГГБЦГ-аар зорчсон гийчдийн ерөнхий сэтгэл ханамж сайн буюу 4.17 гарсан байна. Үйлчилгээний чанартай харьцуулан харахад байгалийн тогтоц, үзэмжит байдал, унаган дагшин байдлаа хадгалан үлдсэн байгаа нь тухайн газрын үнэт зүйл болохыг харуулсан.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг 1-5 оноогоор үнэлэхдээ 1 оноо нь маш их нөлөөтэй, 5 оноо нь маш бага нөлөөтэй гэсэн утгаар тооцов. Нөлөөллийн дундаж үнэлгээ нь 2.29 байгаа нь судалгаанд оролцогчид нөлөөллийг дундаж түвшинд гэж үнэлсэн байна. Хог хаягдал хамгийн их буюу дундаж оноо 1.96, усны бохирдол дунджаас дээгүүр буюу 2.33 оноотой байна. Эндээс харахад байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөө их байж болзошгүй болох нь харагдаж байна (Хүснэгт 50).

*Хүснэгт 50. Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ*

<b>Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ</b>	<b>Дундаж утга</b>	<b>Стандарт хазайлт</b>
Нөлөөллийн нийт дундаж үнэлгээ	2.29	1.016
Хог хаягдал	1.96	1.086
Усны бохирдол	2.33	1.157
Амьтан үргэх, ургамал сүйдэх	2.31	1.188
Хөрсний элэгдэл, эвдрэл	2.29	1.206
Агаарын бохирдол	2.53	1.334

Судалгааны үр дүнгээс харахад ГГБЦГ-ын аялал жуулчлалын үзмэрийн үнэ цэн нь унаган дагшин байгалийн үзэсгэлэн байна. Аяллын дундаж хоног нь 1 өдрөөс 7

хоногийн хугацаа байна. Гэхдээ анх удаа ирж байгаа аялагчид цөөн хоногоор ирж байгаа бол дахин айлчилж байгаа гийчид нь 9 хүртэл хоногоор, зайтай байх аяллын үзмэр бүхий газруудаар аялж байна. Гийчид нь жуулчны баазыг сонгож үйлчлүүлэх нь их байгаа учраас тухайн бүс нутагт байх байр сууцны төрлүүдээс жуулчны баазын үйл ажиллагааг тогтмолжуулах, үйлчилгээг чанаржуулах шаардлага байгаа нь тогтоогдов.

Аяллын зорилго нь амарч зугаалах төлөв нь их байгаа тул ая тухтай замаар, чанартай байгалийн үзмэрийг аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх нь чухал байна. Зам харилцааг сүүлийн жилүүдэд сайжруулснаар засмал замаар холбогдсон үзмэр бүхий газруудыг зорих гийчдийн тоо харьцангуй их байна.

ГГБЦГ-ын мэдээ мэдээллийг интернэт ба сошиал эх сурвалжаас авдаг судалгаагаар харагдсан учраас google платформын trends талбараас цахим хайлт хийж үзэхэд ердөө Ёлын ам, Хонгорын элс, Хэрмэн цав гэсэн үгийн сонголтоор илэрц гарж байна. Энэ нь ГГБЦГ-ын цахим сурталчилгааг сайжруулах, нутаг орны байгалийн төлөөлөл болох газруудыг нээн илрүүлэх нь чухал болохыг харуулж байна.

Говийн бүсийн мал аж ахуйн гаралтай сүү, цагаан идээний худалдаа гийчдийн сонирхлыг их татдаг болох нь харагдсан. Мөн морь тэмээ унах үйлчилгээг зохион байгуулалттайгаар нэмэгдүүлэх боломж байна. Байгалийн үзэмжит байдлыг хамгаалахын тулд авах боломжит арга хэмжээ нь үзмэрийн ойр хавьд морь тэмээн аялал хийх, эсвэл явган аялал хийх зэргээр төлөвлөх нь тогтвортой хөгжлийг бий болгох үндэс суурь болно.

Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зориулж ТХГН-ийн хураамжийг 1000 төгрөгөөс илүү үнээр нэмэгдүүлэхэд гийчид татгалзах зүйлгүй байгаа нь ажиглагдсан. ГГБЦГ-ыг 4 ба түүнээс дээш удаа давтан аялахаар сонгож байгаа гийчид илүү олон хоногоор аялдаг болох нь судалгаанаас ажиглагдсан тул холын зайн аяллын замналыг бий болгон тэмдэгжүүлэх, ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх, одоо байгаа байгууламжуудын ашиглалтыг хэвийн болгох зэргээр сайжруулах шаардлагатай.

Чанарын судалгаа хийж үзэхэд ГГБЦГ-ын байгаль орчин, байгалийн үзэсгэлэнт байдал нь хамгийн гол нөөц болохыг тогтоосон бөгөөд сэтгэл ханамж хамгийн муу байсан үйлчилгээ нь нийтийн бие засах байгууламж, зам ба үзмэрийн тайлбар мэдээ мэдээлэл зэрэг үзүүлэлтүүд байсан. Дээрх асуудалд илүү анхаарлаа хандуулах нь чухал юм.

Байгаль орчинд нөлөөлж байгаа нөлөөллийн хувьд хог хаягдал нь хамгийн эмзэг асуудал байгааг илрүүлсэн бөгөөд хогийг цуглуулж тээвэрлэн устгах ажиллагаа хүндрэлтэй байж болох тул сайжруулах шинэ үеийн технологийг нэвтрүүлэх нь зүйтэй.

## 2. Гадаадын аялагчдаас авсан судалгааны үр дүн

ГГБЦГ-аар зорчсон гадаадын аялагчдаас авсан асуулгын судалгааг 2022 оны 8-р сарын эхний 10 хоногт явуулсан. Судалгааны гол зорилго нь тухайн байгалийн цогцолборт газрын сонирхол татах үзмэрийг тодруулах, аяллын сэтгэл ханамжийн зэргийг тогтоох явдал байсан. Судалгаанд 20 гадаадын иргэд хамрагдсан ба цар тахлын улмаас зорчигчдын тоо цөөн, нөгөө талаар Азийн улс орнуудын иргэд их байсан тул англи хэл дээрх судалгаа бөглөх боломжгүй, мөн өөрсдөө судалгаанд оролцох хүсэлгүй байв.

Судалгаанд хамрагсдын жуулчдын 40% нь 24 хүртэлх насны залуучууд байна. Мөн 65% нь БНСУ-аас ирсэн аялагчид байв.

Хүснэгт 51. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Нас	Хувь	Харьяалал	Хувь
24-оос бага	40.0	БНСУ	65.0
25-39 нас	25.0	Герман	15.0
40-54 нас	20.0	Нидерланд	10.0
55-аас дээш	15.0	Испани	10.0
ГТБЦГ-ын мэдээллийг хаанаас авсан бэ	Хувь	Аяллын зорилго	Хувь
Тур агент	65.0	Адал явдалт	70.0
Найз, гэр бүл	20.0	Нүүдэлчдийн соёл	30.0
Баримтат кино	5.0	Түүх	10.0
Ном хэвлэл	10.0	Палеонтологи	0
Сошиал мэдээ	10.0	Байгаль	5.0
Хамт аялагчдаасаа	5.0	Аялал зохион байгуулсан компанийн харьяалал	Хувь
Үзэсгэлэн	5.0	Монгол	70.0
Телевиз	15.0	Гадаад	30.0
Байгаль хамгаалагч	5.0		

Судалгаанд оролцогчдын 70% нь адал явдал эрэлхийлсэн аялагчид, 30% нь нүүдэлчдийн соёл, аж амьдралыг сонирхож ирсэн аялагчид байна. Тэд ГТБЦГ-ын талаарх мэдээллийг аяллын компаниасаа сонсож мэдсэн бөгөөд дараа нь найз нөхөд, ном хэвлэл, сошиал орчноос мэдээлэл авсан байна. Гадаадын аялагчдын аяллыг зохион байгуулсан байгууллагын 70% нь Монгол туроператор байсан бол 30% нь Солонгос туроператор байв (Хүснэгт 51).

Хүснэгт 52. ГТБЦГ-аар аялах үеийн судалгааны үр дүн

Аялсан хоног	Хувь	Зарцуулсан зардал	Хувь
1 өдөр	35.0	301-500\$	15.0
2 өдөр 1 шөнө	30.0	501-700\$	5.0
3 өдөр 2 шөнө	25.0	701-900\$	0
4 өдөр ба түүнээс дээш	10.0	1000\$ дээш	80.0
Аялсан газрууд	Хувь	Дахин зочлох эсэх	Хувь
Ёлын ам	95.0	1 удаа	15.0
Хавцгайтын булаг	20.0	2-4 удаа	15.0
Хонгорын элс	65.0	4-өөс дээш	30.0
Хэрмэн цав	5.0	Дахин ирэхгүй	25.0
Зулганай	0	Мэдэхгүй	15.0
Дүнгэнээгийн хавцал	5.0	ГТБЦГ-ын талаар мэдээллийг цааш нь түгээх төрөл	Хувь
Үйлчилгээний төрөл	Хувь	Аяллын тухай бусдад ярих	65.0
Ноос, ноолууран бүтээгдэхүүн	60.0	Шуудан илгээх	15.0
Чулуун урлалын гар хийц	20.0	Сошиал эх сурвалж	50.0
Ноосон урлалын гар хийц	30.0	Аяллын цахим хуудас	15.0
Модон урлалын гар хийц	5.0	Сонин ба блог	20.0
Элсэн урлалын гар хийц	5.0	Ном, аяллын хөтөч ном	10.0

ГТБЦГ-аар зорчсон аялагчид 1-2 өдрөөр аялдаг бөгөөд онгоны нислэгийн төлбөрийг оруулаад 1000 доллароос илүү хэмжээний мөнгө зарцуулдаг байна. Жуулчдын 95% нь Ёлын ам, 65% нь Хонгорын элс, 20% нь Хавцгайтын булгаар аялсан байна. Дахин зочлох эсэхийг тодруулахад 30% нь дахин ирнэ, гэхдээ 4-ээс дээш удаа дахин ирнэ гэсэн байна. Гэвч 25% нь дахин ирэх бодолгүй байгаагаа илэрхийлсэн бол

15% нь мэдэхгүй байна гэжээ. ГГБЦГ-аар аялсан гадаадын аялагчид нь ноос, ноолууран бүтээгдэхүүнийг хамгийн их худалдаж авсан байна. ГГБЦГ-ын талаар бусдад цааш нь түгээх эсэхийг асуухад 65% нь бусдадаа ярина, 50% нь социал сувгаар танилцуулна, 20% нь хэвлэл болон блоогоор дамжуулан түгээнэ гэж хариулсан байна (Хүснэгт 52).

*Хүснэгт 53. ГГБЦГ-т ирээд юу үзэж сонирхсон бэ?*

Үйлдлүүд	Ирэхээс өмнө хийхийг хүсэж байсан	Ирээд үзсэн зүйлс	Дараа ирэхдээ хийж үзнэ
Зэрлэг, онгон байгаль	65.0	60.0	35.0
Байгальд алхах	25.0	30.0	10.0
Морь унах	20.0	35.0	25.0
Тэмээ унах	35.0	35.0	10.0
Дэлгүүр	15.0	30.0	15.0
Музей, үзвэр	15.0	15.0	15.0
Түүх, соёл	20.0	10.0	35.0
Монгол хоол идэх	35.0	65.0	15.0
Элсэн манханд спортын сонирхолтой зүйлс хийх	30.0	40.0	20.0
Монгол гэрт байрлах	55.0	65.0	30.0
Үндэсний урлаг	20.0	15.0	15.0
Фото зураг авах	40.0	55.0	25.0

ГГБЦГ-аар аялагчдын 65% нь тухайн газарт ирэхээсээ өмнө унаган зэрлэг байгалийг, Монгол гэрт байрлаж хонож үзэхийг 55% нь ихээр хүсэж ирсэн байна. Үүний дараа 40% нь фото зураг авах, 35% нь тэмээ унаж үзэх, монгол хоол идэж үзэхийг тус тус хүссэн. Ирээд үзэж сонирхсон зүйлсийн хувьд хамгийн их буюу оролцогчдын 65% нь гэрт байрлаж, Монгол хоол идэж үзсэн нь сэтгэлийг их хөдөлгөсөн бол 60% нь байгалийн сайхан байдлыг үзэж сонирхжээ. Судалгаанд оролцогчдын 55% нь Фото зураг авах, 40% нь Хонгорын элс мэт элсэн манхан бүхий газарт чаргаар гулгах гэх мэт сонирхолтой энтертайнмент арга хэмжээнд оролцсондоо таатай байгаа нь ажиглагдсан. Дараа дахин айлчилбал хийж үзэхийг хүссэн зүйлийг нь асуухад 35% нь байгаль, мөн 35% нь түүх соёлын үзмэрийг сонирхоно гэдгээ хэлжээ. 30% нь Монгол гэрт дахин байрлаж амрахыг илүүд үзнэ гэж хариулжээ (Хүснэгт 53).

*Хүснэгт 54. ГГБЦГ-т ирээд үзэж сонирхсон зүйлсээс хамгийн их сэтгэл ханамж авсан зүйлс*

Үйлдлүүд	Ирэхээс өмнөх өндөр хүлээлт	Ирээд үзсэн сэтгэл ханамж
Зэрлэг, онгон байгаль	50.0	50.0
Байгальд алхах	10.0	25.0
Морь унах	10.0	10.0
Тэмээ унах	15.0	15.0
Дэлгүүр	10.0	25.0
Музей, үзвэр	15.0	5.0
Түүх, соёл	25.0	15.0
Монгол хоол идэх	20.0	45.0
Элсэн манханд спортын сонирхолтой зүйлс хийх	20.0	30.0
Монгол гэрт байрлах	25.0	45.0



Үндэсний урлаг	15.0	15.0
Фото зураг авах	30.0	45.0

Судалгаанд оролцсон иргэдийн 50% нь тухайн газраар аялахаас өмнө зэрлэг унаган байгалийг хамгийн ихээр сонирхож ирсэн. Тэдний 30% нь фото зураг авах, 25% нь түүх соёлын үзмэр үзэх, Монгол гэрт байрлаж үзэх, элсэн манханд түшиглэсэн спортын сонирхолтой үйл явдлыг өөрийн биеэр хийж үзэхийг хүссэн байна. Тухайн БЦГ-аар ирээд үйлчлүүлсний дараа нийт оролцогчдын 50% нь байгалийн сайхныг биширсэн бөгөөд 45% нь Монгол хоол идэж Монгол гэрт байрласан болон түүнийхээ фото зураг авсныг, 30% нь элсэн манханд очиж төрөл бүрийн адал явдалт үйлдэл хийж үзсэндээ сэтгэл хангалуун байна (Хүснэгт 54).

*Хүснэгт 55. ГГБЦГ-ын аялал жуулчлалын үйлчилгээний чанар*

Чанарын үнэлгээний төрөл	Дундаж утга	Стандарт хазайлт
Үйлчилгээний нийт дундаж чанар	1.57	0.493
Ерөнхий үйлчилгээ	1.55	0.510
Аюулгүй байдал	1.55	0.510
Хүмүүсийн хандлага	1.50	0.607
Туроператор ба турагент	1.40	0.503
Байр сууц	2.00	0.973
Хоол	1.75	0.786
Тээврийн хэрэгсэл	1.55	0.510
Үзмэр	1.40	0.598
Үйлчилгээний чанар	1.50	0.607

ГГБЦГ-ын аялал жуулчлалын үйлчилгээг Хүснэгт 55-т үзүүлсэн үзүүлэлтүүдээр чанарын судалгааг хийсэн бөгөөд “1” гэсэн оноо нь “маш өндөр”, “4” гэсэн оноо нь маш бага гэсэн утгаар судлав. Судалгаанд оролцогчид нь ГГБЦГ-ын аялал жуулчлалын үйлчилгээнд дунджаар 1.57 гэсэн үнэлгээ өгсөн нь “сайн” гэсэн утгатай ойролцоо байна. Хамгийн бага үнэлгээг авсан үйлчилгээ нь 2 буюу дундаж түвшинд байгаа байр сууцны үйлчилгээ байна. Хамгийн өндөр нь маш сайн гэсэн үзүүлэлт рүү тэмүүлсэн Монгол хоол байв.

*Хүснэгт 56. Хөтчийн үйлчилгээнд өгсөн сэтгэл ханамж*

Чанарын үнэлгээний төрөл	Дундаж утга	Стандарт хазайлт
Сэтгэл ханамжийн нийт дундаж үнэлгээ	4.68	0.602
Мэргэжлийн чадвар	4.60	0.754
Гадаад хэлний мэдлэг	4.70	0.733
Үзмэрийн талаар ерөнхий мэдлэг	4.65	0.745
Туршлага	4.75	0.716

Орон нутгийн хөтчийн үйлчилгээг жуулчдаар үнэлүүлэхдээ 5 шатлалт баллаар үнэлсэн. Ерөнхий сэтгэл ханамжийн түвшин нь 4.68 буюу маш сайн гэсэн үзүүлэлтэй ойр байв. Хөтчийн аяллын туршлага нь 4.75, гадаад хэлний мэдлэг нь 4.7 байгаа нь дунджаас дээгүүр байна (Хүснэгт 56).

*Хүснэгт 57. ГГБЦГ-ын аялал жуулчлалын үйлчилгээний сэтгэл ханамж*

Сэтгэл ханамж өгсөн үнэлгээний үзүүлэлт	Дундаж үнэлгээ
---	----------------

Зам харилцаа дэд бүтэц	3.80
Нийтийн бие засах байгууламж	2.05
Үйлчилгээний чанар	5.35
Интернэт ба утсан харилцаа	3.75
Үзэсгэлэнтэй газруудын талаар мэдээлэл дутмаг	3.20
Хийх зүйлс дутмаг	3.00
Байгууллагууд дутмаг	3.75
Чөлөөт цаг дутмаг	3.90

Сэтгэл ханамжийг дээрх үйлчилгээ тус бүрд 1-8 оноогоор үнэлсэн бөгөөд 1 үнэлгээ нь сэтгэл ханамж доогуур, 8 үнэлгээ нь өндөр гэсэн үг юм. Хамгийн өндөр сэтгэл ханамжтай нь үйлчилгээний чанар буюу дунджаар 5.35 гэсэн үнэлгээ авсан байна. Хамгийн муу нь нийтийн ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ буюу 2.05 гэсэн үнэлгээ авсан байна. Цаашид нийтийн ариун цэврийн байгууламжийн чанарт илүү анхаарах, жуулчдын сонирхлыг татах идэвхтэй үйл ажиллагааг бий болгох болон үзмэрийн талаар мэдээ мэдээллийг сайжруулах, түгээн дэлгэрүүлэх шинэлэг санааг нэвтрүүлэх шаардлагатай байгааг харуулж байна (Хүснэгт 57).

*Хүснэгт 58. ГТБЦГ-ыг бусдад санал болгох байдал*

Үзүүлэлт	Дундаж утга
Бусдад санал болгох эсэх	8.20

ГТБЦГ-аар аялахыг бусдад санал болгох эсэхийг судалж үзэхэд нийт оролцогчид 8.20 оноо өгсөн байна. Хэрвээ санал болгоно гэвэл 10 оноо, огт санал болгохгүй гэвэл 1 оноо өгөхөөр тооцож судалгааг авсан. Иймээс бусдад санал болгох хэмжээний сэтгэл ханамжтай байгааг дээрх хүснэгтээс харж болно (Хүснэгт 58).

*Хүснэгт 59. Гадаадын иргэдээс авсан судалгааны төгсгөлийн хэсэгт оролцогчдоос задгай асуултаар санал авсан.*

Таатай санал	Цаашид сайжруулах санал
Тэмээ унаж сурсан	Интернэтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
Байгалийн гоо үзэмжийг биширсэн	Жуулчны мэдээллийн төвийн мэдээллийг сайжруулах, гадаадын олон хэлээр тайлбар оруулах
Аяллын үзмэрийн гайхамшиг	Нийтийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах, тохижуулах
Уулс, сарлаг	
Байгалийн сайханд алхах	
Шөнийн тэнгэрт од харах, сүүн замыг харах	
Нар жаргах, мандахыг харах	

ГТБЦГ-аар аялагч гадаадын иргэд нь Ёлын ам, Хонгорын элсийг үзэж сонирхсон бөгөөд аяллаар ирэхээсээ өмнө байгалийн үзэсгэлэнт байдал, Монгол гэрт байрлах, фото зураг авах зорилгоор ирдэг. Ирснийхээ дараа Монгол гэр, Монгол хоолыг илүү сонирхож, байгалийн гоо үзэмжит байдлыг биширч, фото зурагт буулгах зэргээр аялж үзсэн байна. Дараа дахин ирэхдээ мөн л байгалийн сайхан тогтоц, унаган байгаль, түүх

соёлыг сонирхоно гэсэн хариулт өгсөн байна. Зэрлэг онгон байгалийг хадгалан хамгаалж чанартай байлгах нь хамгийн чухал зүйл болохыг судалгаанаас харж болно (Хүснэгт 59).

Монгол гэрт байрлах, Монгол хоол идэж үзэх нь мөн л байнгын хүсэж байгаа үйлчилгээ хэдий ч дараа ирэхдээ элсний ач холбогдлыг мэдэрч бөөрний эмчилгээ авах, элсэн чаргаар гулгах зэргээр элсэн манхан бүхий газруудаар идэвхтэй үйл ажиллагаанд оролцохыг хүссэн байна. ГГБЦГ-аар аялах үед нь хамгийн их таалагдсан зүйл нь зэрлэг байгаль байхаас гадна фото зураг авах, монгол гэр, монгол хоол байгальд алхах элсэн манханд идэвхтэй аялал хийсэн зэрэг байна.

Үйлчилгээний чанарын хувьд хамгийн их анхаарал хандуулах, сайжруулах шаардлагатай зүйлийг байр сууцны үйлчилгээ авсан. Тухайн газар нутагт байх амралт, жуулчны баазуудын үйлчилгээг сайжруулах шаардлагатай

Аяллыг удирдсан хөтчид өгсөн үнэлгээ нь харьцангуй сайн байгаа нь аяллыг илүү үнэ цэнтэй болоход ач холбогдолтой байдаг. Судалгаанд хамрагдсан зочид хөтөч нартаа маш сайн гэсэн үнэлгээ өгсөн байв.

Хамгаалалтын захиргааны зүгээс үзмэрийн ойролцоох нийтийн бие засах газрын байгууламжийг тогтмол ажиллуулах, дэвшилтэт технологийг ашиглан шинээр байгуулах хэрэгцээ байгааг анхаарах нь зүйтэй.

ГГБЦГ-аар аялахыг бусдад санал болгох түвшин харьцангуй өндөр байгаа нь цаашид сурталчилгаа болох боломжтой болохыг харуулж байна. Тухайн хамгаалалттай газар нутгийн мэдээллийг аяллын компаниасаа авсан байгаа нь цахим орчинд болон бүтээгдэхүүн үйлчилгээ, аялал жуулчлалын үйл ажиллагааны сурталчилгаа, богино хэмжээний кино бүтээлүүдийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэйг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын саналаар хамгийн олон санал нь байгалийн сайхныг мэдэрсэн явдал, шөнийн тэнгэрт од харах, сүүн замыг өөрийн нүдээр харах, нар жаргах, сарлаг, тэмээ зэргийг харсан нь мартагдахгүй дурсамж бүтээсэн үйл явц болж байгааг дурджээ.

Жуулчны мэдээллийн төвийн мэдээллийг сайжруулах, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, нийтийн бие засах газрын байгууламжийн тав тухгүй байдал, интернэтийн үйлчилгээний хязгаарлагдмал байдал зэрэг нь сайжруулах саналд бичигджээ.

## **3.2. ГГБЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧАДАВХ**

### **3.2.1. Аялагчдыг тогтвортой нэвтрүүлэх Хамгаалалтын Захиргааны хүний нөөцийн чадавх**

ГГБЦГ нь 1 удирдлага, 4 мэргэжилтэн, 25 байгаль хамгаалагч, 5 төрийн үйлчилгээний ажилтан, нийт 36 ажилтан, албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд нийт ажилчдын 69.4% нь байгаль хамгаалагчид байна (График 17).

Үндсэн ажилчдын 52% нь мэргэжлийн, 48% нь мэргэжлийн бус ажиллах хүчин бөгөөд мэргэжлийн бус ажиллах хүчний 7.7% нь захиргааны ажилтан, 92.3% нь байгаль хамгаалагчид байгаа юм (График 18, 19).

Байгаль хамгаалагчдын экологи, байгаль хамгаалал, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хяналт шалгалтын арга барилыг эзэмшүүлэх, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох сургалтуудад тогтмол хамруулж, байгаль хамгаалагчийн эрх үүрэг, тэднийг ажиллуулах, ажлын дүнгээр урамшуулах, байгаль орчны багц хууль, түүнийг дагалдан гарсан журмуудыг хэрэгжүүлэхэд хяналт тавихад анхаарах зүйлс, хууль тогтоомжийн хэрэгжилт, гадаад улс орнуудын байгаль хамгааллын туршлагаас тодорхой ойлголтуудыг өгч мэргэжил дээшлүүлдэг.




График 17. ГГБЦГ-ын ажилчдын бүрэлдэхүүн



График 18. ГГБЦГ-ын ажилчдын мэргэшсэн байдал



График 19. Мэргэжлийн бус ажилчдын бүтэц

ГГБЦГ-ын Хамгаалалтын захиргаанд хэчнээн аялагчийг өдөр бүр тогтвортойгоор нэвтрүүлэх, хяналт тавих боломж байна вэ гэдгийг хүний нөөцийн чадавх буюу ХНЧ гэсэн нэр томъёогоор тодорхойлно. ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаанаас өөрийн чиг үүргээ оновчтой түвшинд гүйцэтгэх хэрэгцээ шаардлага, хяналтын пост дээр ажиллах ажилтны тоо, дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан аялал жуулчлалын даац тодорхой хязгаартай байхыг шаардаж байгаа учраас энэхүү үзүүлэлтийг оруулсан.

Өнөөгийн байдлаар ГГБЦГ-т аялал жуулчлалын оргил үед хяналт тавьж ажиллах хүний нөөцийн хүрэлцээ 69.4% байна. Энэ нь 25 байгаль хамгаалагч тус цогцолборт газарт ажилладаг гэсэн үг ба хэрэв 2 үндсэн маршрутаар хүлээн авах нийт бодит даацын дунджаар өдөрт 614 хүн аялна гэж бодон ХНЧ-ийг тооцвол:

$$\text{ХНЧ} = 614 * 0.69 = 423.66 \text{ буюу } 424 \text{ машин}$$

өдөрт ГГБЦГ-ын бүсэд оруулж хяналт тавих боломжтой байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл нэг байгаль хамгаалагч өдөрт 16-17 машинд хяналт тавьж ажиллана гэсэн үг юм.

Харин 2 маршрутын нийт бодит даацыг хүний нөөцийн бодит хүрэлцээг 69% гэж хэвээр үзэн тооцвол:

$$\text{ХНЧ} = 1227 * 0.69 = 846.63 \text{ буюу } 847 \text{ машин}$$

ГГБЦГ-ын бүсэд оруулан хяналт тавих боломжтой. Энэ нь нэг байгаль хамгаалагч өдөрт 33-34 машинд хяналт тавих ёстой болохыг харуулж байна. Энэ тохиолдолд ХНЧ-ийг нэмэгдүүлэх шаардлагатай болох бөгөөд хүний нөөцийг 10-аар нэмэгдүүлнэ гэж тооцвол:

$$\text{ХНЧ} = 1227 * 0.76 = 932.52 \text{ буюу } 933 \text{ машин}$$

болох бөгөөд нэг байгаль хамгаалагчийн хяналт тавих машины тоо 26-27 болон буурч нэг байгаль хамгаалагчийн ажлын ачаалал буурах боломжтой юм.

Одоогийн байдлаар байгаль хамгаалагчдын ХНЧ 8.25 буюу нэг байгаль хамгаалагч 8 машинд хяналт тавьж ажиллаж байгаа ба ойрын ирээдүйд ГГБЦГ-г ирэх аялагч жуулчдын тоо 95%-иар өснө гэсэн прогноз гарсныг харгалзан үзвэл байгаль хамгаалагч нэмж авах шаардлагагүй. Учир нь өдөрт ирэх жуулчдын тоо 95%-иар буюу хоёр дахин өсөж 600 хүн ирсэн ч одоо ажиллаж буй ХНЧ 16.56 буюу нэг байгаль хамгаалагч 16-17 машинд хяналт тавих боломжтой юм. Ирэх жуулчдын тоо 820-оос давсан тохиолдолд нэмж байгаль хамгаалагч авах нь зүйтэй. Хэдийгээр байгаль хамгаалагч нэмж авах асуудалд байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн норм, нормативыг харгалзан үзэх шаардлагатай ч жуулчдын тоон өсөлтийг бас харгалзан үзэх нь хамгаалалттай нутаг дэвсгэрийн хамгаалалтыг сайжруулах, унаган төрхийг алдагдуулахаас сэргийлэх ач холбогдолтой.

Гэвч тээврийн хэрэгслийг хэт олноор нэвтрүүлэх нь зэрлэг ан амьтдыг стрессүүлж, тэднийг амьдралын хэв маягаа өөрчлөхөд хүргэх, хөрсний эвдрэлийг нэмэгдүүлж болзошгүйг анхаарч, аялал жуулчлалын бодит даацыг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай.

### 3.2.2. ГГБЦГ-ын Хамгаалалтын захиргааны менежментийн чадавх

ГГБЦГ-ын менежментийн чадавхыг маркетинг, үйлдвэрлэл үйлчилгээ, бүтээгдэхүүн, хүний нөөцийн менежмент, байгууллагын менежмент, санхүүгийн чадавх гэсэн үзүүлэлтүүдийг ашиглан тус бүр 5 асуулгаар дүгнэсэн (*Хүснэгт 60-65*).

*Хүснэгт 60. Маркетингийн чадавх*

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Цогцолборт газрын талаарх зар сурталчилгаа, мэдээлэл хүртээмжтэй эсэх?		0
2.	Бусад ТХГН-тай харьцуулахад өрсөлдөх чадвар сайтай эсэх?	1	
3.	Аялагч, жуулчдын эрэлт, хэрэгцээ нэмэгдэж байгаа эсэх?	1	
4.	Аялагч, жуулчдаас сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авдаг эсэх?		0
5.	Зах зээлд эзлэх хэмжээ өмнөх 5 жилээс өсөх боломжтой эсэх	1	
	<b>Нийлбэр дүн</b>	<b>3</b>	<b>0</b>

*Хүснэгт 61. Үйлдвэрлэл, үйлчилгээний чадавх*

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Үйлчилгээний нийлүүлэлт тогтвортой эсэх?		0
2.	Үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа нь эко стандартад нийцсэн эсэх	1	
3.	Үйл ажиллагааны хүчин чадлыг бүрэн ашиглаж чаддаг эсэх?		0
4.	Байршуулах болон хоол, ундааны үйлчилгээгээр хангагдсан эсэх?	1	
5.	Үйлчилгээний талаарх аялагчдын хүлээлт нь бодит байдалтай нийцдэг эсэх		0
	<b>Нийлбэр дүн</b>	<b>2</b>	<b>0</b>

*Хүснэгт 62. Бүтээгдэхүүний чадавх*

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Ижил төрлийн бусад ТХГН-ийн бүтээгдэхүүнээс ялгардаг эсэх?		0
2.	Олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож чаддаг эсэх?		0
3.	Бүтээгдэхүүнээрээ зах зээлд танигдаж чадсан эсэх?	1	
4.	Аялагч, жуулчид бүтээгдэхүүн, үйлчилгээнд сэтгэл ханамжтай эсэх?	1	
5.	Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх боломж	1	
	<b>Нийлбэр дүн</b>	<b>3</b>	<b>0</b>

*Хүснэгт 63. Менежментийн чадавх*

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэг эсэх?		0
2.	ТХГН-ийн менежментийн болон аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажилладаг эсэх?	1	
3.	Байгаль хамгаалах болон аялал жуулчлалыг хөгжүүлэх ажилд нутгийн иргэдийн оролцоог хангадаг эсэх?	1	
4.	Цэвэрлэгээ болон биотехникийн арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг эсэх?	1	
5.	ТХГН-ийн хэмжээнд тогтмол хяналт тавьж чаддаг эсэх?	1	
	<b>Нийлбэр дүн</b>	<b>4</b>	<b>0</b>

*Хүснэгт 64. Хүний нөөцийн чадавх*

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээ хангалттай эсэх	1	
2.	Байгаль хамгаалагчдыг ажиллах нөхцөл, техник хэрэгслээр хангаж чадсан эсэх?	1	
3.	Мэргэжлийн чадварлаг удирдлага бий эсэх?	1	
4.	Цалин, урамшууллын систем сайн эсэх?		0
5.	Хүний нөөцийг тасралтгүй сургаж, хөгжүүлэх боломж бий эсэх?	1	
	<b>Нийлбэр дүн</b>	<b>4</b>	<b>0</b>

*Хүснэгт 65. Санхүүгийн чадавх*

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Нийт хөрөнгийн өсөлт		0
2.	Богино хугацаат өр төлбөрийг цаг хугацаанд нь төлж чаддаг эсэх?		0
3.	Байгаль орчин, ургамал, амьтдыг хамгаалах, таниулах санхүүжилт хангалттай эсэх?	1	
4.	Олон улсын болон дотоодын хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн шугамаар нэмэлт санхүүжилт, хөрөнгө оруулалт бий эсэх?		0



5.	Төсөв санхүү нээлттэй, ил тод эсэх?	1	
	<b>Нийлбэр дүн</b>	<b>2</b>	

Дээрх үзүүлэлтүүдийн үр дүнг графикаар харуулбал дараах байдалтай байна (График 20);




График 20. ГГБЦГ-ын менежментийн чадавхын шинжилгээний үр дүн

Менежментийн чадавхын шинжилгээнээс үзэхэд ГГБЦГ-ын байгууллагын менежментийн үйл ажиллагааны чадавх болон хүний нөөцийн менежментийн чадавхууд бусад үзүүлэлтүүдийг бодвол хамгийн өндөр буюу 4 гэсэн үнэлгээтэй байгаа бөгөөд харин олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрүүдэд оролцох, түүнийг хэрэгжүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Цаашид сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, ижил төрлийн бүтээгдэхүүн санал болгодог ТХГН-тай өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, аялагч жуулчдаас тогтмол сэтгэл ханамжийн судалгаа авч, үнэлэлт дүгнэлт өгдөг болох, жуулчдад ГГБЦГ-аас санал болгодог бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, ингэснээр аялагчдын хүлээлтийг бодит байдалд нийцүүлэх зэрэг маркетингийн үйл ажиллагаанууд, мөн жуулчны бааз, хоолны үйлчилгээний байгууллагыг цогцолборт газрын даацад тохируулан нийлүүлэлтийг улирал харгалзахгүй тогтмолжуулах, үйл ажиллагааны хүчин чадлаа бүрэн ашиглах, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдийг татаж ТХГН-т оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудад анхаарал хандуулах хэрэгтэй юм.

### 3.2.3. Аялагч, жуулчдыг хүлээн авах байршуулах хэрэгслийн чадавх, зөвшөөрөгдөх дээд хэмжээ

ГГБЦГ-ын нутаг дэвсгэр дээр өнөөгийн байдлаар 768 хүн хүлээн авах хүчин чадалтай 7 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид ямар хүчин чадалтай, хэчнээн жуулчны баазыг хаана байгуулах асуудлыг аялал жуулчлалын нөөц болон даацад тохируулан төлөвлөх нь зүйтэй.

Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын жуулчин хүлээн авах чадавхыг дараах байдлаар тооцож үзлээ (Хүснэгт 66)

Хүснэгт 66. ГГБЦГ-ын одоо байгаа жуулчны баазын хүчин чадал (жилээр)


Жуулчны бааз	Хүчин чадал /ор/	Ажиллах хугацаа 150 хоног бол (5-9сар)				Ажиллах хугацаа 90 хоног бол (6-8сар)				Ажиллах дундаж хугацаа 120 хоног бол (5.15-09.15)			
		Дүүргэлтийн хувь											
		25%	50%	75%	100%	25%	50%	75%	100%	25%	50%	75%	100%
Бүрэн	70	2625	5250	7875	10500	1575	3150	4725	6300	2100	4200	6300	8400
Говь-Эрдэнэ	118	4425	8850	13275	17700	2655	5310	7965	10620	3540	7080	10620	14160
Дүнгэнээ	110	4125	8250	12375	16500	2475	4950	7425	9900	3300	6600	9900	13200
Говь дисковъери-2	130	4875	9750	14625	19500	2925	5850	8775	11700	3900	7800	11700	15600
Говийн Анар	100	3750	7500	11250	15000	2250	4500	6750	9000	3000	6000	9000	12000
Жуулчин говь	80	3000	6000	9000	12000	1800	3600	5400	7200	2400	4800	7200	9600
Говийн Өргөө	160	6000	12000	18000	24000	3600	7200	10800	14400	4800	9600	14400	19200
Нийт баазуудын жилд хүлээн авах жуулчны тоо	768	28800	57600	86400	115200	17280	34560	51840	69120	23040	46080	69120	92160
Нэг баазын өдөрт хүлээн авах жуулчны дундаж тоо	-	27	55	82	110	27	55	82	110	27	55	82	110

Одоогийн байдлаар ГГБЦГ-т өдөрт дунджаар 300 хүн (тасалбар авсан болон жуулчны баазаар үйлчлүүлсэн хүний тоо) ирдэг ба тэдгээр нь бүгд жуулчны баазаар үйлчлүүлдэг гэж үзвэл 768 хүн хүлээн авах хүчин чадалтай дээрх 7 бааз нь хүчин чадлынхаа дөнгөж 39%-ийг л ашиглаж байна гэсэн үг юм. Хүснэгт дэх тооцооллын дагуу одоо байгаа баазууд хүчин чадлынхаа 25%-ийг ашиглавал нэг бааз өдөрт дунджаар 27 хүн, 50%-ийг ашиглавал 55 хүн, 75%-ийг ашиглавал 82 хүн, 100% ашиглавал 110 хүн хүлээн авах боломжтой юм. Тэгэхээр 7 бааз бүгд хүчин чадлаа 100% ашиглавал 770 хүн хүлээн авах боломжтой бөгөөд энэ нь ГГБЦГ-ын үндсэн 2 маршрутаар өдөрт хүлээн авах боломжтой бодит даацын нийлбэр болох 1227 хүнээс 62.6%-ийг нь хүлээн авах хүчин чадалтай нь харагдаж байна.

Гэвч даацыг тооцож үзсэн 2 маршрут нь 200 гаруй км газраар давхцаж байгаа тул жуулчны бааз нэмж байгуулах асуудлыг нийт бодит даацын дунджаар үзэх нь зүйтэй гэж үзэв. Ингэвэл дундаж бодит даац өдөрт 614 жуулчин болох бөгөөд тэдгээр жуулчдыг бүгдийг нь жуулчны баазад хүлээн авна гэж үзвэл одоо байгаа жуулчны баазууд хүчин чадлынхаа 79.9%-ийг л ашиглах боломжтойг харуулж байна.

Цаашид аялал жуулчлалын үйл ажиллагааг төлөвлөх, жуулчны бааз байгуулах асуудлыг байгаль ландшафтын эрсдэлийн нэгдсэн үнэлгээний үр дүнг харгалзан эрсдэл маш бага болон бага газруудаар төлөвлөх нь зүйтэй. ГГБЦГ-ын нийт нутаг дэвсгэрийн 55% нь энэ ангилалд багтаж байна. Энэ ангилалд багтаж буй нутаг дэвсгэрээс ойрын маршрутад 15 га, холын маршрутад 20-25 га-г аялал жуулчлалын чиглэлээр төлөвлөх боломжтой гэсэн үг юм.

**ГОВЬГУРВАН САЙХАНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОР ГАЗРЫН  
ШИНЭЭР ЖУУЛЧНЫ БААЗ БАЙГУУЛАХ БОЛОМЖИТ БАЙРШЛЫН ЗУРАГ**



*Зураг 34. Хонгорын элс орчимд шинээр аялал жуулчлалын үйл ажиллагаа төлөвлөх боломжит байршил*

Түүнчлэн ГГБЦГ-ын баруун тийш буюу Гурвантэс сумаас хойш Зулганайн баянбүрд, Наран даац, Бүгийн цавын орчим жуулчны бааз байгуулах нь зүйтэй бөгөөд цогцолборт газрын баруун тийш холын зайн аяллын маршрутын дагуу бодит даац өдөрт 850 хүн байгаа учир жуулчны баазын хэрэгцээ шаардлага тэнд үүсэж байна. Одоогоор цогцолборт газрын баруун хэсэгт орчны бүсэд Батаарын өлгий хэмээх ганц л бааз байгаа бөгөөд тэрхүү баазын хүчин чадлыг 100 хүн гэж үзвэл нэмж 100 орны хүчин чадал бүхий 4-5 жуулчны бааз, 30 орчим гэр бүхий гэр буудал байгуулах боломжтой юм. Мөн Хэрмэн цавын орчимд байгуулагдахаар төлөвлөгдсөн цогцолборыг түшиглэн жуулчны гэр бааз байгуулах боломжтой.

**3.3.ГГБЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ, ДААЦАД ҮНДЭСЛЭН  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, ЗӨВЛӨМЖ**

**3.3.1. ГГБЦГ-ын нөхцөл байдалд хийсэн шинжилгээ**

***SWOT шинжилгээ***

ГГБЦГ-ын байгаль, нийгэм эдийн засаг, аялал жуулчлалын нөөцүүд, өнөөгийн байдлыг судалсны үр дүнд дараах SWOT шинжилгээг хийв (Хүснэгт 67)

*Хүснэгт 67. ГГБЦГ-ын SWOT шинжилгээ*

Давуу талууд (STRENGTHS)	Сул талууд (WEAKNESSES)
1.“Говь” хэмээх дэлхийд танигдсан нэр хүнд 2.Монгол орны аялал жуулчлалын гол бүсийн нэг	1.Аялал жуулчлалын үйлчилгээний чадварлаг хүний нөөц хомс

3.Улаанбаатар хотоос Говь гурван сайхан уул хүртэл хатуу хучилттай замаар холбогдсон 4.Байгалийн өвөрмөц тогтоцтой 5.Түүх соёл, палеонтологийн үл хөдлөх дурсгалын нөөц ихтэй	2.ГГБЦГ-ын баруун хэсэгт аялал жуулчлалын дэд бүтэц муу 3.Хол учир тээврийн зардал өндөр 4.Хонгорын элс, Хэрмэн цав руу очих зам бартаа саад ихтэй 5.Аялал жуулчлалын үйл ажиллагаа хэсэг газраа төвлөрсөн
<b>Боломжууд (OPPORTUNITIES)</b>	<b>Аюулууд (THREATS)</b>
1.Аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, эрүүл ахуй, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх төрийн бодлого 2.Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж буй дотоодын аялал жуулчлалын хөгжил 3.ДЗ-Баяндалай-Сэврэй-Гурван тэс чиглэл дагуух авто замын бүтээн байгуулалт 4.Монгол улс руу аялах визгүй болж тоо нь хурдтай нэмэгдэж буй Солонгос жуулчдын хамгийн гол сонирхдог бүс нутаг нь “Говь” байдаг тул цаашид ч жуулчдын тоо нэмэгдэх боломжтой 5.Палеонтологийн олдвороор дэлхийд эхний 5-д багтдаг тул үлэг гүрвэлтэй холбоотой эвент, арга хэмжээ зохион байгуулах боломжтой	1.COVID-19 цар тахал зэрэг халдварт өвчин, дайн байлдаан, байгалийн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл 2.Хүний нөлөөллийн улмаас Палеонтологийн дурсгал болон соёлын өвд учрах гэмтэл, эрсдэл 3.Үйлчилгээний стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй /00, хог г.м/ 4.Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт удаан байгаа нь жуулчдын эрэлтийг багасгаж болзошгүй 5.Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт

### SWOT-АНР шинжилгээ

SWOT шинжилгээний аргыг ашиглах нь хүчин зүйлсийн нөлөөллийг тоон бус утгаар ерөнхийд нь тодорхойлдог учир нэгтгэн дүгнэхэд хүндрэлтэй байдаг. Тиймээс SWOT-АНР аргыг ашиглан тоогоор үл илэрхийлэгдэх шинжтэй үзүүлэлтийг тоон утгад шилжүүлж тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлэв (Хүснэгт 68).

Хүснэгт 68 ГГБЦГ-ын нөхцөл байдалд хийсэн SWOT-АНР шинжилгээний үр дүн

Үе шат	Бүлгийн эрэмбэ	Асуудал	Бүлэгт хамаарах асуудлын эрэмбэ	Нийт асуудлын эрэмбэ
S	0.517424	1. “Говь” хэмээх дэлхийд танигдсан нэр хүнд	0.503	0.260
		2. Монгол орны аялал жуулчлалын гол бүсийн нэг	0.108	0.056
		3. Улаанбаатар хотоос Говь гурван сайхан уул хүртэл хатуу хучилттай замаар холбогдсон	0.067	0.035
		4. Байгалийн өвөрмөц тогтоцтой	0.206	0.107
		5. Түүх соёл, палеонтологийн үл хөдлөх дурсгалын нөөц ихтэй	0.116	0.060
W	0.157490	1. Аялал жуулчлалын үйлчилгээний чадварлаг хүний нөөц хомс	0.337	0.053
		2. ГГБЦГ-ын баруун хэсэгт аялал жуулчлалын дэд бүтэц муу	0.193	0.030
		3. Хол учир тээврийн зардал өндөр	0.103	0.016
		4. Хонгорын элс, Хэрмэн цав руу очих зам бартаа саад ихтэй	0.054	0.009



		5. Аялал жуулчлал хэсэг газраа төвлөрсөн	0.313	0.049
O	0.250165	1. Аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, эрүүл ахуй, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх төрийн бодлого	0.214	0.054
		2. Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж буй дотоодын аялал жуулчлалын хөгжил	0.312	0.078
		3. ДЗ-Баяндалай-Сэврэй-Гурван тэс чиглэл дагуух авто замын бүтээн байгуулалт	0.061	0.015
		4. Монгол улс руу аялах визгүй болж тоо нь хурдтай нэмэгдэж буй Солонгос жуулчдын хамгийн гол сонирхдог бүс нутаг нь “Говь” байдаг тул цаашид ч жуулчдын тоо нэмэгдэх боломжтой	0.096	0.024
		5. Палеонтологийн олдвороор дэлхийд эхний 5-д багтдаг тул үлэг гүрвэлтэй холбоотой эвент, арга хэмжээ зохион байгуулах боломжтой	0.317	0.079
T	0.074921	1. COVID-19 цар тахал зэрэг халдварт өвчин, дайн байлдаан, байгалийн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл	0.135	0.010
		2. Хүний нөлөөллийн улмаас Палеонтологийн дурсгал болон соёлын өвд учрах гэмтэл, эрсдэл	0.279	0.021
		3. Үйлчилгээний стандартын дэд бүтэц муугаас байгаль экологид сөрөг нөлөөтэй /00-ийн үйлчилгээ г.м/	0.402	0.004
		4. Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт удаан байгаа нь жуулчдын эрэлтийг багасгаж болзошгүй	0.059	0.030
		5. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт	0.126	0.009
SUM				1

SWOT-АНР шинжилгээний үр дүнгээс харахад дараах давуу тал, боломжуудыг бид хамгийн түрүүнд ашиглах хэрэгтэй юм. Үүнд:

1. ГГБЦГ-ын хамгийн чухал давуу тал нь “Говь” хэмээх дэлхийд танигдсан нэр хүнд болон байгалийн өвөрмөц тогтоц байна. Тиймээс энэхүү дэлхийд Монголыг таниулсан нэр хүнд, говийн өвөрмөц, үзэсгэлэнт байгалийг өөрсдийн мэдээлэл, сурталчилгаандаа түлхүү ашиглах, сурталчлах шаардлагатай.
2. Палеонтологийн олдвороор дэлхийд эхний 5-д багтдаг бөгөөд энэхүү нөхцөл байдлыг хамгийн түрүүнд ашиглаж давуу талаа болгох хэрэгтэй. Үүний тулд үлэг гүрвэлийн парк, музейгээ ашиглан үлэг гүрвэлтэй холбоотой томоохон эвент, арга хэмжээг зохион байгуулах боломжтой.
3. Аялагч жуулчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь ГГБЦГ-т аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын тоог нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна. Хэдийгээр 2020, 2021 онуудад Ковид-19 цар тахалтай холбоотой олон улсын жуулчдын тоо буурсан ч, улс орнууд дахь дотоодын аялал жуулчлал өссөн нь тус цогцолборт газрын хувьд боломж юм. Олон улсын судлаачдын үзэж байгаагаар цар тахлын дараа хурдацтай сэргэх салбараар аялал жуулчлалын салбарыг нэрлэсэн байна. Үүнээс харвал Хамгаалалтын

захиргааны зүгээс цогцолбор газрын хэмжээнд аялал жуулчлалын даацад нийцүүлэн тогтвортой эко жуулчлалыг хөгжүүлэх талаар төлөвлөгөө гаргаж ажиллах нь зүйтэй.

4. Тус цогцолборт газрын ховор, ховордсон амьтан, ургамал нь мөн тухайн газрын онцлог шинж, үнэ цэнийг илэрхийлж байгаа тул тэдгээрийн хамгаалалт, нөхөн сэргээлт, судалгаа шинжилгээний ажлуудыг тогтмолжуулах, үр дүнг нийтэд түгээн дэлгэрүүлж, сурталчлахад анхаарах хэрэгтэй. Түүнчлэн энэ чиглэлээр оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөр, дэмжлэгийг татах тал дээр анхаарал хандуулах нь зүйтэй.

Сүүлийн жилүүдэд “Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”, “Алсын хараа - 2050”, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан гаргаж, аялал жуулчлалын салбарыг стратегийн чухал салбарын нэг хэмээн үзэн анхаарал хандуулах болсон нь цогцолборт газрын хэмжээнд аялал жуулчлалыг зүй зохистой хөгжүүлэхэд дэмжлэг, чиглэл болж байна.


SWOT шинжилгээний үр дүнгээс харахад дараах сул талууд болон учирч болзошгүй аюул эрсдэлд анхаарлаа зайлшгүй хандуулах шаардлагатай байна.

1. ГБЦГ-ын хамгийн эхэлж сайжруулах ёстой асуудал нь чадварлаг үйлчилгээний ажилчдыг бэлтгэх асуудал болох нь харагдаж байна. Тиймээс хүний нөөцийг сургаж бэлтгэх замаар үйлчилгээний чанарыг сайжруулах талаар анхаарах хэрэгтэй юм.
2. Мөн аялал жуулчлалын төвлөрсөн хөгжлийг сааруулах, аяллын шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, маршрутыг баяжуулах зайлшгүй шаардлагатай байна.
3. Хамгийн эхэлж анхаарч үзэх ёстой аюул бол аялал жуулчлалын буруу үйл ажиллагаанаас шалтгаалсан байгаль экологийн доройтол болох нь шинжилгээний үр дүнд харагдлаа. Тиймээс Хамгаалалтын захиргааны зүгээс энэ талаар шат дараалсан арга хэмжээнүүдийг авч, үйлчилгээний байгууллагуудад эко стандартын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллах шаардлага тавьж ажиллах нь зүйтэй.

### ***ГБЦГ-ын PESTLE шинжилгээ***

Аливаа УТХГН-уудад нөлөөлж байдаг гадаад орчны хүчин зүйлсийг судлан үзэж цаашдын бодлого, төлөвлөлтдөө анхаарч байх нь зүйн хэрэг бөгөөд ерөнхийд нь дараах хүчин зүйлсээр хэмжиж үздэг (Бүдүүвч 1).





Бүдүүвч 1. PESTLE шинжилгээний загвар

Эдгээр хүчин зүйл ГГБЦГ-ын хувьд ямар байдлаар нөлөөлж байгааг дор дурдъя.

❖ **Political – Улс төрийн хүчин зүйл**

Манай улсын хувьд улс төрийн байдал харьцангуй тайван, тогтвортой орнуудын тоонд багтах бөгөөд дэлхийн улс орнуудтай нээлттэй, чөлөөтэй харьцах боломжтой байгаа нь аялал жуулчлалын хөгжилд таатай нөлөө үзүүлдэг. Өмнөговь аймгийн хувьд аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн удирдлага буюу аймгийн ИТХ, ЗДТГ-ын зүгээс байнга дэмжиж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн байна.

❖ **Economical – Эдийн засгийн хүчин зүйл:**

Манай орны эдийн засгийн өсөлт харьцангуй нэмэгдэж буй боловч цөөн хэдэн салбараас хамааралтай болох хандлагатай /жнь: уул уурхай г.м/ байгаа бөгөөд улс орны стратегийн ач холбогдол бүхий томоохон салбарууд импортоос бүрэн хамааралтай хэвээр байгаа нь /жнь: нефть, шатах тослох түүхий эд материал, гурил улаан буудай, эрчим хүчний систем... г.м/ эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгож байна.

Мөн түүнчлэн мөнгөний ханшны уналт /инфляц/, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, ажилгүйдэл зэрэг эдийн засгийн сөрөг үзэгдэл газар авч байгаа нь бизнес эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж, эрсдэл үүсгэж байгаа юм.

Эдийн засгийн салбарын уналтад нөлөөлсөн хамгийн том хүчин зүйл бол 2019 онд дэлхий нийтийг хамарч эхэлсэн COVID-19 цар тахал юм. Энэхүү тахлын улмаас аялал жуулчлалын салбар 93% орчим хувиар уналтад орсон явдал юм.

Өмнөговь аймаг өрсөлдөх чадварын хувьд бусад аймгуудыг тэргүүлэх хэмжээний үзүүлэлттэй боловч цар тахлын нөлөөллийн улмаас төсвийн хувьд мөн адил хүнд

байдалд байна. Гэвч цар тахлын дараах эдийн засгийг сэргээх бодлого, хөтөлбөрийг аймаг орон нутгийн хэмжээнд амжилттай хэрэгжүүлж эдийн засгийн салбараа сэргээхээр хичээн ажиллаж байгаа билээ.

УБ-аас Өмнөговь аймаг хүртэл 580 км хатуу хучилттай замтай, цаашаа Ёл, Дүнгэнээ, Мухар Шивэрт, Хавцгайтын амуудаас 2-5 км зайтай дамжин өнгөрөх Баяндалай сум хүрсэн 82 км-ийн урттай хатуу хучилттай замтай. Тус амнууд руу явах авто замын хувьд бартаа саад харьцангуй бага. Аялагч амрагчдын аюулгүй байдал, зам маршрутын тохижилт болон жуулчны хэрэгцээг хангахуйц үйлдвэрлэл үйлчилгээний байгууламж дутмаг. Амнуудын орчимд 2-4 жуулчны бааз, эко түрээсийн гэрүүд байрладаг. Ариун цэврийн болоод ахуйн анхдагч хэрэгцээг хангах дэд бүтцийн нөхцөл байдал дутмаг.<sup>1</sup>

❖ ***Social – Нийгэм, соёлын хүчин зүйл:***

Соёлын орчны хувьд манай орны эртнээс нааш уламжилж ирсэн түүх соёл, өв уламжлал, зан үйл нь хэдийнээс нааш гадаадынхны сонирхлыг татаж ирсэн түүхтэй. Аялал жуулчлал нь соёлын солилцоо явагддаг нэгэн том хүчин зүйл гэдэг утгаараа монголчууд бид бүхний соёлын өв уламжлал нь аялал жуулчлалын нөөц болох боломжтой юм.

Сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын хөгжил голлон хөгжиж буй бүс нутгуудад уламжлалт зан чанар, хэв маяг алдагдах байдал илрэх болсон нь туйлын харамсалтай. Харин монголчууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эх орныхоо байгаль, түүх соёлыг танин мэдэх сонирхол харьцангуй нэмэгдэх хандлагатай байгаа нь сайшаалтай.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хил хаагдаж гадаад аяллууд зогссон нь Монголчуудын дотоодын аялал хийхэд томоохон нөлөө үзүүлж байна. Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон ГГБЦГ-ын хувьд аялал жуулчлал хөгжих боломжийг нэмэгдүүлж байна.

Манай улс нь соёл зан заншлын хэдэн зуун жилийн өргөн түүхтэй боловч даяарчлагдсан 21-р зуунд цахим ертөнцөөр дамжуулан нийгмийн эд эс болсон урлаг, спорт, дуу хөгжим, шашин зэргийг нэвтрүүлэн сонирхуулж, сонирхож суралцаж байна.

Нийгмийн хүлээн авах зан авир, үйл хөдлөлд нөлөөлдөг хүчин зүйлүүдийг хэлдэг. Ямар нэг нийгэмд хүмүүс тодорхой итгэл, үнэлэлтэй байдаг ба энэ нь амьдралын хэв маяг, шашин, үзэл бодол юм. Үүнийг шашин шүтлэг, нийгмийн хүрээллийн нөлөөллөөр өөрчилж байдаг.

Уламжлалт амьдралын хэв маягаас гадна тухайн районд байх Маанийн хийд, Уул жаргалант, Цагаан хийдийн туурь, хөшөө чулуу, цагаан хадны сүг зураг гэх мэт соёлын дурсгалууд байдаг хэдий ч ихэнх нь эвдэрч үзмэр үйлчилгээнд ашиглах боломжгүй болсон. Үнэ цэнийг нь өсгөх үйл ажиллагаа хийгдээгүй байна.

❖ ***Technological – Техник, технологийн хүчин зүйл:***

Аливаа эдийн засгийн салбарын амжилт, уналт нь орчны хүчин зүйлсийг хэр зэрэг судалж, дасан зохицож, хувьсан өөрчлөгдөж, магадгүй оновчтой зөв ашиглаж чадсан эсэхээс хамаардаг зүй тогтолтой билээ. Үүний нэгэн адил аялал жуулчлалын бизнесийн амжилт олох, бизнесийн ашиг орлоготой байх эсэх нь шинжлэх ухаан, техник

---

<sup>1</sup> “Өмнөговь аймгийн ГГБЦГ-ын Ёл, Дүнгэнээ, Мухар шивэрт, Хавцгайтын амуудад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө” 2018 он. 14ху

технологийн ололт амжилтыг хэрхэн нэвтрүүлж, бусдаас өрсөж чадсанаар хэмжигдэх цаг үе нэгэнт хаяанд ирээд байна.

Техник, технологийн дэвшил, шинжлэх ухааны ололт амжилт нь дэлхий дахины хөгжилд үзүүлэх нөлөө хурдацтай өсөн буй өнөө цагт аялал жуулчлалын салбарт ч мөн адил шууд болон шууд бус олон хэлбэрээр нөлөө үзүүлж буй бөгөөд энэ нь аялал жуулчлалын салбарын гаднын нөлөөлөлд амархан өртөмтгий байдалтай шууд хамааралтай юм.

Хэдийгээр улс орны аялал жуулчлалын өв нөөц, бүтээгдэхүүн нь жуулчдыг татах гол нөхцөлүүд мөн боловч байгаль, соёлын бодит нөөц, бүтээгдэхүүнийг аялал жуулчлалын зах зээлд хүргэх, менежмент, маркетингийг хийж үнэ цэнийг нэмэгдүүлэх нь түүнээс дутахгүй чухал билээ. Иймээс ч улам бүр өсөн нэмэгдэж байгаа өрсөлдөөнд амжилт олохын тулд зөвхөн байгаль соёлын өв, нөөцөд бус мөн хүний бүтээлч хөдөлмөр, шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурлаж бүтээлч аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлага урган гарч байна.

ГГБЦГ-ын хувьд аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж эко-аялал жуулчлал, ногоон-аялал, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлж “НОГООН ИННОВАЦИ” буюу байгальд ээлтэй техник, технологийн шийдлийг бүрэн ашиглах хэрэгтэй байна. /Жнь: дахин боловсрогдох хогийн уут, лааз, сэргээгдэх эрчим хүч г.м/

❖ **Legal – Хууль, эрхзүйн орчин:**

Төрийн зүгээс аялал жуулчлалыг дэмжиж тэргүүлэх чиглэлд хөгжүүлэх бодлого баримталж байгаа нь аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд таатай боломжийг олгож байгаа. Мөн түүнчлэн аялал жуулчлалын эрх зүйн орчин, хөрс үндсэндээ бүрдсэн гэж үзэж болно.

Монгол улс нь нийгмийн болон олон улсын харилцаагаа өргөжүүлэх үүднээс шинэ шинэлэг спорт соёлын үнэт зүйлүүдийг дэлгэрүүлж ажиллахаар хууль эрх зүйн орчиндоо тунхаглаж төсөлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд туслалцаа, хяналт, эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллаж байна. Энэ хүрээнд “Монгол улсын Алсын хараа – 2050”-д аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэгээр тодорхойлсон байдал, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” бодлогын баримт бичигт “Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно” хэмээн заасан зэрэг нь аялал жуулчлалыг тогтвортой дэмжих, хөгжүүлэх эрхзүйн орчныг бүрдүүлж байгаагийн нэг илрэл юм. Үүнд тулгуурлан “Аялал жуулчлалын Үндэсний Хөтөлбөр”, “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”, “Монгол улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг эрхзүйн баримт бичгүүдэд аялал жуулчлалын хөгжлийг дэмжих тухай тусгажээ. Харин ГГБЦГ-ын хувьд дээр дурдсан хууль, эрхзүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн онцлог, нөхцөл нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын үйлчилгээг чанаржуулах, хөгжлийг дэмжих талаар баримт бичгүүдэд тусгасан байна.

ГГБЦГ-т аялал жуулчлал хөгжүүлэх эрх зүйн орчин болох баримт бичгүүд:

- Аялал жуулчлалын тухай хууль
- ТХГН-ын тухай хууль
- ТХГН-ын орчны бүсийн тухай хууль
- ТХГН-т аялал жуулчлал эрхлэх журам
- Өмнөговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт 2019-2029

- Өмнөговь аймгийн ГГБЦГ-ын Ёл, Дүнгэнээ, Мухар шивэрт, Хавцгайтын амуудад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө
- Хонгорын гол, Хэрмэн цав орчмын байгалийн үзэсгэлэнт газрын менежментийн төлөвлөлт| 2020-2024 он

❖ **Environmental – Байгаль орчин.**<sup>2</sup>

ГГБЦГ-ын нутаг дэвсгэрт Ингэн хөөвөр–Зулганайн элс, Гурвантэсийн элс, Хонгорын элс, Халтар загийн элс зэрэг элсний томоохон хуримтлалууд орших ба эдгээр нь говийн өмнөд нутагт тархсан элсний нэлээд хувийг эзэлнэ. Дээрх элсэнд далан, довцог, бүрхэвч, манхан, цац, суварган сэвхүүл хэв шинжийн элсүүд зонхилохоос гадна бутны хошуунцар, бутны довцог, хунгар элс, сайрын элс зэрэг жижиг хэлбэрүүд мөн тархсан.

Байгалийн өвөрмөц унаган төрх, биологийн төрөл зүйл, ховор ховордсон ургамал амьтны аймагтай, дэлхийд Говь брэнд гэдгээрээ танигдсан хэдий ч хүний үйл ажиллагаанаас хамааралтайгаар үзэгдэх байдал ховордох, дайжих эрсдэлтэй.

Хүрээлэн буй орчны тогтвортой байдлын хувьд говийн бүсийн бусад газруудыг бодвол уул уурхайн салбарын нөлөөнд бага өртсөн хэдий ч байгаль цаг уурын болоод аялал жуулчлалын буруу хэрэгжилтээс хамааран байгаль орчны доройтол, сөрөг нөлөөлөл нь ихсэж байна.

**Өрсөлдөх чадварын шинжилгээ, СРМ матриц**

Хэдийгээр улсын хамгаалалтад авсан газар нутаг бүр өөр өөрийн байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан, түүх, соёлын дурсгалт зүйлс, үзэсгэлэнт байгальтай байдаг. ГГБЦГ нь Монгол орны аялал жуулчлалын гол бүс нутгийн нэг болдог тул аялал жуулчлалын өрсөлдөх чадварын хувьд ойролцоо ТХГН-тай харьцуулан Competitive Profile Matrix (СРМ) буюу Өрсөлдөөнийг тодорхойлогч матрицыг ашиглан шинжилгээ хийлээ. Энэхүү матриц нь салбарын гол өрсөлдөгчид болон салбарыг амжилтад хүргэх хүчин зүйлсийг үнэлж, харьцуулсан үзүүлэлтүүдийг илэрхийлнэ (*Хүснэгт 69*)

*Хүснэгт 69. СРМ матриц*

№	Хүчин зүйлс	Жин	Говь Гурван Сайхан БЦГ		Хөвсгөлийн БЦГ		Хөгнө-Тарнын БЦГ	
			Балл	Жинлэгдсэн оноо	Балл	Жинлэгдсэн оноо	Балл	Жинлэгдсэн оноо
1.	Байгалийн нөөц	0.2	4	0.8	4	0.8	4	0.8
2.	Түүх, соёлын нөөц	0.2	4	0.8	3	0.6	4	0.8
3.	Дэд бүтцийн хөгжил	0.15	3	0.45	3	0.45	3	0.45
4.	Хөрөнгө оруулалт	0.15	2	0.30	3	0.45	2	0.30
5.	Жуулчны үйлчилгээний байгууллага	0.08	2	0.16	4	0.32	3	0.24
6.	Аяллын бүтээгдэхүүн (маршрут)	0.05	2	0.1	3	0.15	2	0.1

<sup>2</sup> “Өмнөговь аймгийн ГГБЦГ-ын Ёл, Дүнгэнээ, Мухар шивэрт, Хавцгайтын амуудад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө” 2018 он. 14ху

7.	Зохион байгуулдаг эвент	0.12	3	0.36	4	0.48	0	0
8.	Бүсийн аяллын маршрутад тусгагдсан байдал	0.05	4	0.2	4	0.2	4	0.2
	<b>Нийт</b>	<b>1</b>		<b>3.17</b>		<b>3.45</b>		<b>2.89</b>

СРМ матрицаас харахад ГГБЦГ нь Хөвсгөлийн БЦГ-тай харьцуулахад түүх, соёлын нөөцийн хувьд илүү, байгалийн нөөц, дэд бүтцийн хөгжлийн хувьд ижил боловч олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж хөрөнгө оруулалт татаж чадаагүй, жуулчны үйлчилгээний байгууллагын хөгжил сул, аяллын маршрутын сонголт бага зэрэг үзүүлэлтүүдээрээ сул байна. Харин Хөгнө-Тарнын БЦГ-тай харьцуулахад зохион байгуулдаг эвент арга хэмжээгээрээ илүү ч жуулчны үйлчилгээний байгууллагын хөгжлөөр мөн бага байна. Тиймээс ГГБЦГ нь цаашид дотоод, гадаадын судалгаа шинжилгээний байгууллагатай хамтарч ажиллах, хөрөнгө оруулалт татах, үйлчилгээний байгууллагуудыг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарах, аяллын шинэ маршрут бий болгож, хөгжүүлэх тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй.

### 3.3.2. ТХГН-г нэвтрэх гадаад, дотоод жуулчдын тоо, орлого, зарлагыг тооцох аргачлал

ГГБЦГ-т аялах амрагч, жуулчдын тоог нарийн гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх нь тус цогцолборт газрын статистик мэдээллийн сан төдийгүй бүс нутаг, улсын аялал жуулчлалын статистик мэдээллийн санг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Энэ нь аялал жуулчлалын салбарын судалгаа шинжилгээ хийх, бүс нутгийн болон улс орны аялал жуулчлалын эдийн засгийн загварчлал гаргах, ирээдүйн таамаглалыг тооцох зэрэг ажлуудын судалгааны суурь болж өгнө.

ГГБЦГ-т нэвтэрсэн, амарч аялсан гадаад, дотоодын жуулчдын статистик тоон үзүүлэлтийг тооцохдоо Монгол улсын “Аялал жуулчлалын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал” (2011)-ыг ашиглах нь зүйтэй. Тус цогцолборт газрын аялал жуулчлалын статистик үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэрт дараах зүйлсийг харгалзан үзэж боломжтой.

1. Хяналтын постоор орсон, гарсан гадаад, дотоодын нийт амрагч, жуулчдын тоон мэдээлэл;
2. Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистикийн (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээлэл;
3. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жуулчдын дунд хийх түүвэр судалгааны дүн;
4. Хамгаалалтын захиргаанаас гадаад, дотоодын жуулчдын дунд хийх түүвэр судалгааны үр дүн;

Дээрх эх үүсвэрүүдийг ашиглан боловсруулалт хийж дараах үзүүлэлтүүдийг тооцно.

- *Цогцолборт газраар аялах нийт амрагч, аялагчдын тоо.* Үүнийг хяналтын постоор орсон, гарсан аялагч, жуулчдын тоогоор гаргах боломжтой.

- *Аялагч, жуулчдын аяллын зорилго, аяллын төрлийг* ангилан гаргана. Үүнийг Хамгаалалтын захиргаанаас авсан түүвэр судалгаанд үндэслэн гаргах боломжтой.
- *Үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо.* Үүнийг аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг жуулчны бааз болон бусад үйлчилгээний байгууллагуудын аяллын улиралд хүлээн авч үйлчилсэн нийт гадаад, дотоодын амрагч, жуулчдын тоогоор гаргах боломжтой (*Хүснэгт 70*). Үйлчилгээ авсан жуулчдын тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тайлант хугацаанд үйлчилгээ авсан жуулчдын тооны нийлбэрээр гаргана.

$$A = \sum_{i=1}^N (B_i + D_i)$$

Үүнд:

- A – Үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо
- N – Аж ахуйн нэгж, байгууллагын нийт тоо
- B<sub>i</sub> – Дотоодын жуулчдын тоо
- D<sub>i</sub> – Гадаадын жуулчдын тоо

Жишээлбэл:

*Хүснэгт 70. ГТБЦГ-ын үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо  
(2022 оны 3-р улирал)*

№	Үйлчилгээний байгууллагын нэр	Үйлчилгээ үзүүлсэн дотоодын жуулчдын тоо	Үйлчилгээ үзүүлсэн гадаадын жуулчдын тоо
1.	Жуулчны бааз 1	78	40
2.	Жуулчны бааз 2	96	62
3.	Жуулчны бааз 3	42	28
4.	Жуулчны бааз 4	85	37
5.	Жуулчны бааз 5	92	58
	<b>Нийт</b>	<b>393</b>	<b>225</b>

$$A = \sum_{i=1}^N (B_i + D_i) = (78+40) + (96+62) + (42+28) \dots\dots\dots + (92+58) = 618$$

- *Нийт орны тоо.* аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, ангийн отог болон жуулчин хүлээн авч, өөрийн зочид буудал, түр хоноглох байраар хангадаг байгууллага, иргэдийн жуулчид хоноглоход зориулсан, бүх эд зүйлээр тоноглогдсон, дэлгээтэй, үйлчилгээнд бэлэн байгаа орыг хамруулна.
- *Нийт өрөөний тоо.* Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, ангийн отог болон жуулчин хүлээн авч, өөрийн зочид буудал, түр хоноглох байраар хангадаг байгууллага, иргэдийн жуулчид хүлээн авч байрлуулахад зориулагдсан бэлэн байгаа гэр болон өрөөг хамруулна.
- *Жуулчдад үйлчилгээ үзүүлсэн ор хоногийн тоо.* Жуулчны бааз, ангийн отог болон жуулчин хүлээн авч, өөрийн зочид буудал, түр хоноглох байраар хангадаг байгууллага, иргэдийн хүлээн авсан жуулчин тус бүрд үйлчилсэн ор хоногийн нийлбэр буюу хүлээн авсан жуулчдын тоо болон хоносон хоногийн тооны үржвэрүүдийн нийлбэрээр гаргана.
- *Үйл ажиллагаа явуулсан өдрийн тоо.* Тайлант хугацаанд жуулчдад зориулан үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийг ойлгоно. Өөрөөр хэлбэл тухайн тайлант улиралд (2-р улирал, 3-р улирал г.м) ажилласан өдрийн тоо юм. Үйл ажиллагаа явуулсан нийт өдрийн тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээний газрын төрлөөр ангилан гаргана (*Хүснэгт 71*). Тайлант хугацаанд үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийн тоог аялал жуулчлалын үйл



ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тоонд харьцуулж аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тухайн хугацаанд үйлчилгээ явуулсан дундаж өдрийн тоог тооцно.

$$\bar{X}_2 = \frac{U}{N} = \frac{\sum_{i=1}^N U_i}{N} =$$

Үүнд:

$\bar{X}_2$  – Үйлчилгээ үзүүлсэн дундаж өдрийн тоо

N – Аж ахуйн нэгж байгууллагын тоо

$U_i$  – Үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийн тоо

Жишээлбэл:

*Хүснэгт 71. ГТБЦГ-ын аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа явуулсан нийт өдрийн тоо (2022 оны 3-р улирал)*

№	Үйлчилгээний байгууллагын нэр	Үйлчилгээ явуулсан нийт өдрийн тоо
1.	Жуулчны бааз 1	98
2.	Жуулчны бааз 2	120
3.	Жуулчны бааз 3	90
4.	Жуулчны бааз 4	85
5.	Жуулчны бааз 5	130
	<b>Нийт</b>	<b>523</b>

$$\bar{X}_2 = \frac{U}{N} = \frac{\sum_{i=1}^N U_i}{N} = \frac{98+120+90+85+130}{5} = \frac{523}{5} = 104.6$$

- *Аялал жуулчлалын салбарын ажилчдын тоо.* Тайлант хугацаанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд ажиллаж буй бүх төрлийн мэргэжилтэй ажилчдыг оруулна.
- *Аялал жуулчлалын салбарт ажиллаж буй аялал жуулчлалын мэргэжилтний тоо.* Тайлант хугацаанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд ажиллаж буй аялал жуулчлалын мэргэжилтэй (аялал жуулчлалын менежер, хөтөч тайлбарлагч, орчуулагч г.м) ажилчдыг хамруулна. Үүнээс хөтөч, тайлбарлагчийн тоог тусад нь гаргана.
- *Аялал жуулчлалаас орох орлого.* ТХГН-т аялж буй гадаад, дотоодын жуулчдын аливаа үйлчилгээ, барааг худалдан авахад зориулан зарцуулсан мөнгөний хэмжээний нийлбэрээр гаргах боломжтой.

Аялал жуулчлалаас орох орлогыг хоёр аргаар тодорхойлж болно.

- 1) Аялал жуулчлалын орлогыг аяллын дундаж зардлаас хамааруулан тооцох. ТХГН-ийн нутаг дэвсгэрт аялал жуулчлал хийж буй жуулчдын тоог (гадаад, дотоодын жуулчдын тоо) аялал зарцуулсан дундаж хугацаа, хоногт зарцуулсан мөнгөний дундаж хэмжээний үржвэрийн нийлбэр дүнгээр орлогын нийт хэмжээг тооцно.

Аялал жуулчлалын орлого = жуулчдын тоо \* аяллын үргэлжлэх дундаж хугацаа \* хоногийн дундаж зардал

- 2) Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жуулчдаас олсон орлогоор тооцох. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жуулчдаас олсон орлогыг тэдгээр аж ахуйн нэгж, байгууллагын улирлын болон жилийн мэдээнээс авч нэгтгэн гаргана.

- Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын жуулчдаас олсон орлого. Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын жуулчдад үйлчилгээ үзүүлж олсон орлогыг оруулна.
- Дотоодын нэг жуулчинд ногдох аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлого. Тайлант хугацаанд дотоодын жуулчдаас олсон аж ахуйн нэгж, байгууллагын нийт орлогын хэмжээг тухайн хугацаанд үйлчилгээ авсан нийт дотоодын жуулчдын тоонд харьцуулж дотоодын нэг жуулчинд ногдох ААНБ-ын дундаж орлогыг тооцно (Хүснэгт 72).

$$\overline{X_{\text{ААНБДО}}} = \frac{O_{\dot{A}}}{E_{\dot{A}}} = \frac{\sum_{i=1}^N O_{\dot{A}i}}{\sum_{i=1}^N E_{\dot{A}i}}$$

Үүнд:

$X_{\text{ААНБДО}}$  – Дотоодын нэг жуулчинд ногдох ААНБ-ын дундаж орлого

$N$  – Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

$O_{\dot{A}i}$  – Дотоодын жуулчдаас олсон ААНБ-ын орлого

$E_{\dot{A}}$  – Дотоодын жуулчдын тоо

Жишээлбэл:

Хүснэгт 72. ГГБЦГ-ын дотоодын нэг жуулчинд ногдох аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлого (2022 оны 3-р улирал)

№	Үйлчилгээний байгууллагын нэр	Дотоодын жуулчдаас орсон орлого(мян.төг)	Дотоодын жуулчдын тоо
1.	Жуулчны бааз 1	26500	78
2.	Жуулчны бааз 2	33600	96
3.	Жуулчны бааз 3	18750	42
4.	Жуулчны бааз 4	29430	85
5.	Жуулчны бааз 5	30428	92
	<b>Нийт</b>	<b>138708</b>	<b>393</b>

$$\overline{X_{\text{ААНБДО}}} = \frac{O_{\dot{A}}}{E_{\dot{A}}} = \frac{\sum_{i=1}^N O_{\dot{A}i}}{\sum_{i=1}^N E_{\dot{A}i}} = \frac{26500+33600+18750+29430+30428}{78+96+42+85+92} = \frac{138708}{393} = 352.95$$

- Аялал жуулчлалын зардал. Тус ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын нийт зардлын жуулчидтай холбоотой зардлыг эдгээр аж ахуйн нэгж, байгууллагын улирлын болон жилийн мэдээнээс авч нэгтгэн гаргана.
- Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын ТХГН-д аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал. Тайлант хугацаанд ТХГН-аар аялуулсан аялалд зарцуулсан ААНБ-ын нийт зардлын хэмжээг тухайн хугацаанд үйлчилгээ авсан дотоодын жуулчдын тоо, гадаадын жуулчдын тооны нийлбэрт харьцуулж ААНБ-ын ТХГН-аар аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардлыг тооцно (Хүснэгт 73).

$$\overline{X_{1\text{жндз}}} = \frac{\sum_{i=1}^N Z_{Mi}}{\sum_{i=1}^N (E_{\dot{A}i} + E_{\dot{A}i})}$$

Хүснэгт 73. ГГБЦГ-ын аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын ТХГН-д аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал (2022 оны 3-р улирал)

№	Үйлчилгээний байгууллагын нэр	ААНБ-ын ТХГН-д аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал (мян.төг)	Дотоодын жуулчдын тоо	Гадаадын жуулчдын тоо
1.	Жуулчны бааз 1	10600	78	40
2.	Жуулчны бааз 2	13440	96	62
3.	Жуулчны бааз 3	7500	42	28
4.	Жуулчны бааз 4	11772	85	37
5.	Жуулчны бааз 5	12171	92	58
	<b>Нийт</b>	<b>55483</b>	<b>393</b>	<b>225</b>

$$\overline{X}_{1\text{жндз}} = \frac{\sum_{i=1}^N Z_{Mi}}{\sum_{i=1}^N (E_{Ai} + E_{\overline{Ai}})} = \frac{10600+13440+7500+11772+12171}{(78+40)+(96+62)+(42+28)+(85+37)+(92+58)} = \frac{55483}{618} = 141.17$$

### 3.3.3. ТХГН-ын нөөц, даацын онцлогийг харгалзсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний норм стандартыг тогтоох

Байгаль орчны доройтол, дэлхийн дулааралтай холбоотойгоор байгалийн нөөцийг ашиглах шинэ арга зам нь дэлхий даяар экологийн жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх асуудал гэж үзэж байна. Олон улсын жуулчлалын нийт орлогод эко жуулчлалын орлогын хэмжээ 10 орчим хувийг эзэлж байгаа гэсэн баримт бий. Эко жуулчлалын хөгжил эрчимжиж байгаа өөр нэг хүчин зүйл бол аялал жуулчлалын төвлөрсөн орон зайд амралтын нягтрал нэмэгдэхийн зэрэгцээ хүн амын аж байдал дээшилж улмаар чөлөөт цагийг ухаалаг ашиглах арга сүвийг эрэлхийлж байгаатай холбон тайлбарлаж байна (“Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн үндэс” хуудас 80).

Аливаа нутаг орны амралт, аялал жуулчлалын орон зайн зохион байгуулалтыг боловсронгуй болгохын тулд 1-рт эрэлт, нийлүүлэлт, 2-рт рекреацийн үйлчилгээний менежмент, 3-рт байгалийн нөөц, экологийн менежмент, 4-рт маркетингийн менежмент, 5-рт газар зохион байгуулалт зэрэг асуудлуудыг нэгдмэл байдлаар авч үзэх бодит шаардлага урган гардаг. Иймээс аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ тухайн орон нутгийн байгаль, түүх соёлын нөөц, түүний даацын онцлогийг харгалзан бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөж өгөх нь оновчтой.

ГГБЦГ нь экосистемийн хувьд хээр, говь, цөлийн бүсийн хэв шинжийг агуулсан эмзэг бүтэцтэй нутагт тооцогдоно. Аялал жуулчлалын нөөцүүдийн хувьд одоогоор байгалийн болон түүх, соёлын онцлогтой нөөцүүд байгаа нь байгальд түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтойг харуулж байна.

Байгалийн рекреацийн нэгдсэн үнэлгээний зургаас харахад сул, дунд өндөр үнэлгээтэй бүсүүд ялгарсан байгаа нь байгаль ландшафтын хувьд өөр өөр онцлогтой аяллыг төлөвлөж, даацыг хэтрүүлэхгүй ашиглах шаардлагыг бий болгож байна. Мөн аялал-рекреацийн үнэлгээ нь амрагч, аялагчдын бие махбод, сэтгэл зүйн таатай орчныг тодорхойлж өгдөг ач холбогдолтой учраас бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэл, стандартыг тогтооход чухал үзүүлэлт нь болдог. Дээрх үндсэн судалгааг харгалзан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дараах байдлаар төлөвлөлөө (*Хүснэгт 74*).

*Хүснэгт 74. Хүснэгт. ГГБЦГ-ын бүсүүдэд хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэл*

Дэд бүс	Аялал жуулчлалын үйл ажиллагааны чиглэл
---------	---

	<b>Зөвшөөрөх</b>	<b>Хязгаарлах</b>	<b>Хориглох</b>
<b>Орчны бүс</b>	Зохион байгуулалттай тойрон аялал, малчин өрхийн аж ахуй, төрөл бүрийн үйлчилгээний байгууллага, хүүхдийн зуслан	Нийтийн зугаалгын цогцолбор	Ан агнуур, ул хөрсний боловсруулалт бүхий үйлдвэрийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа
<b>Хязгаарлалтын бүс</b>	Зохион байгуулалттай тойрон аялал, малчин өрхөд түшиглэсэн ердийн хөсөгтэй аялал, эко жуулчны бааз, өрхийн гэр буудал	Хүүхдийн зуслан, нийтийн зугаалгын цогцолбор	Ан агнуур, үйлдвэрийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, олборлох үйлдвэр
<b>Аялал жуулчлалын бүсүүдэд</b>	Явган аялал, Эко аялал, ердийн хөсөгтэй аялал, тээврийн хэрэгсэлтэй богино зайн аялал, Бага оврын нисдэг тэрэгтэй аялал	Суурьшил, нөхөрлөлийн эко отог, эко жуулчны бааз	Ан агнуур, жуулчны бааз, зочид буудал байгуулах, аж ахуйн үйл ажиллагаа

*Эх сурвалж: ГГБЦГ-ын байгалийн рекреацийн иж бүрэн үнэлгээ. Эшлэл: “Байгалийн рекреацийн газар зүй” М.Билэгсайхан, Б.Чинбат*

Тухайн бүс нутагт эко аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан дотоодын болон олон улсын стандарт, нормыг баримтлан ажиллах шаардлагатай (*Хүснэгт 75*).

*Хүснэгт 75. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний стандарт, норм*

Үйл ажиллагааны чиглэл	Баримтлах баримт бичиг	Анхаарах зүйлс
<b>Эко аялал</b>	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм, Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013	Ан амьтан болон цэцэг ажиглах аяллыг мэргэжлийн хөтөчтэй хийх
<b>Ердийн хөсөгтэй аялал</b>	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм	Орон нутгийн хөтөч, байгаль хамгаалагчийн удирдлагаар аялах
<b>Явган аялал</b>	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм	Ил гал түлэхгүй, хог хаягдлын менежментийн баримтлах,
<b>Тээврийн хэрэгсэлтэй аялал</b>	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм, Жуулчны авто тээврийн үйлчилгээ MNS 5231 : 2003	Авто замаар явах, шинээр зам гаргахгүй байх, хог хаягдлын менежмент, зориулалтын авто зогсоолд байрлуулах

<b>Бага оврын нисдэг тэрэгтэй аялал</b>	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм, Иргэний нисэх нэр томьёо, тодорхойлолт MNS 6409 : 2015	Мэргэжлийн хөтөчтэй явах, Тусгай хамгаалалттай газар нутгаар нислэг хийх зөвшөөрөл авах, Аялал жуулчлалын болон онцгой бүсэд буулт хийхгүй байх, ан амьтныг үргээхээргүй өндөрт нислэг хийх
<b>Жуулчны бааз, амралтын газар</b>	Амралтын газар, жуулчны баазад тавигдах ерөнхий шаардлага MNS 6034 : 2019	Зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх
<b>Зочид буудал</b>	Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927 : 2008	Зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх
<b>Хүүхдийн зуслан</b>	Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага MNS 5633 : 2019	Зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх
<b>Эко жуулчны бааз</b>	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013	Зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх
<b>Өрхийн гэр буудал</b>	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013	Үйлчилгээний аюулгүй байдлыг ханган ажиллах
<b>Нөхөрлөлийн эко отог</b>	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013	Үйлчилгээний аюулгүй байдлыг ханган ажиллах, Байгаль хамгаалагчтай хамтран ажиллах
<b>Спорт ангийн отог</b>	Олон улсын стандарт	Ан амьтан ажиглах болон унтуулж зураг авхуулах, судалгаа шинжилгээний ангийн аялал байна.

*Эх сурвалж: Монгол улсын стандарт*

Орчин үеийн хэрэглэгчид экологийн төлөв байдал, байгаль хамгаалалд анхаарал хандуулж байгааг эх дэлхий гэсэн ёс суртахуун улам төлөвшиж байгаатай холбож тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг эко жуулчлалын хөгжил рүү хандуулж байна. Иймээс ГБЦГ-т Хүснэгт 73-д заасан бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэхдээ эко стандартыг баримтлах нь чухал юм. Эко стандарт, эко шошго, батламж, ногоон гэрчилгээжүүлэлт зэргийг улс орон бүр өөрсдийн

онцлогт тохируулан гаргадаг боловч эдгээрийн гол үндэслэл нь 1992 оны Риогийн тунхаглалаар баталсан “Ногоон дэлхий 21” хөтөлбөрийг баримталж болох юм (*Хүснэгт 76*).

*Хүснэгт 76. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний эко стандартууд*

Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Эко стандартын шалгуур
<b>Эко аялал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Аяллын хөтөлбөр нь хувилбартай байх, жуулчдын хүсэлтээр өөрчлөх боломжтой байх</li> <li>• Цөөн аялагчтай бүлэг, ганцаарчилсан аялагчдад чиглэгдсэн байх</li> <li>• Уламжлалт газруудыг заавал үз гэж тулгахгүй байх</li> <li>• Очих газрын мэдээллийг бүрэн өгөх</li> <li>• Орон нутгийн хөтөчтэй байх</li> <li>• Экологи, байгаль орчны шалгуур, шаардлагыг хангасан тээврийн хэрэгсэл ашиглах</li> <li>• Нутгийн гаралтай хүнсийг ашиглах</li> <li>• Хог хаягдлыг орхилгүй авч явах</li> <li>• Түр буудаллах зориулалтын талбайг ашиглах</li> <li>• ТХГН-аар соёлтой аялах ёс зүйг ухамсарлуулах</li> </ul>
<b>Эко буудал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Химийн хоргүй угаалга, цэвэрлэгээний бодис ашиглах</li> <li>• Тамхигүй орчин бүрдүүлсэн байх</li> <li>• Нөхөн сэргээгдэх эрчих хүч ашиглах</li> <li>• Орон нутгийн органик хүнс ашиглах</li> <li>• Нэг удаагийн сав, баглаа, боодлоос татгалзах</li> <li>• Агаар цэвэрлэх системтэй байх</li> <li>• Саарал усыг цэвэрлэж аж ахуйдаа эргүүлэн ашиглах</li> <li>• Орон нутгийн чулуу хайрга, барилгын материал ашиглах</li> </ul>
<b>Эко гэр буудал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Тээврийн хэрэгслийн зогсоолыг гэрээс 200 метрээс багагүй зайд байрлуулах</li> <li>• Авто болон шороон замаас 2 км-ээс багагүй зайд байрлуулах</li> <li>• Байгалийн тогтоц, түүх соёлын дурсгалт газар, үзмэрээс 2 км-ээс багагүй зайд байрлана</li> <li>• Голын хөвөө, булаг, нуурын эрэг, тогтоол ус, намаг, ойн захаас 100 метрээс багагүй зайд байрлуулна</li> <li>• Ашиглалтын талбай 1 га-аас ихгүй байх ба эдэлбэр газрын ерөнхий зурагтай байна</li> <li>• Гэр хоорондын зай 10 метрээс багагүй зайд байрлана</li> <li>• Гэрээс эргэн тойрон 300 метр газарт байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байна</li> <li>• Бууриа сэлгэх сэлгээний газрыг төлөвлөсөн байна</li> <li>• Хогийн цэг гэрээс 60 метрээс багагүй зайд, салхины дор байрлуулахдаа газрын гадаргаас хөндийрсөн байгууламжид байрлуулна.</li> <li>• Бохир ус цэвэрлэх бичил байгууламжтай байх</li> </ul>



	<ul style="list-style-type: none"> <li>• Жорлонгийн нүх 2 метрээс багагүй гүнтэй байх</li> <li>• Борооны усыг цуглуулах, нөөцлөх бичил байгууламжтай байх</li> <li>• Жорлонгийн бохир усыг 7 хоногт нэг удаа задлагч бодисоор ариутгана</li> <li>• Зуны улиралд ашиглах хатаасан био түлшийг нөөцөлсөн байна</li> </ul>
<b>Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Байр, сууц, хоол, тойрон аяллын үйлчилгээ</li> <li>• Ажил үйлчилгээний мониторинг</li> <li>• Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх</li> <li>• Ажил үйлчилгээний борлуулалт, сурталчилгаа</li> <li>• Засаг захиргаа, төсөл хэрэгжүүлэгчидтэй биологийн төрөл зүйл, байгаль хамгаалах ажлыг хамтран хийж гүйцэтгэх</li> <li>• Аяллын бүтээгдэхүүн төлөвлөх, хөгжүүлэх</li> </ul>

Эх сурвалж: *Green globe 21 хөтөлбөр*

Энэхүү стандарт нь ТХГН-ийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, байр сууцны ажил үйлчилгээг эмх цэгцтэй болгоход чиглүүлэх үйл ажиллагааны үндсэн шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийн баримт бичгийг нийтээр даган хэрэглэхээр зөвшилцлийн үндсэн дээр боловсруулах нь зүйтэй юм. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн, малчин иргэн, нөхөрлөлийн зах зээлд нийлүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээ нь хэрэглэгчийн эрх ашигт харшлах, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүн эсвэл хуурамч бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс урьдчилан сэргийлэх бодлогын хамгийн анхан шатны арга хэрэгсэл бол стандарт юм.

### 3.3.4. Цаашид хэрэгжүүлэх боломжтой, санал болгож буй аяллын хөтөлбөр, маршрут

Бидний судалгааны ажлын үр дүнгээр ГГБЦГ-аар аялах тусгай сонирхлын аяллын маршрутыг хийж санал болгов (Хүснэгт 77-80).

*Хүснэгт 77. Маршрут 1. Баян төхөмийн нуурт шувуу ажиглах аялал /хавар, намрын улиралд/*

<b>Аяллын замын чиглэл:</b> Ёлын ам-Дүнгэнээгийн хавцал-Жаргалантын хийдийн туурь-Баяндалай сум-Баян төхөмийн нуур-Ёлын ам	
<b>Тээврийн хэрэгсэл</b>	Автомашинтай аялал
<b>Нийт замын урт</b>	77 км
<b>Өдөр</b>	2 өдөр 1 шөнө
<b>Амрах цэг</b>	Баян төхөмийн нуур
<b>Хонох газар</b>	Майхан
<b>Үзмэрүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>➢ Ёлын ам</li> <li>➢ Дүнгэнээгийн хавцал</li> <li>➢ Жаргалантын хийдийн туурь</li> <li>➢ Баян төхөмийн нуур</li> </ul>

*Хүснэгт 78. Маршрут 2. Үлэг гүрвэлийн мөрөөр аялал /хавар, намрын улиралд/*

<b>Аяллын замын чиглэл:</b> Хонгорын элс-Нэмэгтийн нуруу-Зулганайн баянбүрд-Хэрмэнцав-Нарандаац-Хонгорын элс	
<b>Тээврийн хэрэгсэл</b>	Автомашинтай аялал
<b>Нийт замын урт</b>	444 км
<b>Өдөр</b>	3 өдөр 2 шөнө
<b>Амрах цэг -1</b>	Нэмэгтийн нуруу
<b>Амрах цэг -2</b>	Зулганайн баянбүрд
<b>Амрах цэг -3</b>	Хэрмэнцав
<b>Амрах цэг -4</b>	Нарандаацын булаг
<b>Хонох газар</b>	Майхан, Наран даацын жуулчны бааз
<b>Үзмэрүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Нэмэгтийн нуруу</li> <li>➤ Зулганайн баянбүрд</li> <li>➤ Хэрмэнцав</li> <li>➤ Нарандаац булаг</li> </ul>

*Хүснэгт 79. Маршрут 3. Морь ба тэмээн аялал*

<b>Аяллын замын чиглэл:</b> Хонгорын элс-Нэмэгтийн нуруу-Хонгорын элс	
<b>Тээврийн хэрэгсэл</b>	Морь, тэмээн аялал
<b>Нийт замын урт</b>	108 км
<b>Өдөр</b>	2 өдөр, 1 шөнө
<b>Хонох газар</b>	Нэмэгтийн нуруу
<b>Үзмэрүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Нэмэгт уул</li> <li>➤ Хонгорын элс</li> <li>➤ Хонгорын гол</li> </ul>

*Хүснэгт 80. Маршрут 4. Холын зайн өвөрмөц аяллын замнал*

<b>Аяллын замын чиглэл:</b> Даланзадгад-Хонгорын элс-Нэмэгтийн нуруу-Наран даац- Хэрмэнцав-Зулганайн баянбүрд-Бүгийн цав-Зулганайн баянбүрд-Нарандаац-Хонгорын элс	
<b>Аяллын онцлог:</b> Өмнө нь Нэмэгтийн дээд давхаргадас хэмээн нэрлэгдэж байсан Нэмэгт формац нь Монголын говиор илэрдэг хожуу цэрдийн хамгийн залуу хурдас хуримтлал юм. Үнэмлэхүй болон харьцангуй нас нь баттай тогтоогдоогүй боловч хожуу Кампани-түрүү болон дунд Маастрихтын цаг хугацааг хамардаг. Энэ нь 400 м хүртэл зузаалагтайгаар Баруун гоёот формац дээр хуримтлагдан тогтдог. Улирлын шинжтэй бороошдог, хагас чийглэг дулаан уур амьсгалтай нөхцөлд хуримтлагдсан уг давхаргадсаас чулуужсан мод, дун хясаа, хоёр нутагтан, загас, яст мэлхий, матар, үлэг гүрвэлийн өндөг, үлэг гүрвэлийн олон төрлийн баялаг олдворууд олддог. Маш олон төрлийн махан идэшт үлэг гүрвэлүүд олддог боловч өвсөн идэштнийх нь ховор олддог.	
<b>Тээврийн хэрэгсэл</b>	Жийптэй аялал
<b>Нийт замын урт</b>	108 км
<b>Өдөр</b>	5 өдөр, 4 шөнө
<b>Хонох газар-1</b>	Нэмэгтийн нуруу
<b>Хонох газар -2</b>	Хэрмэнцав
<b>Хонох газар -3</b>	Зулганайн баянбүрд
<b>Хонох газар -4</b>	Нарандаац

Эдгээр маршрутын дагуу аялал жуулчлалыг энэ нутагт хөгжүүлэх эх үндэс нь Баяндалай сумаас Сэврэй сум хүртэл Хонгорын элсээр дамжин өнгөрөх замын дэд бүтцийг шинээр төлөвлөж хөгжүүлэх шаардлагатай. Жишээ нь Хонгорын элс бол аялагч жуулчдын хамгийн ихээр зорьж очдог газар бөгөөд нөгөө талаар холын зайн аяллын маршрутууд руу явахын тулд Гурван сайхан уул, Хонгорын элсийг үзэж сонирхоод цааш явах хандлага их байдаг тул тэр хэсгийг засмал замтай болгох нь хөрсний эвдрэлийг багасгах юм.

### **3.3.5. ГГБЦГ-т аялал жуулчлалыг түүний нөөц, даацад тохируулан хөгжүүлэхэд анхаарах зүйлс**

Олон улсын аялал жуулчлалын зэрэгцээ дотоодын аялагчдын амралт, аялал жуулчлал хүрээгээ тэлж байгаа нь байгаль рекреаци, түүний орон зайн төлөвлөлт, зохион байгуулалтыг ирээдүй үеийнхний хэрэгцээнд тохирсон тэдэнд хор учруулахгүй бөгөөд одоогийн хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгох бодит шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын шинжээчид тухайн орны гадаадад гарсан, гадаадаас ирж байгаа болон дотоодод аялж байгаа жуулчдын тооны харьцаа 1:1:4 байвал зохистой үзэгдэл гэж үздэг. ГГБЦГ-т ирж байгаа аялагчдын тоог харахад ямагт дотоодын аялагчид нь илүү байхын зэрэгцээ жил ирэх тусам өсөж байна. Энэ нь цаашид дотоодын аяллын томоохон зорин очих газар болох боломжтой байгааг илтгэж байна.

Амралт, аялал жуулчлалын үйл ажиллагаа явагдах орон зайг тэлэх нь нэг талын таатай үзүүлэлт хэдий ч орон зайн бүтэц, оновчтой зохион байгуулалт нь түүнээс илүү ач холбогдолтой асуудал болно. Газар нутгийн амралт аялал жуулчлалын орон зайн зохион байгуулалтыг боловсронгуй болгохын тулд

1. Эрэлт, нийлүүлэлт
2. Рекреацийн үйлчилгээний менежмент
3. Байгалийн нөөц, даац, экологийн менежмент
4. Маркетингийн менежмент
5. Газар зохион байгуулалт

зэрэг асуудлуудыг нэгдмэл байдлаар авч үзэх бодит шаардлага урган гарч байна.

Өнөөдрийн байдлаар бүс нутгийн аж ахуйн чиг үүргийн нэг хэлбэр нь байгалийн аялал-рекреаци болоод байна. Цаашид ч өргөжих хандлагатай байгаа бөгөөд аж ахуйн энэ үйл ажиллагааны гол зорилго нь дотоодын хүн амын таатай аж төрөх, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, экологийн аюулгүй орчныг бүрдүүлэх, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалахад оршино. Байгалийн аялал-рекреацийн хөгжлийн түвшин нь суурьшил, бүсийн нийгэм-эдийн засгийн нөхцөл, газар зүйн байршил, физик газар зүй, байгалийн болон рекреацийн нөхцөл, нөөцөөр тодорхойлогдож байдаг.

Амралт, аялал жуулчлалын бизнес эрхлэгчид ихэвчлэн санхүүгийн хязгаартай нөөц, өөрийн туршлага чадварт тулгуурлан газар зүйн нөхцөл, нөөцийн тухай асуудлыг үл харгалзан ерөнхий төлөвлөлтгүй ажиллавал аюул үзүүлэх юм. Үүнээс сэргийлэхийн тулд:

- *Нэг нэгнээ давтаагүй тодорхой үйл ажиллагааны чиглэл бүхий онцлогтой жуулчны бааз, амралтын газруудын хамтын ажиллагааг бэхжүүлэх.* Цаашид

төлөвлөх жуулчны баазууд бие биеэсээ ялгарах онцлогтой аяллын бүтээгдэхүүнийг санал болгож, үйлчилгээ үзүүлэх. Жишээ нь: нэг бааз нь цагаан идээний боловсруулалтыг амрагчдад үзүүлж, нутгийн брэнд бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг байхад нөгөө бааз нь морин аялал явуулдаг байх гэх мэт

- *Орон зайн хуваарилалт нь рекреацийн хөгжлийг удирдах сонгодог арга бөгөөд бичил бүсүүдийн оройн зайд аялал-рекреацийн бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх эсвэл сарниулах стратегийн сонголт хийх*
- *Рекреацийн нөхцөлийн үр дүнд тулгуурлан бичил бүсүүдийн рекреацийн дэд бүтцийг оновчтой байрлуулах, байгаа нөөцөө зах зээлийн эргэлтэд оруулж давуу тал болгох боломжийг бүрдүүлэх*
- *Хамгаалалтын захиргаа нь аялал жуулчлалын бизнест бодлогын чанартай хамтрагчаар оролцож, хөгжлийн үйл явцыг хянах*

Жуулчны баазын үйл ажиллагаанд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

1. БЦГ-т аялал жуулчлалын үйл ажиллагааг хөгжүүлэхдээ аль болох хязгаарлалтын бүс болон орчны бүсэд жуулчны баазуудыг төлөвлөх нь зүйтэй юм. Орчин үед олон улсын жуулчид яг үзмэр дээрээ байрлан хоноглохоос илүүтэй нэг талаас тогтвортой аялал жуулчлалыг дэмжих, нөгөө талаас идэвхтэй аялал хийж адал явдал эрэлхийлэхийг илүүд үзэх болсон. Тиймээс баазуудыг аялал жуулчлалын бүсээс гадна төлөвлөж баазад хоноглосон жуулчид үзмэрт очихын тулд явган аялал, морин болон тэмээн аялал, дугуйн аялал, авто машинтай аялал зэрэг аяллын төрлүүдээс сонгож, эсвэл тээврийн хэрэгслийг хосолсон байдлаар ашигладаг болох нь байгаль орчин, хамгаалалттай нутаг дэвсгэрийн экосистемд ач холбогдолтой юм.
2. Түүнчлэн одоо байгаа жуулчны баазууд хэтэрхий нэг дор төвлөрсөн байгааг анхаарах хэрэгтэй. Жуулчны баазыг жуулчдын тухайн цогцолборт газарт хүрэлцэн ирэх зам чиглэл, үзмэрүүдийн байрлал, орон зай, хүрэх боломж, цаг хугацаа, аялал жуулчлалын даац болон бизнесийн ашигтай байдлыг харгалзан тараан байршуулах нь байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх нэг гарц болно.
3. Бидний дотоодын жуулчдаас авсан судалгаанаас харахад тэдний 27.3% нь жуулчны баазад хоноглох хүсэлтэй байгаа бол 46.6% нь майхан болон хамаатан садан, найз нөхдийндөө хоноглохыг илүүд үзсэн байна. Үүнээс үзвэл бодит байдал дээр дотоодын жуулчдаас гадаадын жуулчид жуулчны баазуудад илүүтэй байрлан хоноглох бөгөөд жуулчны олон бааз байгуулахаас илүү отоглох цэгийг нэмж байгуулах нь зүйтэй юм.

Жуулчны баазын хүчин чадлыг бүрэн ашиглахын тулд баазууд аялагч, жуулчдад санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ сонголт, нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөхүйц үнэ санал болгох хэрэгтэй. Түүнчлэн ГБЦГ-ын Хамгаалалтын Захиргааны зүгээс тус цогцолборт газарт үйл ажиллагаа явуулах жуулчны баазуудад энэхүү тайлангийн 3.3.3. хэсэгт заагдсан Монгол улсын болон олон улсын эко стандарт, шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үйл ажиллагаа явуулахыг шаардах, хяналт тавих хэрэгтэй юм.

### 3.3.6. Аялал жуулчлалын нөөцийг зохистой ашиглах, хамгаалах байдлаар ГГБЦГ-т хөгжүүлэх боломжтой аяллын зарим төрлүүд

ГГБЦГ-т байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг дэмжих, ялангуяа экологийн аялал жуулчлалын төрлүүдийг хөгжүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй.

- *Амьтан ажиглах аялал жуулчлалыг хөгжүүлэх.* Орчин үед ан амьтныг агнахаасаа илүү ажиглах сонирхолтой хүмүүсийн тоо огцом өсөж, улс, тив дамжин ан амьтныг харах, ажиглах, аялах болсон нь энэ аялал хөгжих үндэс болно. 2000-аад оноос хойш гадаадын жуулчдын аяллын багийн бүрэлдэхүүнд амьтан ажиглагчид олширсон нь аялал жуулчлалын операторууд өөрсдийн ан амьтан ажиглах маршрут болон хөтөлбөртэй болох нөхцөлийг бүрдүүлсэн. ГГБЦГ-т хавтгай тэмээ, аргаль хонь, янгир ямаа, цоохор ирвэс, хулан адуу, хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг дэлхийд ховорт тооцогдох болсон амьтдыг ажиглах, зураглах аяллыг хөгжүүлэх боломжтой. Хамгаалалтын захиргааны зүгээс амьтан ажиглах аяллыг хөгжүүлэх талаар томоохон зорилт тавин ан амьтдын талаар нарийвчилсан судалгаануудыг холбогдох мэргэжлийн хүмүүстэй хийх, ховор болон нэн ховор ан амьтдыг тодорхойлж, амьдрах орчин, экологийн зохистой нутаг, онцлог бүрд харгалзуулан аяллын маршрут хийж, хүүхэд залуусыг төлөвшүүлэх, аяллын бүтээгдэхүүн болгон цаашид тогтвортой хөгжүүлэх боломж байна.

Жуулчдад амьтдыг хаанаас олж харах асуудал илүү чухал. ГГБЦГ-т тархсан хөхтөн амьтдыг харах боломжтой газрыг хүснэгтээр тодорхойлов (Хүснэгт 81).

*Хүснэгт 81. Нэн ховор, ховор амьтдыг ажиглах боломжтой газрууд*

№	Зүйлийн нэр	Харах боломжтой газар нутаг	Харагдах хугацаа, анхаарах зүйлс
1	Аргаль хонь	Хүрмэн сумын нутаг Зүүн сайханы Дүнгэнээгийн эх, Хүрэн шанд, Хүрэн шандын хэцийн хар, Мухар эрэг, Хөндлөн, Далан ухаа, Хашаат, Баяндалай сумын Баянцагаан, Дундсайхан, Сэврэй сумын Баянбор нуруу, Зөөлөн уулын баруун хойд хэсэг, Сэврэй уулын зүүн хойд хэсэг, Эрээн уул, Гурвантэс сумын Алтан, Гилбэнт, Нэмэгт, Тост уул	Жилийн турш харах боломжтой, намар, өвөл, хавар өглөөд уулын энгэрт нарлах үеэр, зун эрт усанд орох газарт, нялх төлтэй байхдаа хүнээс дайжимтгай, уулын хэц хажуугаас зайчиж бэлчдэг.
2	Янгир ямаа	Хүрмэн сумын нутаг Зүүн сайханы Дүнгэнээгийн эх, Хүрэн шанд, Хүрэн шандын хэцийн хар, Мухар эрэг, Хөндлөн, Далан ухаа, Хашаат, Баяндалай сумын Баянцагаан, Дундсайхан, Сэврэй сумын Баянбор нуруу, Зөөлөн уулын баруун хойд хэсэг, Сэврэй уулын зүүн хойд хэсэг, Эрээн уул, Гурвантэс сумын Алтан, Гилбэнт, Нэмэгт, Тост ууланд байршина	Жилийн турш харах боломжтой, намар, өвөл, хавар өглөөд уулын энгэрт нарлах үер, зун аргаль хонины дараа усанд орох газарт, нялх төлтэй байхдаа хүнээс дайжимтгай, уулын хэц хажуугаас холдохгүй бэлчинэ.
3	Хар сүүлт	Сэврэй сумын Баянбор нуруу, Зөөлөн уулын баруун хойд хэсэг, Сэврэй уулын зүүн хойд хэсэг, Эрээн уул, Гурвантэс сумын Алтан, Гилбэнт, Нэмэгт, Тост уул зэрэг том уулсаар дагаж байршина	Өдөртөө уулын өгсүүр, бартаа дагаж идээшлэн, шөнөдөө уулаас бууж нам хэсэгт
4	Хулан адуу	Сэврэй нурууны ар, өвөр, Зөөлөнгийн нурууны өвөр хоолой, Базагуучийн хоолой хүртэл,	Дулаан улиралд усанд орох газарт

		Эрээний нурууны ар хүртэл цөөн тоогоор нутаглана.	
5	Цоохор ирвэс	Атан уул, Нэмэгт, Гилбэнт, Зөөлөн, Баруунсайхан, Дундсайхан, Зүүнсайхан уулсын өндөрлөг хэсэгт байрлана.	Ул мөрийн үлдэц бүхий газар автомат камер ашиглан зураг бичлэг хийх боломжтой.
6	Халиун буга	Хоёр байрлалд гаршуулан тэжээж байгаа	Жилийн турш
7	Цагаан зээр	Гурван сайханы ар хэсэгт нүүдлийн байдлаар үзэгдэнэ.	Өвлийн улирал
8	Саарал чоно	Бартаа бүхий бүх хэсэгт тархсан	Говийн бартаа бүхий гадаргад ойртож ажиглах боломж багатай

Аяллын энэхүү төрлийг хөгжүүлэхийн тулд бүх талуудыг оролцуулан ан амьтан ажиглах аяллын урт хугацааны, тогтвортой, чанартай бүтээгдэхүүнийг боловсруулах хэрэгтэй. Ан амьтан тус бүрийн экологийн зохистой бүс нутагт тохирсон үйлчилгээ, үзэх ажиглах орчныг бий болгох, бүс бүрийн ан амьтад, шувууны зүйлийн өвөрмөц бүрдлийг илэрхийлсэн ан амьтан ажиглах аяллын маршрут бий болгох, түүнд тулгуурласан мэдээллийн төвийг ажиллуулах, өөрийн нутаглаж буй нутаг орноо сайн мэддэг, өрхийн орлогоо нэмэгдүүлэх сонирхол бүхий нутгийн иргэдэд түшиглэж амьтан ажиглах аяллын хөтчийг сургаж бэлтгэх нь зүйтэй.

- *Шувуу ажиглах аялыг хөгжүүлэх.* Олон улсад өндөр хөгжсөн шувуу ажиглах аялал нь Монголд 20 гаруй жилийн өмнөөс эхэлсэн ч өнөөг хүртэл тогтвортой бус байгаа нь энэ аялалд шаардагдах үндсэн нөхцөлүүд хангагдаагүйтэй холбоотой юм. Шувуу ажиглах аялал гэдэг нь байгалийн баялаг болох жигүүртэн амьтдын амьдралын онцлог, үйл хөдлөл зэргийг мэргэжлийн болон хувийн сонирхолдоо тулгуурлан ямар нэгэн сөрөг нөлөөгүйгээр аяллын үзмэр болгон ашиглаж, судлахыг хэлдэг.

Шувуу ажиглахаар ирдэг гадаадын жуулчид Монголд харахыг хүссэн 30 орчим зүйл шувуудын нэрсийг жагсаан ирдэг бөгөөд тэдгээрийн дийлэнх нь манай орны хээр болон говийн бүсээр тархалттай шувууд байдаг. Жишээ нь хулан жороо *Podoces hedersoni*, монгол ногтруу *Syrhaptes paradoxus*, цөлийн зэржгэнэ *Sylvia nana*, цөлийн чогчого *Oenanthe deserti*, загийн бор шувуу *Passer ammodendri*, мөн монгол болжмор *Melanocorypha mongolica*, монгол газрын бор шувуу *Pyrghilauda davidiana* зэрэг шувууд үүнд багтдаг. ГБЦГ нь зөвхөн говь, цөлийн бүсэд орших өвөрмөц шувуудын бүрдэлтэй бөгөөд энэ чиглэл амжилттай хөгжих боломжтой.

- *Ургамал ажиглах аялал хөгжүүлэх.* Байгалийн эко аялал жуулчлалд идэвхтэй байр суурь эзэлдэг аяллын нэг төрөл нь “Цэцэг, ургамал үзэх аялал” юм. Тус аялалд 50-иас дээш насны эмэгтэй жуулчид голчлон оролцдог ба цэцэгсийн талаарх мэдлэг боловсрол өндөр байдаг. Бие биеэсээ асууж сураглан таньж мэдэх, тааралдсан цэцгийнхээ зургийг дарж таашаал авах зэргээр аялдаг бөгөөд цэцэгсийг таслах, дээгүүр нь алхаж гишгэхээс зайлсхийдэг. Жуулчид ихэвчлэн тухайн цэцгийн орон нутгийн нэрийг андахгүй мэддэг бөгөөд шинжлэх ухааны нэрийг заавал мэдэж авах хэрэгтэй гэж улайрдаггүй онцлогтой. Говийн бүс нутагт дэлгэрэх цэцэгс төрлийн хувьд цөөн боловч говь хээрийн тал нутгийг



битүү бүрхэн дэлгэрч жуулчдыг дуу алдуулан гайхшируулах тохиолдлууд бий. Зарим хүмүүсийн төсөөлөлд говийн бүсэд “цэцэг үзэх аялал”-ыг зохиох боломжгүй гэж ойлгодог. Харин ч эсрэгээрээ “үлдвэр ургамал” хэмээх тодотголтой эртний ургамал цэцгийн төрлүүдээс энэ бүсэд тааралдах нь бий. Говийн бүсийн цэцэгс хангай газрын цэцэг ургамлаас илүү тод, гүн өнгөтэй байдаг онцлогтой. Халуун нар төөнөсөн, хуурай салхилсан, гол усны нөөцгүй хахир хатуу нөхцөлтэй говь цөлийн бүсэд ч жуулчид болон дэлхийн ургамал судлалын мэргэжилтнүүдийн анхаарлыг татсан цэцэг ургамал нэлээд бий. Өөрөөр хэлбэл, нэн ховор статустай ургамлууд их ургадаг нь ургамал зүйн бүлэглэлээр бол гаднынханд их сонирхолтой байдаг. Орос, Герман, Америк, Хятад, Японы эрдэмтэн судлаач аялагчид Монголын говь цөлийн бүсэд сүүлийн жилүүдэд идэвхтэй судалгаануудыг хийж байна. Оросуудын хувьд сүүлийн 50 жилийн туршид Монголын говийн ургамлын судалгааг “маш сонирхолтой” хэмээн хэрэгжүүлж иржээ. Говийн бүсэд Бүйлс, Ягаан сухай, Монгол догор, Потанины улаан тулам, Ацан цахилдаг, Хулангийн ундаа гэх мэт ховор цэцгүүд анхаарал татдаг. Мөн Заг модны үндсэн дээр паразиталж ургадаг Цагаан ба Улаан гоёо нь судалгааны бас нэгэн судлагдахуун болно. ГГБЦГ-т нэн ховор, ховор ургамлыг хаанаас үзэх боломжтой, тархац нутгийг сумын хэмжээнд тодорхойлохыг зорилоо (Хүснэгт 82-83).

Хүснэгт 82. ГГБЦГ-ийн нэн ховор ургамалын тархац, сумдаар

№	Сумдын нэрс	Ховор ургамлын нэрс	Зүйлийн тоо
1	Сэврэй	Хонин арц ( <i>Juniperus sabina</i> L.), Хулан хойрго ( <i>Potaninia mongolica</i> Maxim.), Хойрог харгана ( <i>Caragana brachypoda</i> Pojark.), Монгол буурцгана ( <i>Chesneya mongolica</i> Maxim.), Потанины хотир ( <i>Zygophyllum Potaninii</i> Maxim.), Алтан бэрмэг ( <i>Limonium aureum</i> (L.) Hill ex Ktze.), Говийн тост ( <i>Brachanthemum gobicum</i> Krasch.)	7
2	Баяндалай	Шивлээхэй зээргэнэ ( <i>Ephedra equisetina</i> Bge.), Элдэв навчит улиас ( <i>Populus diversifolia</i> Schrenk.), Ганц судалт гишүүнэ ( <i>Rheum uninerve</i> Maxim.), Монгол мөнххаргана ( <i>Ammopiptanthus mongolicus</i> (Maxim. ex Kom.) Cheng.), Ганц навчит сальжир ( <i>Gueldenstaedtia monophylla</i> Fisch.), Потанины хотир ( <i>Zygophyllum Potaninii</i> Maxim.), Алтан бэрмэг ( <i>Limonium aureum</i> (L.) Hill ex Ktze.), Сибирь тэмээн хөх ( <i>Vincetoxicum sibiricum</i> (L.) Decne.), Потанины улаан тулам ( <i>Incarvilla Potaninii</i> Batal.), Цөлийн аргамжин цэцэг ( <i>Cistanche deserticola</i> Ma.), Төв Азийн лавай ( <i>Asterothamnus centrali-asiaticus</i> Novopokr.), Цагаан навчит хасзул ( <i>Olgaea leucophylla</i> (Turch.) Pjin)	12
3	Булган	Хойрог харгана ( <i>Caragana brachypoda</i> Pojark.), Потанины хотир ( <i>Zygophyllum Potaninii</i> Maxim.), Алтан бэрмэг ( <i>Limonium aureum</i> (L.) Hill ex Ktze.),	3
4	Ханхонгор	Хонин арц ( <i>Juniperus sabina</i> L.), Ганц судалт гишүүнэ ( <i>Rheum uninerve</i> Maxim.), Ягаан мөгээ ( <i>Rhodiola rosea</i> L.), Сайханы бамбай ( <i>Valeriana saichanensis</i> Kom.)	4
5	Гурвантэс	Хонин арц ( <i>Juniperus sabina</i> L.), Шивлээхэй зээргэнэ ( <i>Ephedra equisetina</i> Bge.), Элдэв навчит улиас ( <i>Populus diversifolia</i> Schrenk.), Хулан хойрго ( <i>Potaninia mongolica</i> Maxim.), Хойрог харгана ( <i>Caragana brachypoda</i> Pojark.), Монгол буурцгана ( <i>Chesneya mongolica</i> Maxim.), Потанины хотир ( <i>Zygophyllum Potaninii</i> Maxim.),	9

		Алтан бэрмэг ( <i>Limonium aureum</i> (L.) Hill ex Ktze.), Говийн тост ( <i>Brachanthemum gobicum</i> Krasch.)	
6	Хүрмэн	Элдэв навчит улиас ( <i>Populus diversifolia</i> Schrenk.), Хулан хойрго ( <i>Potaninia mongolica</i> Maxim.), Хойрог харгана ( <i>Caragana brachypoda</i> Rojark.), Монгол мөнххаргана ( <i>Ammoptanthus mongolicus</i> (Maxim. ex Kom.) Cheng.), Цагаан навчит хасзул ( <i>Olgaea leucophylla</i> (Turch.) Iljin)	5

Хүснэгт 83. ГГБЦГ-ийн ховор ургамалын тархац, сумдаар

№	Сумдын нэрс	Ховор ургамалын нэрс	Зүйлийн тоо
1	Сэврэй	Эгэл нишингэ ( <i>Phragmites communis</i> Trin.), Шивүүрт цулихир ( <i>Agriophyllum pungens</i> (Vahl) Link ex.A. Dietr.), Зүүнгарын гоёо ( <i>Synotarium songaricum</i> Rupr.), Өргөст ортууз ( <i>Oxytropis aciphylla</i> Ldb.), Үлдэн могойн идээ ( <i>Sedum aizoon</i> L.), Нангиад зээргэнэ ( <i>Ephedra sinica</i> Stap.), Хуурамч хорон хурган ( <i>Rumex pseudonatronatus</i> Borb.).	7
2	Баяндалай	Эгэл нишингэ ( <i>Phragmites communis</i> Trin.), Шивүүрт цулихир ( <i>Agriophyllum pungens</i> (Vahl) Link ex.A. Dietr.), Зүүнгарын гоёо ( <i>Synotarium songaricum</i> Rupr.), Өргөст ортууз ( <i>Oxytropis aciphylla</i> Ldb.), Монгол бүйлээс ( <i>Amygdalus mongolica</i> Maxim.), Урал чихэр өвс ( <i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.), Шаргал шарилж ( <i>Artemisia rutifolia</i> Steph. ex Spreng.)	7
3	Булган	Эгэл нишингэ ( <i>Phragmites communis</i> Trin.), Шивүүрт цулихир ( <i>Agriophyllum pungens</i> (Vahl) Link ex.A. Dietr.), Зүүнгарын гоёо ( <i>Synotarium songaricum</i> Rupr.), Өргөст ортууз ( <i>Oxytropis aciphylla</i> Ldb.), Алтайн сонгино ( <i>Allium altaicum</i> Pall.), Потаниний цахилдаг ( <i>Iris Potaninii</i> Maxim.), Ацан ажигана ( <i>Stellaria dichotoma</i> L.), Үлдэн могойн идээ ( <i>Sedum aizoon</i> L.), Монгол хунчир ( <i>Astragalus mongolicus</i> Bge.), Монгол тарваган шийр ( <i>Thermopsis mongolica</i> Czefr.).	10
4	Ханхонгор	Эгэл нишингэ ( <i>Phragmites communis</i> Trin.), Шивүүрт цулихир ( <i>Agriophyllum pungens</i> (Vahl) Link ex.A. Dietr.), Зүүнгарын гоёо ( <i>Synotarium songaricum</i> Rupr.), Өргөст ортууз ( <i>Oxytropis aciphylla</i> Ldb.) Согтоонги дэрс ( <i>Achnatherum inebrians</i> (Hance) Keng.), Алтайн сонгино ( <i>Allium altaicum</i> Pall.), Потаниний цахилдаг ( <i>Iris Potaninii</i> Maxim.), Монгол шээрэнгэ ( <i>Silene mongolica</i> Maxim.), Сайханы намуу ( <i>Papaver saichanense</i> Grub.), Том үрт тольт өвс ( <i>Galitzkya macrocarpa</i> (Ik.-Gal.) V. Bocz.), Үлдэн могойн идээ ( <i>Sedum aizoon</i> L.), Өргөст тошлой ( <i>Grossularia acicularis</i> (Smith) Spach.), Монгол хунчир ( <i>Astragalus mongolicus</i> Bge.), Семеновын гиш ( <i>Vicia Semenovii</i> (Rgl. et Herd.) B. Fedtsch.), Сахлай дэгд ( <i>Gentiana barbata</i> Froel.), Нэлэмгэр сунараа ( <i>Asperula humifusa</i> (M.B.) Bess.), Алтайн далан хальс ( <i>Lonicera altaica</i> Pall.)	17
5	Гурвантэс	Эгэл нишингэ ( <i>Phragmites communis</i> Trin.), Шивүүрт цулихир ( <i>Agriophyllum pungens</i> (Vahl) Link ex.A. Dietr.), Зүүнгарын гоёо ( <i>Synotarium songaricum</i> Rupr.), Өргөст ортууз ( <i>Oxytropis aciphylla</i> Ldb.), Говийн хотир ( <i>Zygophyllum gobicum</i> Maxim.), Хар шарилж ( <i>Artemisia santolinifolia</i> Turcz. ex Bess.), Согтоонги дэрс ( <i>Achnatherum inebrians</i> (Hance) Keng.), Алтайн сонгино ( <i>Allium altaicum</i> Pall.), Потаниний цахилдаг ( <i>Iris Potaninii</i> Maxim.), Үлдэн могойн идээ ( <i>Sedum aizoon</i> L.), Монгол бүйлээс ( <i>Amygdalus mongolica</i> Maxim.), Монгол бүйлээс ( <i>Amygdalus mongolica</i> Maxim.), Үнэгэн сүүлхэй лидэр ( <i>Sophora alopecuroides</i> L.), Урал чихэр өвс ( <i>Glycyrrhiza</i>	18

		<i>uralensis</i> Fisch.), Хөх ногоон хоног будаа ( <i>Setaria glauca</i> (L.) P.B.), Юлдэн тэмээн хөх ( <i>Vincetoxicum lanceolatum</i> (Grub.) Grub.), Цагаан хошоон ( <i>Melilotus albus</i> Medic.), Говийн азар ( <i>Calligonum gobicum</i> Bge.ex Meisn.).	
6	Хүрмэн	Эгэл нишингэ ( <i>Phragmites communis</i> Trin.), Шивүүрт цулихир ( <i>Agriophyllum pungens</i> (Vahl) Link ex.A. Dietr.), Зүүнгарын гоёо ( <i>Synomorium songaricum</i> Rupr.), Өргөст ортууз ( <i>Oxytropis aciphylla</i> Ldb.), Говийн хотир ( <i>Zygophyllum gobicum</i> Maxim.).	5

Энэхүү хүснэгтэд тулгуурлан ямар ургамлыг хаанаас хэзээ үзэх боломжтойг тогтоож цэцэг, ургамал сонирхогчдод зориулсан тусгай аяллын маршрут зохиох боломжтой. Аяллын маршрутыг хүнд хүргэхийн тулд эдгээр нэн ховор, ховор ургамлын зурагт лавлах гаргаж сурталчлах нь илүү үр дүнтэй. Ургамал, цэцэг нь нэг газраа тогтвортой байдаг тул тархац нутгийг нэг тодорхойлсон тохиолдолд удаан хугацаанд ашиглах боломжтой, тогтвортой аяллын төрөл юм.

### 3.3.7. Аялал жуулчлалын нөөцийг зохистой ашиглах, хамгаалах талаар өгөх зөвлөмж

ГГБЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацыг тогтоосон дээрх судалгааг үндэслэн цаашид үйл ажиллагаандаа баримтлах дараах зөвлөмжийг санал болгож байна.

#### 1. Аймаг, сумын төрийн захиргааны байгууллагуудад өгөх зөвлөмж

- Аймгийн аялал жуулчлалын бодлого, төлөвлөлттэй уялдуулан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны санал, зөвлөмжийн дагуу аялал жуулчлалын аливаа үйл ажиллагааг дэмжих
- Бүс нутгийн аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөхүйц, аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах хэлбэрээр зохион байгуулах ажлыг дэмжих
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрт аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд, нутгийн иргэдийг хамруулах ажлыг дэмжиж ажиллана
- Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний байгууллагуудын ажил үйлчилгээг хууль дүрэм журам, стандартын дагуу явуулж хэвшүүлэх, үйлчилгээний соёл хэвшүүлэхэд Орон нутгийн удирдлагын харьяа газар, албатуудын хүч нөөцийг зөв дайчилж оролцуулж иргэд, аж ахуйн нэгжийг дэмжихдээ зөвлөж сургах, чиглүүлэх замаар ажиллах
- 2023, 2024, 2025 онуудыг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан ГГБЦГ-т аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх
- Аймгийн БОАЖГ-т аялал жуулчлалын асуудал эрхэлсэн ажилтны орон тоог нэмэгдүүлж ажлын чиг үүргийг оновчтой тогтоож өгөх
- Аялал жуулчлал, амралт, сувилал, бусад үйлчилгээний зориулалтаар газар олголт хийхдээ тухайн бүс нутгийн аялал жуулчлалын болон байгаль экологийн даацад нийцүүлэн газар олголтыг төлөвлөж, олгож байх

#### 2. Хамгаалалтын захиргаанд өгөх зөвлөмж

- Их ашиглагдсан нөөцүүдийн хэрэглээг хязгаарлах, тэдгээрт шууд болон шууд бусаар нөлөөлөх нөлөөллийг багасгах
- Их ачааллын үед хоногт ирэх жуулчдын тоог даацын дагуу хязгаарлаж, “Гийчдийн менежмент”-ийг ТХГН-ийн экологийн зарчим бүхий олон улсын стандартад нийцүүлэн “цагийн менежмент”-ийн зохицуулалтаар төлөвлөх
- Аялал жуулчлалын зориулалтаар ашиглах боломжтой газруудын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бий болгож, түүнийг эргэлтэд оруулахдаа дуудлага худалдаагаар зориулалтын дагуу хэрэгжүүлэх төслийг шалгаруулах, мөн санхүүгийн чадавхыг харгалзаж газар олгох зөвшөөрлийг өгч байх
- Хүний үйл ажиллагааны нөлөөллийг бууруулахын тулд олон салаа авто замыг хаах, нөхөн сэргээхэд мэргэжлийн байгууллагын санал зөвлөмжийг тусгах, байгаль ландшафт, хөрсний доройтлоос сэргийлж голлох үзмэрүүдэд хүрэх замыг сайжруулах эсвэл бий болгох
- Байгаль хамгаалах үйл ажиллагаанд олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдийг татах, олон улсын болон дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Байгаль орчныг хамгаалах байгууллагатай зөвлөлдөх, байгальд ээлтэй үйл ажиллагааны хэрэгжилтэд хариуцлагатай хандах
- Энэхүү бодлогын бичиг баримтад тусгагдсан эко аяллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, байгалийн сайхныг үзэж сонирхох ердийн хөсгөөр аялах болон явган аяллын маршрутуудыг бий болгох. Хамгаалалтын захиргаа нь экологийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд санаачилгатай ажиллах хэрэгтэй бөгөөд Хүрмэн сумын нутаг Зүүн сайханы Дүнгэнээгийн эх, Сэврэй сумын Баянборын нуруу, Зөөлөн уулын баруун хойд хэсэг, Сэврэй уулын зүүн хойд хэсэг, Эрээн уул, Гурвантэс сумын Алтан, Гилбэнт, Нэмэгт, Тост уул зэрэг нутгууд амьтны аялал-рекреацийн үнэлгээгээр өндөр үнэлгээтэй гарсан тул эдгээр газруудад аргаль хонь, янгир ямаа, цоохор ирвэс, хулан адуу, хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг дэлхийд ховорт тооцогдох болсон амьтдыг ажиглах, фото сафари аяллыг хөгжүүлэх боломжтой юм.
- Нутгийн иргэдэд аялал жуулчлалын мэдлэг олгох сургалт, зөвлөгөө зохион байгуулах
- Уламжлалт мал аж ахуй, газар тариалан, уул уурхайгаас нутаг дэвсгэрийг хамгаалах
- ТХГН-ийн аялал жуулчлалын болон онцгой бүсэд төрөл бүрийн суурьшлыг төлөвлөхгүй байх, тэдгээр дэх мал аж ахуйн өсөлтөд тодорхой хязгаарлалт тавих
- Байгалийн үзэсгэлэнт газрууд нь аялал жуулчлалын сурталчилгаа болох гол үнэт чанар тул сурталчилгаандаа түлхүү хэрэглэх
- Нийтийн бие засах байгууламжийн үйлчилгээг шинэчлэх, сайжруулах, тогтмолжуулах
- Гадаад, дотоодын аялагчдаас тогтмол судалгаа авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх
- Хамгаалалтын захиргаанаас нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд аялал жуулчлалыг зүй зохистой хөгжүүлэх стратегийг боловсруулах

- Дахин ирж буй жуулчдын сонирхлыг татах үзмэр бүхий газрын дэд бүтэц, жуулчны байр сууц, нийтийн бие засах байгууламжийг хөгжүүлэх
- Augmented Reality (AR), Virtual Reality (VR) зэрэг дижитал аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх
- Жуулчны мэдээллийн төв болон өөрийн веб сайтын мэдээллийг шинэчлэх
- Аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцох өрх, нөхөрлөл, хоршоонд дэмжлэг үзүүлэх, хамгаалалтын захиргаанаас үйл ажиллагааг хянах
- Наадам эвент арга хэмжээний үеэр холбогдох байгууллагатай хамтран баяр наадмын талбайд Жуулчны мэдээллийн төвийг Нүүдлийн хэлбэрээр зохион байгуулах
- ГГБЦГ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн давхцалыг арилгах, хамгаалалтын зэрэглэл, хамгаалалтад авсан огноо, тушаал шийдвэр, солбицлыг тодорхой болгох, нарийвчилсан судалгаа, бүртгэлжүүлэлтийг хийж, аялал жуулчлалын эргэлтэд оруулах, хамгаалалтад аваагүй дурсгалуудыг орон нутгийн хамгаалалтад авах шаардлагатай. Өмнөговь аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаар Соёлын үндэсний төв, Аймгийн музейн хамтарсан судалгааны үр дүнг авч холбогдох мэргэжлийн хүмүүстэй хамтран ГГБЦГ-ын бүсэд багтах эсэхийг тодорхойлох нь зүйтэй. Ингэж зарим дурсгалуудын нарийн солбицлыг зөв тогтоож ГГБЦГ-ын орчны бүсэд багтаж байгаа эсэхийг тодруулах, багтаж байвал хамгаалалтад авах, судлах хэрэгтэй. Тухайлбал, Ханхонгор сумаас өмнө зүгт 65 орчим км-т байх Баруун булгийн адаг Шар хороотын хадны зураг, Хүрмэн сумын Хүрмэн багаас баруун тийш 25 орчим км-т орших Бардан Чандманий булш, Гурвантэс сумын баруун урд 28 км-т орших Гэцэлийн усны хадны зураг, зүүн урд зүгт орших 57 км-т орших Эрдэнэ хайрханы хадны зураг зэрэг зарим дурсгалууд хамгаалалттай нутаг дэвсгэрийн орчны бүсэд багтаж байгаа эсэхийг тодруулах нь зүйтэй. ГГБЦГ-ын сайт дээрх түүх, соёлын дурсгалуудын жагсаалтад Уул жаргалантын хийдийн туурийг Баяндалай сумаас 25 км-т Баян багийн нутаг дэвсгэрт оршино гэсэн бол Соёлын өвийн Үндэсний төвөөс бэлтгэн гаргасан “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” бүтээлийн XII дэвтэрт тусгаснаар Хүрмэн сумын төвөөс баруун зүгт 30 км-т, Хүрмэн багийн нутаг дэвсгэрт оршино хэмээжээ. Хэрэв Хүрмэн багийн нутаг дэвсгэрт багтдаг нь үнэн бол ГГБЦГ-ын орчны бүсэд багтах эсэх нь эргэлзээтэй юм.
- Наадам эвент арга хэмжээний үеэр холбогдох байгууллагатай хамтран баяр наадмын талбайд урьдчилан зохион байгуулж шилж сонгосон гадаад хэлний мэдлэгтэй сайн дурын ажилтан залуучууд оюутнуудаар жуулчны цагдаа ажиллуулж мэдээлэл хүргэх, тусалж дэмжих, аюулгүй байдал хангах, замчлах хөтөчлөх зэргээр үйлчлүүлэх
- Баяр наадмын талбайн орчимд худалдаа үйлчилгээ эрхлэх, хоол ундааны үйлчилгээ үзүүлэхдээ ариун цэвэр, соёлжилт, хог хаягдал хаяхгүй байх менежмент, найрсаг соёлтой зочломтгой үйлчилгээг хэвшүүлэх аяныг зохион байгуулах
- Баяр наадам эвент арга хэмжээний үеэр жуулчдаас болон аяллын компаниас санал сэтгэгдлийг тусгай хуудсаар авч үйл ажиллагааны талаар статистик дүгнэлт гаргаж ажиллах



3. *Малчин өрх, нутгийн иргэдэд өгөх зөвлөмж*
  - Хамгаалалтын захиргааны ажилчид, байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах
  - Аялал жуулчлалын сургалт, зөвлөгөө авч, нөхөрлөл, эко отог хэлбэрээр болон морин, ердийн хөсөгтэй аяллыг хамгаалалтын захиргаатай хамтран хэрэгжүүлэх
  - Уламжлалт зан заншлыг хадгалсан аж ахуйг эрхэмлэж аялал жуулчлалаас нэмэлт орлого олох
  - Байгалийн болон соёлын өв, нөөцөд ухаалаг хандах
  - Аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцох нутгийн иргэд, өрх гэр, малчин айлууд хамтарч нөхөрлөл, хоршооны чиглэлээр ажиллах
4. *Жуулчдад өгөх зөвлөмж*
  - Эко аяллын зарчимд нийцсэн байдлаар аялах
  - Хог хаягдал хаяхгүй байх, шинээр зам жим гаргахгүй байх
  - Хамгаалалтын захиргаанаас гаргасан зөвлөмжийг хүндэтгэн үзэж, дагаж мөрдөх
  - Ховор ховордсон биологийн төрөл зүйл, палеонтологийн олдворыг хөндөхгүй байх
5. *Эко отог, жуулчны бааз, гэр буудлуудад өгөх зөвлөмж*
  - Тээврийн хэрэгслийн зогсоолыг гэрээс 200 метрээс багагүй зайд байрлуулах
  - Байгалийн тогтоц, түүх, соёлын дурсгалт газар, үзмэр, авто замаас 2 км-ээс багагүй, булаг шанд, рашаан ус, гол горхи зэргээс 100-аас багагүй метрийн зайд өндөрлөг, нөмөр газар байрлах
  - Эко гэрийн отгийн ашиглалтын талбай 1 га-аас ихгүй байх ба эдэлбэр газрын ерөнхий зурагтай байх
  - Гэр хоорондын зай 10 метрээс багагүй зайд байрлах
  - Гэрээс эргэн тойрон 300 метр газар байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэсэн байна.
  - Жуулчны бааз, амралтын газрууд нь үндэсний онцлогийг илэрхийлсэн гэр баазын зохион байгуулалтаар тогтмол ажилладаг байх. Дараа дахин ирнэ гэсэн жуулчид монгол хоол ба монгол гэрийг их сонирхож байгаа нь судалгаагаар илэрсэн.
  - Хогийн цэг гэрээс 60 метрээс багагүй зайд, салхины дор байрлах
  - Хогийн савыг хог ялган хийх тасалгаатай хийж, газрын гадаргаас хөндийрсөн байгууламжид байрлуулах, хогоо ангилан ялгаж сурах
  - Эко аяллын бүтээгдэхүүнийг аялагч, жуулчдад санал болгох
  - Бусад бааз, гэр буудлуудаа ялгарах өөрийн гэсэн имиж, дүр төрхийг бүрдүүлэх
  - Хамгаалалтын захиргааны баталсан, санал болгосон аяллын замналаар жуулчдыг аялуулах
  - Хог хаягдал, цэвэр ба бохир ус, цахилгаан эрчим хүч, дулаан зохицуулалтыг эко шийдлээр гүйцэтгэх
  - Жуулчны баазууд бие биеэсээ ялгарах онцлогтой байх
  - Биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгаль орчныг нөхөн сэргээх зэрэг хамгаалалтын үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлж, Хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах
  - Цэвэр байгалийн гаралтай эрүүл хүнс болох мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, байгалийн экологийн цэвэр бүтээгдэхүүнээр жуулчдад үйлчлэх, энэ талаараа сурталчлан таниулах



## ДҮГНЭЛТ

1. Цар тахлаас өмнө цогцолборт газраар аялж буй гадаадын жуулчдын тоо 2012-2014 онуудад тогтмол өсөж байсан боловч 2015 онд өмнөх жилээс 37.4%-иар буурч, 2016 оноос эргээд тогтвортой өссөн байна. 2019 онд жуулчдын тоо сүүлийн арван жилд хамгийн их байсан ба өмнөх жилээс 92.7%-иар өссөн үзүүлэлттэй гарчээ. Гэвч дэлхийг хамарсан Ковид-19 цар тахлаас шалтгаалж дэлхийн аялал жуулчлалын салбар 0 зогсолт хийсэнтэй холбоотой жуулчдын тоо 2019 онтой харьцуулахад 2020 онд 71%, 2021 онд 84%-иар огцом буурсан байна. Гэвч дараагийн 5 жилд тус цогцолборт газрыг зорин ирэх жуулчдын тоо 95%-иар өсөх магадлалтай байна.
2. Дотоодын жуулчдаас авсан судалгаанаас харахад ГГБЦГ-ын аялал жуулчлалын үзмэрийн үнэ цэн нь унаган дагшин байгаль байгаа бөгөөд аялагчдын аяллын дундаж хоног нь 3-4 хоног байна. Түүнчлэн анх удаа ирж буй жуулчид богино хугацаагаар буюу Гурвансайхан уул, Хонгорын элс орчмоор, харин давтан ирж буй жуулчид 9 хүртэл хоногоор алсын зайн маршрутаар аялахыг хүсдэг байна. Гадаадын жуулчдын хувьд Ёлын ам, Хонгорын элсийг ихэвчлэн үзэж сонирхсон бөгөөд Монгол гэр, Монгол хоолыг илүү сонирхож, байгалийн үзэмжит байдлыг биширч, түүнийг фото зурагт буулгах зэргээр аялдаг байна. Гадаадын болон дотоодын жуулчдын хувьд байр сууцны үйлчилгээний чанарыг сайжруулах, бие засах газрын асуудалд хамгийн их анхаарал хандуулж, сайжруулахыг хүссэн юм.
3. ГГБЦГ-ын дотоод бүс дэх малын тоо толгойнд хяналт тавих шаардлагатай. Ялангуяа онцгой бүсэд байрлах малчин өрхүүдийн малын тоо, толгой 2020 онд өмнөх жилүүдээс огцом өссөн байна. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг Монгол орны онцлогтой холбоотой бараг бүх тусгай хамгаалалттай газар нутагт ард иргэд уламжлалт мал аж ахуйгаа эрхэлсээр ирсэн. Энэхүү үйл ажиллагааг хамгаалалтын бүсүүдээр зохицуулж ирсэн боловч зарим газар дахь аялал жуулчлал болон бэлчээр ашиглалтын давхцал нь байгалийн даацыг нэмэгдүүлэх, байгаль орчныг доройтуулах томоохон хүчин зүйл болж байна. Бэлчээрийн нөлөөлөл ихтэй газрын хөрсний бүтцийн бат бөх байдал алдагдаж, гаднын нөлөө, үйлчлэлийг даах чадваргүй болж элсний агууламж нэмэгдэх, цогцолборт газрын хөрс талхлагдах, доройтох үндэслэл болдог.
4. Хөрсний чанарын үнэлгээгээр тус нутаг дэвсгэрийн ландшафтын хэв шинж нь 61.9 гэсэн үнэлгээтэй буюу аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад “тохиромжтой” гэсэн үр дүн гарсан бол рекреацийн тааламжийн үнэлгээгээр ГГБЦГ нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд “тааламжтай” гэсэн үнэлгээтэй гарсан.
5. ГГБЦГ-ын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийн 10%-д авто замын нөлөөлөл хүчтэй илэрсэн, 24.23% нь бэлчээр ашиглалтын нөлөөлөлд ихээр өртсөн, 0.3%-д жуулчны баазын нөлөөлөл хүчтэй илэрчээ. Жуулчны баазын нөлөөлөл хүчтэй илэрсэн нутаг дэвсгэр нь 6524.61 га талбай буюу одоогийн жуулчны баазууд байгаа Ёлын ам, Хонгорын элс орчмын газар нутаг юм. Нэгдсэн үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 10.75%-д хүний үйл ажиллагааны нөлөө хүчтэй, 88.45%-д бага болон дунд хэмжээтэй байна.

6. Ландшафтын аялал-рекреацийн нэгдсэн үнэлгээгээр ГГБЦГ-т аялал жуулчлал, рекреацийн үйл ажиллагааг хөгжүүлэх сул, дунд, өндөр гэсэн 3 түвшин ялгарсан бөгөөд энэхүү үр дүн нь цаашид тухайн нутаг дэвсгэрийг аялал-рекреацийн чадавхиар ялган бүсчлэх, ашиглалтын хэтийн төлөвийг тодорхойлох боломжийг олгоно.
7. Аялал жуулчлалын даацыг одоо байгаа үндсэн 2 маршрутаар тооцож гаргасан бөгөөд ойрын зайн буюу Гурван сайхан уул, Хонгорын элс орчмын аяллын маршрутын бодит даац өдөрт дунджаар 377 жуулчин, холын зайн буюу ГГБЦГ-ын баруун тийш Хэрмэн цавын чиглэлийн маршрутын даац нь өдөрт 850 жуулчин байна. Үүнээс харвал Гурвансайхан уул, Хонгорын гол орчмоор аялах жуулчдын тоо өсвөл аялал жуулчлалын даац хэтрэх аюултай. Тиймээс Гурвансайхан уул, Хонгорын гол орчимд аялал жуулчлалыг даацыг нь хэтрүүлэлгүй тогтвортой хөгжүүлэхэд анхаарах, Гийчдийн менежмент (айлчлалын менежмент ч гэж нэрлэдэг)-ийн бодлого баримталж цагийн зохицуулалтыг хийх (тухайлбал өдөрт ирэх нийт жуулчдыг тодорхой цагуудад хуваарилан нэвтрүүлэх, өөрөөр хэлбэл 30 жуулчин нэвтэрснээс хойш 30 минутын дараа дараагийн 30 жуулчныг нэвтрүүлэх зэргээр нэгж хугацаанд нэг дор жуулчдыг олноор нэвтрүүлэхээс татгалзах г.м) шаардлагатай. Жуулчдын даац хэтрэх магадлал бүхий зорих гол газруудыг (Ёлын ам, Мухар шивэрт, Хонгорын элс г.м) холбосон хатуу хучилттай зам байгуулах нь замын эвдрэл, хөрсний талхагдлаас урьдчилан сэргийлэх, жуулчдын тоон өсөлтөөс байгаль экологид учруулах сөрөг нөлөөллийг бууруулж даац хэтрэх аюулыг багасгах арга зам болно. Мөн Бүгийн цав, Наран даац, Зулганай, Хэрмэн цав руу хийх алсын зайн аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлж аялал жуулчлалын хөгжлийн төвлөрлийг бууруулах нь зүйтэй.
8. Одоогийн байдлаар гэрээт болон үндсэн байгаль хамгаалагчдын ХНЧ 8.25 буюу нэг байгаль хамгаалагч 8 машинд хяналт тавьж ажиллаж байгаа ба ойрын ирээдүйд ГГБЦГ-т ирэх аялагч жуулчдын тоо 95%-иар өснө гэсэн прогноз гарсныг харгалзан үзвэл байгаль хамгаалагч нэмж авах шаардлагагүй. Учир нь өдөрт ирэх жуулчдын тоо 95%-иар буюу хоёр дахин өсөж 600 хүн ирсэн ч одоо ажиллаж буй ХНЧ 16.56 буюу нэг байгаль хамгаалагч 16-17 машинд хяналт тавих боломжтой юм. Ирэх жуулчдын тоо 820-оос давсан тохиолдолд нэмж байгаль хамгаалагч авах нь зүйтэй. Хэдийгээр байгаль хамгаалагч нэмж авах асуудалд байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн норм, нормативыг харгалзан үзэх шаардлагатай ч жуулчдын тоон өсөлтийг бас харгалзан үзэх нь хамгаалалттай нутаг дэвсгэрийн хамгаалалтыг сайжруулах, унаган төрхийг алдагдуулахаас сэргийлэх ач холбогдолтой.
9. Менежментийн чадавхын шинжилгээнээс үзэхэд ГГБЦГ-ын байгууллагын менежментийн үйл ажиллагааны чадавх болон хүний нөөцийн менежментийн чадавхууд бусад үзүүлэлтүүдийг бодвол хамгийн өндөр буюу 4 гэсэн үнэлгээтэй байгаа бөгөөд харин олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрүүдэд оролцох, түүнийг хэрэгжүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Цаашид сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, ижил төрлийн бүтээгдэхүүн санал болгодог ТХГН-тай өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, аялагч жуулчдаас тогтмол сэтгэл ханамжийн судалгаа авч, үнэлэлт дүгнэлт өгдөг болох,

жуулчдад ГБЦГ-аас санал болгодог бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, ингэснээр аялагчдын хүлээлтийг бодит байдалд нийцүүлэх зэрэг маркетингийн үйл ажиллагаанууд, мөн жуулчны бааз, хоолны үйлчилгээний байгууллагыг цогцолборт газрын даацад тохируулан нийлүүлэлтийг улирал харгалзахгүй тогтмолжуулах, үйл ажиллагааны хүчин чадлаа бүрэн ашиглах, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдийг татаж ТХГН-т оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудад анхаарал хандуулах хэрэгтэй юм.

10. ГБЦГ-т үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазууд хүчин чадлынхаа 39%-ийг ашигладаг бөгөөд тэдгээр 7 бааз хүчин чадлаа 100% ашиглавал 770 хүн хүлээн авах боломжтой. Даацыг тооцож үзсэн 2 маршрут нь 200 гаруй км газраар давхцаж байгаа тул жуулчны бааз нэмж байгуулах асуудлыг нийт бодит даацын дунджаар үзвэл өдөрт 614 жуулчин болох бөгөөд тэдгээр жуулчдыг бүгдийг нь жуулчны баазад хүлээн авна гэж үзвэл одоо байгаа жуулчны баазууд хүчин чадлынхаа 79.9%-ийг ашиглах боломжтойг харуулж байна.
11. Цаашид аялал жуулчлалын үйл ажиллагааг төлөвлөх, жуулчны бааз байгуулах асуудлыг байгаль ландшафтын эрсдэлийн нэгдсэн үнэлгээний үр дүнг харгалзан эрсдэл маш бага болон бага газруудаар төлөвлөх нь зүйтэй юм. ГБЦГ-ын нийт нутаг дэвсгэрийн 55% нь энэ ангилалд багтаж байна. Аялал жуулчлалын үйл ажиллагааг цаашид төлөвлөх, түүний дотор жуулчны бааз байгуулах боломжит газар нь ойрын маршрутад 15 га, баруун тийш буюу Гурвантэс сумаас хойш Зулганайн баянбүрд, Наран даац, Бүгийн цавын орчим 55-60 га байна. Мөн Хэрмэн цавын орчимд байгуулагдахаар төлөвлөгдсөн цогцолборыг түшиглэн жуулчны гэр бааз байгуулж болох юм. Гэвч
12. SWOT-АНР шинжилгээний үр дүнгээс харахад ГБЦГ-ын хамгийн чухал давуу тал нь “Говь” хэмээх дэлхийд танигдсан нэр хүнд болон байгалийн өвөрмөц тогтоц байна. Тиймээс энэхүү дэлхийд Монголыг таниулсан нэр хүнд, говийн өвөрмөц, үзэсгэлэнт байгалийг өөрсдийн мэдээлэл, сурталчилгаандаа түлхүү ашиглах, сурталчлах шаардлагатай. Харин хамгийн эхэлж сайжруулах ёстой сул тал нь чадварлаг үйлчилгээний ажилчдыг бэлтгэх асуудал гэсэн үр дүн гарсан тул хүний нөөцийг сургаж бэлтгэх замаар үйлчилгээний чанарыг сайжруулах талаар үйлчилгээний байгууллагууд анхаарах хэрэгтэй. Мөн аялал жуулчлалын төвлөрсөн хөгжлийг сааруулах, аяллын шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, маршрутыг баяжуулах асуудал ч чухал юм. ГБЦГ-ын хувьд анхаарч үзэх ёстой гол аюул бол аялал жуулчлалын буруу үйл ажиллагаанаас шалтгаалсан байгаль экологийн доройтол болох нь шинжилгээний үр дүнд харагдлаа. Тиймээс Хамгаалалтын захиргааны зүгээс энэ талаар шат дараалсан арга хэмжээнүүдийг авч, үйлчилгээний байгууллагуудад эко стандартын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллах шаардлага тавьж ажиллах нь зүйтэй.
13. Өрсөлдөөнийг тодорхойлогч СРМ матрицыг ашиглан ГБЦГ-ыг Хөвсгөлийн БЦГ, Хөгнө-Тарнын БЦГ-тай харьцуулан шинжлэлээ. ГБЦГ нь Хөвсгөлийн БЦГ-тай харьцуулахад түүх, соёлын нөөцийн хувьд илүү, байгалийн нөөц, дэд бүтцийн хөгжлийн хувьд ижил боловч олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж хөрөнгө оруулалт татаж чадаагүй, жуулчны

үйлчилгээний байгууллагын хөгжил сул, аяллын маршрутын сонголт бага зэрэг үзүүлэлтүүдээрээ сул байна. Харин Хөгнө-Тарнын БЦГ-тай харьцуулахад зохион байгуулдаг эвент арга хэмжээгээрээ илүү ч жуулчны үйлчилгээний байгууллагын хөгжлөөр мөн бага байна. Тиймээс ГГБЦГ нь цаашид дотоод, гадаадын судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтарч ажиллах, хөрөнгө оруулалт татах, үйлчилгээний байгууллагуудыг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарах, аяллын шинэ маршрут бий болгож, хөгжүүлэх тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй.

## НОМ ЗҮЙ

1. Амьтны тухай хууль. 2012.
2. Ариунсүрэн П, 2016. Өмнөговь аймгийн байгалийн ургамлын аймаг
3. Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож, Соёлын өвийн Үндэсний төв “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” XII дэвтэр, Өмнөговь аймаг, 2019 он
4. Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөө (2014-2018 он)
5. Дуламцэрэн.С, Д.Цэнджав, Д.Авирмэд, 1989, БНМАУ-ын амьтны аймаг, Хөхтөн амьтан, ШУА-ийн хэвлэлийн газар, УБ, 160 х.
6. Монгол улсын хөхтөн амьтны улаан данс. Ред. С.Дуламцэрэн нар. 2010,
7. Монгол улсын хөхтөн амьтны хамгааллын төлөвлөгөөний эмхтгэл. Ред. С.Дуламцэрэн нар. 2010,
8. Монгол улсын улаан ном, ред.Ц.Шийрэвдамба, О.Шагдарсүрэн нар, 1997.
9. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс, ред.М.Мөнхбаатар нар, 2010.
10. Мөнхбаяр.Х, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, 2010, “Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчид”, УБ,
11. Монгол дахь шувуудад чухал газруудын лавлах: байгаль хамгааллын түшиц нутгууд, эмхэтгэсэн Б. Нямбаяр, Н. Цэвээнмядаг УБ 2009,
12. Монгол Улсын Үндэсний атлас. 2009. Улаанбаатар хот.
13. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц, 1971, Рамсар, Иран.
14. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай” (Рамсарын) конвенцийн тайлан, 2012, нэгтгэсэн С.Гомбобаатар, УБ.
15. О.Намнандорж, Ш.Цэрэн, Ө.Нямдорж “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын рашаан”, 1966 он
16. О.Намнандорж “О.Намнандорж” III, IV, V боть, 2005 он
17. Отгонтамир Ч., 2019 “Говь гурвансайханы байгалийн цогцолборт газрын мануул (*Otocolobus manul pallas.* 1776)-ын тархалт болон хамгааллын судалгаа (зүүнсайхан, дундсайхан уулсын жишээн дээр)” магистрын ажил
18. “Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөө”, 2014 он
19. “Өмнөговь аймгийн Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газар дахь Ёл, Дүнгэнээ, Мухар шивэрт, Хавцгайтын амуудад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө”
20. Пүрэвжав Л., 2020, “Говь гурвансайханы байгалийн цогцолборт газрын Нэмэгт, Гилбэнтийн уулсад автомат камер байршуулсан судалгааны ажлын тайлан”
21. Пүрэвжав Л.,Нарангэрэл Б.,Чинбат Р., 2014, “Говь гурвансайханы байгалийн цогцолборт газрын зарим уулсад автомат камер байршуулсан судалгааны ажлын тайлан”
22. Пүрэвжав Л., 2015, “Говь гурвансайханы байгалийн цогцолборт газрын зарим уулсад автомат камер байршуулсан судалгааны ажлын тайлан”
23. SMS-ийн Боннын конвенци. 2002. Улаанбаатар хот

24. Соёлын өвийг хамгаалах тухай Монгол улсын хууль
25. Састэйнабилити Ийст Азиа ХХК, Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Статистикийн Судалгааны Төв, Аризонагийн Их Сургууль “Оюу толгой төслөөс хэрэгжүүлж буй “өмнөговь аймгийн соёлын өвийн хөтөлбөр боловсруулах” төслийн нэгдүгээр үе шатны тайлан”
26. Соёлын өвийн үндэсний төв “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” XII дэвтэр
27. CITES-ийн зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн лавлах. 2006 Улаанбаатар хот.
28. Тэнгис Б., 2019 “Өмнөговь аймгийн Тостын нуруу, түүнтэй хил залгаа зарим уулсын цоохор ирвэс (*panthera uncia schreber 1775*)-ийн нягтшил ба шилжилт хөдөлгөөн” магистрын ажил
29. Тэнгис Б., 2019 “Говь Гурвансайхан БЦГ-ын Зөөлөнгийн нурууны цоохор ирвэс (*Panthera uncia schreber, 1775*) – ийг автомат камер ашиглан бодгаль тус бүрийн өвөрмөц толбоор нь ялган таних судалгаа” багдаврын ажил
30. Хонгорын гол, Хэрмэн цав орчмын байгалийн үзэсгэлэнт газрын менежментийн төлөвлөгөө 2020-2024”, 2019 он
31. Цэвэгмэд, Ш. 1969. Монгол орны физик газарзүй. Улаанбаатар хот.

*Ашигласан цахим хаягууд*

32. <https://www.1212.mn>
33. <http://gobigurvansaikhan.mpa.gov.mn>
34. <https://ncch.gov.mn>
35. <https://www.gazar.gov.mn>
36. <http://www.touristinfocenter.mn>
37. <https://www.mongolianguideschool.com>